


ECONOMIC ANALYTICA

УЛС ТӨРИЙН ЭДИЙН ЗАСАГ СУДЛАЛ



ТАТВАР, ТАТВАРЫН БОДЛОГО ГЭЖ ЮУ ВЭ?

№1 (02) 2018

ECONOMIC ANALYTICA

УЛС ТӨРИЙН ЭДИЙН ЗАСАГ СУДЛАЛ

**ТАТВАР, ТАТВАРЫН
БОДЛОГО ГЭЖ ЮУ ВЭ?**



Конрад-Аденауэр-Сан



Глобал Эдийн Засгийн
Судалгааны Хүрээлэн

РЕДАКЦЫН БОДЛОГО

- Монгол Улсын өмнө тулгамдаад буй эдийн засгийн асуудлуудад дүн шинжилгээ хийж, судалгааны ажлуудыг хүргэх замаар нийгэм, олон нийтэд эдийн засгийн шинжлэх ухаан, боловсролыг түгээн дэлгэрүүлнэ.
- Эдийн засгийн шинжлэх ухааны салбарын эрдэмтэн, судлаачдыг дэмжих, тэр дундаа залуу эдийн засагч, эдийн засаг судлаачдыг дэмжиж ажиллана.
- Эдийн засагч, судлаачид, эрдэмтэн багш нарын судалгаа, шинжилгээний ажлыг шийдвэр гаргагчид болон бодит эдийн засагт оролцогчдод хүргэх үндсэн платформ болно.

РЕДАКЦЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Ерөнхий эрхлэгч:** А.Анар /“Амаржаргал Сан” ТББ-ийн Гүйцэтгэх захирал/
Гүйцэтгэх эрхлэгч: Ж.Батхуяг /СЭЗИС-ийн ГЭЗСХ-ийн гүйцэтгэх захирал/
Редакцын зөвлөл: Р.Амаржаргал /Монгол Улсын 21 дэх Ерөнхий сайд/
Д.Батжаргал /СЭЗИС-ийн УЗ-ийн гишүүн/
Ц.Даваадорж /СЭЗИС-ийн зөвлөх профессор/
Dr. Peter Hefele /Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгч/
Б.Сүхбат /Конрад-Аденауэр-Сангийн Төслийн зохицуулагч/
С.Түвшинзаяа /СЭЗИС-ийн Докторын хөтөлбөрийн эрхлэгч/
Ч.Наранчимэг /СЭЗИС-ийн ХМСТ-ийн профессор/
С.Норжинлхам /СЭЗИС-ийн ХУТ-ийн дэд профессор/
Д.Мөнгөнтуул /СЭЗИС-ийн ГЭЗСХ-ийн эрдэм шинжилгээний референт/
Ц.Наранцацрал /СЭЗИС-ийн ГЭЗСХ-ийн ЭШС-ны зохицуулагч/

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Д.Ганчимэг

Хавтасны эхийг бэлтгэсэн: Б.Гэрээдэй

Хэвлэлийн хуудас 16,6 хх

Хэвлэлийн Адмон принт ХХК-д хэвлэв.

ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн санхүүжилтээр СЭЗИС-ийн эрхлэн гаргах эрдэм шинжилгээ, судалгааны сэтгүүл

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хувилах, олшруулахыг хориглоно.

АГУУЛГА

ГОЛ ЯРИЛЦЛАГА

Татвар гэж юу вэ?

Д.Батжаргал Монгол Улсын гавьяат багш, СЭЗИС

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Монгол Улсын татварын орчин, төсөвт үзүүлэх нөлөө

Ж.Дэлгэрсайхан

Орлогын татварын шинжилгээ

П.Гантөмөр

Монгол Улсын татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний зарим асуудал

Ж.Ариунболд

Монгол Улсын хувь хүний орлогын албан татварын хуулийн шинэчлэлийн асуудал

Ч.Өнөржаргал, Б.Бат-Амгалан

Татварын захиргааны акт болон татварын шийдвэр гаргах ажиллагааны эрх зүйн зохицуулалт

С.Батбуян, Б.Билгүүн

Хувь хүний орлогын албан татварын судалгаа

Ч.Наранчимэг, С.Бямбаохорлоо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨГҮҮЛЭЛ

Монголын улс төр, эдийн засгийн нөхцөл байдлыг шинэ улс төрийн макроэкономиксийн үүднээс авч үзэх нь

Ц.Батсүх, С.Өнөр

БАЙР СУУРЬ

Татварын шинэчлэл эдийн засагт дараагийн том эргэлтийг авчирна

Б.Лхагважав, МҮХАҮТ-ын ерөнхийлөгч

Татварын бодлогын өөрчлөлт бүхэлдээ эдийн засгийн суурь шинэчлэл рүү чиглэж байна

Б.Тэмүүн, Сангийн Яам, Төсвийн орлогын хэлтсийн дарга

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БУЛАН

Үнэ цэн бүтээх "хуваалцахуйн" зарчим

Т.Ууганболд, Б.Идэрсүрэн

ДОКТОРАНТ, МАГИСТРАНТЫН БУЛАН

Татварын ерөнхий хуулийн шинэчлэн зохицуулсан асуудлууд

Д.Отгончимэг

Тогтвортой хөгжлийн хэрэгжилтийг хангахад аялал жуулчлалын оруулах хувь нэмэр

Д.Мөнгөнтуул

Уул уурхайн салбарын орон нутгийн банкны нэгжүүдэд үзүүлж буй нөлөө

Б.Амарзаяа

Орон сууцны найман хувийн зээлийн чадамж иргэн, банк аль аль талдаа шавхагдаж байна уу?

З.Боргиммаа

ТАТВАР ГЭЖ ЮУ ВЭ?

Д.БАТЖАРГАЛ

Доктор (Ph.D), профессор
Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

Татвар төлөгчдөө “таргалуулах”-ын тулд санхүүжилтийн зардлыг бууруулах бодлогоор дэмжих нь чухал.

ЮУНЫ ӨМНӨ ТАТВАР БОЛОН ТАТВАРЫН БОДЛОГО ХОЁРЫН ЯЛГААГ ТАЙЛБАРЛАНА УУ. ТАТВАР НЬ БОДЛОГЫН АРГА ХЭРЭГСЭЛ БОЛОХ УУ?

Татвар гэдэг нь хэн нэг иргэн, аль нэг аж ахуйн нэгж байгууллагын цалин, үйл ажиллагааны орлогоос тодорхой төрөл, хэлбэр, хувь хэмжээгээр хуулиар тогтоосны дагуу төрд авч байгаа орлого юм. Татварын бодлого гэдэг нь энэхүү татварын төрөл хэлбэрээр дамжуулж татвар төлөгчдийн үйлдлийг зохистой болгож өгөхөд чиглэсэн нөлөөллийг хэлж буй юм. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчдийн үйлдлээр дамжиж буй нөлөөллийг татварын бодлого гэж ойлгож болно. Татвараас хамаарч татвар төлөгчдийн үйлдэл янз бүрээр илэрдэг. Төр татварын бодлогоор дамжуулж татвар төлөгчдийн үйлдлийг зохистой, үр ашигтай чиглэлд хөтөлж чадаж байвал бодлого сайн хэрэгжиж байна гэсэн үг. Хэрэв татварын хувь хэмжээ, төрөл хэлбэрээс хамаарч татвар төлөгчид үүрэг хариуцлагаасаа зайлсхийж байвал татварын бодлого гаж нөлөөтэй буюу зохисгүй байгаа хэрэг юм. Зүй нь татварын төрөл, хувь хэмжээ нь татвар төлөгчид үүрэг хариуцлагаасаа зугтахгүй, тэдний үйл ажиллагаанд аль болох үр ашигтай нөлөөлж чадаж байвал татварын бодлого нь сайн явж байна гэсэн үг.

ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ҮЙЛДЭЛД ТАТВАРЫН ТӨРӨЛ, ХУВЬ ХЭМЖЭЭ ШУУД НӨЛӨӨТЭЙ ЮУ?

Татварыг юунд, хэдий хэмжээгээр ноогдуулж байгаа нь буюу татварын нэр төрөл, хувь хэмжээ нь татвар төлөгчдийн үйлдлийг удирдаж байдаг. Тэр үйлдэл нь хоёр янзаар илэрнэ. Татвар төлөгчид үр ашигтай, зохистой шийдвэр гаргахад нөлөөлж байна уу, эсвэл үр ашиггүй шийдвэр гаргахад нөлөөлж байна уу гэдгээр үйлдэл нь илэрч, үүнээс хамаараад татварын бодлого сайн, муу болох нь хамаардаг.

ТАТВАРЫН БОДЛОГЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ ХЭРХЭН ХЭМЖИХ ВЭ?

Хэрвээ татварын зохистой, жигд бодлого нь эерэг нөлөө үзүүлээд байвал нийгэм, эдийн засгийн нэгдсэн гол үзүүлэлтүүд тухайн улс орны хэмжээнд сайжраад л явчихна. Тэгэхээр үндсэн индикаторууд нь татвар төлөгчдийн үйлдлийн үр дүн болж гарч ирж байгаа болохоор үзүүлэх нөлөөг нь нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлтээр дамжуулан хэмжиж болно гэсэн үг. Ер нь нийгэм, эдийн засгийн ерөнхий үзүүлэлтээр татварын бодлогын үр нөлөөг хэмжиж болдог.

ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙГЭМД ШИЛЖСЭНЭЭС ХОЙШИХ 30-ААД ЖИЛИЙН ХУГАЦААНД МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН БОДЛОГО ЯМАР ҮЕ ШАТТАЙ ХӨГЖИЖ ИРСЭН БЭ. ЭНЭ ДУНДАА ХАМГИЙН ОНОВЧТОЙ БОДЛОГО ХЭРЭГЖИЖ БАЙСАН ҮЕ?

Энэ хугацааны татварын бодлогыг ерөнхийд нь гурван ч үе болгон хувааж болох юм. 2000 оныг хүртэл эхний 10 жилд үндсэндээ зах зээлийн эдийн засагт нийцсэн татварын тогтолцоог бүрэлдүүлэх үе шат байлаа. Энэ үед татварын өнөөгийн алба бүрэлдэн бий болж, татварын төрөл хэлбэрүүд нь тодорхой болсон юм. Хувийн өмчийн хэлбэрийг хүлээн зөвшөөрч, хувийн өмчид суурилсан шинэ тутам бизнесүүд бий болсноор татварын шинэ нэр төрлүүд үүссэн байна. Эдгээрийг хуульчлах ажил эхний арван жилд эрчтэй хийгджээ. Мөн татварын албыг тусад нь бие даасан хэлбэрээр байгуулсан гээд маш олон суурь ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Хамгийн гол ололттой зүйл нь Нэмэгдсэн өртгийн орлогын албан татварыг цоо шинээр хуульчилсан явдал байв. Ингэснээр татварын алба нь бие даасан босоо удирдлага бүхий тогтолцоо цоо шинээр бий болж төлөвших эхлэл тавигдсан юм.

Хоёр дахь үе шатыг нь 2000-2010 он гэж зааглаж болно. Энэ үед татварын албыг улам бэхжүүлж, орчин үеийн зах зээлийн тогтолцоонд нийцсэн үйл ажиллагаатай болгох үе шат байв. Харин 2010 оноос хойших гурав дахь үеийг зах зээлийн нийгэмд нийцсэн хамгийн зохистой тогтолцоог бий болгох үе шат гэж үзэж болно. Эдгээрээс хамгийн оновчтой бодлого, тогтолцоо бүхий үе гэх юм бол 2010 оноос хойших болж таарч байгаа юм. Учир нь, аливаа хөгжил үе шат дамжин улам бүр боловсронгуй, зохистой болж байдаг болохоор тэр юм. Хамгийн сүүлийн үеийн амжилттай зүйл юу байна гэхээр Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг хэрэгжүүлж эхэлсэн явдал. Иргэд үүнийг тун сайшаан

дэмжиж хүлээн авсан тул үүнийг татварын бодлогын оновчтой тогтолцоо бий болж байна гэж хэлж болох юм.

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТ ИРГЭДИЙН ХҮЛЭЭЛТЭД НИЙЦСЭН ЗҮЙЛ БОЛСОН, НӨГӨӨ ТАЛААР ЭНЭ НЬ ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН БААЗ СУУРИЙГ НЭМЭГДҮҮЛСЭН ҮҮ?

Татварын хувь хэмжээг нэмэхээс илүүтэй татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэх нь чухал юм. Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг иргэнд өгдөг болсноор татвар хураалтад иргэдийн хяналт, оролцоо нэмэгдэж, татварын бааз, суурийг өргөжүүлж байна. НӨАТ-ын буцаан олголтоо авахын тулд иргэд баримтаа шаардах, өөрсдийнхөө төсвийг хянах зэрэг эерэг, зохистой хандлагууд бий болжээ. Тиймээс л хамгийн оновчтой гэж хэлээд байгаа юм.

ТӨР ТАТВАРЫН ОРЛОГООС ТӨСВӨӨ БҮРДҮҮЛДЭГ ЗАРЧИМТАЙ. ЭНЭ Ч ҮҮДНЭЭС ТӨСӨВ ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ХЯНАЛТАД БАЙХ ЁСТОЙ. НӨГӨӨТЭЭГҮҮР ТАТВАРЫН МӨНГИЙГ ЗӨВ ЗОХИСТОЙ ЗАРЦУУЛАХ ХЭРЭГТЭЙ. ЭНЭ АСУУДАЛД ТА ЯМАР ДҮН ТАВИХ ВЭ?

Энэ нь өргөн утгаараа Монголын төрийн тогтолцоог зохистой өөрчлөх асуудал болж хувирна. Татвар төлөгчдөөс хурааж авсан орлогоор төрийн зохицуулалтууд хийгдэж байгаа. Төрийн зохицуулалт хийгдэнэ гэдэг нь УИХ, Засгийн газрын хоорондын харилцаа, бодлогын уялдаа холбоо болж таарна. Татвар төлөгчдийн мөнгийг илүү үр ашигтай зарцуулах эсэх нь Төсвийн болон Төсвийн удирдлага, санхүүжилтийн тухай хууль гэхчлэн бусад хууль, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилттэй холбоотой яригдана гэсэн үг. Төсвийн зарцуулалт, түүний бодлогын үр дагавар, хяналтыг яривал асуудал маань өргөн хүрээтэй болоод явчихна.

Өөрөөр хэлбэл, татвар төлөгчдийн мөнгийг хэр үр ашигтай зарцуулж байна вэ гэдэг нь бүхэлдээ Монгол Улсын төрийн тогтолцоог бүхэлд хамарна гэсэн үг. Хөгжлийн үйл явцаа дагаад иргэд ялангуяа Нэмэгдсэн өртгийн орлогын албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, Компанийн ашгийн татвар зэрэгт маш мэдрэмжтэй болсон нь харагдаж байгаа юм. Татвар төлөгчид татварын бодлогын аливаа өөрчлөлтөд илүү ухамсартай ханддаг болсныг саяхны жишээ харууллаа. Өмнөх Засгийн газрын үед санаачилсан Татварын багц хуулийн өөрчлөлтийг татвар төлөгчид нэгдэн нийлж байгаад янз бүрийн арга хэмжээ, акц зохион байгуулах замаар эсэргүүцээр болиулсан байна.

ТАТВАРЫН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ХИЙХДЭЭ БОДЛОГО ТОДОРХОЙЛОГЧИД МААНЬ ТӨРИЙН САНХҮҮ, МӨНГӨНИЙ ГЭЭД БУСАД БОДЛОГОТӨЙ УЯЛДАА ХОЛБООТОЙ АВЧ ҮЗЭЖ ЧАДАЖ БАЙНА УУ?

Бодлогын бусад арга хэрэгслүүдтэй уялдаа холбоотойгоор асуудлыг харах түвшинд хараахан хүрээгүй байна. Төрийн бодлого гэдэг нь санхүүгийн, мөнгөний, татварын, цаашлаад нийт иргэдийн үйл ажиллагаа, зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд нөлөөлөх гээд тоо томшгүй үр дагавар бүхий олон арван бодлогын нийлбэр байдаг. Энэ бүхэн хоорондоо уялдаж чадахгүй байгаа. Зүй нь бол тэдгээр бодлого хоорондоо уялдаж байж, хөгжил дэвшлийг авчирна. Зөвхөн санхүү, мөнгөний бодлого гэлтгүйгээр төрөөс явуулж байгаа бүх бодлого хоорондоо уялдаатай байх ёстой. Тийм уялдаа холбоо бүхий цогц бодлогыг өнөө хэр нь явуулж чадаагүй, түүний тусгал илрэл нь бид бүгдийн өнөөгийн байгаа бодит байдал.

ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ХУВЬД АЛИВАА ТАТВАР, ХУРААМЖ НЬ ТОДОРХОЙ ХЭМЖЭЭНИЙ ДАРАМТ БОЛЖ БАЙДАГ. ЭНЭ ДАРАМТЫГ АЛЬ БОЛОХ БУУРУУЛАХ, ЗӨӨЛӨХИЙН

ТУЛД ӨӨР БУСАД БОДЛОГООР ХЭРХЭН ДЭМЖИЖ БОЛОХ ВЭ?

Татвар, хураамжийн зардал аж ахуй эрхлэгчдийн орлогыг багасгаж байдаг учраас энэ дарамтыг зөөллөхийн тулд зээлийн эх үүсвэр, зээлийн хүүг бууруулах арга замыг эрэлхийлэх учиртай. Зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг арилжааны банкны зээлээс өөр арга хувилбараар бий болгох нь татвар төлөгчид дээр ирж байгаа татварын дарамтыг бууруулахад тус нэмэртэй болно.

Зээлийн хүүг бууруулах, урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр ашиглах боломж, нөхцөлийг бүрдүүлж өгч чадах юм бол татварын төлөгчдийн дарамтыг шууд бууруулна. Тэр нь цаанаа баялаг бүтээгчдийг улам дэмжиж, урамшуулдаг. Татвар төлөгчид нь даац, тоо, чанарын хувьд ч сайжрах нөлөө үзүүлнэ.

БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ТАТВАР БОЛОН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРДАЛ НИЙТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ХЭД ОРЧИМ ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА ВЭ. ЭНЭ ХЭМЖЭЭ ХЭДИЙ ХЭМЖЭЭНД БАЙХ НЬ ЗОХИСТОЙ ГЭЖ ҮЗЭХ ВЭ?

Санхүүжилтийн зардал гэдэг нь зээлийн хүүгийн зардал юм. Тэгэхээр зээлийн хүү гэдэг нь дам утгаараа "татвар" болоод явчхаж байгаа хэрэг. Монголбанкны жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн дунд явуулдаг судалгаагаар аж ахуйн нэгжүүд цалин, татварт нийт зардлынхаа 19 орчим хувийг, санхүүжилтийн буюу зээлийн хүү, хураамж, шимтгэлд 14 орчим хувийг нь зарцуулдаг гэсэн тоо гардаг. Аж ахуйн нэгжүүд ашиг, орлогоосоо татвар төлнө. Дээрээс нь зээлийн хүү төлнө гэхээр давхар давхар дарамтад орж байгаа юм. Татварын хувь хэмжээг олон дахин өөрчлөөд байх нь тийм ч оновчтой биш. Юут нь өөрчлөх вэ гэхээр санхүүжилтийн зардлыг нь багасгах л арга хэмжээ авч явах ёстой. Татвар төлөгчдөө "таргалуулах" гэж заримдаа ярьдаг юм. Өөрөөр хэлбэл,

санхүүжилт авахад, олоход, татахад, хөрөнгө босгоход зардал нь бага байх ёстой. Татвар төлөгчдийнх нь ашиг орлого нь нэмэгдээд байвал татварын хувь хэмжээг нэмээгүй харьцангуй бага түвшиндээ байхад нь татварын орлогын хэмжээ ихэснэ л гэсэн үг. Тэгэхээр санхүүжилтийн зардлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч байж, санхүүгийн зах зээлээ цогцоор нь хөгжүүлж байж татвар төлөгчдөд очих дарамт буурна. Шууд утгаараа биш ч гэсэн дам нөлөө нь буурах юм.

ТӨСВИЙН ТАТВАРЫН ОРЛОГООС ҮЗВЭЛ АЛЬ НЭР ТӨРЛИЙН ТАТВАР ХАМГИЙН ӨНДӨР ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА ВЭ. ТӨР ОРШИН БАЙГААГИЙН ХУВЬД “ХҮЧЭЭР” ДАЛАЙЛГАН АВДАГ ТАТВАРУУД ИЛҮҮ ӨНДӨР ХУВЬТАЙ БАЙНА УУ, ЭСВЭЛ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН АШИГ ОРЛОГООС СУУТГАДАГ ТАТВАР ӨНДӨР ХУВЬТАЙ БАЙНА УУ.

Ер нь хамгийн өндөр хувьтай татвар бол одоогийн байдлаар Нэмэгдсэн өртгийн орлогын албан татвар. Энэ төрлийн татварт буцаан олголтыг хэрэгжүүлснээр ямар эерэг үр дагавар гарч байна вэ гэхээр хэрэглэгчийн хэрэглээг зохистой болгох үйлдэлд хүргэж байгаа юм. Ер нь хэрэглээний татвар нь Онцгой албан татварын өндөр хувь хэмжээтэй архи, тамхи, согтууруулах ундаа зэрэг хэрэглээг хянах, багасгахад нөлөөтэй.

Нөгөөтгээгүүр татварын буцаан олголт авч байгаа учраас хэрэглэгчид, татвар төлөгчид хэрэгцээндээ заасан зардлаа хянаж эхэлнэ. Энэ утгаараа Нэмэгдсэн өртгийн орлогын албан татвар бол хүчээр авч байгаа татвар биш. Хэрэглээнээс нь авч байгаа татвар юм. Тэр утгаараа энэ нь зохистой үйлдэлд хүргэдэг юм. Харин шууд ашиг, орлогоос нь татвар аваад ирэхээр дарамт болоод баялаг бүтээгчдийн үйл ажиллагаа хумигдахад хүргэдэг. Ер нь хэрэглээнээс авах татвараа ихэсгээд, татвар төлөгчдийн ашиг орлогоос авах хэмжээг бууруулах юм бол татвар төлөгчид үйлдвэрлэлээ нэмж, ашиг орлогоо нэмэх боломж бүрдэнэ.

УИХ-ААР ТАТВАРЫН БАГЦ ХУУЛИУДАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ГЭЖ БАЙГАА. ЦААШИД ТАТВАРЫН ОРЧИНД ЯМАР БОДЛОГО ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙГААГ СУДЛААЧИЙН ХУВИАР ТОДОРХОЙЛЖ ӨГНӨ ҮҮ?

Хэрэглээнд суурилсан татварыг аль болох түлхүү хөгжүүлэх хэрэгтэй. Ер нь ашиг орлогод ногдох татварыг дахин дахин өөрчлөх нь сайн зүйл биш. Тиймээс татварын хуулийг урт хугацаанд хэрэгжүүлж явах нь зөв. Энэ хугацаанд иргэд, аж ахуйн нэгжүүд эрүүлжинэ. Эрүүл ухаанаар төсвөө зохиох, онцгой албан татвар ногдулдаг янз бүрийн бараанаас татгалзах гээд маш олон үр нөлөө бий. Үүнийгээ хадгалаад явах хэрэгтэй.

МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ОРЧИН, ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Ж.Дэлгэрсайхан

СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн дэд профессор (МВА)

Abstract. A primary goal of this research is to assess the current circumstance of Mongolian tax environment and tax burden with the consideration of the respective taxation theory and international experiences. To fulfill the goal, the researcher firstly makes assessment by analyzing Mongolian legal environment of taxation and the numerical indicators between tax and economic growth, secondly he reaches a key conclusion by conducting comprehensive analysis to define whether Mongolian tax environment is favorable or not, using such demonstrations as tax burden, tax sensitivity and flexibility.

In the final part of the research, the income impact of tax on public budget was determined by the use of the budget income related quantitative data, their relationship and difference between income planning and its performance.

The researcher concluded that the unstable tax environment and reasonably volatile tax income for developing country like Mongolia depends on dramatic changes in economy and inappropriate budget planning methods so these factors negatively affect the budget income.

Key words: Tax, Tax to Gross Domestic product ratio, Tax elasticity, Tax buoyancy,

Хураангуй. Энэ судалгааны өгүүлэгт татвар, татварын онол, ОУ-ын чиг хандлагад суурилан Монгол Улсын татварын орчны нөхцөл байдал, татварын ачааллыг үнэлэх асуудлыг үндсэн зорилгоо болгож ажиллав. Үүний тулд i) Монгол Улсын татварын эрх зүйн орчин, татвар эдийн засгийн өсөлтийн тоон үзүүлэлтүүд, тэдгээрийн өөрчлөлтийг ашиглан татварын орчныг үнэлэх ii) Татварын ачаалал, татварын мэдрэмж, татварын уян хатан байдал зэрэг үзүүлэлтийг ашиглан татварын орчинд шинжилгээ хийж дүгнэсэн болно. Судалгааны төгсгөлд төсвийн орлого болон татварын орлогын тоон үзүүлэлтүүд, хоорондын хамаарал, төлөвлөлт гүйцэтгэлийн зөрүү зэргийг ашиглан, татварын төсөвт үзүүлэх нөлөөллийг тодорхойлов. Судалгааны үр дүнд татварын орчин хөгжиж буй улсын хувьд харьцангуй өндөр бөгөөд эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт төлөвлөлтөөс хамаарч татварын орлогын хэлбэлзэл ихтэй байгаа нь төсвийн орлогын байдалд сөрөгөөр нөлөөлж байна гэсэн дүгнэлт хийв.

Түлхүүр үгс: Татвар, татварын ачаалал, татварын мэдрэмж, татварын уян хатан байдал, төсөв

ОРШИЛ

Татварын хувьд онолын олон чиг хандлага байдаг боловч татвар нь улс орны хөгжлийн түвшингээс

шалтгаалж харилцан адилгүй байх боломжтой гэсэн үзэл баримтлал нь сүүлийн жилүүдэд нэлээд өргөн цар

хүрээтэй болж байна. Энэ үүднээс татварын хувь хэмжээ нь хөгжиж буй орнуудын хувьд харьцангуй бага байдаг бол улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин дээшлэхийн зэрэгцээ татварын хувьд хэмжээ нэмэгдэж байдаг нь ОУ-ын чиг хандлагаас ажиглагдаж байна. Үүнээс гадна татварын бодлого хэмээх чухал зүйл байх ба энэ нь улс орны тухайн үеийн эдийн засаг, ойрын ирээдүйн чиг хандлагыг харгалзан үзсэн байхаас гадна тухайн орны хөгжлийн бодлоготой салшгүй холбоотой байх шаардлагатай юм.

Татварын талаар төрийн зардлын эх үүсвэр гэж үзэх онолын хандлага одоо ч гэсэн хүчтэй байгаа хэвээр боловч энэ нь хэт нэг талыг баримталсан зөвхөн татварын санхүүгийн үүргийг голчилж үзсэн эдийн засаг, нийгмийн үүргийг орхигдуулсан чиг хандлага юм.

Иймээс бидний хувьд татварын өөрчлөлт шинэчлэлийг хэрхэн хэрэгжүүлж ирсэн, тэдгээр нь улс орны эдийн засагт хэрхэн нөлөөлж байсан

зэрэг нь чухал асуудал юм. Нөгөө талаас татвар нь төсвийг бүрдүүлэгч гол арга хэрэгсэл тул татвар, татварын бодлого, төлөвлөлт ямар түвшинд байх нь төрийн бодлого түүний хэрэгжилтэд чухал нөлөө үзүүлэх нь тодорхой юм.

Монгол Улс 1992 оноос хойш хэд хэдэн удаа татварын өөрчлөлт шинэчлэлийг хийж ирсэн бөгөөд энэ нь тухайн үеийн эдийн засгийн нөхцөл байдал, цаг үеийн шаардлагаас хамаарч байсан гэдгийг үгүйсгэх. Хамгийн сүүлд 2007 оноос хэрэгжиж эхэлсэн дөрвөн 10-ын систем буюу татварын хувь хэмжээг тэгшитгэн бууруулсан нь өнөөг хүртэл үргэлжилж байна. Энэ өөрчлөлтийг эдийн засагт сайн нөлөө үзүүлэх төдийгүй нийгмийн чиг баримжаатай сайн өөрчлөлт болж чадсан гэж үзэж байсан юм.

Энэ судалгааны ажлаар Монгол Улсын татварын орчныг үнэлэх, төсөвт үзүүлэх нөлөөллийг тодорхойлохыг зорьсон болно.

НЭГ. ТАТВАРЫН ЗОРИЛГО, ХАНДЛАГА

1.1 ТАТВАР, ТАТВАРЫН ЗОРИЛГО

Орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааны эхлэл буюу Адам Смит 1776 онд «Ард түмний баялаг» хэмээх бүтээлдээ татварын эдийн засаг, нийгмийн агуулгыг онолын үүднээс анх тодорхойлон тавьсан байна. Гол нь татварын систем тэгш шударга, бодитой тодорхой, төлөгдөх боломжтой, үр ашигтай байна гэж үзжээ.

Кейнсийн онолын хүрээнд “татвар нь эдийн засгийг зохицуулагч гол хөшүүрэг бөгөөд эдийн засгийн хөгжлийг хангагч хүчин зүйл. Хуримтлал нь орлогын эх үүсвэр болдгоороо эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлдэг тул татвараар дамжуулан эргэлтэд

оруулах нь зүйтэй. Төрийн эдийн засгийн оролцооны гол хэлбэр нь татвар хэмээн үздэг.

Энэ мэтчилэн татварын олон онолын урсгалууд хөгжиж ирсэн бөгөөд татварыг зөвхөн төрийн санхүүгийн эх үүсвэр, зохицуулалтын механизм гэж үзэхээс гадна татвар төлөгчийн эрхийг хамтад нь хангах ёстой гэж үзэх хандлага нэлээд бий болсон байна.

Татварын онолуудад татварыг ялгаатай байдлаар тайлбарласан боловч татварын дарамтыг бууруулах, бизнесийн орчныг сайжруулснаар бизнесийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа түргэн хурдацтай

хөгжиж, эдийн засгийн өсөлт хөгжил хангагдана гэсэн гол үзэл баримтлал нийтлэг байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн нэмэгдэх, тэр нь харьцангуй тогтвортой байгаа үед татварыг нэмэгдүүлэх, хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгах боломж бүрддэг байна.


Татварын бодлого нь улс орны зайлшгүй хэрэгцээт төсвийн орлогыг бүрдүүлэх, татвар төлөгчийн ачааллыг багасгах, зах зээлийн хэвийн үйл ажиллагааг хангах, үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийгдэх орчныг бүрдүүлэх, бизнесийн таатай орчныг бий болгох гэх мэт зорилтыг хангаж ажиллахад чиглэгддэг.

1.2 ТАТВАРЫН ЧИГ ХАНДЛАГА

Татварын ачааллыг үнэлэхдээ татварын харьцаа буюу татварын орлогыг ДНБ-д харьцуулсан харьцааг ашигладаг. Үүнээс гадна татварын уян хатан чанар¹, татварын мэдрэмж² зэрэг үзүүлэлтийг ашигладаг бөгөөд эдгээр үзүүлэлтийн хүрээнд дэлхийн чиг хандлагыг авч үзье.

Татварын харьцаа нь ЭЗХАХБ-ын гишүүн өндөр хөгжилтэй орнуудын хувьд нэлээд өндөр байдаг бөгөөд тэр дундаа хөгжлийн түвшингээр урт хугацаанд тэргүүлж байгаа улсуудад энэ харьцаа харьцангуй өндөр байна.

Зураг 1. ЭЗХАХБ-ын зарим орны татварын ачаалал



Эх сурвалж: (OECD, 2016)


¹ Tax buoyancy-ДНБ олон татварын өөрчлөлтийн хувийг ашиглан тооцдог энэхүү үзүүлэлт нь эдийн засаг, татварын өөрчлөлтийн уялдааг харуулдаг. Онолын хувьд 1 тэй ойролцоо байх нь зүйтэй хэмээн үздэг байна.

² Tax elasticity-Татварын бодлогын өөрчлөлтөөс хамаарах ҮНБ,ДНБ болон татварын орлогын хамаарад суурилж тооцно. Энэ үзүүлэлт 1-ээс өндөр байвал мэдрэмж сайтай буюу зөв бодлого хэмээн үздэг.

2015 оны байдлаар энэ харьцаа 16-45 хувийн ангилалд байгаа бөгөөд Белги, Дани, Швед зэрэг эдийн засаг, нийгмийн хөгжил өндөр орнуудад 40-өөс дээш байгаа бол Чили, Мексик зэрэг оронд 20-оос доош байна. Гэтэл Азийн бүсийн дийлэнх орнууд болон бусад хөгжиж буй орнууд 10-15, 15-20 интервалд багтаж байна.

Татварын ачааллын түвшинг дэлхийн хэмжээнд харвал эдийн засаг хөгжихийн хэрээр татварын ачаалал нэмэгдсээр байгаа ч дэлхийн дундаж нь өндөр хөгжилтэй орнуудын татварын ачааллаас хэд дахин доогуур үзүүлэлттэй байна.

Зураг 2. Дэлхийн татварын ачаалалын түвшин. Татварын орлого/ДНБ



Эх сурвалж: (World bank, 2017)

Дээрх татварын үзүүлэлтийн түвшин нь хөгжиж буй болон доогуур орлоготой орнуудын хувьд бага байдагтай холбоотойгоор дээрх түвшин тайлбарлагдаж байгаа бөгөөд ОУВС-ийн 2017 оны судалгаагаар хөгжингүй орнуудын хувьд 33.8, хөгжиж буй орнуудын хувьд 17.3, бага орлоготой

орнууд 13.4 хувийн дундажтай байсан байна. (IMF, 2017/1)

Харин татварын мэдрэмжийн хувьд татварын орлогын өөрчлөлтийн хувийг ДНБ-ын өөрчлөлтийн хувьд харьцуулж тооцдог бөгөөд хөгжлийн түвшингээр дараах байдалтай байна.

Хүснэгт I-1 Татварын уян хатан байдлын үзүүлэлт

Хөгжлийн түвшин	Урт хугацаанд	Богино хугацаанд
Хөгжингүй орнууд	1.06	1.06
Хөгжиж буй орнууд	1.15	1.21
Бага орлоготой орнууд	1.15	0.96

Эх сурвалж: (IMF, 2017/1)

Үүнээс гадна урт хугацаанд хөгжингүй болон бага орлоготой орнуудын хувьд корпорацийн орлогын татварын хувьд, богино

хугацаанд хөгжиж буй орнуудын хувьд бүтээгдэхүүн үйлчилгээний татварын мэдрэмж өндөр гарсан байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ОРЧИН, ТӨСӨВ

2.1 МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1993 оноос эхлэн мөрдөгдөж ирсэн татварын өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын татварын орчин нь 2007 оны шинэчлэлийн хүрээнд харьцангуй сайжирч тухайн жилдээ энэ талаар гаргасан дэлхийн банкны судалгаагаар 45-рт эрэмбэлэгдсэн нь хамгийн амжилттай үзүүлэлт байв.

Монгол Улс зах зээлийн харил-

цаанд шилжин орсноос хойш аж ахуйн нэгжийн болон хүн амын орлогын албан татварын хуулийг хэрэгжүүлж иржээ. Үүн дээр нэмээд НӨАТ-ын тухай хууль, нийгмийн даатгалын асуудал нь татварын нөлөөлөлд хамаарч ирсэн байна. Энэ төрлийн татвар шимтгэл нь дараах байдлаар зохицуулагдаж өнөөг хүртэл мөрдөгдөж ирсэн байна.

Хүснэгт II-1. Монгол Улсын татварын орчны өөрчлөлт

Татварын төрөл	1993-1997	1997-2001	2001-2004	2004-2007	2007-2017
ХХОАТ	5 шатлалтай	3 шатлалтай		3 шатлалтай	1 шатлалтай
Хувь	0, 2, 15, 27, 40 хувь	10, 20, 40 хувь		10, 20, 30 хувь	10 хувь
ААНэгжийн орлогын албан татвар	4 шатлалтай 15/25/35/40 хувь	2 шатлалтай 15/40 хувь		2 шатлалтай 15/30 хувь	2 шатлалтай 10/25 хувь
НӨАТ хувь	5 хувь	10 хувь	15 хувь	15 хувь	10 хувь
НДШ (Ажил олгогч/ажилтан)	15/7 Хувь	19/10 Хувь	19/10 Хувь	19/10 хувь	10/10 хувь

Эх сурвалж: (Б.Мэндбаяр, 2010)

Монгол Улсын татварын орчны хувьд эдгээр өөрчлөлтийн хүрээнд татварын хэмжээг бууруулах, нэр төрлийг бууруулах, шатлалыг арилгах зэрэг өөрчлөлт хийж байсан байна. Мөн үүний зэрэгцээ татварын хөнгөлөлтийг ихээр хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ нь төсвийн орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлөх хандлагатай байдаг. (ҮАГазар, 2015/04)

2.2 ТАТВАРЫН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын татварын орчны талаар харилцан адилгүй ойлголт мэдээлэл байдаг. Энэ нь татварын дарамтын хувьд их, бага татварын орчин сайн муу гэх байдлаар илэрдэг. Үүнийг макро эдийн засаг, татварын тоо баримтууд болон татварын харьцаа, мэдрэмжийн үзүүлэлтүүдийн хувьд тооцож үзье. Тэгвэл ДНБ ба татварын хоорондын харилцан хамаарал, татварын мэдрэмж, уян хатан байдлын хувьд Монгол Улс нь ямар байгааг авч үзье.

Хүснэгт II-2. ДНБ, татварын орлого / сая төгрөг/

Он	ДНБ /оны үнээр/	Татварын орлого	Орлогын албан татвар	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	Хувь хүний орлогын албан татвар
2006	4,027,558.60	1,128,140.60	476,833.00	222,338.70	76,973.60
2007	4,956,647.20	1,504,309.90	648,514.40	219,817.50	74,984.30
2008	6,555,569.40	1,890,896.60	754,839.90	253,279.90	116,712.70
2009	6,590,637.10	1,620,549.60	520,170.60	205,403.20	128,240.60
2010	9,756,588.40	2,688,236.30	974,970.80	390,854.50	160,944.50
2011	13,173,763.40	636,866.00	833,738.90	545,631.10	232,257.30
2012	6,688,419.60	4,179,321.50	871,401.50	524,325.90	347,019.70
2013	19,174,242.60	5,036,793.30	1,109,204.90	660,159.00	449,045.90
2014	22,227,054.30	5,157,024.50	1,101,030.20	621,237.00	507,864.60
2015	23,150,385.60	5,118,979.40	1,170,831.30	688,496.80	519,979.80
2016	23,935,853.70	4,996,833.90	1,043,368.70	519,958.70	523,410.00
2017	27,167,034.70	6,302,609.80	1,609,896.20	962,683.40	691,683.40

Эх сурвалж: ҮСХороо

Дээрх хүснэгтээс харахад татварын орлого нь онол, ОУ-ын нийтлэг хандлагын дагуу ДНБ-тэй шууд хамааралтай байгаа бөгөөд хамаарлын түвшин 0.89-0.99 хувьтай байна. Харьцангуй хамаарал багатай нь ААН-н орлогын албан татвар бөгөөд хамаарлын түвшин 0.92 байна.

Энэ нь Монгол Улсын татварын бодлого үр ашигтай байдлыг шууд илэрхийлэхгүй бөгөөд татварын орлого өсөлтийн түвшин, татварын мэдрэмж, уян хатан чанарыг тодорхойлсны үндсэн дээр гаргах хэрэгтэй юм.

Хүснэгт II-3. ДНБ, Татварын орлого, өөрчлөлт


Он	ДНБ /оны үнээр/ /сая төгрөг/	ДНБ өөрчлөлт /сая төгрөг/	ДНБ өсөлт % /оны үнээр/	Татварын орлого /сая төгрөг /	Татварын орлогын өөрчлөлт /сая төгрөг /	Татварын орлогын өөрчлөлт %
2006	4,027,558.60	986,152.90	32.42	1,128,140.60	435,934.10	62.98
2007	4,956,647.20	929,088.60	23.07	1,504,309.90	376,169.30	33.34
2008	6,555,569.40	1,598,922.20	32.26	1,890,896.60	386,586.70	25.70
2009	6,590,637.10	35,067.70	0.53	1,620,549.60	(270,347.00)	(14.30)
2010	9,756,588.40	3,165,951.30	48.04	2,688,236.30	1,067,686.70	65.88
2011	13,173,763.40	3,417,175.00	35.02	3,636,866.00	948,629.70	35.29
2012	6,688,419.60	3,514,656.20	26.68	4,179,321.50	542,455.50	14.92
2013	19,174,242.60	2,485,823.00	14.90	5,036,793.30	857,471.80	20.52
2014	22,227,054.30	3,052,811.70	15.92	5,157,024.50	120,231.20	2.39
2015	23,150,385.60	923,331.30	4.15	5,118,979.40	(38,045.10)	(0.74)
2016	23,935,853.70	785,468.10	3.39	4,996,833.90	(122,145.50)	(2.39)
2017	27,167,034.70	3,231,181.00	13.50	6,302,609.80	1,305,775.90	26.13

Эх сурвалж: ҮСХороо

Энэ хүснэгтээс харахад ДНБ болон татвар нь хэдий өндөр эерэг хамааралтай байсан боловч татварын орлогын өөрчлөлт ДНБ-ний өөрчлөлтөөс

маш ялгаатай байгаа нь харагдаж байна. Дээрх ялгааг дүрслэлээр харуулбал дараах байдалтай байна.

Зураг 3. ДНБ, татварын орлогын өөрчлөлт



Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Монгол Улсын хувьд ДНБ, татварын орлого нь хамаарал өндөртэй боловч өсөлтийн түвшний ялгаа өндөр бөгөөд татварын орлогын өөрчлөлт өндөр байна. Зарим онд татварын орлого ДНБ-ээс 2 дахин илүү өссөн байхад,


зарим жилд ДНБ нь татварын орлогоос илүү өссөн байна. 2011 оны хувьд ДНБ, татварын орлогын өөрчлөлт нь тэнцүү байгаа нь эдийн засаг хамгийн өндөр жилтэй давхцаж байна.

ТАТВАРЫН АЧААЛАЛ

ОУ-ын жишгээр татварын нөхцөл байдлыг тодорхойлдог эхний үзүүлэлт болох татвар, ДНБ харьцаа үзүүлэлтийг 2006 оноос хойших байдлаат тооцвол 21-30.4 хувийн

хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд ОУВС-ийн тооцооллоор хамгийн сүүлийн тооцооллоор 33.8 байсан нь тухайн цагт Польш улстай адил Өмнөд Солонгос улсаас давсан үзүүлэлт юм.

Зураг 4. Татвар ба ДНБ-ний харьцаа /хувь/




Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Энэ үзүүлэлт нь дээр дурдсанчлан улс орнуудын хөгжлийн түвшингээр харилцан адилгүй байдаг. Монгол Улсын хувьд харьцуулж болох хөгжиж буй орнуудын хувьд 15-20 орчим хувьд байдаг бөгөөд манай улсын хувьд энэ үзүүлэлт нь харьцангуй өндөр байна гэсэн үг юм. 2006 оноос хойших дундаж хэмжээ 25.64 байгаа нь хөгжлийн түвшин ойролцоо улсуудаас өндөр, дэлхийн дунджаас бараг 1.7 дахин илүү үзүүлэлт юм. Мөн эдийн засгийн

идэвхжил тухайн үзүүлэлтийн хооронд хамаарал их байдал байгаа бөгөөд хямрал нь бууруулах нөлөөтэй байна. Энэ нь татварын бааз суурь, орлогын түвшний эмзэг байдлыг илэрхийлж байна. Ерөнхийдөө татварын ачааллын хувьд хэлбэлзэл өндөр байгаа нь Монгол Улсын татварын орчны нөхцөл байдлыг сөрөг байдлаар үнэлэхэд хүргэж байгаа бөгөөд энэ нь зөвхөн татварын тогтолцооноос гадна бусад олон шалтгаантай байж болох юм.

Зураг 5. ААНОТ, ХХОАТ-ын хэмжээ /сая төгрөг/



Эх сурвалж: ҮСХороо

Татварын бүтцийн хувьд ч бидний хувьд харьцангуй анхаарал татсан байдалтай байгаа бөгөөд ХХОАТ-ын хэмжээ ААНОТ-тай

ойролцоо, зарим жилд өндөр байгаа нь татварын тогтолцооны хандлагаар мөн л харьцангуй өндөр хөгжилтэй орнуудын жишигтэй харьцуулах үзүүлэлт юм.

ТАТВАРЫН МЭДРЭМЖ

Энэхүү үзүүлэлтийг тооцохын тулд ДНБ, татварын орлогын өөрчлөлтийг тодорхойлох шаардлагатай

бөгөөд эдгээр нь ойролцоо байгаа тохиолдолд тохиромжтой үр дүн гарах боломжтой юм.

Зураг 6. ДНБ, Татварын орлогын өөрчлөлтийн хувь




Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

ДНБ, татварын орлогын өөрчлөлтийн хувийг харвал хэт ялгаатай байдал өндөр байна. Харин эдийн засаг хамгийн өндөр өссөн 2011 онд эдгээр үзүүлэлтийн өөрчлөлт бараг ижил түвшинд байсан байна. Үүний улмаас татварын уян хатан байдлын хувьд сүүлийн жилүүдийн байдлаар

тооцож үзвэл мөн л дээрхийн адил үр дүн харагдаж байна. Учир нь, татварын орлого, ДНБ-ны өөрчлөлтөөр тодорхойлогддог энэхүү үзүүлэлтийн хэлбэлзэл өндөр, онолын хүлээлт болон ОУ-ын жишиг үзүүлэлтээс хол байдал ажиглагдаж байна.

Зураг 7. Татварын уян хатан байдлын үзүүлэлт



Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Дээрх үзүүлэлтийн 2009 оныг оролцуулалгүй тооцсон дундаж 1.85 байгаа нь дээрх нөхцөл байдлыг баталж байгаа бөгөөд 2011 онд онолын хүлээлттэй хамгийн ойролцоо, 2012 онд хэт доогуур үзүүлэлттэй байсан байна. 2009 онд 2 үзүүлэлт 2 лаа буурснаас 12.48 гарчээ. Энэ нь татварын орлого ДНБ-ээс 12 дахин ихээр буурсныг харуулна. 2014-2016 онуудад татварын орлого буурч байснаас үзүүлэлт хасах утгатай харагдаж байна. Түүнчлэн татварын өөрчлөлт нь ДНБ-ний өөрчлөлтөөс илүү байгаа байдал нь татварын орчин хэт мэдрэмжтэй байдлыг харуулна.

Татварын бодлогын нөлөөллийн хувьд 2007 онд хийсэн шинэчлэл нь эерэг нөлөө үзүүлсэн байдал нь дээрх нөхцөл байдлын улмаас шууд тодорхойлогдох боломж бага байна.

Учир нь, татварын орчныг өөрчилснөөс хойш татвар, ДНБ-ын өөрчлөлтөөс өндөр байсан жил 2010, 2013, 2017 онуудад тохиосон байна. Үүнээс гадна дэлхийн эдийн засгийн болон дотоодын шалтгаантай хямралд ойрхон өртсөний улмаас тодорхой зүй тогтол ажиглагдахгүй байна. Ерөнхийдөө Монгол Улсын хувьд татварын орчин түүнээс хамаарсан тогтвортой, зөв зүй тогтол бий болоогүй байна.

2.3 ТАТВАР, ТӨСӨВ

Монгол Улсын эдийн засгийн хэмжээ нэмэгдэхийн хэрээр татварын орлого, төсвийн орлого нэмэгдэж эдгээрийн хамаарал болон төлөвлөлт, хэрэгжилтийн байдлыг товчхон авч үзье.

Зураг 8. ДНБ, Төсөв, Татварын үзүүлэлтүүд

Он	ДНБ /оны үнээр/	ДНБ өөрчлөлт	ДНБ өсөлт	Төсвийн орлого	Төсвийн орлогын өөрчлөлт	Татварын орлого	Татварын орлогын өөрчлөлт
2006	4,027,558.60	986,152.90	32.42	1,360,409.80	62.37	1,128,140.60	62.98
2007	4,956,647.20	929,088.60	23.07	1,880,488.90	38.23	1,504,309.90	33.34
2008	6,555,569.40	1,598,922.20	32.26	2,170,370.00	15.42	1,890,896.60	25.70
2009	6,590,637.10	35,067.70	0.53	1,993,995.60	(8.13)	1,620,549.60	(14.30)
2010	9,756,588.40	3,165,951.30	48.04	3,122,464.20	56.59	2,688,236.30	65.88
2011	13,173,763.40	3,417,175.00	35.02	4,400,621.80	40.93	3,636,866.00	35.29
2012	16,688,419.60	3,514,656.20	26.68	4,957,777.20	12.66	4,179,321.50	14.92
2013	19,174,242.60	2,485,823.00	14.90	5,986,925.00	20.76	5,036,793.30	20.52
2014	22,227,054.30	3,052,811.70	15.92	6,316,522.60	5.51	5,157,024.50	2.39
2015	23,150,385.60	923,331.30	4.15	5,983,397.70	(5.27)	5,118,979.40	(0.74)
2016	23,935,853.70	785,468.10	3.39	5,872,075.90	(1.86)	4,996,833.90	(2.39)
2017	27,167,034.70	3,231,181.00	13.50	7,922,488.80	34.92	6,302,609.80	26.13

Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Татварын орлогын хоорондын хамаарал өндөр байгаа боловч

өөрчлөлтийн ялгаа их, ялангуяа төсвийн орлого, татварын ДНБ-ий

өөрчлөлтөөс ялгаатай байдал өндөр байна. Зарим жилд татварын өөрчлөлт төсвийн орлогын өөрчлөлтийн ялгаа өндөр байна. Мөн татварын орлого буурсан тохиолдолд төсвийн орлого өсөх тохиолдол гарч байгаа нь төсвийн

орлогын төлөвлөлт, гүйцэтгэл бодитой бус байгааг харуулж байна.

Үүнээс гадна төсөв, татварын төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү өндөр байгаа бөгөөд энэ төсвийн орлого, алдагдалд ихээхэн нөлөө үзүүлж байна.

Хүснэгт II-4. Төсөв, татварын орлогын өөрчлөлт, төсвийн алдагдал

Он	Төсвийн орлогын зөрүү	Зөрүү %	Татварын орлогын зөрүү	Зөрүү	Төсвийн алдагдал
2006	511,066.40	60.17	405,483,881.51	56.11	123,401.80
2007	584,889.20	45.14	428,050,912.10	39.85	133,178.40
2008	(233,329.20)	(9.71)	(104,691,431.51)	(5.25)	(296,404.40)
2009	(229,820.90)	(10.33)	(207,328,301.49)	(11.34)	(342,634.10)
2010	695,640.50	28.66	604,702,287.24	29.02	41,779.10
2011	922,563.20	27.92	770,895,129.03	26.61	(769,861.80)
2012	(944,491.40)	(16.21)	(2,258,210,062.49)	(34.95)	(1,136,628.60)
2013	(1,148,267.00)	(16.20)	(1,397,699,997.49)	(21.60)	(224,618.60)
2014	(607,280.16)	(8.82)	(1,070,129,580.00)	(17.18)	(867,959.14)
2015	(1,178,907.20)	(16.47)	(781,477,013.26)	(13.24)	(1,156,909.90)
2016	(1,161,822.80)	(16.56)	(588,068,700.00)	(10.62)	(3,667,830.20)
2017	1,947,689.90	32.60	1,396,996,800.00	28.48	1,741,891.00

Эх сурвалж: Судлаачийн тооцоолсноор

Татварын орлого 5-56 хувь хэлбэлзэж, үүнээс шалтгаалж төсвийн орлого 10-60 хувиар төлөвлөсөн хэмжээнээс өөрчлөгдөж байгаа нь төсвийн бодлогын хэрэгжилт алдагдах, төсвийн алдагдлын хэмжээ нэмэгдэх

сөрөг үр дагаврыг бий болгож байна. Энэ нь татварын тогтолцоо, бодлого, хэрэгжилтийн хүрээнд тогтсон зүй тогтол бий болж чадаагүй татварын орлогын бааз суурь, хураалт муу байгаатай холбоотой юм.

ДҮГНЭЛТ

- Монгол Улсын эдийн засаг нэмэгдэхийн хэрээр болон татварын бодлогын нөлөөлөөр татварын орлого нэмэгдэж байгаа нь сайн зүйл юм. Мөн татварын орчны өөрчлөлтүүд нь татварын дарамтыг бууруулах, татвар төлөгчдөд сайнаар нөлөөлөх байдлаар өөрчлөгдөж ирсэн нь цаашид эерэг нөхцөл байдлыг бий болгох магадлалтай юм.
- Гэсэн хэдий ч татварын бодлого, төлөвлөлтийн хүрээнд анхаарах зүйлс олон байна.
- Монгол Улсын татварын орчны хувьд татварын ачаалал харьцангуй өндөр гэсэн дүгнэлт хийхээс аргагүй байна. Татварын харьцаа хөгжиж буй орнуудаас өндөр, зарим жилүүдэд 30 хувьтай ойролцоо

байгаа нь үүний шалтгаан юм. Энэ нь далд эдийн засаг өндөр байгаа, татварын суурийг хангалттай тэлж чадахгүй байгаа энэ үед шударга татвар төлөгч байгууллага, хувь хүнд ирэх татварын дарамтыг нэмэгдүүлэх магадлалтай. Иймээс татварын хамрах хүрээ, суурийг нэмэгдүүлэх асуудалд анхаарах шаардлагатай байна.

- Татварын мэдрэмж, уян хатар чанарын хувьд ямар нэгэн зүй тогтол, зохистой байдал ажиглагдахгүй байна. Мөн дундаж үзүүлэлт өндөр, зарим жилийн үзүүлэлт хэт өндөр байгаа нь татварын бодлогын тодорхой нөлөө бага бөгөөд эдийн засгийн мөчлөг

дагасан байдалтай байна гэж үзэхэд хүргэж байна. Энэ нь татварын тогтолцоо, бодлогоос гадна нийт эдийн засаг улс төрийн тогтворгүй байдал, сүүлийн 10 жилд 2 хямрал тохиосон зэрэгтэй холбоотой байх магадлалтай юм.

- Татварын төлөвлөлтийн хувьд хангалтгүй байна. Төлөвлөсөн орлого, гүйцэтгэлийн зөрүүний дээд хэмжээ хэтрэлт 56 хувь, тасалдал 35 хувь байгаа нь үүний илрэл юм.
- Цаашид татварын хамрах хүрээг нэмэгдүүлэх, татвар тогтолцоог сайжруулах ажлын хүрээнд дээр асуудлуудыг анхааран ажиллах нь зүйтэй юм.

НОМ ЗҮЙ

1. EHTISHAM AHMAD and NICHOLAS STERN. (2010). *TAXATION FOR DEVELOPING COUNTRIES*. London: The London School of Economics.
2. IMF. (2014/6). *Tax Buoyancy in OECD Countries*. IMF.
3. IMF. (2017/1). *How Buoyant is the Tax System?* IMF.
4. Jane H. Leuthold. (1986). *Tax Buoyancy vs Elasticity in a Developing Economy*. Urbana-Champaign: University of Illinois.
5. OECD. (2016). *OECD, stat, report*. OECD.
6. World bank. (2017). *Tax revenue and GDD*. Washington, D.C.: World bank.
7. World bank group, PwC. (2017). *Paying Taxes 2017*. PwC.
8. Б.Мэндбаяр. (2010). *ТАТВАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВӨЛТ БОЛОН БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ АСУУДЛУУД*. Улаанбаатар: Сангийн яам.
9. ОУВС. (2011). *ТАТВАРЫН БОДЛОГО БА УДИРДЛАГА*. Улаанбаатар: ОУВСан.
10. Сангийн яам. (2017). *Монгол Улсын нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт 1991-2017*. Улаанбаатар: Сангийн яам.
11. ҮАГазар. (2015/04). *Гүйцэтгэлийн аудитын тайлан*. Улаанбаатар: ҮАГазар.
12. ҮТЕГ. (2006). *Монгол Улсын ТАТВАРЫН ОРЧИН*. Улаанбаатар: ҮТЕГ.
13. Үүрийнтуяа. (2014). *Татварын орчны шинэчлэлийн асуудал*. Улаанбаатар: Интоор Финанс ТМЗ.
14. ҮХШХороо. (2012). *ТАТВАРЫН БОДЛОГЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОН ШИНЭЧЛЭХ АСУУДЛУУД*. Улаанбаатар: Хүлэг ХХК.

ОРЛОГЫН ТАТВАРЫН ШИНЖИЛГЭЭ

П.Гантөмөр

СЭЗИС-ийн Экономиксийн тэнхимийн профессор, доктор (Ph.D)

Abstract. The proportion of income tax in total budget income is relatively high in Mongolia. For instance, from January 2001 to December 2017, income tax proportion was 83% on average. In other words, this weighs relatively high in Mongolian budget. Thus, this study aims to analyze how this trend of income tax will maintain in the long run.

Markov chain has been used for modelling many practical issues. Many of the studies emphasize that Markov chain is one of the efficient ways to model time series. Some of the time series are modeled by first order discrete Markov chain model, while others are modeled by higher order discrete Markov chain model. This paper analyzes the income tax proportion data by applying Markov chain model.

Key words: Markov chain, time series analysis, mathematical model, optimization of income tax

Хураангуй. Монгол Улсын хувьд төсвийн орлогод орлогын татварын эзлэх хувь харьцангуй өндөр байдаг. Тухайлбал, 2001 оны 1-р сараас 2017 оны 12 сар хүртэлх хугацааг хамруулан дундажаар авч үзвэл төсвийн орлогод орлогын татварын эзлэх жин 83%-тай тэнцүү байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын төсөвт нэлээд өндөр хувийг эзэлдэг гэдгийг харуулж байна. Ийм учир төсвийн орлогын энэ хандлага цаашдаа хэр зэрэг хадгалагдах төлөвтэй байгаад анхаарлаа хандуулан уг сэдвийн хүрээнд шинжилгээг хийж гүйцэтгэв.

Практикийн олон асуудлыг загварчлахад Марковын гинжийг ашигласаар байна. Уг аргачлал нь хугацааны цувааг загварчлахад мөн үр ашигтай арга хэрэгслийн нэг болдог гэдгийг олон судалгааны ажлуудад дурдсан байдаг. Зарим хугацааны цуваа нэгдүгээр эрэмбийн дискрет хугацааны Марковын гинжин загвараар илэрхийлэгдэж байхад бусад цуваа дээд эрэмбийн Марковын гинжин загвараар илэрхийлэгддэг. Энэ судалгааны ажлын хүрээнд орлогын татварын нийт татварын орлогод эзлэх хувиар хугацааны цувааны өгөгдөл үүсгэх замаар Марковын гинжин загварыг ашиглан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Түлхүүр үгс: Марковын гинж, хугацааны цувааны шинжилгээ, математик загварчлал, орлогын татварын оновчлол

ОРШИЛ

Марковын гинж нь дарааллын систем (Ching, 2001 ба Sharma, 1995), үйлдвэрлэлийн систем (Buzacott & Shanthikumar, 1993), бараа, материалын нөөцийн татан авалт (Ching, Fung & Ng ба Nahmias, 1997) гэх мэт практикийн олон асуудлыг загварчлахад чухал арга

хэрэгсэл болдог. Категоричлагдсан өгөгдлийн дарааллын загварчлалд Марковын гинжин загварын хэрэглээг Чинг, Фунг болон Нж, Макдоналд болон Зуккини (Ching, Fung & Ng; Macdonald & Zucchini) нар мөн авч үзсэн байна.

НЭГ. МАРКОВЫН ГИНЖИН ЗАГВАР

1.1 НЭГДҮГЭЭР ЭРЭМБИЙН МАРКОВЫН ГИНЖИН ЗАГВАР

1-р эрэмбийн Марковын гинжин загвараар хугацааны цувааг загварчлахад $E = (1; 2; \dots; k)$ гэсэн k төлөвт байдаг гэж үзье. k төлөвт байдаг нэгдүгээр эрэмбийн Марковын гинж дараах хамаарлыг хангадаг.

$$P(x_{t+1} = i_{t+1} | x_t = i_0, x_1 = i_1, \dots, x_t = i_t) = P(x_{t+1} = i_{t+1} | x_t = i_t)$$

Энд: x_t -t хугацаан дахь хугацааны цувааны төлөв ба $i_j \in E$.

Нөхцөлт магадлал $P(x_{t+1} = i_{t+1} | x_t = i_t)$ -ыг Марковын гинжний нэг алхамт шилжилтийн матриц гэж нэрлэдэг. Эдгээр магадлалуудыг E -ийн i ба j -ийн хувьд $P(x_{t+1} = i | x_t = j)$ гэж бичиж болно. $P(p_{ij})_{k \times k}$ -ийг нэг алхамт шилжилтийн магадлалын матриц гэдэг. P матрицын элементүүд доорх хоёр чанарыг хангадаг гэдгийг тэмдэглэе.

$$0 \leq p_{ij} \leq 1; \forall i, j \in E \text{ ба } \sum_{i=1}^k p_{ij} = 1, \forall i, j \in E.$$

Ажиглалтын хугацааны цувааны хувьд нэгдүгээр эрэмбийн Марковын гинж дараах нөхцөлийг хангана.

$$x_{t+1} = P x_t \tag{1}$$

Чанар 1. P матрицын хувийн утга 1-тэй тэнцүү байж болно. P -ийн бүх хувийн утгууд модулиараа 1-ээс бага эсвэл, нэгтэй тэнцүү байна.

Чанар 2. (Perron-Frobenius-ийн теорем) A матриц нь сөрөг бус бөгөөд m эрэмбийн irreducible буюу өөрчлөгддөггүй 1 квадрат матриц болог. Энэ тохиолдолд дараах нөхцөлүүдийг хангадаг.

i) A матрицын эерэг бодит хувийн утга λ нь түүний спектриал

радиустай тэнцүү байна. Өөрөөр хэлбэл, $\lambda = \max_k |\lambda_k(A)|$. Энд: $\lambda_k(A)$ - A матрицын k -р хувийн утгыг тодорхойлно.

ii) λ нь бодит, эерэг байх тооны z хувийн вектор харгалзана. $Az = \lambda z$.

iii) λ нь A матрицын хувийн утга болно.

Дээрх чанаруудыг харгалзан үзвэл дараах эерэг вектор оршин байдаг гэдгийг харж болно.

$$z = (z_1, z_2, \dots, z_m)^T$$

P нь өөрчлөгддөггүй бол $Pz = z$ байна.

Нормчлогдсон хэлбэрт z векторыг P матрицын тогтвортой төлөвийн магадлалын вектор гэдэг. z_i нь систем тогтвортой i төлөвт байх магадлал юм.

1.2 ДЭЭД ЭРЭМБИЙН МАРКОВЫН ГИНЖИН ЗАГВАР

Дээд эрэмбийн (n -р эрэмбийн) Марковын гинжин загваруудыг Raftery, Ching болон бусад эрдэмтэд категоричлагдсан өгөгдлийн дарааллыг загварчлахад санал болгосон байдаг. m категоритай категоричлагдсан өгөгдлийн дараалал $\{x_t\}$ -ыг векторуудын (магадлалын тархалт) -ын дарааллаар дүрсэлж болно. Үүнд: $\{x_0, x_1, x_2, \dots\}$

Дээрх бичиглэлийг каноник хэлбэрийн дүрслэл гэдэг. Систем $(t+i)$ агшинд $j \in M$ төлөвт байдаг бол төлөвийн магадлалын тархалтын векторыг дараах хэлбэрт бичиж болно.

$$x_{t+i} = \left(0, 0, 0, \dots, \underbrace{j}_{j\text{-р элемент}}, 0, \dots \right)^T$$

¹ Мөр, баганын зэрэг хувиргалтаар дээрээ гурвалжин хэлбэрт шилждэг бол уг матрицыг reducible матриц гэдэг.

Чингийн санал болгосон ёсоор $t=r+1$ агшин дахь төлөвийн магадлалын тархалт $t = r, r-1, r-n+1$ агшин дахь төлөвийн магадлалын тархалтаас хамаардаг гэж таамагладаг. Загвар нь дараах хэлбэрт бичигддэг гэж үздэг.

$$X_{r+i} = \sum_{h=1}^n \lambda_h P_h X_{r-h+1}, \quad r = n-1, n, \dots \quad (2)$$

X_0, X_1, \dots, X_{n-1} -анхны утгууд.

Энд: X_r -г агшин дахь төлөвийн магадлалын тархалт

P_h -h алхамт шилжилтийн магадлал, λ_h -сөрөг бус жингүүд, Нийт параметрийн тоо $n \cdot m^2$ байна.

λ_h жингүүд нь дараах нөхцөлийг хангадаг сөрөг бус бодит тоонууд байна.

$$\sum_{h=1}^n \lambda_h = 1 \quad (3)$$

Шугаман программчлалын асуудлыг шийдвэрлэдэг энгийн болон тоон алгоритмаар загварын P_h, λ_h параметруудийг олно.

1.3 НЭГДҮГЭЭР ЭРЭМБИЙН ОЛОН ХУВЬСАГЧИЙН МАРКОВЫН ГИНЖИН ЗАГВАР

Ching болон бусад эрдэмтэд адил эх үүсвэрээс үүсгэгдсэн олон категоритай дарааллын загварт нэгдүгээр эрэмбийн олон хувьсагчийн Марковын гинжин загварыг хэрэглэсэн байна. s категоритой ба категори бүр m боломжит төлөвтэй гэж таамагладаг. Мөн $t=r+1$ агшин

дахь j-р дарааллын төлөвийн магадлалын тархалт $t=r$ агшин дахь бүх дарааллын төлөвийн магадлалаас хамаардаг гэж таамаглана. Нэгдүгээр эрэмбийн олон хувьсагчийн Марковын гинжин загварт дараах хамаарал оршин байдаг.

$$X_{r+1}^{(j)} = \sum_{k=1}^s \lambda_{kj} P^{(jk)} X_r^{(k)} \quad j = 1, \dots, s; \quad r = 0, 1, \dots \quad (4)$$

$$\text{Энд: } \lambda_{kj} \geq 0, 1 \leq j, k \leq s, \sum_{k=1}^s \lambda_{kj} = 1 \quad j = 1, 2, \dots, s \quad (5)$$

$X_0^{(j)}$ -j-р дарааллын анхны тархалтын магадлал. $(r+1)$ агшин дахь j-р дарааллын $X_{r+1}^{(j)}$

төлөвийн магадлалын тархалт нь $P^{(jk)} X_r^{(k)}$ -ийн жигнэсэн дундажаас хамаардаг.

Энд: $P^{(jk)}$ -k-р дарааллын t хугацаан дахь төлөвөөс t+1 агшин дахь j-р дарааллын төлөв дэх нэг алхамт шилжилтийн магадлалын матриц, $X_r^{(k)}$ -г агшин дахь k-р дарааллын төлөвийн магадлалын тархалт.

Нэгдүгээр эрэмбийн олон хувьсагчийн Марковын гинжин загварын матрицан хэлбэр нь дараах байдлаар бичигддэг.

$$X_{r+i} \equiv \begin{pmatrix} X_{r+i}^{(1)} \\ X_{r+i}^{(2)} \\ \vdots \\ X_{r+i}^{(s)} \end{pmatrix} = \begin{pmatrix} \lambda_{11} P^{(11)} & \lambda_{12} P^{(12)} & \dots & \lambda_{1s} P^{(1s)} \\ \lambda_{21} P^{(21)} & \lambda_{22} P^{(22)} & \dots & \dots \\ \vdots & \vdots & \ddots & \vdots \\ \lambda_{s1} P^{(s1)} & \lambda_{s2} P^{(s2)} & \dots & \lambda_{ss} P^{(ss)} \end{pmatrix} \begin{pmatrix} X_r^{(1)} \\ X_r^{(2)} \\ \vdots \\ X_r^{(s)} \end{pmatrix}$$

Шугаман программчлалд суурилсан тоон алгоритмаар загварын параметрууд болох $\lambda_{ji}; P^{(ij)}$ -ийг олох боломжтой байдаг.

ХОЁР. ШИНЖИЛГЭЭ

2.1 ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ БОЛОН ОРЛОГЫН ТАТВАРЫН НИЙТ ОРЛОГОД ЭЗЛЭХ ХУВЬ ХОЁРЫН ХООРОНДЫН ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ


Эдийн засгийн өсөлтөөс аж ахуйн нэгжийн ашиг, хүн амын цалин болон түүнтэй адилтгах орлогын хэмжээ ихээхэн хамааралтай билээ. Нөгөө талаар ашиг болон цалингаас

орлогын татварын төсөвт төвлөрөх хэмжээ хамаарна. Иймээс аж ахуйн нэгжийн ашгийн өсөлт, мөн цалингийн өсөлт орлогын татварын хэмжээг өсгөнө. Эдийн засгийн өсөлт болон

орлогын татварын нийт орлогод эзлэх хувь хоёрын хооронд сул боловч эерэг

хамаарал байгааг зураг 1-ээс харж болно.

Зураг 7. Орлогын татварын нийт орлогод эзлэх хувь ба эдийн засгийн өсөлтийн хамаарал



Эх сурвалж: Судлаачийн тооцоо

2.2 ОРЛОГЫН ТАТВАРЫН НИЙТ ОРЛОГОД ЭЗЛЭХ ХУВИЙН ОНОВЧТОЙ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ШИНЖИЛГЭЭ

Лафферын муруйн хандлагаар нийт татварын орлогын хэмжээг хамгийн их байлгадаг татварын түвшинг тодорхойлж болно. Энэ үзэл санаанд тулгуурлал нийт татварын орлогын хэмжээг хамгийн их байхаар орлогын татварын нийт төсвийн орлогод эзлэх хувийг тодорхойлж болох уу? гэдэг асуулт тавигдаж болох юм. Энэ асуултад хариулт өгөхийн тулд Ричард Арми (Armeu, et al., 1995)-ийн санал болгосон "Армийн муруй"-г ашиглав. Армийн муруй нь эдийн засаг дахь нийгмийн секторын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь болон бодит ДНБ-ий хоорондын хамаарлыг харуулдаг. Нийгмийн секторын зардлын өсөлт эдийн засгийн өсөлтийг хамгийн их утгад хүргэдэг цэг хүртэл дотоодын нийт бүтээгдэхүүнийг өсгөнө. Эдийн засгийн өсөлт оргил цэгтээ хүрсэн үед нийгмийн зардлын ахиу бүтээмж хувийн секторын зардлын ахиу бүтээмжтэй

тэнцдэг гэдэг санааг Армийн муруй илэрхийлдэг.

Орлогын татварын нийт орлогод эзлэх хувь болон нийт төсвийн орлогын хооронд

"∩" хэлбэрийн хамаарал оршин байдаг гэдэг таамаглал тавьж болно. Өөрөөр хэлбэл,

"∩" хамаарал оршин байхын тулд дараах хэлбэрийн тэгшитгэл хангагдах ёстой.

$$Revenue_t = b_0 + b_1 TAX_t + b_2 TAX_t^2 \quad b_2 < 0$$

Энд: Revenue-нийт төсвийн орлогын хэмжээ, TAX-орлогын татварын нийт төсвийн орлогод эзлэх хувь

Дээрх тэгшитгэлээс орлогын татварын нийт төсөвт эзлэх хувийн хамгийн их түвшинг дараах томъёогоор олж болно.

$$TAX^* = -b_1 / (2 \cdot b_2)$$

Үнэлгээний үр дүнгээс үзвэл b_2 коэффициент сөрөг байх нөхцөлийг хангаж байна. Ийм учраас нийт татварын орлого хамгийн их утгаа авах үеийн орлогын татварын нийт орлогод эзлэх хувийг тодорхойлох боломжтой

юм. Нийт татварын орлого өмнөх үеийн нийт татварын орлого болон орлогын татварын нийт орлогод эзлэх хувийн өмнөх үеэс хамаарч өөрчлөгддөг гэдгийг үнэлгээний үр дүн харуулж байна.

Үнэлгээний үр дүн

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	-24460391	6914857	-3.537367	0.0005
TAX	49797301	16629634	2.994492	0.0031
TAX^2	-34191522	10797790	-3.16653	0.0018
REVENUE(-1)	0.779016	0.046023	16.92658	0.0000
TAX(-1)	8512552	1934738	4.399847	0.0000
R-squared	0.689695	Mean dependent var		1236810
Adjusted R-squared	0.683163	S.D. dependent var		1368715
S.E. of regression	770426.2	Akaike info criterion		29.97258
Sum squared resid	1.13E+14	Schwarz criterion		30.0565
Log likelihood	-2917.327	Hannan-Quinn criter.		30.00656
F-statistic	105.5754	Durbin-Watson stat		1.896832
Prob(F-statistic)	0.0000			

Эх сурвалж: Суллаачийн тооцоо

Орлогын татварын нийт орлогод эзлэх хувийн жингийн оновчтой түвшин 0.728 байна. Өөрөөр хэлбэл, орлогын татварын нийт орлогод эзлэх хувийг 72.8 хувь байхаар хүн ам болоод аж ахуйн ашгаас авч буй татварын хувь, хэмжээг тогтоовол нийт татварын орлогоо хамгийн их байлгах боломжтой байна. Практикт орлогын татварын хувь хэмжээг тогтоох замаар

татварын орлогоо бүрдүүлдэг. Харин бодлого боловсруулагчид аж ахуйн нэгж болон хүн амын орлогоос авах шууд татварын хувь хэмжээгээ дээрх нөхцөлийг хангаж байхаар татварын түвшинг тогтоовол татварын орлогоо хамгийн их байлгаж болох юм гэдгийг энэ үр дүн илэрхийлнэ. Хавсралт 1-ээс үнэлсэн утга, бодит утга, үлдэгдлийн график дүрслэлийг харна уу.

2.3. НЭГДҮГЭЭР ЭРЭМБИЙН МАРКОВЫН ГИНЖИН ЗАГВАРЫН ШИНЖИЛГЭЭ

2017 онд хүн амын орлогын татварыг өөрчилж, 2018 оны эхнээс хэрэгжүүлэх ажлыг эхлэх үед ард түмний хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан төдийгүй татварыг хуучин дүрэм, журмаар мөрдөх шийдвэрийг төрийн зүгээс гаргасан билээ. Хүн амын болоод аж ахуйн нэгжийн олсон орлогоосоо төлж буй нийт татвар нь төсвийн орлогыг бүрдүүлэхэд чухал

эх үүсвэрийн нэг байдаг гэдгийг дээр дурдсан. Шинжилгээг гүйцэтгэхэд онолын хүрээнд товч авч үзсэн нэгдүгээр эрэмбийн Марковын гинжин болон дээд эрэмбийн Марковын гинжин загваруудыг ашиглалаа.

Орлогын татварын төсвийн орлогод эзлэх хувийг 4 төлөвт байдаг гэсэн таамаглалд тулгуурлан судалгааг гүйцэтгэв. Үүнд:

Орлогын татварын нийт татварын орлогод эзлэх хувь	Категориуд
$0 < TAX < 0.75$	1
$0.75 \leq TAX < 0.80$	2
$0.80 \leq TAX < 0.85$	3
$0.80 \leq TAX < 1.00$	4

Эх сурвалж: Судлаачийн ангилал

Энд: TAX-орлогын татварын нийт татварын орлогод эзлэх хувь

Хавсралт 2-оос категориор үүсгэсэн дарааллыг харна уу. Бид судалгаандаа 216 сарын өгөгдөл ашигласан учраас 216 урттай категоричлагдсан өгөгдлийн дараалал дараах хэлбэрт бичигдэж байна. Үүнд:

$$\underbrace{\{2,2,2,1,2,\dots,2,2,2\}}_{216}$$

Дээрхээс үзвэл 2000 оны 1-р сард орлогын татварын нийт орлогод эзлэх хувь 2 түвшинд буюу 75%-80%-ийн интервалд байсан гэдгийг илтгэнэ. Дээрх хэлбэрт бичигдсэн дарааллыг каноник хэлбэрийн дүрслэлээр доорх байдлаар бичих боломжтой.

$$x_0 = (0,1,0,0)^T, x_1 = (0,1,0,0)^T, x_2 = (0,1,0,0)^T, x_3 = (1,0,0,0)^T, x_{216} = (0,1,0,0)^T,$$

Энд: $x_0 = 2, x_1 = 2, x_2 = 2, x_3 = 1, \dots, x_{216} = 2$ Марковын гинжин загварын хувьдшилжилтийн магадлалын матрицыг байгуулахад дараах энгийн процедураар гүйцэтгэдэг. Тухайн үзүүлэлт k төлөвөөс j төлөвт шилжих тооцооллыг хийхэд шилжилтийн давтамжийн матрицыг эхлээд байгуулдаг. Уг шилжилтийн давтамжийн матрицаа ашиглан шилжилтийн магадлалын матрицыг байгуулна.

$$F_1 = \begin{pmatrix} 6 & 1 & 2 & 0 \\ 3 & 38 & 6 & 0 \\ 0 & 8 & 28 & 2 \\ 0 & 1 & 2 & 10 \end{pmatrix} \rightarrow P_1 = \begin{pmatrix} 0.6000 & 0.0175 & 0.0484 & 0.0000 \\ 0.4000 & 0.8070 & 0.1129 & 0.0000 \\ 0.0000 & 0.1579 & 0.6935 & 0.1163 \\ 0.0000 & 0.0175 & 0.1452 & 0.8837 \end{pmatrix}$$

Энд: F1-шилжилтийн давтамжийн матриц, P1-шилжилтийн магадлалын матриц

Нэгдүгээр эрэмбийн Марковын гинжин загварыг категоричлагдсан өгөгдлийн хүрээнд дараах хуулиар бичигддэг гэж (1) томьёонд дурдсан билээ.

$$X_{t+1} = P_1 X_t$$

Орлогын татварын нийт татварын орлогод эзлэх хувь 3-р төлөвөөс бусад төлөвүүдэд шилжих магадлалыг тооцвол дараах үр дүн гарч байна.

$$X_{t+1} = (0.0484; 0.1129; 0.6935; 0.1452)^T$$

Үр дүнгээс үзвэл орлогын татварын нийт орлогод эзлэх хувь 80%-85% байснаа 75 хувь болж өөрчлөгдөх магадлал 4.84%, 75-80 хувийн түвшинд байх магадлал 11.29%, 80-85 хувийн түвшиндээ байх магадлал 69.3%, 85-аас дээш хувьд хүрэх магадлал 14.52%-тай тэнцүү байна. Энэ бүхнээс дүгнэвэл орлогын татварын нийт орлогын татварт эзлэх хувь 80%-85%-ийн түвшинд байх магадлал хамгийн өндөр, өөрөөр хэлбэл, орлогын татварын төсвийн орлогод эзлэх хувь цаашдаа 80%-85%-ийн түвшинд 70 орчим хувиар хадгалагдах хандлагатай ажээ.


ДҮГНЭЛТ

- Орлогын татварын нийт орлогод эзлэх хувь 72.8% байхад нийт төсвийн орлого хамгийн их утгаа авч байна. Иймийн учир аж ахуйн нэгж болон хүн амын орлогоос авч буй татварын хувь, хэмжээг тогтоохдоо уг үр дүнг харгалзаж байх нь чухал ач холбогдолтой юм. Учир нь 216 урттай сарын мэдээллээр авч үзвэл орлогын татварын нийт орлогод эзлэх дундаж 83% байсан нь оновчтой түвшин уг дундажтай ойролцоо гарсан байна.
- Эдийн засгийн өсөлт болон орлогын татварын нийт орлогод эзлэх хувийн хооронд эерэг хамаарал байгаа хэдий ч хүч нь нэлээд сулавтар байв. Иймээс эдийн засгийн өсөлтийг дагасан орлогын татварын төсөвт цугларах хэмжээг нэмэгдүүлэх боломж, арга замуудыг бий болгох талаар цаашдаа анхаарах шаардлагатай гэдгийг илтгэнэ.
- Нэгдүгээр эрэмбийн Марковын гинжин загвараар авч үзвэл татварын орлогын нийт орлогод эзлэх хувь 80-85 хувийн түвшинд байх магадлал 70 орчим хувьтай тэнцүү байна.

НОМ ЗҮЙ

1. Wai-Ka Ching, Michael K. Ng, Eric S.Fung, Higher-order multivariate Markov chain and their applications, 2007
2. Umay Uzunoglu Kocer, Forecasting intermittent demand by Markov chain model, 2012.
3. A. Raftery, A model for higher order Markov chains, Journal of Royal Statistical Society, Series B, vol.47, pp.528-539, 1985.
4. R. Sasikumar, A. Sheik Abdullah, An application of multivariate Markov chain for fuel price changes in India, Global and Stochastic Analysis, vol.4 N1, January (2017), 49-61.
5. Web: 1212.mn
6. <http://www.springer.com/978-0-387-29335-6>, Markov Chains: Models, Algorithms and Applications, Wai-Ka Ching, Michael K.Ng, 2006, XIV, 208 p, 18 illus., Hardcover.

Хавсралт 1. Орлогын татварын нийт орлогод эзлэх хувийн оновчтой түвшинг тодорхойлсон үнэлгээний үр дүн



Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Хавсралт 2. Орлогын татварын нийт орлогод эзлэх хувиар үүсгэсэн өгөгдлийн дараалал

2	2	2	1	2	2	2	2	2	2	2	3	1	3	2	3
3	1	1	2	1	2	2	2	2	2	2	3	2	2	2	2
2	2	2	2	4	3	3	3	2	2	2	2	2	2	2	2
3	3	3	2	3	3	3	3	3	3	3	3	3	3	3	3
3	3	3	3	3	3	3	3	3	3	4	4	4	3	2	3
3	3	3	3	3	3	3	1	1	1	1	2	2	2	3	3
3	3	3	3	2	3	3	4	4	4	4	4	4	4	4	4
4	5	5	3	3	2	2	2	3	3	3	3	3	3	3	4
4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	5	4	4	4
4	4	4	4	4	4	3	3	5	4	4	4	4	4	4	4
4	4	4	3	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4
4	4	4	4	4	4	3	4	3	3	4	4	3	5	4	4
4	4	4	4	4	4	4	4	4	5	4	4	4	4	4	4
4	4	4	4	4	2	2	3								

Эх сурвалж: Судлаачийн ангилсан категори

МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРИМ АСУУДАЛ

Ж.Ариунболд

СЭЗИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

Abstract. The objective of this research is to examine CTCS effectiveness among Mongolian entities. Saving money, saving time, legal compliance and capability improvement factors were developed to test effectiveness of CTCS. A total of 125 respondents who are working at finance and management related positions participated in the survey as sample for the research. The data was collected via self-completion online delivery questionnaire and analyzed through descriptive analysis, measurement and structural model assessment. The result of the research suggests that the usage level of CTCS in Mongolia is 33.6% and perceived effectiveness of CTCS was measured at 3.36 to 3.49 point out of 5 point. Further, the research found that saving money, saving time, legal compliance and capability improvement factors do not have significant relationship with CTCS effectiveness.

Key words: Tax consulting service, Qualified Tax Accountant, Effect of tax services, Factors of tax service, Authorized Tax Accountant

Хураангуй. Бидний хийсэн энэхүү судалгааны ажил бусад судлаачдад бодитой мэдээлэл өгнө гэдэгт итгэлтэй байна. Бид уг судалгааг тоон болон чанарын үзүүлэлтийг ашиглан хийв. Энэхүү судалгааны үндсэн асуудал нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ нь олон нийт буюу аж ахуй нэгжүүд хэрхэн ашиглаж байгаа, цаашдаа бид юунд хаана анхаарах талаар хийсэн судалгаа юм.

Түлхүүр үгс: Татварын зөвлөх үйлчилгээ, татварын мэргэшсэн зөвлөх, татварын үйлчилгээний үр нөлөө, татварын үйлчилгээнд нөлөөлж буй хүчин зүйлс, татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч

СУДАЛГААНЫ ЗОРИЛТУУД

1. ТМЗ үйлчилгээний хэрэгцээг тогтоох
2. ТМЗ үйлчилгээний нөлөөллийг тогтоох
3. ТМЗ үйлчилгээний үр ашигт нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох

СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ:

Академик

- ТМЗ үйлчилгээний үр нөлөөнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах, цаашдын судалгааны суурь болох

Мэргэжлийн байгууллагууд

- Мэргэжлийн байгууллагуудад бодлого боловсруулах, шийдвэр гаргахад нь туслах

ТМЗ үйлчилгээ үзүүлэгч нар

- ТМЗ үйлчилгээ үзүүлэгч нар үйлчилгээнийхээ үр нөлөөг хэмжихэд туслах

ТМЗҮ-НИЙ ҮҮСЭЛ:

- 2012 онд Татварын Мэргэшсэн Зөвлөх Үйлчилгээний тухай хууль батлагдаж ТМЗҮ-ний эрх зүйн орчин баталгаажсан байна.

- Хуулиар шаардсаны дагуу ТМЗҮ-г зөвхөн тусгай зөвшөөрөл авсан компани эсвэл нөхөрлөл хүргэх боломжтой.

2017 оны байдлаар нийт 1300 ТИНБ, 50 ТМЗҮ үзүүлэгч фирм байна.

СУДЛАГДСАН БАЙДЛЫН СУДАЛГАА

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээтэй холбоотой болон тус үйлчилгээний үр нөлөөний талаар хийсэн судалгааны ажлууд, судлаачид, гол үр дүнгийн талаар авч үзлээ. Үүнд: Нэг. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээтэй холбоотой судалгаа

1	Сэдэв	Татварын үйл ажиллагаан дахь ТМЗҮ-ний оролцоо
	Судлаач	Х.Тунгалагмаа, Н.Алтанзул, Э.Намжилмаа
	Гол үр дүн	ТМЗҮ нь татвар төлөгч нартаа татвараа зөв ногдуулах, тайлагнах болон төлөх явцад нь туслалцаа үзүүлэх байдлаар илэрч байна. Мөн татвар төлөгчдийг эрсдэлээс хамгаалах, хууль эрх зүйн орчныг сайжруулахад санал дүгнэлт гаргах, хуулийг ойлогмжтой хэлбэрээр тайлбарлах үйл ажиллагаа нь татварын үйл ажиллагаанд оруулж буй нь ТМЗҮ-ний оролцоо юм. Энэ нь нөгөө талаас татвар төлөгч, татварын байгууллагын хооронд зуучлагчаар ажиллан, татварын байгууллагын зарим чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг үйлчилгээ юм. Судлаачдын үзсэнээр Монголын татварын албанаас ТМЗҮ үзүүлэгч нартаа харилцан уялдаат байдал сул байгаа бөгөөд үүнийг сайжруулах шаардлагатай ингэснээрээ нийгэмд эерэг сэтгэл зүйг бий болгон гэж үзсэн байна.
2	Сэдэв	Монголын татварын зөвлөх үйлчилгээний өнөөгийн байдал болон тулгамдсан асуудал
	Судлаач	Б.Авирмэд
	Гол үр дүн	Монголын татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд судалгаа хийж өнөөгийн байдал болон тулгамдсан асуудлыг дүгнэсэн байна. ТМЗҮК-ийн хувьд сургалт болон тусгай эрхийг авахад маш их анхаардуулж байгаа бөгөөд зөвлөхийн үр чадварыг нэмэгдүүлэхийн тулд тодорхой нэг чиглэлээр мэргэшүүлэн сургах шаардлагатай байна. Өндөр мэдлэг, үр чадвар бүхий зөвлөх авч ажиллуулах нь татварын мэргэшсэн зөвлөгөө өгөх үйл ажиллагааны чанар, үр дүнг дээшлүүлэхэд нэг чухал алхам болно. Мөн чанарын хяналтыг гэрээт ажлын түвшин, байгууллагын түвшин, үндэсний түвшинд үнэлж чадвал татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмэр болох юм. Татварын мэргэшсэн зөвлөхийн зохистой байдлын талаар дүрэм боловсруулан мөрдөх, чанарын хяналтын тогтоолцоог бэхжүүлэх нь гол тулгамдаж буй асуудал болж байна гэж дүгнэсэн байна.

Хоёр. Үйлчилгээний үр нөлөөний талаарх судалгаа

1	Сэдэв	Үр нөлөөний онол: Факультет хөгжүүлэх кэйс
	Судлаач	Smith. R.A ба Schwartz. F.S
	Гол үр дүн	Зөвлөх үйлчилгээний үр нөлөөний 3 гол хүчин зүйлийг дэвшүүлжээ. Эдгээр нь (1) Зөвлөх нь тулгараад буй асуудлыг маш сайн, тодорхой ойлгосон байх; (2) Зөвлөх ба үйлчлүүлэгчийн хоорондох харилцаа чөлөөтэй байх ба харилцан ойлголцох; (3) Үйлчлүүлэгч нь өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх хүсэлтэй байх ба зөвлөмжийг хэрэгжүүлсний үр дүнг хянах сонирхолтой байх (Smith, 1985).
2	Сэдэв	Татварын тайлан бэлтгэх үйлчилгээг сонгоход нөлөөлөх гол хүчин зүйлс: Туршилтын судалгаа
	Судлаач	Fleischman. G.M ба Stephenson. T
	Гол үр дүн	Татварын тайлан бэлтгэх үйлчилгээг сонгоход нөлөөлөх 4 гол хүчин зүйлсийг дэвшүүлж, судалгаа хийжээ. Судалгааны үр дүн нь (1) Мөнгө хэмнэх; (2) Цаг хэмнэх; (3) Хуульд нийцэх; (4) Татварын албанаас хамгаалуулах гэсэн 4 хүчин зүйл нь бүгд татварын үйлчилгээ авахад нөлөөлдөг хүчин зүйлс болох нь тогтоогдсон байна. (Gary M. Fleischman, 2012)
3	Сэдэв	Татварын зөвлөхийн үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын хандлага
	Судлаач	Г.Алтанзаяа
	Гол үр дүн	Хэдийгээр Монгол Улсад нягтлан бодох бүртгэлийн систем бий болж төлөвшсөн байгаа боловч нягтлан бодох бүртгэл нь төдийлөн үр нөлөөтэй бус бөгөөд хяналт дутмаг байна. Тиймээс аудит болон татварын зөвлөх үйлчилгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээнүүдийг тусад нь үзүүлж, тус бүрийнх нь үр нөлөөг сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна. (Altanzaya.G, 2014)

ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Тус судалгааны ажил нь Gary M. Fleischman (2012)-ын онолын загварт суурилсан болно.

Хүчин зүйлс	Тодорхойлолт	Судлаач
Мөнгө хэмнэх	Тухайн судалгаанд оролцогч нь ТМЗҮ-г ашигласнаар өөрийнх нь байгууллага мөнгө хэмнэсэн талаарх тунгаалт.	(Gary M. Fleischman, 2012)
Цаг хэмнэх	Тухайн судалгаанд оролцогч нь ТМЗҮ-г ашигласнаар өөрийнх нь байгууллага цаг хэмнэсэн талаарх тунгаалт.	(Gary M. Fleischman, 2012)

Хууль тогтоомжийн нийцэл	Тухайн судалгаанд оролцогч нь ТМЗҮ-г ашигласнаар өөрийнх нь байгууллага хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн талаарх тунгаалт.	(Gary M. Fleischman, 2012)
Чадавхи дээшлүүлэх	Тухайн судалгаанд оролцогч нь ТМЗҮ-г ашигласнаар өөрийнх нь татварын талаарх мэдлэг, ур чадвар, хандлага зэрэгээр өөрчлөгдсөн талаарх тунгаалт.	Судлаачдын дэвшүүлсэн хүчин зүйл

Судалгааны арга зүй

Зүйлс	Тодорхойлолтууд
Судалгааны дизайн	Тайлбарлах судалгаа / Тоон хандлага
Эх олонлог	Үйл ажиллагаа явуулж буй 72,182 ААНБ (Delgetmaa.M, 2017)
Түүвэр	127 НББ, санхүү, эдийн засаг, удирдах ажилтнууд /0.2%/; энгийн түүврийн арга;
Шинжилгээний нэгж	Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй байгууллагад НББ, санхүү, эдийн засаг, удирдах албан тушаалд ажиллаж буй ажилтнууд
Өгөгдөл цуглуулалт	Өөрөө бөглөх асуулга; Google хэлбэр, социал медиа талбараар авна
Хэмжилтийн хэрэгсэл	5 оноот Лайкерт хэмжүүр Likert Scale IV: (1) SM – 2 ; (2) ST – 2 ; (3) LC – 3 ; (4) CI – 3 ; DV: CTCS Үр дүн-2 /Нийт 12/
Найдвартай ба Бодит байдал	Хэжилтийн загвар үнэлгээ – Найдвартай байдлын нийлэлт, Ялгамжтай найдвартай байдал;
Өгөгдлийн шинжилгээ	SPSS 20.0 – Тодорхойлох шинжилгээ; Smart PLS – Хүчин зүйлийн ба регрессийн шинжилгээ Бүтцийн загварын үнэлгээ – Коллиниар үнэлгээ, Path coefficient, Детерминацийн коэффициент, медиаши нөлөөний үнэлгээ, таамаглалын үнэлгээ

ҮР ДҮН

1. Тодорхойлох шинжилгээ

ТМЗҮ-ний хэрэгцээг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> • 33.6% ТМЗҮ авч байсан • 66.4% ТМЗҮ авч байгаагүй
ТМЗҮ-ний үр нөлөө	<ul style="list-style-type: none"> • ТМЗҮ нь зорилгодоо хүрсэн эсэх: 43.6% нь дундаж, 25.5% нь сайн, 20% нь маш сайн гэж үнэлсэн байна. • ТМЗҮ нь үр нөлөөтэй байсан эсэх: 40% нь дундаж, 29.1% нь сайн, 14.5% нь маш сайн гэж үнэлсэн байна. • Тиймээс, 5-point Likert scale-ээр хэмжиж үзэхэд ТМЗ-ний үр нөлөө нь 3.425 буюу "дундаж"-аас "сайн" гэсэн үзүүлэлтийн хооронд байна.

Хүйс	<ul style="list-style-type: none"> • 82% эмэгтэй
Ажлын туршлага	<ul style="list-style-type: none"> • 31.2% 5 – 10 жилийн ажлын туршлагатай • 28% 10 – 15 жилийн ажлын туршлагатай • 40.8% Бусад насны бүлэгт хамаарч байна.
Мэргэжил, албан тушаал	<ul style="list-style-type: none"> • Мэргэжил: • 80.3% Нягтлан бодогч мэргэжилтэй • Албан тушаал: • 62.6% Нягтлан бодогчоор ажиллаж байна. • 12.8% Удирдах албан тушаалд ажиллаж байна.
Ажиллаж буй салбар	<ul style="list-style-type: none"> • 25.6% Худалдааны салбар • 12.8% Уул уурхайн салбар • 11.2% Банк, даатгал болон санхүүгийн бусад салбаруудад ажилладаг байна.
Өмчлөлийн хэлбэр	<ul style="list-style-type: none"> • 84% Хувийн өмчлөлтэй
НББ-ийн үзэл баримтлал	<ul style="list-style-type: none"> • 74.2% НББОУС • 22.5% УСНББОУС
Татварын зөвлөх үйлчилгээ авах давтамж	<ul style="list-style-type: none"> • ТИНБ-оос - 5-аас 2.04 буюу давтамж нь "Жилдээ нэгээс цөөн удаа" байгаа юм. • Татварын алба болон байцаагчаас - 5-аас 2.34 • Аудиторуудаас - 5-аас 2.39 • Бусад нягтлан бодогч нараас - 5-аас 2.27 байна.
ТМЗҮ-ний үр нөлөөг сайжруулахад анхаарах зүйлс	<ul style="list-style-type: none"> • ТМЗҮ-ний үр нөлөөг сайжруулахад анхаарах зүйлс: • 61.9% нь практик мэдлэгийг сайжруулах; • 38.1% нь татварын онолын болон хуулийн мэдлэгийг сайжруулах; • 26.2% нь үүрэг хариуцлагыг сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.
ТМЗҮ-ний талаарх мэдээлэл хүлээн авч буй сувгууд	<ul style="list-style-type: none"> • ТМЗҮ-ний талаарх мэдээлэл хүлээн авч буй сувгууд: • 46.7% нь Мэргэжлийн байгууллагуудаас; • 35.2% нь вэбсайтаас; • 21.3% нь найз нөхдөөсөө; • 18.9% нь сошиал медиагаас мэдээлэл авдаг.

2. Хэмжилтийн загварын үнэлгээ

Найдвартай байдлын нийлэлт

Indicator loading (Hair, Hult, Rinle, & Sarstedt, 2014)

Дотоод нийцэмжийн бодит байдал

Нуйлмэл нийцэмжтэй (Hair, Hult, Rinle, & Sarstedt, 2014)

Ялгамжтай найдвартай байдал

LC 2 индикатаор үзүүлэлт тохироогүй Cross-loading (Hair, Hult, Rinle, & Sarstedt, 2014)

Форнел-Ларкер шалгуур Fornell-Larcker criterion (Hair, Hult, Rinle, & Sarstedt, 2014)

3. Судалгааны загварын дагуу хийсэн үнэлгээ

Таамаглалууд	Үр дүн	Дүгнэлт
H1: Мөнгө хэмнэх хүчин зүйл нь ТМЗҮ-ний үр нөлөөнд эерэг нөлөөтэй.	No: ($\beta = 0.022$; NS)	Дэмжигдээгүй
H2: Цаг хэмнэх хүчин зүйл нь ТМЗҮ-ний үр нөлөөнд эерэг нөлөөтэй.	No: ($\beta = 0.236$; NS)	Дэмжигдээгүй
H3: Хууль тогтоомжид нийцэх хүчин зүйл нь ТМЗҮ-ний үр нөлөөнд эерэг нөлөөтэй.	No: ($\beta = 0.163$; NS)	Дэмжигдээгүй
H4: Чадавхи сайжруулах хүчин зүйл нь ТМЗҮ-ний үр нөлөөнд эерэг нөлөөтэй.	No: ($\beta = 0.165$; NS)	Дэмжигдээгүй

ДҮГНЭЛТ

- Дөрвөн хүчин зүйл нь хамтдаа зөвхөн 24.9% - ийн өөрчлөлтийг тайлбарлаж байна.
- ТМЗҮ нь зах зээл дээр харьцангуй шинэ үйлчилгээ учраас судалгаанд оролцогчдын уг үйлчилгээний талаарх ойлголт, мэдлэг дутмаг байж болзошгүй. (Altanzaya.G, 2014).
- Судалгаанд оролцогчдын тоо бага
- Субъектив хэмжилт ихтэй байна Монгол Улсад

ЗӨВЛӨМЖ

- 1: ТМЗҮ үзүүлдэг аж ахуй нэгжүүдийн удирдлагаг:
- ТМЗҮ ашиглаж буй байгууллагын тоо бага байгаа учир зах зээлээ өргөжүүлэн боломж байна.
 - ТМЗҮ үр нөлөө нь "дундаж"-аас "сайн" түвшинд байгаа учраас үйлчилгээний үр нөлөөг сайжруулахад анхаарах шаардлагатай.
 - Үйлчилгээний үр нөлөөг сайжруулахын тулдажилтнуудынхаа практик мэдлэгийг сайжруулах шаардлагатай.
- 2: Цаашид энэ сэдвээр судалгаа хийх суглаачгаг:
- ТМЗҮ-ний үр нөлөөг хэмжих бусад нэмэлт хүчин зүйлсийг тусган судалгааны моделийг өргөжүүлэх.
 - Цаашид энэ чиглэлийн судалгаа хийхдээ түүврийн тоог өсгөх.

НОМ ЗҮЙ

1. A Prime on Partial Least Squares Structural Equation Modelin (PLS-SEM)2014USAS Sage Publications Inc
2. A Theory of Effectiveness: Faculty Development Case Studies1985To Improve the Academy91
3. Altanzaya.G 2014 Current developments and future direction of accounting and CTCS in Mongolia
4. Avirmed.Bn/aCurrent situations of CTCS in Mongolia and issues faced in the industry
5. Basic Statistics for Business & Economics2011New YorkMcGraw-Hill Irwin

МОНГОЛ УЛСЫН ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Ч. Өнөржаргал

СЭЗИС-ийн НББ-ийн тэнхимийн ахлах багш /ММНБ, ТМЗ, МВА/

Б. Бат-Амгалан

СЭЗИС-ийн НББ-ийн тэнхимийн багш /ММНБ, ТМЗ, МВА/

Abstract. *The third truth' to pay tax' comes from two universal truths of human life that are to be born and to die. A person earns income from their employment, running business, capital, capital sale, using their capital, etc. In recent years it has been a common duty of every citizen of every country to pay appropriate amount of tax imposed on their received income.*

Similar to others, a primary duty of all citizens in our country is to pay the imposed tax in accordance with the related law.

According to the related study sources, the role of individual income tax in the global states has increased and not only the person individually files his income and tax but also he or she can file the earned income and the imposed tax with his or her family members.

Other countries have been implementing the best practical experiences of self-defined tax rather than tax withholding method that increases the public knowledge of taxation, instills an awareness of paying tax, upgrading citizen's and family registrations.

Although certain changes in tax collecting concept have been made based on self-defined tax method for citizen since the implementation of Mongolian taxation reform in 2007, this has not brought sufficient improvement at all.

It is obvious that how fair and how efficient tax is defined by the way of obeying the related law. Yet, this indicator shows the current proportion of individual tax income in total tax income of Mongolia is not sufficient enough.

Under the framework of the second taxation reform, a new amendment to the Law on individual income tax is being made.

In relation to this, our research addresses some issues to consider own country's feature as well as international experience based on newly implementing law project.

Key words: *Personal income, personal income tax, taxation principles, tax rate, tax credit, tax exemption, implementation of tax, tax reform*

Хураангуй. *Хүн хорвоод төрөх нь үнэн үхэх нь үнэн гэсэн 2 үнэний хооронд "татвар төлөх нь үнэн" гэсэн үг бий болжээ.*

Аливаа хүн ажил хөдөлмөр эрхлэх, бизнес эрхлэх, хөрөнгө эзэмших, байгаа хөрөнгөө худалдах, байгаа хөрөнгөө ашиглаж мөнгө бий болгох зэргээр төрөл бүрийн орлого олж амьдардаг. Ямар ч төрлийн орлого олсон түүнээсээ тодорхой хэмжээний татвар төлөх нь аль ч улсын иргэдэд бий болсон нийтлэг үүрэг болоод байна.

Манай улсын хувьд ч ялгаагүй хуулиар ногдуулсан татварыг төлөх нь иргэн хүний үндсэн үүрэг юм.

Дэлхийн улс орнуудын татварт хувь хүний орлогын албан татварын эзлэх байр суурь нэмэгдэж байгаа бөгөөд хувь хүн дангаараа биш гэр бүлээрээ орлого, татвараа тодорхойлж төлөх хэлбэрт шилжих байдал нэмэгдэж байгааг эх сурвалжуудаас харж болно.

ХХОАТ-ын хэрэгжилтийг суутгалын аргаар хураахаас татвар төлөгч өөрөө тодорхойлон төлөх аргад суурилж зохион байгуулах нь иргэдийн татварын боловсрол дээшлэх, татвар төлөх ухамсар төлөвших, иргэн гэр бүлийн бүртгэл сайжрахад түлхэц болох зэрэг олон давуу талуудтай болохыг бусад улс орнууд олж харж авч хэрэгжүүлж иржээ. Манай Улс 2007 оноос хэрэгжүүлсэн татварын шинэчлэлийн хүрээнд иргэдийг татвараа өөрөө тодорхойлох аргад суурилж татварыг хураах үзэл баримтлал дээр суурилж өөрчлөлтийг хийсэн боловч хэрэгжилт төдийлөн хангалттай биш гэж үзэж болно.

Татвар хэр шударга, үр ашигтай вэ гэдгийг хуулийн хэрэгжилтийн түвшингээр тодорхойлох нь дамжиггүй. Гэвч Монгол Улсын татварын нийт орлогод ХХОАТ-ын эзлэх хувь, татвар төлөгчдийн тоо зэргээс харвал энэ үзүүлэлтийг хангалтгүй гэж хэлж болно.

Татварын 2 дахь шинэчлэлийн асуудлын хүрээнд хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэх ажил хийж байна.

Үүнтэй холбоотойгоор шинэчлэн найруулж хэлэлцүүлж байгаа хуулийн төслийг судалж бусад орны туршлага, өөрийн орны онцлогийг харгалзсан шинэчлэл хийхэд анхаарах зарим асуудлыг хөндлөө.

Түлхүүр үгс: Хувь хүний орлого, хувь хүний орлогын татвар, татварын зарчим, татварын хувь хэмжээ, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын хэрэгжилт, татварын шинэчлэл

ТОВЧИЛСОН ҮГ

ХХОАТ – Хувь хүний орлогын албан татвар	ОУ – Олон улсын
ААНОАТ – Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	НД – Нийгмийн даатгал
МАА – Мал аж ахуй	НДШ – Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ – Нэмэгдсэн өртгийн албан татвар	ЦХХО – Цалин хөдөлмөрийн хөлсний орлого
ТНО – Татвар ногдуулах орлого	ЦХХ – Цалин хөдөлмөрийн хөлс
	МУ – Монгол Улс
	ТУ – Тухайн улс

ОРШИЛ

Хүн өөрийн орлогод хуулийн дагуу татвараа төлж, үүргээ биелүүлэхэд энгийн ойлгомжтой, тэгш шударга, төлөх боломжтой, үр ашигтай байх зарчмуудыг хангасан татварын зохицуулалт зайлшгүй хэрэгтэй болно.

Мөн хүний амьдралын зайлшгүй зардлыг татвар ногдох орлогоос хасаж тооцдог, хүмүүсийн амьдралын байдлаас хамаарсан татварын хувь хэрэглэдэг, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлого нь хүн амын нийгмийн асуудлыг зохицуулахаас гадна татвараа үнэнч шударгаар өөрөө тодорхойлон төлөх байдлыг урамшуулан дэмжих зорилготой байх зэрэг иргэнээ бодсон төрөл бүрийн үр дүнтэй зохицуулалт хийхийн зэрэгцээ ирээдүйн татвар төлөгчдийг тэдний эцэг эх, гэр бүлийн тусламжтайгаар татвар төлөгч болгон төлөвшүүлж бэлтгэх зэрэг бусад улс онуудад хэдийнээ хэвшсэн сайн туршлагауудыг авч хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

ХХОАТ-ЫН ОНОЛ, АРГАЗҮЙ

Хувийн буюу хүний орлогоос татвар ногдуулахад А.Смитийн үндэслэсэн:

1. Тэгш шударга байх
2. Энгийн ойлгомжтой байх
3. Төлөх боломжтой байх
4. Үр ашигтай байх гэсэн зарчмууд хангагдаж байх учиртай.

Дээрх зарчмуудыг хангасан татварын системийг бий болгохын тулд татварын хуулиудыг эдгээрт нийцүүлэх шаардлага тавигдах болно.

Тэгш шударга байна гэдэг нь ижил орлого олж байгаа хүмүүс ижил хэмжээний татвар төлөх өөрөөр хэлбэл

Манай улсын хувьд 2007 оноос хэрэгжсэн хувь ХХОАТ-ын хуулиар хүмүүс орлогын хэмжээ хамаарахгүйгээр 10%-иар татвар төлөх болсон нь бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй бага хувь хэмжээтэй татвартай болсон давуу талтай болсон хэдий ч үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн хувьд ААНОАТ-тай харьцуулбал тэгш шударга бус байдлыг үүсгэх орлогын хэт ялгаатай байдлыг дэмжсэн зохицуулалт болсон гэж үзэж болно. Мөн хөнгөлөлт, чөлөөлөлтийн зарим зохицуулалт нь иргэдийг татвараа тайлагнаж төлж сурах дадал, хэвшилд сургахад биш харин ч татвар буцаан авахын тулд л татварын албанд ханддаг бусад үед үүргээ мартдаг зуршилд сургасан, иргэд түрээсийн болон бизнес эрхэлсний орлогоосоо татвар төлөхөөс зайлсхийдэг зэрэг сөрөг зуршилтай болж төлөвшихөд нөлөөлсөөр байна.

амьдралын түвшин төлбөрийн чадвар ойролцоо буюу ижил хүмүүс татварын харилцаанд адил тэгш оролцож ижилхэн үүрэг хүлээх хэрэг гэж ойлгож болно.

Энгийн ойлгомжтой гэдэг нь татвар төлөгч ямар орлогоосоо, хэдийд ямар хэмжээний татварыг хэрхэн төлөх нь ойлгомжтой буюу төлөх тайлагнах процесс дарамтгүй төвөг чирэгдэл багатай байх ёстой гэсэн үг.

Төлөх боломжтой гэдэг нь татвар төлөгч өөрийн олсон орлогоосоо татвар төлөхөд цаашид түүний ажил амьдрал хэвийн үргэлжлэх, боломжид нь тулгуурласан бөгөөд цаг хугацааны хувьд төлөхөд тохиромжтой үед

татварын өрийг нэхдэг байх гэсэн ойлголтоор илэрнэ.

Үр ашигтай байх гэдэг нь татвар төлөгч ба татварын албаны аль алиных нь хувьд ярих ойлголт бөгөөд татварын албаны хувьд татварын орлого ба татвар хураах зардал хоорондын харьцаагаар тодорхойлж үнэлдэг үзүүлэлт юм. Харин татвар төлөгчийн хувьд энэ нь татвар төлөх зардал бага байх татвараа төлөхөд түүний эдийн засаг санхүүгийн чадавхад нөлөөлж буй байдал нийгмийн бараа үйлчилгээний чанар хүртгээмж, засгийн газрын үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байх байдал зэргээр хэмжигдэж болох юм.

Хувь хүний орлого гэдэгт юуг хамааруулж авч үзэх вэ, татварын суурийг хэрхэн тодорхойлох вэ, хувь хэмжээ нь хэдий байвал тохиромжтой бол, татварыг ямар аргаар хураах вэ, хөнгөлөлт чөлөөлөлтийг хэнд хэрхэн эдлүүлэх вэ зэрэг асуулт нь татварын үндсэн зарчмуудыг хангаж чадах татварын системийн хариулт болох учиртай.

Манай улсын хувьд Ч.Энхбаяр, Л.Пүрэвдорж, Д.Сувдаа зэрэг судлаач эрдэмтэд ХХОАТ-аар дагнасан бүтээл туурвиж, бусад эрдэмтэн судлаачид бүтээлдээ ХХОАТ-ын асуудлыг хөндөж мөн хэд хэдэн магистрант, судлаачид судалгааны ажил хийж байжээ.

Татварын онолын үзэл баримтлалыг дэлгэрүүлэгч эрдэмтэд өөрийн судалгааны ажил, бүтээлээрээ дамжуулж ХХОАТ-ын онол аргазүйн хувьд дараах байдлаар томъёолсон гэж үзэж болно. Үүнд:

- ХХОАТ-ыг орлогод ногдуулах эсвэл шууд хэрэглээнд ногдуулах

- Гэр бүлийн орлогод эсвэл хувь хүний орлогод
- Олон шатлалтай хөнгөлөлт чөлөөлөлтөөр зохицуулсан эсвэл нэг шатлалтай хөнгөлөлт чөлөөлөлт багатай
- Өөрөө тодорхойлж төлөх аргад эсвэл суутгуулах аргад суурилсан

Simons (1938) нь хувийн орлогын татварын суурийг тооцох аргачлалыг анх бий болгосон бөгөөд орлого нь хэн нэгэн тодорхой хугацаанд олох орлого гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолт нь эх үүсвэр болон буцаалтын ялгааг, тухайлбал үүнд бодит орлого, бэлэг эсвэл өв залгамжлал зэрэг үнэ төлбөргүй болон хөрөнгийн орлогуудыг тайлбарлаж чадаагүй. (Сувдаа, Д., 2013)

Хувийн орлогын татвар нь хэрэгжүүлж хянахад хамгийн төвөгтэй татварын төрөл гэж судлаачид үзэж байгаа бөгөөд үүнд дараах хүчин зүйлс нөлөөлж байгаа гэж үзэж болно.

- Татварын харилцаанд оролцогч буюу татвар төлөгчийн тоо бусад татварын төрөлтэй харьцуулахад олон
- Иргэд, татвар төлөгчдийн талаарх мэдээллийн нэгдсэн сан учир дутагдалтай
- Төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу.
- Ажил олгогч эзэд татварын хуулийг биелүүлэхгүй байх.
- Иргэдийн татварын боловсрол хангалттай биш.
- Засгийн газрын үйл ажиллагаанд иргэд төдийлөн сайшаалтай бус хандах хандлага.
- Татвар төлөхгүй байж болоод

байгаа нь иргэдийн татвар төлөх ухамсар төлөвшлийг муутгаж байгаа.

- Хариуцлагын механизм харилцан адилгүй үйлчилдэг.

Татвараас зайлсхийх зугтаах зөрчил гаргадаг татвар төлөгчдийн судалгааны үр дүнгүүдээс харахад дундаж орлоготой иргэд хуулийг илүү сайн сахин биелүүлдэг харин өндөр орлоготой иргэд хуулийг хэрэгжүүлэхгүй байх татвар төлөхгүй байх явдал илүү их байдаг гэсэн үр дүн гарсан байдаг байна. Манай улсын хувьд ч мөн ялгаагүй албан бус секторт ажил хөдөлмөр эрхэлдэг иргэд өөрийн орлогод ногдуулсан татварыг суутгуулаад харин хувиараа бизнес эрхэлдэг, байшин барилга аливаа хөрөнгө түрээслүүлдэг, хувиараа мөнгө зээлдүүлдэг болон албан бус бүртгэлгүй үйл ажиллагаа явуулж /тухайлбал зуучлах/ их хэмжээний орлого олдог хэсэг нь татвар төлдөггүй дүр зураг шууд харагддаг билээ.

Татварын тайлангуудын бүтцийг харвал татварын тайлан ирүүлсэн иргэдийн ихэнх нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх зорилгоор л татварын тайлан ирүүлж байгаа нь үүний нотолгоо юм.

Мөн мэргэжлийн статус доогуур, орлого багатай болон гэр бүлийн хариуцлага хүлээдэггүй хүмүүс татвараас зугтдаг хандлага илүү байдаг гэж судлаачид үзжээ. Манайд ч ялгаагүй албан бус секторт гар дээрээс худалдаа эрхэлдэг, ХАА-н бүтээгдэхүүний ченж, хувиараа бичил уурхай эрхлэгчид, хувиараа тээвэр болон үйлчилгээ эрхэлдэг иргэд шилжин суурьшсан боловч хаягийн бүртгэл хийлгэдэггүй, гэр бүлийн бүртгэлгүй байх зэрэг үзэгдлүүд их байгаа нь татвар төлөлт

хангалтгүй байхад нөлөөлж байна.

Татварын хууль хэрэгжихгүй эсвэл бүрэн хэрэгжихгүй байх нь дараах хэд хэдэн шалтгаантай байдаг.

- Хэтэрхий нарийн бүтэцтэй байх.
- Ойлгоход төвөгтэй байх.
- Өөр хоорондоо болон бусад хуультай зөрчилдсөн заалттай байх.
- Цоорхой буюу хийдэл ихтэй байх.

Татвар төлөх чадварыг бүрэн тодорхойлон шударга байх зарчмыг хангахын тулд бүх төрлийн орлогыг нэгтгэн тооцсон нийлбэрээс татвар авахаас өөр аргагүй. (Сувдаа.Д, 2013) Хувь хүний бүх орлогыг нэгтгэн ижил хувь хэмжээгээр татвар ногдуулах нь хэвтээ чиглэлт татварын тэгш шударга байдлыг хангах сайн талтай. Харин татварын тайлагналын төвөгтэй байдал бий болох талтай. Гэвч татвар төлөгчдийг татвараа төлдөг ухамсартай болгох, өөрсдийн олсон орлого ашгийн талаар албан ёсны мэдээлэл нотолгоотой болох, хууль зөрчсөн асуудалд хүргэхгүй байх, эцэг эх гэр бүлээр нь дамжуулж ирээдүйн татвар төлөгчдийг бэлтгэх зэрэгт нийт орлогыг нь тайлагнуулах систем зайлшгүй чухал болно.

Орлогыг тэгш хуваарилан босоо чиглэлд татварын тэгш шударга байх зарчмыг хангах нэг арга нь татварын өсөн нэмэгдэх хувь хэрэглэдэг байна. Гэвч энэ нь татвараас зугтах сонирхлыг нэмэгдүүлж болзошгүй байдал үүсэх бүрэн боломжтой. Ялангуяа шатлалын орлогын хэмжээг оновчтой тодорхойлохгүй бол манайх шиг иргэдийн татвар төлөх ухамсар төлөвшөөгүй улсын хувьд татвараас зугтаах үзэгдлийг ихэсгэх талтай.

Орлогын төрлүүд, өөрөөр хэлбэл орлого олох арга замуудыг бүтдийг нь

адил тэгшээр татварт хамруулахгүй бол татваргүй буюу татвар багатай хэсэг рүү хөрөнгө, нөөцийг шилжүүлж гажуудал үүсдэг байна. Энэ нь татварын хуулийг дутуу боловсруулсан, эсвэл зориудын бодлогын үр дүн байж болох талтай. (Сувдаа.Д, 2013) Үүнийг манайд

мөнгөө хүүтэй зээлдүүлэх, хадгалуулах, үл хөдлөх хөрөнгө худалдан авч түрээслүүлэх зэрэг бүтээмж багатай ажлын байр, бодитой үйлдвэрлэл бий болгодоггүй салбарт хөрөнгө оруулалт ихээр хийж байгаагаас харж болно.

ХХОАТ-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Өнөөгийн татварын тогтолцоонд шилжихээс өмнө манай улсад

- Мал бүхий иргэдээс хураах МАА-н албан татвар
- Хот суурин газар ашиглаж байгаа малын татвар
- Нөхөргүй буюу эхнэргүй, хүүхэдгүй иргэдээс хураах татвар
- Ашиг орлогын татвар гэсэн нэр төрлийн татварыг иргэдээс хурааж байсан байна.

Манай улсад орчин үеийн татварын тогтолцоо бүрэлдэн тогтож 26 жил хөгжиж байна. 1993 онд анх мөрдөж эхэлсэн хүн амын орлогын татвар орлогын хэмжээнээс хамаарсан 11 шатлалтай, татварын дээд хувь 45% байсан. 1992-2018 оны хооронд зөвхөн татварын хувь хэмжээнд 8 удаа өөрчлөлт оруулжээ. Татварын хувь хэмжээг өөрчлөхдөө татварын шатлалын тоог цөөрүүлэх, дээд хувь хэмжээг бууруулах, хөнгөлөлт чөлөөлөлтийг багасгаж татварын бааз суурийг өргөтгөх чиглэл барьж байсан байна. Хүн амын орлогын албан татварын хууль хэрэгжиж эхэлснээс өнөөг хүртэл нийт 20-иод удаа хуулинд өөрчлөлт оруулж, бодлогын чанартай өөрчлөлтүүд хийснээс хамгийн томоохон шинэчлэлийн нэг нь 2007 оноос мөрдөж эхэлсэн хуулийн өөрчлөлт байлаа. Энэ өөрчлөлтөөр татварын бааз суурийг

өргөтгөж, 10, 20, 30 гэсэн өсөн нэмэгдэх хувь хэрэглэж байсныг хувийн орлогын ихэнхи нэр төрөлд нэгдсэн 10%-аар татвар ногдуулахаар хуульчилсан байна. ХХОАТ-ыг жигд 10 хувийн бага хувиар ногдуулах нь татварын системд шударга, үр ашигтай, энгийн байх зарчмыг хангаж, татварын ачааллыг жигдрүүлснээр хувь хүмүүсийн орлого, хөрөнгөө нуух явдлыг бууруулж, татвараа тайлагнах, төлөх явц сайжирч, төсвийн орлого нэмэгдэнэ хэмээн тооцоолсон байдаг. ХХОАТ-ын орлого нь нийт татварын орлогын 11 орчим хувь төсвийн орлогын 9 орчим хувийг бүрдүүлж байна. 2017 оныг дуустал хугацаанд ХХОАТ-ын тайлагнал төлөлтөд төдийлөн ахиц гараагүйг ХХОАТ-ын орлогын 90%-95%-ийг нь зөвхөн цалин хөдөлмөрийн хөлсний орлоготой иргэдийн орлого эзэлж харин хувиараа аж ахуй эрхэлсэн иргэдийн төлсөн татвар дөнгөж 2,4-6,6 хувь эзэлж байгаагаас харж болно.

2016 оноос НӨАТ-ын хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэнтэй уялдуулан ХХОАТ-ыг хоёр өөр хуулиар зохицуулж байсныг болиулж орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэд тогтмол татвар төлөхөө больж ХХОАТ-ын хуулийн дагуу орлого ба татвараа өөрөө тодорхойлж орлогоосоо уг орлогыг олохтой холбоотой зардлыг хассан дүнгээс буюу ТНО-оос 10%-аар татвар төлөхөөр зохицуулсан байна.

Орлогын хэмжээнээс үл хамааран бүх хүний орлогод үйл ажиллагааны болон хөрөнгийн, зарим хөрөнгө борлуулсны орлогод 10%-ийн татвар ногдуулж, хуулийн таатай орчин бий болгож, хувь хэмжээний хувьд шударга байгаа ч зарим орлогын төрөлд татвар ногдуулахгүй байх, татварын хэсэгчилсэн чөлөөлөлт эдлүүлэх, заримынх нь татварыг чөлөөлөх, зарим татвар төлөгчөөс татвар бүрэн хураан авч чадахгүй зэрэг гажуудал буюу татварын хуулийн хэрэгжилт хангалтгүй байсаар байна. Хэдийгээр хуулинд хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгө ба хөрөнгө борлуулсны болон бусад бүх орлогыг татварын суурьт хамруулан татвар төлөхөөр заасан боловч орлогоос суутган авсан татвар бүрдүүлж, үйл ажиллагааны орлогоос төлсөн татварын дүн 2-6 хувийг эзэлж байгаа, татвар төлөгчдийн тооны өсөлт зэргээс үзэхэд үйл ажиллагааны орлого, түрээсийн орлого, хувьцаа борлуулсны орлого, эрхийн шимтгэлийн орлого олсон иргэд татварт бүрэн хамрагдахгүй, ХХОАТ-ын ачааллыг тогтмол ажлын байртай, гэрээгээр хөдөлмөр эрхэлж буй хүмүүс

ХХОАТ-ЫН ХОЁР ДАХЬ ШАТНЫ ШИНЭЧЛЭЛ

Татварын шинэчлэлийн 2 дахь шатны шинэчлэл яригдаж ажил хэрэг болж эхлээд байгаа бөгөөд хуулиудын төслийг боловсруулж олон нийтээр хэлэлцүүлэх шатны ажлыг хийж байна.

Уг шинэчлэлээр тэгш шударга байдлыг хэвтээ болон босоо түвшинд хангасан, энгийн ойлгомжтой хэрэгжүүлэхэд хялбар, үр ашигтай, төлөх боломжтой татварыг бий болгосон хуулийг боловсруулан баталж, түүнийг нэг мөр ижил тэгш хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

үүрч татварын шударга байх зарчим хангагдахгүй байгааг нотолж байгаа юм.

Нэгэнт хууль эрхзүйн орчин бүрдээд байхад түүний биелэлт хангалтгүй байгаа нь татварын удирдлага зохион байгуулалтын асуудал, татварын мэдээлэл, төрийн байгууллагуудын уялдаа холбоо зэрэгт учир дутагдал байгаагийн илэрхийлэл юм.

Мөн 2017 онд цалин хөдөлмөрийн хөлсний орлогод ногдуулах татварыг 2006 он ба түүнээс өмнөх хугацаанд мөрдөж байсан олон шатлалтай хэлбэрт шилжүүлэх өөрчлөлт хийсэн боловч тооцоо судалгаа дутуу хийсэн зэргээс үүдэлтэйгээр хүн амын дундаж давхаргын орлогод сөргөөр нөлөөлж тэдний бодит орлогыг бууруулж байна гэсэн үндэслэлээр эсэргүүцэлтэй тулгарч уг өөрчлөлтийг хүчингүй болгосон билээ.

Хувиараа бизнес эрхлэгч иргэдийн орлого буюу үйл ажиллагааны орлого, татварыг тодорхойлох, тайлагнах процесс нь аж ахуйн нэгжтэй адил нарийн төвөгтэй байгаа нь татварын тайлагналд төвөг учруулж байна.

Татварын хуулийг нэг мөр хэрэгжүүлж болохуйц хэтэрхий нарийн бүтэцтэй биш, нэг мөр ойлгохуйц, өөр хоорондоо болон татварын бусад хуулиудтай зөрчилдөөгүй, нийцтэй, цоорхой, хийдэлгүй хууль бий болгох нь одоо төдийгүй ирээдүйд ихээхэн ач холбогдолтой байх нь дамжиггүй.

"Ямаагаа бага майлууулж хамгийн их ноолуур самнах" зарчмыг баримталж ирээдүйд татвар төлөгчдөд сөрөг асуудал аль болох үүсгэхгүйгээр зохицуулалт хийж боломжит хамгийн

их татварыг хураах ирээдүйн татварын бааз суурийг тэлэх нь татварын хуулийн шинэчлэлийн гол зорилго байх учиртай.

Үүнтэй уялдуулан ХХОАТ-ын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн өөрчлөлтийг судалж үзээд татварын үндсэн зарчмууд, Татварын онолын үзэл баримтлал, ОУ-ын чиг хандлага, ХХОАТ-ын өмнөх хуулиудын хэрэгжилтэд тулгамдаж байсан асуудлууд зэргийг харьцуулан үзлээ.

Хуулийн төсөлд хууль хоорондын зөрүүтэй болон хийдэлтэй асуудлыг зохицуулах зүйл заалтууд тусгажээ. Үүнд:

- Хуульд нэлээд олон нэр томъёоны тодорхойлолтыг оруулж бусад хуулиудтай нийцүүлсэн,
- Татварын тооцоолол хийх асуудлыг хөнгөвчилж бичил үйл ажиллагаа эрхлэгчээс татвар хураах зохицуулалт хийсэн,
- Орлого багатай татвар төлөгч хялбаршуулсан зохицуулалтаар татвараа төлөх тайлагнах

сонголттой боломжийг НӨАТ-ын хууль болон ААНОАТ-ын хуультай уялдуулж бүрдүүлсэн

- Биет бус хөрөнгө борлуулсны орлогод татвар ногдуулах асуудлыг зохицуулсан байна.
- Давхар татварын асуудлыг зохицуулсан,
- Харилцах хамаарал бүхий этгээд гэсэн тодорхойлолтыг бусад хуулиудтай нийцүүлж нэг мөр ойлгоход дөхөм болсон,
- Хувь хүний төлөөний газар гэсэн ойлголтыг оруулсан нь орхигдсон харилцааг зохицуулсан,
- Бэлнээр олгосон хоол унаа, байрны үнийн хөнгөлөлтийг шууд орлогын ангилалд оруулсан нь зарчмын хувьд алдаатай байсан ангиллыг зассан байна.

Харин ХХОАТ-ын харилцаанд үүссэн, үүсч болох асуудлыг бүрэн зохицуулж чадахааргүй учир дутагдалтай анхаарвал зохих зүйл байгааг хуулийн бүтэц, зүйл заалт бүрээр тодорхойлж авч үзлээ.

ХУУЛИНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судлаачийн зүгээс дараах санал зөвлөмжийг санал болгож байна

1. “Малчин өрх, мал бүхий этгээдийн орлогод татвар ногдуулах, чөлөөлөх” гэсэн агуулга бүхий ХХОАТ-ын 4.1.5, 4.1.6, 8.3, 23.1.4 зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Малчин өрх, мал бүхий этгээд гэж ангилсан мөртлөө малчин өрхийн малын ашиг шимийн орлогыг үйл ажиллагааны орлогод хамааруулж татвар ногдуулах, малын тоо толгойд ногдох татварыг чөлөөлөхөөр зааж мал бүхий этгээд татвар төлөх эсэх талаар ямар нэгэн заалт алга.	Малын ашиг шим гэж юут ойлгох, ТНО-ыг хэн хэрхэн тодорхойлох, мал бүхий этгээд татвар төлөх эсэх нь тодорхойгүй. Малчин өрхийн малын ашиг шимийн орлогыг тодорхойлох нь малын тоо толгойд татвар ногдуулахаас илүү хүндрэлтэй. Орон нутаг бүр өөр хэрэгжүүлэх гажуудуулах, хийдүүлэх магадлал өндөр.	Малчин өрхийн малын тоо толгойд татвар ногдуулж харин малчин өрхийн ам бүлийн гишүүдийн тооноор татварын чөлөөлөлт эдлүүлэх замаар дундаж амьжиргаатай малчин өрхийг татвараас чөлөөлж олон мянган малтай өрхөөс татвар хураахаар зохицуулах. Мөн мал бүхий этгээдийн малын тоо толгойд татвар ногдуулахаар зохицуулах.

2. "Бие даан эрхэлсэн мэргэжлийн ажил, үйлчилгээний орлого" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 8.1.1) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Өнөөгийн мөрдөж байгаа НД-ын хуулиар НДШ суутгахыг шаард даг энэ нөхцөлд уг орлого нь үйл ажиллагааны орлого биш ЦХХ-ний орлого болж хувирдаг.	НД-ын хуулинд холбогдох өөрчлөлтийг оруулах нэг мөр ойлгох хэрэгжүүлэх ажлыг хангахгүй бол НД-ын байгууллага НДШ суут гана гэвэл энэ төрлийн орлогыг ХХОАТ-ын хуулийн дагуу тайлагнах боломжгүй байгаа.	НДШ суутгачихвал үйл ажиллагааны орлого биш ЦХХ-ний орлого болчих учраас үүнийг зохицуулах /НД-ын хуульд өөрчлөлт оруулах санал оруулах/

3. "Ажил олгогчийн төлсөн сайн дурын даатгалын хураамж" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 11.1.7) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Шууд бус оргогод хамааруулж татвар ногдуулахаар	Тэтгэврийн нэмэлт даатгал, гэнэтийн ослын даатгал гэх мэт даатгалд ажиллагсдаа хамруулах замаар ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх санаачилгыг хаасан заалт болно	ААНОАТ-ын хуулинд хасагдах зардал болохоор зохицуулалт хийх.

4. "Тухайн ажлын байранд ажлын цагаар ажиллуудаг цайны газар, кафе, амралтын өрөөнд бүх ажилтныг адил нөхцөлөөр хоолоор хангасан" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 11.2.1) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Татвараас чөлөөлөх зохицуулалт	Цөөн ажиллагсадтай өөрийн ажлын байранд хоолоор үйлчлэх боломжгүй ажил олгогчийн ажиллагсдаа хоолох боломжийг дэмжээгүй.	Өөрийн ажлын байрнаас өөр ААН, иргэдийн ажиллуудаг цайны газар, кафе ажиллагсдыг адил нөхцөлөөр хоолоор хангасан гэсэн заалт нэмэх.

5. "Ажил үүргээ биелүүлэх нөхцөлийг нь сайжруулах зорилгоор ажил олгогчоос ажилтанд олгож байгаа дараах шууд бус орлогыг албан татвар ногдох оргогод хамааруулахгүй" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 11.2) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Татвараас чөлөөлөх агуулгатай зохицуулалтыг тусад нь томъёолсон.	Ижил агуулгатай буюу татвараас чөлөөлөх утгатай зүйлсийг тусад нь өөр өөр зүйл заалтаар томъёолсон	23-р зүйлд оруулах

6. "Үнэ төлбөргүйгээр бусдаас авсан хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 12.1.5) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал,

зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Орлогд хамааруулж татвар ногдуулахаар зохицуулсан	Бэлэглэл, өв залгамжлалын асуудлыг орлогын татвартай хольж хутгаснаас үүдэлтэй маргаан, хэрэгжүүлэхэд хүндрэл гарч болзошгүй.	ААНОАТ-ын болон ХХОАТ-ын хуулиар биш тусад нь татварын хуулиар зохицуулах

7. Харилцан хамаарал бүхий этгээд хооронд зах зээлийн үнээс хямд, эсхүл өндөр үнээр бараа борлуулсан, шилжүүлсэн, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн эсхүл харилцан солилцсон тохиолдолд татварын алба бодит үнэ тодорхойлох журмын дагуу албан татвар ногдох орлогыг тодорхойлно” гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 13.3) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Энэ хуулинд харилцан хамаарал бүхий этгээд гэж хэн хэнийг ойлгохыг тодорхойлоогүй	Хэрэгжүүлэхэд хүндрэл, маргаан гарна	ХХОАТ-ын хуулиар харилцан хамаарал бүхий этгээд гэж хэнийг хамааруулж ойлгохыг тодорхойлох.

8. “Албан татвар төлөгчийн гэр бүлийн гишүүдэд олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож хасагдах зардалд тооцно” гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 15.5) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
15.4-т хувь тэнцүүлэн тооцож энд хувь тэнцүүлэн бодож...	Ижил төстэй ойлголт зохицуулалтыг өөр өөр үгээр илэрхийлсэн	15.4 ба 15.3-ыг хувь тэнцүүлэн тооцоолж гэж оруулах.

9. “Албан татвар төлөгчийн хувь нийлүүлсэн аж ахуйн нэгж татан буугдсан бол тухайн аж ахуйн нэгжийн үлдсэн хөрөнгийг худалдаж олсон орлогоос албан татвар төлөгчийн хүртсэн хувийг тодорхойлохдоо анх хувь нийлүүлсэн хэмжээгээр хувь тэнцүүлэн хувааж, хувь нийлүүлэхдээ гаргасан зардлыг хасаж тооцно.” гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 16.2) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Анх нийлүүлсэн хувь хэмжээ гэдэгт ногдол ашигт хуваарилахгүйгээр хуримтлагдсан ашгаар хөрөнгө оруулсан дүнг хэрхэн хамааруулах талаар зохицуулалт байхгүй.	Хувь хүний хөрөнгө оруулсан ААН татан буутгахад ногдол ашигт хамаарах хэсгийг тодорхойлоход хүндрэл учирна.	Ногдол ашиг хуваарилаагүй тул хөрөнгө оруулалтыг хийх үед Ногдол ашиг гэж үзэж татвар суутгахгүй харин ногдол ашиг хуваарилж авалгүй хуримтлагдсан болон цэвэр ашгаараа өөрийн хувь эзэмшдэг ААН-д нэмэлт хөрөнгө оруулалт хийсэн бол татан буугдах үед уг хөрөнгө оруулалтыг анхны хөрөнгө оруулалтын дүнд оруулахгүй байхаар зохицуулах. /Ногдол ашигт мөнгө хуваарилж аваагүй үед татвар нэхэх, ногдол ашгийн татвар төлөөгүй орлогыг дараа үеийн орлогоос хасах гэх мэт 2 талтай сөрөг нөлөөллийг арилгана./

10. "Ногдол ашиг, хүүгийн орлого" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 16) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Хувь хүн хөрөнгө оруулалт хийсэн ААН-ээс хүүгийн орлого хүлээн авах үед нимгэн капиталжуулалтын дүрмээр түүнийг хүүгийн биш ногдол ашгийн орлого гэж үзэх зохицуулалтыг орхисон.	Хүүгийн орлого ба ногдол ашгийн орлогыг заглаж татвар ногдуулахад асуудал үүснэ.	Уг зохицуулалтыг хуулийн төсөлд оруулах. Хүүгийн орлого, ногдол ашгийн орлогын тодорхойлолтыг нарийвчилж өгөх.

11. "Оршин суугч бус татвар төлөгчийн ЦХХО-д ногдуулах татвар 10%" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 22.1) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Өөрийн орны оршин суугч иргэдтэй оршин суугч бус иргэдийг ижил түвшинд авч үзэж байна.	Өөрийн орны оршин суугч иргэдтэй оршин суугч бус иргэдийг ижил түвшинд авч үзэх нь зохимжгүй.	Аль ч улс орон аливаа татварын зохицуулалтаараа өөрийн орны оршин суугч иргэдтэй оршин суугч бус иргэдийн хооронд ялгаатай зохицуулалт байхаар тусгах.

12. "20.1.2- заасан оршин суугч бус албан татвар төлөгчийн МУ-д болон ТУ-аас эх үүсвэртэй хүүгийн орлогод 10%-ийн татвар" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 22.2.4) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Өөрийн орны оршин суугч иргэдтэй оршин суугч бус иргэдийг ижил түвшинд авч үзэж байна.	Өөрийн орны оршин суугч иргэдтэй оршин суугч бус иргэдийг ижил түвшинд авч үзэх нь зохимжгүй.	Аль ч улс орон аливаа татварын зохицуулалтаараа өөрийн орны оршин суугч иргэдтэй оршин суугч бус иргэдийн хооронд ялгаатай зохицуулалт байхаар тусгах.

13. "Ажлын байр, лангуу бүхий байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж буй хувь хүн 2000-120000 төгрөг/ сард/" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 22.4.1) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Тогтоосон мөнгөн дүнгээр татварын хувь хэмжээг тогтоосон.	Тогтмол мөнгөн дүнгээр татварын хувь хэмжээг тогтоох нь тодорхой хугацааны дараа орлого ашиг үйл ажиллагаатай харьцуулахад харьцангуй дүнтэй болох сөрөг зүйл илэрдэг.	Тооцох нэгж эсвэл тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тодорхой хувиар тогтоох.

14. “Хувиараа зорчигч, эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж буй хувь хүн 12 000-480 000 төгрөг” гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 22.4.2) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Тогтоосон мөнгөн дүнгээр татварын хувь хэмжээг тогтоосон.	Тогтмол мөнгөн дүнгээр татварын хувь хэмжээг тогтоох нь тодорхой хугацааны дараа орлого ашиг үйл ажиллагаатай харьцуулахад харьцангуй дүнтэй болох сөрөг зүйл илэрдэг.	Тооцох нэгж эсвэл тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тодорхой хувиар тогтоох.

15. “Хөдөлмөрийн чадвараа 50 болон түүнээс дээш хувиар алдсаныг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоос тогтоосон магадлагаатай хувь хүний орлого” гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 23.1.2) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан буюу 70% ба түүнээс дээш хувиар алдсан хүнийг орлого ЦХХ-ний ба үйл ажиллагааны орлого олохоор төсөөлсөн.	Хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу 70% түүнээс дээш хувиар алдсан иргэн орлого олсон гэж татварын чөлөөлөлт эдлэхэд УТ хүнийг тухайн орлогыг олох боломжтой эсэх дээр маргаан үүснэ.	50-70 хүртэл %-иар буюу бусад хуулиудад хөдөлмөр эрхлэхийг зөвшөөрсөн дэмжсэн байдаг хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээтэй уядуулах.

16. “7.1.1-7.15, 7.1.17-д заасан орлогод шаталсан хэмжээгээр 0-240000 төгрөгийн татварын хөнгөлөлт эдлүүлэх” гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 24.1) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Мөнгөн дүнг хуульд заасан	Тодорхой хугацааны дараа орлогын өсөлттэй уялдуулан авч үзээгүйгээс ач холбогдол багатай болж хувирах	Тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 100%, 90%, 80%, 70%, 60%, 50% гэх мэт хэмжигдэхүүн тавьж өгөх

17. “Монгол Улсын иргэн амьдран суух зориулалтаар ипотекийн зээлийн хөрөнгөөр хувьдаа, анх удаа орон сууц худалдан авсан бол албан татвар төлөгчид Монгол Улсын Засгийн газрын тодорхойлсон ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүү хоорондын зөрүүд төлсөн дүнтэй тэнцэх хэмжээний албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ” гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 24.3) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Хүүгийн зөрүүгийн нийт дүнгээр татварын хөнгөлөлт эдлүүлэхээр тусгасан.	Хэрэгжүүлэхдээ хүүгийн зөрүүгээр татварын хөнгөлөлт биш орлогын чөлөөлөлт эдлүүлэх юм биш.	Үнэхээр хүүгийн зөрүүтэй тэнцэх хөнгөлөлт эдлүүлэх юмуу эсвэл хүүгийн хэмжээг татварын хувиар үржүүлсэн дүнгээр татварын хөнгөлөлт эдлүүлэхийн аль нь болохыг эргэж харах.

18. "Монгол Улсын иргэн өөрийн татвар ногдсон орлого болон банк, санхүүгийн байгууллагаас авсан энэ хуулийн 24.3-т зааснаас бусад зээлийн хөрөнгөөр амьдран суух зориулалтаар зөвхөн хувьдаа, анх удаа орон сууцны барилга барьсан, эсхүл орон сууц худалдан авсан бол албан татвар төлөгчид 6 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 24.4) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Тогтмол мөнгөн дүнгээр илэрхийлсэн.	Тодорхой хугацааны дараа орлогын өсөлттэй уялдуулан авч үзээгүйгээс ач холбогдол багатай болж хувирах	Тухайн үеийн 1 өрөө байрны зах зээлийн үнэ ханшийн мэдээлэлд үндэслэж тогтоосон дүнгийн 10%-тай тэнцэх хэмжээний хөнгөлөлт эдлүүлнэ. /Орон сууцны жишиг үнийн сангийн яамнаас жил бүр зарлана гэх мэтээр.../

19. "Албан татвар төлөгчийн өөрийн хэрэгцээнд зориулан худалдан авсан нар, салхи, газрын гүний дулааны болон бусад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, нүүрснээс хагас кокжсон түлш, хийн болон шингэн түлш гарган авах тоног төхөөрөмж, стандартад нийцсэн зуух, нам даралтын зуух, дулаалгын материал, цахилгаан болон хийн халаагуур худалдан авсан баримтаар нотлогдож буй төлбөртэй тэнцэх тухайн жилийн орлогод ногдох албан татварын хөнгөлөлтийг эдлүүлнэ." гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 24.7) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Агаарын бохирдлыг бууруулах ажлыг дэмжсэн хуулийн заалт мөртөө зуух, нам даралтын зуухыг худалдан авахыг дэмжсэн.	Үндсэн зорилгод нийцээгүй утаа гаргагч эх үүсвэрийн зүйлсийг оруулсан	Зуух, нам даралтын зуух гэсэн зүйлсийг хасаж найруулах.

20. Донорын олговор, даатгалын нөхөн төлбөр Монгол Улсын төрийн шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын ардын болон гавьяат цолтны шагнал, шинжлэх ухааны нээлтийн шагнал" гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 24.9) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Орлогыг нь чөлөөлөх биш татварыг нь хөнгөлөхөөр тусгасан.	Ач холбогдол, юуг зохицуулж байгаа нь тодорхойгүй байна. Татвар төлөгчийн татварын тайлагналыг төвөгтэй болгоно.	Орлогыг нь татвараас чөлөөлөх зохицуулалтаар байх.

21. "Суутган төлөгч энэ хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийн дүнг 12 сард тэнцүү хэмжээгээр хуваан тооцно " гэсэн агуулга бүхий (ХХОАТ-ын 24.13) зүйл заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхийн үндсэн зорилго зарчмыг гажуудуулж жилийн хөнгөлөлт эдлэх боломжийг хааж давхардах нөхцөлийг бүрдүүлсэн	Сар бүрийн ЦХХ-ийн тооцоололд хүндрэл учруула. Орлого, татвараа тайлагнах үүргээ биелүүлсэн татвар төлөгчийг урамшуулах зорилгыг гажуудуулсан. Давхардах нөхцөл бий болгосон.	Сар бүр ЦЦХ-ий орлогоос хөнгөлөлт хасаагүй дүнгээр татварыг суутгаж жилийн эцэст татварын тайлангаар орлого, татвараа өөрөө тодорхойлж тайлагнасан татвар төлөгч жилийн дүнгээр татварын хөнгөлөлтийг 1 удаа эдлүүлэхээр зохицуулах.

22. “Тодорхой зохицуулалт тусгаагүй.” гэсэн агуулга бүхий заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Гэр бүл жилийн нийт орлогоо тодорхойлоод дундаа татварын тооцоолол хийж болох, татварын хувь хэмжээ биш юмаа гэхэд татварын хөнгөлөлтийн дүн гэр бүлийн гишүүдийн тоо буюу орлого ологчоор тэжээлгэж байгаа өрхийн гишүү-дийн тоо, бүтцээс хамаарсан зохицуулалт байхгүй.	Гэр бүлийн бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн хариуцлагатай байдал, гэр бүлийг дэмжих нийгмийн бодлоготой уялдсан зохицуулалт байхгүй.	Татварын тайлан, тооцоогоо татвар төлөгч хүсвэл гэр бүлээрээ хийж болох сонголт бий болгож ингэсэн тохиолдолд гэр бүлийн гишүүдийн тооноос хамаарсан татварын хөнгөлөлтийн зохицуулалт хийх. Энэ энэ гэр бүлээр дамжуулж ирээдүйн татвар төлөгчдөд иргэний боловсрол тэр дундаа татвар, санхүүгийн боловсрол мэдлэг олгох бага ч гэсэн ач холбогдолтой.

23. “Зарим орлогод татварыг суутгуулаад өөрөө тайлагнах албагүй үйл ажиллагааны болон түрээсийн орлого олж буй иргэн л татварын тайлан бэлтгэхээр зохицуулсан” гэсэн агуулга бүхий заалтын хувьд зохицуулах хувилбарыг авч үзье.

Зохицуулах хувилбар
Жилийн эцсийн зохицуулалттай өрөөр хэлбэл орлого олгох тухай бүрд татварыг суутгаж оны эцэст тухайн жилд авсан орлогынх нь нийт дүнгээр татварын тооцоог дахин хийж урьд төлсөн суутгалтай зохицуулан дуусгах хэлбэр юм.

24. “Гэр бүлийн дундын орлогод татвар ногдуулах зохицуулалт” гэсэн агуулга бүхий заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Гэр бүлийн дундын орлогод татвар ногдуулах зохицуулалт байхгүй.	Тодорхой хэмжээний гажуудал үүсгэж байгаа.	Хүүгийн орлого, ногдол ашгийн орлого, хөрөнгө худалдсаны орлого, үйл ажилла- гааны орлого зэрэг орлого нь ихэнхдээ нэг хувь хүн дангаараа эрхэлсэн биш гэр бүлийн гишүүдийн оролцоотой, дундын өмч хөрөнгө хамтын оролцоон дээр тулгуурласан орлого байдаг тул гэр бүлийн гишүүд хамтдаа татвараа тайлагнах боломжийг бүрдүүлж өгөх нь гэр бүлийг дэмжих ач холбогдолтой.

25. “Үйл ажиллагааны орлогын татварын хувь хэмжээ, тайлагнах хугацаа” гэсэн агуулга бүхий заалтын хувьд дутагдалтай асуудал, үүсэх асуудал, зохицуулах хувилбарыг тус бүрд нь авч үзье.

Дутагдалтай асуудал	Үүсэх асуудал	Зохицуулах хувилбар
Шатлал огт байхгүй, хугацаа жилд ганцхан удаа.	Ижил орлогод ижил хэм- жээний татвар ногдуулах зарчим хэрэгжихгүй байна. Жилд ганцхан удаа тайлагнахад их хэмжээ-ний орлоготой татвар төлөгч нэг дор их хэмжээ-ний татвар төлөх болно.	Үйл ажиллагааны орлогын татварын хувь хэмжээ, тайлагнах хугацааг орлогын хэмжээнээс хамаа-руулж ААНОАТ-ын хувь хэмжээтэй ижил байхаар хуульчлах

ДҮГНЭЛТ

Дараах зүйлсээс шалтгаалж ХХОАТ-ын хуулийн шинэчлэл зайлшгүй хийх шаардлага гарч байна.

- Татварын шинэчлэлийн хүрээнд татварын хувь хэмжээг нэг шатлалтай болгож, улмаар бууруулснаар ХХОАТ-ын бааз суурь ихээхэн нэмэгдэж татварын орлогод ХХОАТ-ын эзлэх хувь хэмжээ өснө гэсэн тооцоолол төдийлөн биеллээ олсонгүй.
- ХХОАТ-ын ихэнх хэсгийг албан ёсоор ажил хөдөлмөр эрхэлдэг иргэдийн ЦХХ-ний орлогод ногдуулж суутгасан татвар эзэлж байгаа нь татварын бааз суурь тэлээгүйг харуулж байна.
- Татвар төлөгчдийн дийлэнх нь зөвхөн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхийн тулд татварын тайлан бэлтгэдэг байдал хэвээр байна.
- Түрээсийн орлого, хувиараа бараа бүтээгдэхүүн борлуулах, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх бизнесийн орлого буюу үйл ажиллагааны орлогод татвар ногдуулах үйл явц хангалтгүй байна.
- НӨАТ-ын хуулийн шинэчлэлийн хүрээнд ХХОАТ-ын харилцааг 2 өөр хуулиар зохицуулж байсныг больж

үйл ажиллагаа эрхлэгч иргэд e-barimt олгож, татвараа өөрөө тайлагнахаар болсон боловч энэ үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, татвар огт төлдөггүй иргэдийн тоог өссөн.

- Үйл ажиллагаа эрхэлдэг иргэд бүртгэлээ хэрхэн хөтөлж орлого, зардал, татвараа тодорхойлох нь тодорхойгүй, хүндрэлтэй.

Татварын хоёр дахь шатны шинэчлэлийн хүрээнд дараах асуудлыг анхаарч үзэх шаардлага гарч байна.

- Татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг иргэдийг дэмжихээс гадна татвараа тайлагнадаг дадал хэвшилд сургах хөшүүрэг болгон хэрэгжүүлэх.
- Татвар төлөгч өөрөө хүсвэл гэр бүлээрээ орлого, татвараа тайлагнаж тэжээлгэгчийн тооноос хамаарч татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдэлдэг сонголт хийх боломжийг бүрдүүлэх нь одоо биш ч ирээдүйд эерэг үр нөлөө авчирна.
- Хуульд татвар, хөнгөлөлтийг тогтмол мөнгөн дүнгээр биш тооцох нэгж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ,

- хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тодорхой хувь гэх мэт үзүүлэлтээр илэрхийлэх нь уг зүйл заалтын ач холбогдлыг хадгалах, ойр ойрхон өөрчлөх шаардлага гарахгүй байх сайн талтай.
- Татвар үл төлдөг, тайлагнадаггүй иргэд, татварт хамруулж чадахгүй байгаа орлогоос татвар хураахад чиглэсэн бодлого баримтлах.
 - Үйл ажиллагаа эрхлэгч, хөрөнгө түрээслүүлэгч иргэд орлого, зардлаа бүртгэж тайлагнах энгийн бүртгэлийн загвар, заавар, аргачлалыг татварын албаны зүгээс боловсруулж мөрдүүлэх шаардлагатай.
 - Иргэдийн орлогын талаарх хөндлөнгийн мэдээллийн чанар, агуулгыг сайжруулах талаар татварын алба, бусад төрийн байгууллага холбогдох байгууллагуудын ажлын уялдааг хангах.
 - Татварын албаны мэдээллийн баазын чанар хүртээмжийг сайжруулах.
 - Татварын механизмыг сайжруулах .
 - Хуулийг чадварлаг менежер ур чадвартай мэдлэгтэй ажилтнууд л сайн хэрэгжүүлэх учраас татварын албаны ажилтнуудын ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх, татварын албаны ажилтанд тавигдах шаардлагыг хангасан хүмүүсээр баг бүрдүүлэх.

НОМ ЗҮЙ:

1. Сувдаа.Д ХХОАТ ногдуулалтыг боловсронгуй болгох нь, УБ 2013
2. Алтанзаяа.Г. Татвар, УБ 2013
3. Пүрэвдорж.Л. Хувийн орлогын татвар, УБ 2000
4. Намжил.Д, Сувдаа.Д, Албан татвар ногдуулалт, УБ 2002
5. Ганхөлөг нар, Татварын тогтолцоо, УБ 2002
6. <https://data.oecd.org/tax/tax-revenue.htm#indicator-chart>
7. www.KPMG.com
8. www.mta.mn
9. www.em.gov.bc.ca
10. www.skatteverket.se
11. www.vero.fi/eng-US
12. www.nta.go.jp/foreign_language/
13. www.nts.go.kr/eng/
14. www.kpmg.com
15. www.aicpa.com
16. <http://mof.gov.mn/discussion/107>
17. МУ-ын татварын албаны статистик мэдээлэл

ТАТВАРЫН ЗАХИРГААНЫ АКТ БОЛОН ТАТВАРЫН ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

С.Батбуян

СЭЗИС-ийн ахлах багш, хуульч, өмгөөлөгч

Б.Билгүүн

Legal policy ХХН-ийн хуульч

Abstract. The modern “Administrative Act” institute has been successfully adopted by theoretical and practical concepts rooted in the Mongolian Administrative Law since 2002. The regulation of administrative act was comprehensively legitimised in accordance with the General administrative law approved by the Mongolian parliament in 2016.

The administrative act is considered as an independent institute or a mechanism at international standards. In other words, this concept includes not only the scope and the legal requirements but also the consequences. The mechanism is used in all administrative laws, or the administrative body uses this mechanism in its operation. The Administrative Cases Court also reviews the disputes in the same way as the Administrative Act mechanism does. The research paper addresses the legal regulation of tax administration act and tax decision making.

Key words: General tax law, Administrative acts, Court decision, Taxation and tax dispute, Taxation and tax dispute, Tax Compensation

Хураангуй. Төр өөрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, улсын сан хөмрөгийг баяжуулах зорилгоор төрөөс албан татвар тогтоон түүнийг харьяат албат, иргэдээс хураан авах шаардлага төр анх үүссэн цаг үеэс бий болсон гэж үздэг. Аливаа улс татварын талаарх өөрийн орны эдийн засгийн бодлогын хүрээнд нарийн зохицуулалт хийж ирсэн байдаг. Энэ нь татвар өөрөө тухайн улсын төсөв, цаашлаад эдийн засгийн тогтвортой байдал, хөгжлийн нэг үндсэн хүчин зүйл болдогтой холбоотой юм. Татвар ногдуулалтыг ихэнх улсад дотоодын эрх зүйгээр зохицуулж, үүнд татвар төлөгч, татварын төрөл, шийдвэр гаргах ажиллагаа, татварын хөнгөлөлт болон татварын байгууллагын чиг үүргийг тодорхойлж өгдөг байна.

Монгол Улсын захиргааны эрх зүйд 2002 оноос хойш орчин үеийн “Захиргааны акт”-ын институт онол болон практикт хүлээн зөвшөөрөгдөн амжилттай хэрэглэгдэж байна. УИХ-аас 2016 онд баталсан Захиргааны ерөнхий хуулиар захиргааны актын зохицуулалтыг цогцоор нь хуульчилсан.

Захиргааны акт бол бие даасан институт буюу механизм гэж олон улсын жишигт үздэг. Өөрөөр хэлбэл, уг ойлголт нь өөрийн гэсэн хамрах хүрээ, эрх зүйн шаардлагатай төдийгүй үр дагаврыг агуулдаг. Уг механизм нь захиргааны эрх зүй дэх бүх хуулиудад хэрэглэгддэг буюу захиргааны байгууллага нь үйл ажиллагаандаа уг механизмыг ашигладаг байна. Мөн захиргааны хэргийн шүүх (ЗХШ) маргааныг хянан шийдвэрлэхдээ Захиргааны актын механизмыг мөн адил хэрэглэж хэрэг маргааныг хянан шийдвэрлэж байна. Тус судалгааны ажилд татварын захиргааны акт болон татварын шийдвэр гаргах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын асуудлыг авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Татварын ерөнхий хууль, Захиргааны акт, Шүүхийн шийдвэр, Татварын хэрэг, маргаан, Татварын шийдвэр гаргах үйл ажиллагаа, Нөхөн татвар

ОРШИЛ

Монгол Улс нь Япон улстай адил "татварын хувь хэмжээг татвар төлөгч өөрөө тодорхойлж төлөх арга" буюу тайланд үндэслэх нийтлэг арга /self-assessment/-ийг хэрэглэдэг. Иймээс иргэн, хуулийн этгээд татварын албанд татвар төлөгчөөр өөрөө бүртгүүлж, татварын ногдлоо тодорхойлдог тул уг шатанд татварын захиргааны шийдвэр гаргах ажиллагаа байхгүй бөгөөд үүний дараа татварын хууль тогтоомжийн

биелэлтэд хяналт тавих ажлын хүрээнд татварын ногдуулалт, хураалтын үйл ажиллагаа хууль эрх зүйн дагуу үнэн зөв явагдаж байгаа эсэхийг хянан шалгах үеэс татварын алба, татварын улсын байцаагчаас (ТУБ) холбогдох шийдвэрүүд гарч эхлэх боловч Татварын ерөнхий хуулинд (ТЕХ) шийдвэр гаргах ажиллагааны үе шатыг нарийн тодорхойлж, зохицуулаагүй байна.

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

ТЕХ-д татварын алба, татварын улсын байцаагчаас татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх хуудас, төлбөрийн хуудас, дүгнэлт, гэрээ, үйл ажиллагааны тэмдэглэл зэрэг баримт бичгүүдийг үйлдэх боловч эдгээрийн аль нь иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхолд халдах боломжтойг ялгаж өгөөгүй байна. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сангаас татварын хэрэг маргаанаар шийдвэрлэсэн нийт 521¹ шийдвэрийг шүүж үзвэл:

А/А	Шийдвэрийн төрөл	Шийдвэрийн тоо
1	ТУБ-ын акт	460
2	Эс үйлдэхүй	21
3	Үйлдэл	10
4	Тушаал	5

5	ТУБ-ийн дүгнэлт	4
6	Хэм хэмжээний акт	4
7	Албан бичиг	3
8	Шийтгэвэр	3
9	Мэдэгдэх хуудас	3
10	Шаардлага	1
11	Томилот	1
12	Удирдамж	1

Эндээс үзвэл шүүхээр хянагдаж буй ихэнх татварын маргааны хувьд шүүгч нөхөн татвар, хүү, торгуулийн дүнг шалгаж хуулийн зөрчлийг илрүүлэх маргаан зонхилж байх бөгөөд энэ тохиолдолд шүүхээс зөрчилд ногдуулсан мөнгөн дүн үндэслэлтэй гарсан эсэхэд дүгнэлт өгдөг.

2017 оны 05 сарын байдлаар¹

¹ 2017 оны 05 сарын байдлаар

ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН

Татварын шийдвэр гаргах ажиллагааны үе шат тодорхойгүй, үе шат болгонд захиргааны актыг хуульчилж өгөөгүй, захиргаан актыг ялгаагүйгээс ТУБ-ын актаар хяналт шалгалтын ажлаас илэрсэн маш олон зөрчилд 1 акт тогтоосныг шүүхээс шийдвэрлэхдээ актаар тогтоосон зөрчил мөн эсэх, татвар ногдох зүйл мөн эсэх, татварыг зөв ногдуулсан эсэх, нөхөн татвар, хүү, торгууль, алдангийн тооцоолол зөв эсэхийг дүгнэж, түүнд тохирсон шийдвэр гаргах, төлбөрийг өөрчилж шийдвэрлэх бол тооцооллын алдаа гаргахгүй байх шаардлагатай тул шүүгчээс мөнгөн дүн ногдуулсан зөрчил болгоныг шалгаж, аль хэсэгт татварын эрх зүйн зөрчил байгаа болохыг олж илрүүлэхийг хичээдэг.

Иймд ТЭХ-нд татварын шийдвэр гаргах ажиллагааг нарийн зохицуулаагүй, ойлгомжгүй, татварын байгууллагаас гарч буй шийдвэрүүдийг дэс дараалалгүй буюу хуулийн энд тэнд хуульчилсан нь ямар үед, ямар журмаар шийдвэр гарах нь ойлгомжгүй байх тул татвар ногдох зүйлийг тогтоох, татварыг тодорхойлох, татварыг ногдуулах, татвар төлөх, албадан гүйцэтгэх, татварын хяналт шалгалтын ажиллагааг тус тусад нь ТЭХ-аар зохицуулах шаардлагатай байна.

Мөн татварын захиргааны актыг

ялгаж өгөөгүйгээс шүүхээс татварын шийдвэрүүд дээр захиргааны хэргийг ялгаатайгаар үүсгэн хянан шийдвэрлэж, шүүхээс ижил хэрэг маргааныг өөр байдлаар шийдвэрлэж нийгэмд /татвар төлөгчидөд/ эргэлзээтэй байдал үүсгэж байгаа нь доорх байдлаар актыг ялгах шаардлага буйг харуулж байна.

Татварын захиргааны актад татварын албаны удирдамж, татварын улсын байцаагчын акт, шаардлага, мэдэгдэх хуудас, төлбөрийн хуудас, шийтгэвэр зэрэг багтахаас гадна, татварын албаны даргын үйлдэх баримт бичгүүдээс татварын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг халах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сахилгын шийтгэл хүлээлгэх, шагнал урамшуулал олгох болон татварын улсын байцаагчийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, татварын маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг баталгаажуулах, өөрчлөх, хүчингүй болгох зэрэг нь хамаарахаар байна.

Монгол Улсын хувьд Татварын ерөнхий хуулинд /ТЭХ/ захиргааны актын нарийвчилсан зохицуулалт байдаггүй учир Татварын эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд захиргааны хэргийн шүүхээс захиргааны ерөнхий хуулийн захиргааны актын механизмыг хэрэглэж байна.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

ХБНГУ-ын ТЭХ-ийн зохицуулалтаас үзвэл захиргааны актын тодорхойлолтыг хуульчилж өгснөөр татварын захиргааны акт гэсэн бие даасан ойлголтыг бий болгожээ. Иймээс татварын захиргааны актын зохицуулалт

захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн зохицуулалт дээр үндэслэсэн байна. Монгол Улсын ТЭХ-тай харьцуулбал ХБНГУ-ын ТЭХ нь дараах онцлогтой байна. Үүнд, татварын шийдвэр гаргах ажиллагаа бүрийн дэс

дараалалтайгаар нарийн тодорхойлсон, эдгээр ажиллагаа тус бүрээс татварын захиргааны актуудыг ялгаж өгсөн байна. Тухайлбал татварыг мэдүүлэх, татварыг тодорхойлох, ногдлыг тодорхойлох, ногдуулах, хэмжих, хүүгийн шийдвэр, хожимдуулсны алданги, хойшлуулах шийдвэр, чөлөөлөх шийдвэр, хугацаа сунгах болон албадлага тодорхойлох зэрэг татварын байгууллагын шийдвэрийг татварын захиргааны актад хамруулсан байдаг.

Мөн татвар ногдох зүйлийг тогтоох, татварыг тодорхойлох, татварыг ногдуулах, татварыг төлөх ажиллагааны

үе шат гэсэн байдлаар шийдвэр гаргах ажиллагааг задалсан байдлаар хуулийн зохицуулалт хийгджээ. Түүнчлэн татварын салбарын онцлогийг захиргааны актын механизмын үе шат болгон дээр суулган өгч маш дэлгэрэнгүй зохицуулалт хийсэн байна.

Харин шүүхийн шийдвэрээс үзвэл ХБНГУ-ын санхүүгийн шүүхээс татварын хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ татварын ерөнхий хуулийн захиргааны актын зохицуулалтыг суурь болгож дээр нь тухайн төрлийн татварын хуулийг хэрэглэж байна.

ДҮГНЭЛТ

Юуны өмнө шүүхийн шийдвэрт тухайн маргаж буй акт нь ямар төрлийн татварын захиргааны акт болохыг шууд нэрлэн зааж холбогдох шийдвэр гаргах ажиллагаа, хөөн хэлэлцэх хугацаа, гомдол гаргах журам зэрэг татварын ерөнхий хуулийн \Abgabenordnung (AO)\ зүйл заалтуудыг хэрэглэж татварын хэрэг маргааныг шийдэж байна. Мөн татварын шийдвэр гаргах ажиллагааны аль үе шатанд гарсан татварын захиргааны актад маргаж байна тухайн акт шүүхээс хүчингүй болсон тохиолдолд шийдвэр гаргах ажиллагааны хойших шийдвэрүүд хууль зүйн хувьд хүчингүй болж байна.

Ингэснээр татвар төлөгч иргэн, хуулийн этгээдийн эрх хуульд нийцэхгүй гарсан шийдвэрүүдээр зөрчигдөхгүй болох нь харагдаж байна.

Иймд захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтыг татварын салбарын онцлогт тохируулан нарийвчлан тодруулсан татварын шийдвэр гаргах ажиллагааг хуульчлан татварын захиргааны актын ойлголт, төрлийг нарийн тодорхойлсноор хамрах хүрээ өргөсч, татвар төлөгчдийн эрхээ хамгаалж маргах боломж нэмэгдэж, шүүхийн зөв практик тогтох юм.

Дүгнэлтээс дараах саналыг дэвшүүлж байна.

Д/А	Санал	Ач холбогдол
	Татварын ерөнхий хуулинд захиргааны актын зохицуулалтыг бүхэлд нь тухайн салбарын онцлогийг тусган цогц байдлаар хуульчлах;	<ul style="list-style-type: none"> · ЗЕХ-ийн зохицуулалтыг ТЕХ-нд нарийвчлан тусгаж хуульчилснаар Монголын эрх зүйн тогтолцооны нэгдмэл байдлыг хангаж, орчин үеийн татварын эрх зүйн тогтолцооны суурь тавигдана. · ТЕХ болон бусад хуулийн хоорондын зөрчил арилж, хэрэглэгдэхэд хялбар болно. · Татварын хууль тогтоомжийн тогтвортой байдал баталгаажна.

Татвар хураах үйл ажиллагааны үе шат болгонд татварын захиргааны акт гарахаар зохицуулалт бий болгох;

- Салбарын онцлог, тусгай шаардлагуудыг захиргааны актын зохицуулалтад тусгаж өгснөөр ТЭХ-ийн зохицуулах чадавх эрс сайжирна.
- Татварын захиргааны актыг ангилан төрөлжүүлснээр татварын байцаагчийн гаргах шийдвэр тодорхой болно. Татвар хураах үйл ажиллагааны аль үе шатанд ямар шийдвэр гаргах, ямар шаардлага хангасан байх, дараагийн шийдвэртэй хэрхэн уялдах гэх мэтээр илүү системчлэгдэж үйл ажиллагаа нь цэгцтэй тодорхой болох юм.
- Татвар төлөгчдийн хувьд зөрчигдсөн эрхээ хамгаалах боломж илүү нэмэгдэж эрх зүйн хамгаалалт сайжирна.

Ялангуяа татварын байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны зохицуулалтыг ерөнхий болон тусгай хэсгүүдээр ангилж татварын ерөнхий хуульд хуульчлах;

- Татвар хураах ажиллагаа ил тод болж, татварын байцаагч үзэмжээрээ шийдвэр гаргах боломж багасаж хуулийн дагуу ажиллах болно.
- Татвар хураах ажиллагааны үе шат болгоныг нарийвчлан зохицуулснаар татварын байцаагч ямар үйл ажиллагаа, ямар шийдвэр гаргахыг татвар төлөгчид мэдэх боломжтой болж итгэл үнэмшил нь нэмэгдэнэ.
- Шийдвэр гаргах ажиллагааны нарийвчилсан цогц зохицуулалтыг бий болгосноор аливаа хүнд суртал, татвар төлөгчдийн эрхийг зөрчих байдал эрс багасна.

НОМ ЗҮЙ

НЭГ. Монгол эх сурвалж

1. Чимид.Б. Бүгд Найрамдах Монгол ард улсын захиргааны эрх зүй ерөнхий анги. УБ., 1988.
2. Сүхбаатар.Ж. Монгол Улсын захиргааны эрх зүй. УБ., 2002.
3. Дашцэдэн. Д. Монгол Улсын захиргааны эрх зүй II. УБ., 2003.
4. Жавзандулам.Ж. Татварын эрх зүй. УБ., 2005.
5. Долгорсүрэн.Ж. Монгол Улсын захиргааны эрх зүйн удиртгал. УБ., 2006.
6. Буянхишиг.Г, Долгорсүрэн.Ж. Монгол Улсын захиргааны эрх зүй. УБ., 2008.
7. Захиргааны эрх зүй, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн ойлголтууд. Ханнс-Зайделийн сан, "Эрх зүйн боловсрол" академи. УБ., 2003.
8. Сүхбаатар.Ж. Өрнөдийн улсы орнуудын Захиргааны эрх зүйн ерөнхий тойм. УБ., 2001.
9. Алтантуяа.Г. Татварын онол, бүртгэл. УБ., 1999.
10. Баатар.С, Пүрвээ.Я, Ганхүлэг.Б. Татварын онол, арга зүйн зарим асуудлууд. УБ.,1997
11. Мэндсайхан.Т. Олон улсын татварын эрх зүй. УБ., 2009.
12. Уянга.М. Олон Улсын эдийн

- засгийн эрх зүй, 2 дахь хэвлэл. УБ., 2014.
13. Ганхүлэг.Б. Татварын тогтолцоо. 1, 2-р дэвтэр. УБ., 2002.
 14. Гомбосүрэн.М, Мишигдорж.Ц. Татварын зөрчлийг шийдвэрлэх нь. УБ., 2011.
 15. ЗХХШтХ-ийн тайлбар. Монгол Улсын Дээд шүүх, Ханнас-Зайделийн сан. УБ., 2012.
 16. Хонинхүү.М. Захиргааны илт хууль бус актад гомдол гаргах асуудал. Эрх зүй сэтгүүл. 2013 №3 (25).
 17. Хуульчид, оюутан, судлаач, практикийн ажилтанд зориулсан гарын авлага., Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн.УБ., 2004.
 18. Захиргааны хэргийн шүүх цуврал гарын авлага №11., Захиргааны акт. УБ., 2007.
 19. Захиргааны хэргийн шүүх цуврал гарын авлага №6., Гадаад орнуудын захиргааны хэргийн шүүх. УБ., 2005.
 20. Татварын эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. УБ., 2011.
 21. Монгол Улсын шүүхийн тайлан. Шүүхийн ерөнхий зөвлөл. УБ., 2014, 2015, 2016

ХОЁР. Гадаад эх сурвалж

1. Verwaltungsverfahrensgesetz
2. Abgabenordnung(AO) von Deutsche
3. И.Рихтер, Г.Ф. Шупперт. Судебная практика по административному праву. М., 2000.
4. Bundesgericht. VersR 1979.
5. Dieter Birk, Steuerrecht 13 Auflage, 2011

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН СУДАЛГАА

Ч.Наранчимэг

СЭЗИС-ийн ХМСТ-ийн профессор, Доктор (PhD)

С.Бямбахоорлоо

СЭЗИС-ийн санхүү эрхэлсэн дэд захирал, дэд профессор, Доктор (PhD)

Abstract. It has been about 28 years since Mongolia moved into market economy and the transition required to renew policies on tax. In the meantime, tax package laws have emerged and new tax forms have been created. Taxes create state budget revenues and become a crucial tool to implement social policies. Particularly, personal income tax is an appropriate tax to manage unequal distribution of income in the country. Most of the countries have graduated personal income tax system which decreases gap between the rich and the poor in society and supports livelihood level of those with less income. Regarding the joint program with IMF for increasing budget revenues, Government of Mongolia prepared initiative to increase 7 types of taxes. The initiative approved by the Parliament and became effective from 1 January 2018. This study was carried out before the initiative takes in place and the purpose was to identify what kind of inaccuracy can be come out regarding the changes in the law. The study considers that who is a personal income tax payer, what is the tax payers' attitude, current situation of tax environment and practices and lessons learned of personal tax income in some countries.

Key words: Tax, Personal income tax, tax payer, taxable income, employment income, personal income, tax rate/amount

Хураангуй. Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсон цаг үеэс татварын бодлогыг шинээр тодорхойлох шаардлага урган гарсан бөгөөд тэр цаг үеэс хойш эдүгээ 28 орчим жил өнгөрчээ. Энэ хооронд татварын багц хуулиуд гарч, татварын шинэ төрлүүд бий болсон. Албан татварууд нь улсын төсвийн орлогыг бүрдүүлэхээс гадна нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл болдог. Ялангуяа хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) нь тухайн улс орны иргэдийн орлогын тэгш бус хуваарилалтыг зохицуулахад тохиромжтой татвар юм. Дэлхийн нэлээдгүй улс орнууд ХХОАТ-ын шаталсан тогтолцоотой байдаг ба энэхүү тогтолцоо нь нийгэм дэх баян, ядуугийн эрс зөрүүг багасган, бага орлоготой иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулахад чиглэгддэг. Манай улс төсвийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор ОУВС-тай хамтарсан хөтөлбөрийн дагуу Засгийн газраас долоон төрлийн татварыг нэмэгдүүлэх шийдэл боловсруулж УИХ-ын чуулганаар батлуулсан билээ. Энэхүү долоон төрлийн татвар дотор ХХОАТ-ыг нэмэгдүүлэх буюу шатлалтай болгох шийдэл батлагдан 2018 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн боловч тун удалгүй энэ шийдэл цуцлагдан хуучин татварын системээ дахин хэрэгжүүлж эхэлсэн. ХХОА татварыг шатлалтай болгосон шийдвэр хэрэгжиж эхлэхээс өмнө энэ хуулийн шинэчлэл дээр ямар алдаа үүсч болзошгүйг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааны ажил хийгдсэн бөгөөд тус өгүүлээр Монгол Улсын хувь хүний орлогын албан татвар төлөгч гэж хэнийг хэлэх, татварын шинэчлэлтэй холбоотойгоор татвар төлөгч иргэдийн хандлага ямар байсан болон татварын орчны өнөөгийн байдал, зарим улс орны хувь хүний орлогын албан татварын талаарх туршлага, сургамж зэргийг авч үзсэн болно.

Түлхүүр үгс: Албан татвар, ХХОАТ, албан татвар төлөгч, албан татвар ногдох орлого, хөдөлмөр эрхлэлтийн орлого, хувь хүний орлого, албан татварын хувь/хэмжээ

ОРШИЛ

Манай улс төсвийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор ОУВС-тай хамтарсан хөтөлбөрийн дагуу Засгийн газраас долоон төрлийн татварыг нэмэгдүүлэх шийдэл боловсруулж УИХ-ын чуулганаар батлуулан, үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн билээ. Энэхүү долоон төрлийн татвар дотор ХХОАТ-ыг нэмэгдүүлэх буюу шатлалтай болгох шийдэл батлагдан 2018 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн боловч тун удалгүй энэ шийдэл цуцлагдан хуучин татварын системээ дахин хэрэгжүүлж эхэлсэн. ХХОАТ-ын шатлал нь төсвийн орлогыг 110 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх зорилготой байсан ба сарын орлогоос хамааран 1'500'000 (нэг сая таван зуу мянга) хүртэл төгрөгийн цалинтай хүний хувь хүний орлогын татвар 10% буюу хуучин хэвээр, 1'500'000 – 2'500'000 (нэг сая таван зуу мянгаас хоёр сая таван зуу мянга) төгрөгийн цалинтай хүний хувь хүний орлогын татвар 15%, 2'500'000 – 3'500'000 (хоёр сая таван зуу мянгаас гурван сая таван зуу мянга) төгрөгийн цалинтай хүний хувь хүний орлогын татвар 20%, 3'500'000 (гурван сая таван зуу мянга)-аас дээш төгрөгийн цалинтай хүний

хувь хүний орлогын татвар 25% байхаар төлөвлөгдсөн. Энэхүү цалингийн шатлал нь нийгмийн даатгалын шимтгэл (НДШ), эрүүл мэндийн даатгалын шимтгэл (ЭМДШ)-ийг хассан дүн буюу татвар ногдуулах орлогын хэмжээ юм. Нийт татвар төлөгч иргэдийн 20 орчим хувь нь 1.5 саяаас дээш төгрөгийн цалинтай гэх боловч энэхүү татварын шатлал нь ямар судалгаан дээр үндэслэсэн эсэх нь тодорхойгүй, татварын ерөнхий зарчмыг алдагдуулсан, логик үндэслэл муутай байсан төдийгүй нийгмийн дундаж давхаргад дарамт үүсгэсэн, иргэдийн халаас руу шууд дайрсан шинэчлэл болсон. Иймд бид энэхүү татварын хуулийн шинэчлэл дээр ямар алдаа үүсч болзошгүйг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийсэн бөгөөд Монгол Улсын хувь хүний орлогын албан татвар төлөгч гэж хэнийг хэлэх, татварын шинэчлэлтэй холбоотойгоор татвар төлөгч иргэдийн хандлага ямар байсан болон татварын орчны өнөөгийн байдал, зарим улс орны хувь хүний орлогын албан татварын талаарх туршлага, сургамж зэргийг авч үзсэн болно.

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Хувь хүний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбоотой аливаа харилцаа нь 2016 оны 6-р сарын 16-ны өдөр батлагдсан “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-аар зохицуулагддаг. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд “Төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тухайн жилд төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын

тэнцлийг Монгол Улсын нэгдсэн төсөв” гэнэ гэж заасан байдаг. Хувь хүний орлогын албан татвар нь дундажаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 8 орчим хувийг бүрдүүлдэг.

Монгол Улсын “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-ийн II бүлэгт албан татвар төлөгч гэж хэнийг хэлэх тухай нарийвчлан зааж хуульчилсан байдаг. Тухайлбал, тухайн татварын жилд албан татвар ногдох орлого олсон, эсхүл тийм орлого олоогүй

ч хуульд заасны дагуу албан татвар төлөх үүрэг бүхий Монгол Улсад оршин суугч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна. (Эх сурвалж: ХХОАТ-ын хуулийн 5.1 заалт) Албан татвар төлөгчийг Монгол Улсад байнга оршин суугч болон оршин суугч бус албан татвар төлөгч гэж ангилна.

Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгч гэж Монгол Улсад оршин суух байртай, тухайн татварын жилд 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад амьдарсан иргэн (Монгол Улсын хилээр орсон өдрөөс хуанлийн хоногоор тоолох бөгөөд олон удаа орж гарсан тохиолдолд албан татвар төлөгчийн Монгол Улсад байсан хоногийн нийлбэрээр тодорхойлно), мөн гадаад улсад томилогдон ажиллаж байгаа Монгол Улсын төрийн албан хаагч иргэнийг хэлнэ. Харин Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн үндэстний байгууллага, түүний

салбарт томилогдон ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүд нь Монгол Улсад оршин суугчид хамаарахгүй болно. (Эх сурвалж: ХХОАТ-ын хуулийн 6-р зүйл заалт)

Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч гэж Монгол Улсад оршин суух байргүй, тухайн жилд 183 ба түүнээс дээш хоног Монгол Улсад оршин суугаагүй хувь хүнийг хэлнэ. Оршин суугч бус албан татвар төлөгчийн Монгол Улсад байсан хугацааг Монгол Улсын хилээр орсон өдрөөс хуанлийн хоногоор тоолох бөгөөд олон удаа орж гарсан тохиолдолд Монгол Улсад байсан хоногийн нийлбэрээр тодорхойлно. (Эх сурвалж: ХХОАТ-ын хуулийн 7-р зүйл заалт)

Албан татвар төлөгч иргэний албан татвар ногдох орлого, албан татвараас чөлөөлөх орлого зэргийг ХХОАТ-ын хуулийн III, IV бүлэгт хуульчилан заасан байдаг бөгөөд хуулийн дагуу иргэд татвараа төлж бүртгэл хийлгэн албажуулах үүрэгтэй.

ТАТВАР ТӨЛӨГЧ ИРГЭДИЙН ХАНДЛАГЫН СУДАЛГАА


Татвар төлөгч иргэдийн хандлагыг тодрхойлох зорилгоор сошиалаар судалгаа авсан. Нийтдээ 6324 хүн судалгаанд хамрагдсан бөгөөд эдгээрийн 61% нь өнөөгийн татварын орчин тааламжгүй байгаа талаар, 86% нь татварын шинэчлэлийг дэмжихгүй, 45% нь хувь хүний орлогын татварын шатлал хэрэгжиж эхэлвэл татвараас зайлсхийх болон төлөхгүй байх талаар санаа бодлоо илэрхийлсэн. Мөн 2017 онд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим болон МУИС-ийн Бизнесийн сургуулийн судлаачдын хамтран хийсэн "Монголын бизнесийн орчны судалгаа"-аар судалгаанд оролцогсдын 57.5% нь татварын орчин тааламжгүй гэж дүгнэсэн байна. Энэ

нь дээрх судалгааг мөн бататгаж байгаа билээ.

Улсын төсвийн орлогод ХХОАТ-ын эзэлж буй хувь хэмжээний 2006-2017 оны 12 жилийн динамикаас харахад дундажаар 6.74%, хамгийн ихдээ 9.7%, хамгийн багадаа 4% байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлт 8.4% байна.

Улсын татварын орлогод ХХОАТ-ын эзэлж буй хувь хэмжээний 2006-2017 оны 12 жилийн динамикаас харахад дундажаар 8.06%, хамгийн ихдээ 11.5%, хамгийн багадаа 5% байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлт 10.05% байна.

Зураг 1. Манай улсын ХХОАТ-ын төсөв, татварын орлогод эзлэх хувь



Эх сурвалж: УСХ, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

ХХОАТ-ын орлогын бүтцийн 2006-2016 оны 11 жилийн динамикаас цалин, түүнтэй адилтгах орлого, аж ахуй эрхэлсний орлого гэсэн 2 төрлөөс зөвхөн ХХОАТ бүрдэж байна гэж

дүгнэж болохоор байна. Иймд цаашид бусад төрлийн орлогын бүртгэлийг тодорхой болгож, улмаар татвар авах үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 1. Манай улсын ХХОАТ-ын орлогын бүтэц

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Жишгээр ногдуулсан татвар	1.0%	1.3%	1.0%	1.1%	0.9%	0.6%	0.5%	0.4%	0.3%	0.3%	0.0%
Малчин, мал бүхий иргэд	3.4%	3.8%	3.0%	1.6%	0.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Патент	2.1%	2.6%	1.7%	1.7%	1.5%	1.3%	0.9%	0.8%	0.7%	0.7%	0.0%
Цалин, түүнтэй адилтгах орлого	90.9%	97.7%	91.5%	93.2%	94.6%	95.2%	95.3%	96.1%	93.0%	93.8%	93.2%
Аж ахуй эрхэлсний орлого	2.6%	4.5%	2.8%	2.4%	2.9%	2.9%	3.4%	2.7%	6.0%	5.3%	6.8%
Нийт дүн	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%

ХХОАТ-ЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Улс орны хөгжлийн түвшин нэмэгдэхийн хэрээр хувь хүний орлогын албан татварын хувь хэмжээ дагаад

нэмэгдэх ёстой гэсэн үзэл баримтлал байдаг хэдий ч хөгжлийн түвшин ойролцоо улс орнуудын хувьд ХХОАТ-

ын хувь хэмжээ харилцан адилгүй байсаар байна. Бид энэ хэсэгт жишээ болгон Турк, Япон улсын ХХОАТ-ын тухай авч үзэх болно.

- Турк улсын ХХОАТ

Турк улс нь 2014 оны 12-р сарын 30-ны өдөр ХХОАТ-аа шинээр тогтоосон. Турк улсын байнгын оршин суугч нарын ХХОАТ нь дотоод болон гадаадын орлогуудаасаа тооцогддог бол түр оршин суугч нарын ХХОАТ нь зөвхөн дотоодын цалин болон цалингаас гадуурх орлогоосоо бодогддог байна. Турк улсын иргэдийн орлогыг төгрөгт

шилжүүлэн тооцоолвол Т 8'049'786 (найман сая дөчин есөн мянга долоон зуун наян зургаа) хүртэлх цалингийн орлогын татвар 15%, Т 8'049'786-аас Т 18'577'370 (найман сая дөчин есөн мянга долоон зуун наян зургаас арван найман сая таван зуун далан долоон мянга гурван зуун дал)-ын хооронд багтаж байгаа цалингийн орлогын татвар 20%, Т 18'577'370 (арван найман сая таван зуун далан долоон мянга гурван зуун дал)-аас Т 68'116'208 (жаран найман сая нэг зуун арван зургаан мянга хоёр зуун найм) хүртэлх цалингийн орлогын татвар 27%, түүнээс дээш цалинтай бол 35%-ийн татвар тооцогддог байна.

Хүснэгт 2. Турк улсын ХХОАТ-ын хувь хэмжээ (Хөдөлмөр эрхлэлтийн орлого)

Интервал		Татварын хувь хэмжээ	Интервалын урт (хэвтээ чиглэлд)	Интервалын урт (босоо чиглэлд)
Доод хил	Дээд хил			
Т 1	Т 8'049'786	15%	Т 8'049'785	-
Т 8'049'786	Т 18'577'370	20%	Т 10'527'584	Т 10'527'584
Т 18'577'370	Т 68'116'208	27%	Т 49'538'838	Т 49'538'838
Т 68'116'208	Дээш	35%	-	-

Эх сурвалж: taxsummaries.pwc.com

Турк улсын иргэдийн хөдөлмөр эрхлэлтээс бусад төрлийн орлогыг төгрөгт шилжүүлэн тооцоолвол Т 8'049'786 (найман сая дөчин есөн мянга долоон зуун наян зургаа) хүртэлх орлогын татвар 15%, Т 8'049'786-аас Т 18'577'370 (найман сая дөчин есөн мянга долоон зуун наян зургаас арван найман сая таван зуун далан долоон мянга гурван

зуун дал) хүртэлх орлогын татвар 20%, Т 18'577'370 (арван найман сая таван зуун далан долоон мянга гурван зуун дал)-аас Т 43'345'566 (дөчин гурван сая гурван зуун дөчин таван мянга таван зуун жаран зургаа) хүртэлх орлогын татвар 27%, түүнээс дээш орлоготой бол 35%-ийн татвар тооцогддог байна.

Хүснэгт 3. Турк улсын ХХОАТ-ын хувь хэмжээ (Хөдөлмөр эрхлэлтээс бусад төрлийн орлого)

Интервал		Татварын хувь хэмжээ	Интервалын урт (хэвтээ чиглэлд)	Интервалын урт (босоо чиглэлд)
Доод хил	Дээд хил			
Т 1	Т 8'049'786	15%	Т 8'049'785	-
Т 8'049'786	Т 18'577'370	20%	Т 10'527'584	Т 10'527'584
Т 18'577'370	Т 43'345'566	27%	Т 24'768'196	Т 24'768'196
Т 43'345'566	Дээш	35%	-	-

Эх сурвалж: taxsummaries.pwc.com

Турк улсын хувьд Т 18'577'370 (арван найман сая таван зуун далан долоон мянга гурван зуун дал) хүртэлх цалин болон цалингаас гадуурх орлогын татварын хувь нь ижил байдаг байна. Харин цалингаас гадуурх орлого Т 43'345'566 (дөчин гурван сая гурван зуун дөчин таван мянга таван зуун жаран зургаа) -аас давсан тохиолдолд ногдох татвар 35% байна.

- Япон улсын ХХОАТ

Япон улс нь албан татвар төлөгчөө түр оршин суугч, удаан хугацааны бус оршин суугч, байнгын оршин суугч гэж 3 ангилан, орлогыг нь төрөлжүүлэн татвар ногдуулдаг. Япон улсын иргэдийн орлогыг төгрөгт шилжүүлэн тооцоолвол Т 42'912'624 (дөчин хоёр сая есөн зуун арван хоёр мянга зургаан зуун хорин дөрөв) хүртэлх цалингийн орлогын татвар 5%, Т 42'912'624-өөс Т 72'621'740 (дөчин хоёр сая есөн зуун арван хоёр мянга зургаан зуун хорин дөрвөөс далан хоёр сая зургаан зуун хорин нэгэн мянга

долоон зуун дөч)-ийн хооронд багтаж байгаа цалингийн орлогын татвар 10%, Т 72'621'740 (далан хоёр сая зургаан зуун хорин нэгэн мянга долоон зуун дөч)-өөс Т 152'945'934 (нэг зуун тавин хоёр сая есөн зуун дөчин таван мянга есөн зуун гучин дөрөв) хүртэлх цалингийн орлогод 20%, Т 152'945'934 (нэг зуун тавин хоёр сая есөн зуун дөчин таван мянга есөн зуун гучин дөрөв)-өөс Т 198'059'958 (нэг зуун ерэн найман сая тавин есөн мянга есөн зуун тавин найм) хүртэлх цалингийн орлогод 23%, Т 198'059'958 (нэг зуун ерэн найман сая тавин есөн мянга есөн зуун тавин найм)-аас Т 396'119'916 (гурван зуун ерэн зургаан сая нэг зуун арван есөн мянга есөн зуун арван зургаа) хүртэлх цалингийн орлогод 33%, Т 396'119'916 (гурван зуун ерэн зургаан сая нэг зуун арван есөн мянга есөн зуун арван зургаа)-аас Т 880'266'480 (найман зуун наян сая хоёр зуун жаран зургаан мянга дөрвөн зуун наян) хүртэлх цалингийн орлогод 40%, түүнээс дээш цалинтай бол 45%-ийн татвар тооцогддог байна.

Хүснэгт 4. Япон улсын ХХОАТ-ын хувь хэмжээ (Улсын цалингийн орлого)

Интервал		Татварын хувь хэмжээ	Хасагдах хэмжээ	Интервалын урт (хэвтээ чиглэлд)	Интервалын урт (босоо чиглэлд)
Доод хил	Дээд хил				
Т 1	Т 42'912'624	5%	-	Т 42'912'623	-
Т 42'912'624	Т 72'621'740	10%	Т 2'145'142	Т 29'709'116	Т 29'709'116
Т 72'621'740	Т 152'945'934	20%	Т 9'407'316	Т 80'324'194	Т 80'324'194
Т 152'945'934	Т 198'059'958	23%	Т 13'996'012	Т 45'114'024	Т 45'114'024
Т 198'059'958	Т 396'119'916	33%	Т 33'801'274	Т 198'059'958	Т 198'059'958
Т 396'119'916	Т 880'266'480	40%	Т 61'529'130	Т 484'146'564	Т 484'146'564
Т 880'266'480	Дээш	45%	Т 105'542'454	-	-

Эх сурвалж: taxsummaries.pwc.com

Япон улсын хувьд 7 шатлалтайгаар ХХОАТ ногдуулдаг байх бөгөөд түр оршин суугч иргэнд жилээс бага хугацаанд амьдарч байгаа хүмүүс, удаан хугацааны бус оршин суугч иргэнд 5-аас доош жил амьдарсан, Японд

удаан хугацаагаар амьдрах сонирхолгүй хүмүүс орох ба байнгын оршин суугч иргэний ангилалд Японд дор хаяж 5 жил амьдарсан, цаашид үргэлжлүүлэн урт хугацаагаар амьдрах төлөвтэй байгаа хүмүүс багтдаг байна.

ДҮГНЭЛТ

- Хөдөлмөр эрхлэлтийн орлого буюу цалингийн орлогоо нуун дарагдуулах замаар НДШ болон хувь хүний орлогын албан татвараа багасгаж төлөх магадлалтай байна.
- Татвар төлөгч иргэдийн хандлагын судалгаанаас харахад нийт ард иргэдийн дунд татвар төлөх сэтгэлгээ төлөвшөөгүй, татвараас зайлсхийх хандлага өндөр байна гэж дүгнэж болохоор байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн орлогоос өөр бусад орлогоор тайлагнах замаар татвараас зайлсхийх боломжтой байна. Тухайлбал, ажил олгогчоос өгдөг хоолны мөнгө, хамтран ажиллах гэрээний орлого, нэг удаагийг тусламж гэх мэт.
- Тухайн хуулийн шатлалын интервал хэт ойр буюу нэг сая хүртэлх төгрөг байгаа нь одоогийн нөхцөл байдалд тохирохгүй байна. Хэрвээ шатлалтай татварын бодлого хэрэгжүүлэх тохиолдолд хэвтээ болон босоо чиглэлийн интервалын уртыг ихэсгэх, тооцоо судалгаанд үндэслэх хэрэгтэй.
- ОУ-ын жишиг болон шатлалтай татварын бодлогын хүрээнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болон дээд хэмжээг харгалзан шатлалыг тогтоодог байна.
- Ам бүлийн гишүүдийн тоо болон бусад хүчин зүйлийн нөлөөллийг тооцоогүй байна. Өөрөөр хэлбэл, өрхийн ам бүлийн тоо, ажил эрхэлж буй өрхийн гишүүний тоо, тэжээлгэгч иргэдийн тоо зэргийг харгалзан авч үзэх хэрэгтэй.
- Хөдөлмөрийн бүтээмж, мэдлэг ур чадвар, илүү цагаар хөдөлмөрлөх гэх мэт хүчин зүйлсийг заавал хамааруулан авч үзэх шаардлагатай.
- ХХОАТ-ын шинэчлэлийн хүрээнд бодит хэрэглээний зардлыг огт тооцож үзээгүй байна гэж дүгнэж болохоор байна. Тодруулбал, анхдагч хэрэгцээгээ хангах болон хүүхдийн боловсрол, орон сууцны зээл гэх мэт.
- Онолын хувьд аж ахуйн ашгийн татвараас хувь хүний орлогын албан татвар өндөр байх боломжгүй юм.
- Хөдөлмөр эрхлэлтийн орлого буюу цалингаас бусад төрлийн хувь хүний олж байгаа орлогоос одоогоор татвар авч чадахгүй байна. Хэрэв орлогыг тэгшитгэх бодлого барьж, ялгаатай татвар авч байгаа бол ногдол ашгийн татвар, түрээсийн орлого, гавъяа шагналын орлого, спорт урлагийн оддын орлого гэх мэт орлогоос шатлалаар татвар авах нь зүйтэй болов уу.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
2. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, МУИС-ийн Бизнесийн сургууль "Монголын бизнесийн орчны судалгаа", УБ 2017 он
3. Б.Сувдаа "Хувь хүний орлогын албан татвар ногдуулалтыг сайжруулах нь", УБ 2016 он
4. ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"
5. Монгол Улсын Их Хурлын вэб сайт <http://www.parliament.mn/>
6. Сангийн яамны шилэн дансны цахим хуудас
7. Татварын Ерөнхий газрын вэб сайт <http://www.mta.mn>
8. Жайка ОУ-ын байгууллага, ТЕГ-ын хамтран хэрэгжүүлсэн төслийн тайлан. УБ 2016 он
9. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: www.1212.mn
10. Worldwide Tax Summaries вэб сайт: <http://www.pwc.com>

МОНГОЛЫН УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ШИНЭ УЛС ТӨРИЙН МАКРОЭКОНОМИКСИЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ

Ц.Батсүх

СЭЗИС-ийн Экономиксийн тэнхимийн профессор,
Монгол банкны мөнгөний бодлогын зөвлөлийн хараат бус гишүүн, доктор (Ph.D),

С.Өнөр

СЭЗИС-ийн Экономиксийн тэнхимийн багш (MBA),

Abstract. Since the 1970s, the research on the interaction between politics and macroeconomics has expanded vigorously. In this paper, we investigated the interaction between macroeconomic key variables of along with six parliamentary elections and consequent government policies in Mongolia from 1991 to 2017. More precisely, we addressed whether Mongolian political parties have opportunistic or partisan behavior. The main results are (1) after 2008, political parties have shown more opportunistic behavior, (2) however, the opportunistic action does not affect election results, (3) incumbent party has disadvantage on the upcoming election and (5) finally changing prime minister has a negative outcome for the incumbent party.

Key words: Partisan, Opportunistic behavior, New Political Macroeconomics, Manipulation, Political business cycle.

Хураангуй. Сүүлийн дөч гаруй жилийн хугацаанд улс төр болон макро эдийн засгийн хоорондын харилцан хамаарлын төрөл бүрийн хэлбэрүүдийн талаарх судалгаа эрчимжин, макроэкономикс, нийтийн сонголтын онол, тоглоомын онолын уулзварт “шинэ улс төрийн макроэкономикс” хэмээх эдийн засгийн онолын шинэ сургаал хөгжиж байна. Энэ чиглэлийн эдийн засагчид эдийн засгийн шинжилгээний орчин үеийн арга хэрэгслийг ашиглан, төрийн бодлогын талаар тоон судалгааг хийх аргагүйг хөгжүүлсэн болно.

Бид энэхүү өгүүлэлдээ Монгол Улсын 1991-2017 оны макро эдийн засгийн тоон мэдээлэл болон УИХ-ын сүүлийн 6 сонгуулийн үр дүн, эрх барьж байсан улс төрийн хүчнүүдийн бодлого, шийдвэрүүдийг ашиглан Хиббсийн тууштай дэмжигчийн хийгээд Нордхаусын ашигч үйл хөдлөлийн загварын үндсэн нөхцөлүүдийг шалгасан. Судалгааны үр дүнд 2008 оны сонгуулиас хойш улс төрийн намууд ашигч үйл хөдлөл хийх сэдэл эрчимжсэн болохыг тогтоов. Ашигч үйл хөдлөл нь сонгуулийн амжилтад богино хугацаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй байгаа хэдий ч Засгийн газрын үе хоорондын төсвийн хязгаарлалтын асуудлыг үүсгэж, санхүүжүүлсэн зардлын хөтөлбөрүүд нь ирээдүйн татварын дарамтын шалтгаан болох талтайг тогтоосон болно.

Түлхүүр үгс: Тууштай дэмжигч үйл хөдлөл, ашигч үйл хөдлөл, шинэ улс төрийн макроэкономикс, Манипуляци, Улс төрийн бизнесийн мөчлөг

НЭГ. СУДААГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

Төр эдийн засагт хэрхэн нөлөөлөх тухай үе, үеийн эдийн засагчид анхаарлаа хандуулж иржээ. Адам Смитээс эхлэлтэй сонгодог эдийн засагчид эдийн засаг дахь төрийн оролцоог дэмждэггүй. Хувь хүн бүрийн оновчтой үйл хөдөл үл үзэгдэх гараар зохицон нийгэмд үр ашигтай тэнцвэрийг бий болгоно гэж үздэг. (Smith, 1776)

Гэвч сонгодог эдийн засагчдийн *laissez-faire* зарчим 1929-1932 оны Их хямралын дараагаас үндсэндээ эвдэгдсэн юм. Их хямралыг сонгодог онолын суурь санаагаар тайлбарлах боломж нэн хомс байлаа. Улмаар 1936 онд Жон Кейнс үр ашигтай эрэлтийн механизм, тэр дундаа сангийн бодлогыг идэвхтэй ашиглаж, эдийн засгийг бүрэн ажил эрхлэлтэд хөтлөх ёстой гэх үзэл санааг дэвшүүлснээр 20-р зууны эхний хагаст төрийн эдийн засгийн оролцоог зөвтгөх болов (Keynes, 1937). Үр дүнд нь, Дэлхийн хоёрдугаар дайны дараагаас эдийн засаг дахь төрийн оролцоо дэлхийн бүх улс оронд мэдэгдэхүйц өссөн юм (Snowdon & Vane, 2005). Кейнсч загварт төрийг нийгмийн


төлөвлөгч бөгөөд нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн их байлгах зорилготой гэж таамагладаг (Tinbergen 1952), (Theil 1958). Кейнсийн экономикс эрчээ алдсан 1970-аад оноос энэхүү буяналаг, халамжлагч төрийн тухай таамаглалд эргэлзэх нь хүчтэй болжээ.

1975 онд Уиллям Нордхаус макро эдийн засгийн хувьсагчдын өөрчлөлт нь улс төрөөс шалтгаалдаг тухай санааг дэвшүүлж, макро эдийн засгийн аналитик загвар босгожээ. (Nordhaus 1975) Хэдийгээр төрийн төгс бус байдлын талаар Нордхаусаас өмнөх үеийн судлаачид тухайлбал, Калецки (1946), Акерман (1947) нар дурдаж байсан ч Нордхаус анхны системтэй, ач холбогдол бүхий тайлбар өгчээ. Энэ нь шинэ улс төрийн макроэкономиксийн эхлэл байв. Үүнээс хойш улс төрийн үйл хөдлөлийг (1) ашигч, (2) тууштай дэмжигч, (3) холимог гэх гурван чиглэлээр загварчилсан байна. Эдгээр загваруудын талаар товч тоймлон авч үзье.

1.1 Ашигч үйл хөдлөл буюу Нордхаусын загвар

Энэ загварт улс төрчдийн гол зорилго нь нийгмийн сайн сайхан байдлын функцийг хамгийн их утгатай байлгах бус, харин дахин сонгогдох хүсэлдээ хөтлөгдөх явдал гэж авч үздэг. Мөн сонгогчид хоорондоо адилшсан шинжтэй (Downs, 1957), аль нэг үзэл бодлыг дагаж туйлширдаггүй. Цаашлаад сонгогчид харьцангуй мартамхай учраас эрх баригч сонгуульд дахин ялахын тулд ашигч үйл хөдлөл буюу эдийн засгийн манипуляци хийдэг.

Сонгуулийн өмнө санаатайгаар хийсэн манипуляцийн (V_2 саналтай G цэгээс V_1 саналтай E_1 -д шилжих) шилжих механизм нь ажилгүйдэл, инфляцийн мөчлөг үүсгэдэг. Иймээс G цэгтэй харьцуулахад ажилгүйдэл багатай, харин инфляци өндөртэй төлөв рүү шилжүүлэлт хийгдэнэ.



Эх сурвалж: (Snowdon & Vane 2005, x.529)

Зурагт харуулсан V график нь санал авах боломжууд ба $V_1 > V_2 > V_3 > V_4$ байна. S график нь богино хугацааны Филлипсийн муруйг илтгэнэ

1.2 Тууштай гэмжигч үйл хөдлөл буюу Хиббсийн загвар

Сонгогчид үзэл бодлын хувьд хуваагдмал гэж үзнэ. Зүүний нам ажилгүйдлийн нам дор, харин барууны нам инфляцийг нам дор барих сонирхолтой.

Улс төрийн нам үзэл суртлынхаа дагуу бодлогоо явуулна. Эрх баригч нам сонгуульд ялагдаж, сөрөг хүчин засгийн эрхэд гарвал намын үзэл баримтлалаас үүдэн улс төрийн бизнесийн мөчлөг үүснэ. Нэгдсэн Вант Улс болон АНУ-ын эдийн засагт сангийн бодлогоос бусад хувьсагчдын хувьд ашигч үйл хөдлөлийн нөлөө сул, харин тууштай дэмжигч үйл хөдлөл хүчтэй нөлөөтэй байдаг гэж дүгнэжээ. (Alesina, 1995) Зүүн чигийн нам L цэгт, харин баруун чигийн нам R цэгт сонголт хийдэг.

1.3 Ашигч болон тууштай гэмжигч үйл хөдлөлийн нэгдэл (Фрей ба Шнайгер 1978)


Хэрвээ эрх баригч ялна гэдэгтээ итгэлтэй бол тууштай бодлого баримталдаг, харин ялах эсэх нь эргэлзээтэй (тухайлбал эдийн засгийн нөхцөл байдал тааруу) бол ашигч үйл хөдлөл хийх хандлагатай гэж үзжээ.

Инфляци, ажилгүйдэл зэрэг зорилгын хувьсагч нь хэт богино хугацаанд өөрчлөгдөх боломж багатай тул ашигч үйл хөдлөлийг засгийн газрын арга хэрэгсэл гэх хувьсагчаар тайлбарлах нь зохимжтой гэж дүгнэдэг. Үүнд нь батлан хамгаалахаас бусад засгийн газрын зардал, шилжих төлбөр, төрийн албан хаагчдын ажлын байрны тоог багтаасан байна.

"Засгийн газар эдийн засагт хэр их манипуляци хийх нь намын тухайн үеийн санал асуулгаар тодруулсан нэр хүндтэй сөрөг хамааралтай" гэсэн таамаглалыг Их Британид шалгаж, сөрөг хамаарал байгааг нь тогтоожээ. (Schultz, 1995)

ХОЁР. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА

Эдийн засаг дахь бизнесийн мөчлөгийн нэг шалтгаан нь улс төртэй холбоотой болохыг 40 гаруй жилийн өмнөөс онолын үндэслэлтэй тайлбарлах болсон. Хиббсийн үндэслэлээр улс төрийн намууд өөрийн үзэл баримтлалдаа үнэнч байж, зүүний болон барууны чиг баримжаатай эдийн засгийн бодлого ээлжлэн явуулснаар эсвэл Нордхаусын тайлбарласнаар дахин сонгогдох хүсэлдээ хөтлөгдөн намууд сонгуулийн өмнө санал авах зорилгоор ашигч үйл хөдлөл хийснээр улс төрийн бизнесийн мөчлөг үүсдэг.



Эх сурвалж: (Snowdon & Vane 2005, x.533)

LL муруй зүүний намын таашаал буюу бага ажилгүйдэл, RR муруй нь барууны намын таашаал буюу бага инфляцийг харуулна.

Эдийн засгийн идэвхжил технологийн инновацийн өөрчлөлтийн 54 жилийн үетэй Кондратиевын долгионоос аваад жилийн доторх сар, улирлын онцлогоос хамаарсан хэлбэлзэлд байнга өртдөг. Тэдгээрээс эрдэс бүтээгдэхүүний үнийн 18 жилийн үетэй, цаг хугацааны тооллын онцлогтой холбоотой 5 эсвэл 10 жилийн хугацаатай хэлбэлзлүүд оршин байдгийг техник шинжилгээнд авч үздэг.

Эдгээрээс гадна улс төрийн сонгуулийн хугацаатай холбоотой

4 жилийн урттай мөчлөг байдгийг тогтоосон байна. Ийм мөчлөг оршин байгааг илрүүлэх хамгийн энгийн арга нь 4 цэгийн шилжүүлэн дундажлах арга юм. Энэ аргаар мөчлөгийг ялгасны дараа төр барих хугацаанд улс төрийн намууд эдийн засгийн ямар бодлого явуулсныг илэрхийлэх бололцоотой гэж үзэв.

Ашигч үйл хөдлөл хийж

Бүдүүвч 1. Засгийн газрын манипуляцийн шалтгаан болон үр дагавар



Сонгуулийн амжилт төрийн эрх барьж байх хугацааны нийт эдийн засгийн нөхцөл байдлаас болон засгийн эрх барьж буй улс төрийн хүчний нэр хүнд, засгийн газрын тогтвортой байдлаас хамаардаг болохыг энэ чиглэлийн судалгаанд авч үздэг. Хэрвээ эдийн засаг, улс төрийн байдал тааруу байсан бол дахин сонгогдохын тулд

байгааг техник шинжилгээний аргаас гадна олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээний аргаар тогтоож болохыг зарим судалгаанд авч үзсэн байна. Ашигч үйл хөдлөл хийхэд хүргэх шалтгаан нь сонгуулийн өмнөх үеийн эдийн засгийн өсөлт, инфляци, ажилгүйдэл, валютын ханш зэрэг болно. Дараах бүдүүвчийн дагуу ашигч үйл хөдлөлийн хүчин зүйлсийн шинжилгээг хийв.

манипуляци хийх шаардлага илүүтэй гардаг. Өөрөөр хэлбэл сонгуулийн өмнө эрх барьж буй хүчин өөрийн алдааг далдах, сонгогчдын сэтгэлийг татах, нөгөө талаас сөрөг хүчний үзэл суртлын дайралтаас хамгаалах зорилгоор сангийн бодлогын арга хэрэгслүүдээр хурдан хугацаанд эдийн засагт нөлөөлөх оролдлогыг хийдэг.

2. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

Шинжилгээний хэсэгт бид Хиббсийн тууштай дэмжигчийн болон Нордхаусын ашигч үйл хөдлөлийн онол, загваруудаар Монгол Улсын улс төр,

эдийн засгийн нөхцөл байдлыг хэрхэн тайлбарлаж болох үндэслэлийг тогтоох зорилго тавив.

2.1 ХИББСИЙН ТУУШТАЙ ҮЙЛ ХӨДЛӨЛИЙН ЗАГВАРЫН ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭ



Хиббсийн тууштай дэмжигч үйл хөдлөлийн онолд намууд өөр, өөрийн үзэл баримтлалдаа үнэнч байх бөгөөд эдгээр намууд төр ээлжлэн барьсан тохиолдолд эдийн засагт улс төрийн мөчлөг үүсэх нөхцөл бүрдүүлдэг хэмээн үздэг. Зүүний чигийн үзэл баримтлалтай нам нийгмийн асуудалд

илүү анхаарал хандуулдаг тул ажилгүйдлийг багасгахад, барууны нам эдийн засгийн эрх чөлөөг илүү эрхэмлэн инфляцийг нам түвшинд байлгахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Энэ шинж манай улсын хувьд илэрч байна уу гэдгийг ажилгүйдэл, инфляцийн мэдээлэлд тулгуурлан харуулья.

Дээрх үзүүлэлтүүдийн сонгуулийн хугацаатай холбоотой мөчлөгийг тодорхойлохын тулд дөрвөн цэгийн шилжүүлэн дундажлах аргаар үзүүлэлтүүдийн урт хугацааны чиг

хандлага, урт мөчлөгийн нөлөөг ялгасны дараа, үзүүлэлтүүдийн богино хугацааны зөрүүний дундаж утгуудыг тодорхойлов.


Зураг 1. Инфляцийн түвшин, хандлага болон урт мөчлөг, хазайлт



Дээрх зургаас харахад 1997-2000 онд болон 2013-2016 онд Ардчилсан хүчин дангаар засгийн эрх барих үед инфляцийн түвшин урт хугацааны чиг хандлагаасаа доогуур байсан бол МАН дангаар, мөн ардчилсан хүчинтэй хамтарч засгийн эрх барьсан тохиолдлуудад инфляци чиг хандлагынхаа түвшинд болон түүнээс дээгүүр байжээ.

Ажилгүйдлийн түвшин ямар байсныг дараах зургаас харж болно. Ардчилсан хүчин дангаар төрийн эрх барих үед ажилгүйдлийн түвшин чиг хандлагаасаа дээгүүр, Ардын нам /МАХН/ дангаар эрх барьсан 2001-2004 онд мэдэгдэхүйц доогуур, хамтарсан 2 үед ажилгүйдэл дундаж чиг хандлагаас дээгүүр болон урт хугацааны түвшнийхээ орчим байсан байна.

Зураг 2. Ажилгүйдлийн түвшин, хандлага болон мөчлөг, хазайлт




Эдгээр тайлбараас харахад Хиббсийн загварын нөхцөл биелж байгаа мэт боловч, Ардчилсан нам төрийн эрх дангаар барьсан хугацаанд эдийн засгийн хямралтай үе таарсан тул ажилгүйдэл их, инфляци бага байх, харин бусад үед эдийн засгийн уналт саарсан, тогтворжсон, мөн өсөлттэй үе байсан нь инфляци ихсэх, ажилгүйдэл буурах төлөвтэй давхцаж байна. Тиймээс бидний авч үзсэн хугацааны

мужид Хиббсийн тууштай дэмжигчийн загварын нөхцөл биелж байна гэсэн дүгнэлтийг хийх бололцоо байхгүй юм.

Зураг 3-д инфляци, ажилгүйдлийн хослол аль мужид байгаа нь улс төрийн ямар үзэл баримтлалтай намуудтай холбоотой болохыг харуулав. Мөн сүүлийн 5 сонгуулийн хугацаанд манай эдийн засаг ямар төлөвтэй байсныг үзүүлэв.

Зураг 3. Хиббсийн баруун болон зүүний намын байршил ба Монгол Улс




2.2 НОРДХАУСЫН АШИГЧ ҮЙЛ ХӨДЛӨЛИЙН ЗАГВАРЫН ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭ

Ашигч үйл хөдлөл нь сонгуулийн жилүүд болон түүний өмнөх жилүүдэд сангийн бодлогын хувьд илүү илэрдэг болохыг судлаачид тогтоосон байдаг. Манай улсын хувьд энэ шинж

тэмдэг илэрч байгаа эсэхийг тогтоохын тулд эхлээд улсын төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийн динамикийн хувьд шинжилгээ хийв.

Зураг 4. ДНБ-ий динамик болон өсөлтийн хувь, төрийн албан хаагчдын тоо




2004 оноос эдийн засгийн өсөлт мэдэгдэхүйц хурдасч, түүний нөлөөгөөр төсвийн орлого, зарлага их хэмжээгээр нэмэгдэж, төрийн албан хаагчдын тоо 120 мянгаас 190 мянган хүн боллоо өсчээ.

Ашигч үйл хөдлөл хийж буйг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг нь төсвийн их хэмжээний алдагдал юм. Улсын төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийн мөчлөгийг мөн л шилжүүлэн дундажлах аргаар тодорхойлоход 1996-2002 оныг хүртэлх хугацаанд төвлөрлийг

сааруулах чигийн төсвийн бодлого явуулснаар олон төсөв захирагчид сахилга баг алдсанаар ерөнхийдөө алдагдал ихсэх хандлагатай байсан бол 2002-2008 онд “төсвийн удирдлага, санхүүжилтийн хууль” батлагдан төсвийн зарцуулалт харьцангуй төвлөрснөөр алдагдал багасаж, харин 2008 хойш “төсвийн тогтвортой байдлын хууль” баталсан хэдий түүнийгээ баримтлалгүй, олон дахин өөрчилснөөр төсвийн сахилга, хариуцлага дахин муудаж, төсвийн алдагдал нэмэгдсэн байна.

Зураг 5. Улсын төсвийн алдагдал, түүний мөчлөг, ашигч үйл хөдлөлийн илэрц



Зураг 5-ын 2 дахь хэсгээс харахад 2008 оны сонгуулиас хойш ашигч үйл хөдлөл хийх нь нэмэгдсэн

гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Ялангуяа 2016 оны сонгуулиар энэ нөхцөл илүү ажиглагджээ.

Зураг 6. Улсын төсвийн цалин хөлсний зарлага, чиг хандлага, ашигч үйл хөдлөлийн илэрц



Ажигч үйл хөдлөлийг илэрхийлдэг үзүүлэлтүүд нь цалин, хөлсний зарлага, татаас болон урсгал шилжүүлгүүд байдгийг судлаачид тогтоосон байдаг. Манай улсын хувьд ч мөн ижил үр дүн гарч байна. 2008, 2012 оны сонгуулийн жилүүдэд цалин, хөлсний зарлага бусад жилүүдтэй харьцуулахад чиг хандлагаасаа харьцангуй ихээр өссөн байдлыг Зураг 6-аас харж болно.

Судлаачдын санал болгосон ашигч үйл хөдлөлийг илтгэх өөр нэг үзүүлэлт нь төсвийн урсгал шилжүүлэг, татаас байдаг. Сүүлийн сонгуулийн жилд татаас, шилжүүлэг урьд жилүүдээсээ ихэссэн бол түүний өмнөх хоёр сонгуулиар сонгуулийн болон өмнөх жилд энэ төрлийн зарлага бусад жилүүдтэй харьцуулахад мэдэгдэхүйц ихэссэн байна.

Зураг 7. Төсвийн татаас болон бусад урсгал шилжүүлэг, чиг хандлага, ашигч үйл хөдлөлийн илэрц



Графикт тулгуурласан техник шинжилгээний тусламжтай манай улс төрийн намууд сонгуулийн үеэр ашигч үйл хөдлөл хийж байгааг харуулаа. Үүнийгээ баталгаажуулах зорилгоор

олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээний тусламжтай Засгийн газрын манипуляцийн дараах загварыг үнэлэв. Энд манипуляцийг улсын төсвийн цалин, хөлсний зарлагын урт

хугацааны хандлагаас хазайж буй хэлбэлзлээр сонгосон ба түүнийг ойрын

хугацааны макро эдийн төлөв байдал тайлбарлана хэмээн үзлээ.

Хүснэгт 1. Засгийн газрын манипуляцийн загвар

Хувьсагчийн төрөл	Хувьсагчийн нэр	Тэмдэглэгээ	Загвар
Тайлбарлагдагч хувсагч	Цалингийн өсөлт	WD	1
Тайлбарлагч хувьсагч	Тогтмол	C	-258694.5**
	Цалингийн өмнөх жилийн өсөлт	WD(-1)	0.93**
	Хоёр жилийн өмнөх ажилгүйдлийн түвшин	UCR(-2)	20699.5**
	Инфляцийн түвшин	Inf	7360.5**
	Сонгуулийн жилийн дамми	Dummy_ey	60252.8**
Загварын статистикууд		R ²	0.86
*, **, *** нь харгалзан 10%, 5%, 1%-ийн түвшинд ач холбогдолтой		DW	1.75
		F	25.55

Цалингийн зарлагын өсөлтөд өмнөх жилийн инерцийн нөлөөнөөс гадна хоёр жилийн өмнөх ажилгүйдлийн түвшин, тухайн үеийн инфляцийн түвшин эерэг нөлөөтэй байгаагаас гадна, сонгуулийн жил тухайн төрлийн зарлага бусад жилүүдээс илүүтэй


нэмэгддэг болохыг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, эрх барьж буй хүчин цалингийн зарлагаар дамжуулан манипуляци хийж байгаа нь хүчин зүйлсийн шинжилгээгээр нотлогдож байна.

2.3 СОНГУУЛИЙН АМЖИЛТ, ЭДИЙН ЗАСАГ, УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дараах зургаас харахад төр барьж байх хугацаанд эдийн засгийн өсөлт жил дараалан хурдассан, аль эсвэл

удааширсан тохиолдолд сонгуулийн үр дүн сөрөг хүчний талд гарах магадлалтай байна.

Зураг 8. Сонгуулийн амжилт ба эдийн засгийн өсөлт



Эдийн засгийн өсөлт удааширч, эдийн засаг хямралтай байсан тохиолдолд

сонгогчид эрх баригчдад "хариуцлага тооцож" сөрөг хүчнийг сонгодог бол

хурдассан нөхцөлд шинэ хүчнийг хүсэмжилсэн, уйдмхай чанараар сонгуулийн үр дүнг эргүүлдэг бололтой.

Сонгуулийн амжилтад улс төр, эдийн засгийн ямар хүчин зүйлс нөлөөтэй байгааг дараах 4 төрлийн загварыг үнэлгээгээр харуулав.

Хүснэгт 2. Сонгуулийн амжилтын загварууд

Хувьсагчийн төрөл	Хувьсагчийн нэр	Тэмдэглэгээ	1-р загвар	2-р загвар	3-р загвар	4-р загвар
Тайлбарлагдагч хувьсагч	МАН(МАХН)-ын УИХ дахь суудлын хувь	ES	1	1	1	1
Тайлбарлагч хувьсагч	Тогтмол	C	-66.47***	66.15***	45.12***	65.13***
	Эрх баригч хүчин	dummy_rp	-28.63**	-	-	-
	ЗГ-ын тогтворгүй байдал	dummy_zg	23.63*	-	39.63**	-
	Эдийн засгийн өсөлтийн чиг хандлага	gap_growth	-	-2.7**	-	-2.85**
	Манипуляци	wd	-	-	-0.00005	0.000012
Загварын статистикууд		R ²	0.93	0.74	0.87	0.74
*, **, *** нь харгалзан 10%, 5%, 1%-ийн түвшинд ач холбогдолтой		DW	1.3	2.32	2.58	2.22
		F	23.3	11.57	10.77	4.43

Энд тайлбарлагдагч буюу эндоген үзүүлэлтээр МАН-ын УИХ дахь суудлын тооны хувийг сонгон авсан бол тайлбарлагч хувьсагчаар тухайн үед эрх баригч хүчин байсан эсэх, төр барих хугацаандаа засгийн газар нь тогтвортой ажилласан эсэх гэсэн хоёр дамми хувьсагч, мөн эдийн засгийн урт хугацааны хандлагыг илэрхийлсэн үзүүлэлт, сонгуулийн өмнө сонгогчдод нөлөөлсөн эсэхийг илтгэсэн манипуляцийн хувьсагчдыг сонгон авав. Өгөгдлийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан улс төр, эдийн засгийн үзүүлэлтүүдийг ялган тус, тусад нь үнэлгээ хийсэн болно.

1-р загварын хувьд зөвхөн улс төрийн хувьсагчдыг тайлбарлагчаар сонгон үнэлэхэд хэрвээ тухайн нам эрх баригч байсан бол сонгуулийн амжилт 28.6 хувиар, дээр нь засгийн газар нь тогтворгүй байсан бол дахин 23.6 хувиар буурахаар байна.

Эдийн засгийн өсөлтийн чиг хандлага гэсэн үзүүлэлтээр засгийн эрх авсны дараах эхний жилийн эдийн засгийн өсөлт болон сонгуулийн жилийн өсөлтийн ялгаврыг авсан ба энэ нь эрх барьж байх хугацаанд эдийн засгийн өсөлт удааширсан бол сөрөг, хурдассан бол эерэг утгатай үзүүлэлт байна. 2-р загвар эдийн засгийн өсөлтийн чиг хандлага сонгуулийн үр дүн урвуу хамааралтай байгааг харуулж байна.

Сүүлийн хоёр загварын хувьд засгийн газрын манипуляци сонгуулийн үр дүнд хэрхэн нөлөөлж байгааг тогтоох зорилго агуулсан болно. Цалингийн зарлагын өсөлтөөр манипуляцийн механизмыг төлөөлүүлэн авсан ба хоёр загварын хувьд хоёулаанд нь статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан байна. Бидний төлөөлүүлэн авсан үзүүлэлт бодит байдлыг илэрхийлж чадсан гэж үзвэл сонгуулийн өмнөх манипуляци нь амжилтад нөлөөгүй

байна гэж дүгнэж болох ба дараагийн эрх баригч хүчинд санхүүгийн дарамт болж үлдэх талтай. Төлөөлөгч үзүүлэлт бодит байдлыг илэрхийлж чадахгүй

тохиолдолд манипуляцийн нөлөөг илэрхийлж чадахуйц өөр хувьсагчийг сонгон авч дахин шинжилгээ хийх шаардлагатай юм.

ДҮГНЭЛТ

- Эдийн засгийн гол чиглэлийн (Сонгодог болон Кейнсийн) сургуулиуд төрийг нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн их байлгах зорилготой төлөвлөгч гэж үздэг нь бодит байдалтай тэр бүр нийцдэггүй.
- Шинэ улс төрийн макроэкономикс нь үзэл санааны тууштай байдал болон ашигч үйл хөдлөлөөс шалтгаалан бизнесийн мөчлөг үүсэж болох онолын үндэслэлийг дэвшүүлсэн.
- Монгол Улсад тууштай дэмжигч шинж чанар эдийн засгийн ерөнхий нөхцөл байдалтай уялдан харьцангуй сул, харин ашигч үйл хөдлөл 2008 оноос хойш хүчтэй ажиглагдаж байна.
- Засгийн газар эдийн засагт манипуляци хийх сонирхол нь ойрын хугацааны эдийн засгийн нөхцөл байдлаас, тухайлбал хоёр жилийн өмнөх ажилгүйдлийн түвшин, тухайн үеийн инфляци, сонгуулийн жил тохиосон эсэхээс хамаарч байна.
- Манипуляцийн сонгосон хувьсагч сонгуулийн амжилтад статистикийн хувьд ач холбогдол бүхий нөлөө үзүүлэхгүй байна.
- Бүрэн эрхийн хугацаанд нь бодит ДНБ-ий өсөлт дараалан хурдассан эсвэл удааширсан тохиолдолд сонгуульд ялах магадлал багасахаар байна.
 - Хурдассан тохиолдолд сонгогчийн уйдамахай зан төлөв илэрч, харин удааширсан тохиолдолд эрх баригчдын бодлогын алдаанд хүчтэй хариу үйлдэл үзүүлдэг бололтой.
- Эрх баригч нам сонгуульд оролцоход амжилт нь сөрөг хүчнээс 29 орчим нэгж хувиар доогуур байх бөгөөд хэрвээ засгийн газар нь тогтворгүй байсан бол уг амжилт дахин 23 орчим нэгж хувиар нэмж буурахаар байна.

НОМ ЗҮЙ

1. Alesina, A. (1995). Elections, party structure and the economy. *Modern Political Economy*, 145-170.
2. Downs, A. (1957). An economic theory of political action in a democracy. *Journal of political economy*, 65(2), 135-150.
3. Fair, R. (2011). *Predicting presidential elections and other things*. Stanford University Press.
4. Frey, B. S., & Schneider, F. (1982). Politico-economic Models in Competition with Alternative Models: Which Predict Better? *European Journal of Political Research*, 10(3), 241-254.
5. Keynes, J. M. (1937). *The general theory of employment, interest and money*. London: Macmillan and Co., Limited.
6. Nordhaus, W. D. (1975). The political business cycle. *The review of economic studies*, 42(2), 169-190.
7. Schultz, K. A. (1995). The politics of the political business cycle. *British Journal of Political Science*, 25(1), 79-99.
8. Smith, A. (1776). An inquiry into the nature and causes of the wealth of nations. *George Routledge and Sons*.
9. Snowdon, B., & Vane, H. R. (2005). *Modern macroeconomics: its origins, development and current state*. Edward Elgar Publishing.

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ ЭДИЙН ЗАСАГТ ДАРААГИЙН ТОМ ЭРГЭЛТИЙГ АВЧИРНА

Б.Лхагважав

МУХАУТ-ын ерөнхийлөгч

Татварын эрх зүйн орчныг өөрчлөх хэрэгцээ, шаардлага, бодит үр дагаврын тухай ярилцлага.

ЗАСГИЙН ГАЗРЫН ЗҮГЭЭС ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ӨӨРЧЛӨХӨӨР ИДЭВХТЭЙ АЖИЛЛАЖ БАЙНА. ТАТВАР ТӨЛӨГЧИД, БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ХҮСЭЛ, ЭРМЭЛЗЭЛ ҮҮНТЭЙ САНАЛ НИЙЛЖ БАЙГАА ГЭЖ ОЙЛГОЖ БАЙГАА НЬ ЗӨВ ҮҮ?

Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталснаар капиталист нийгэмд шилжин орохдоо дагалдуулан баталсан татварын хууль эрх зүй маань энэхүү чөлөөт нийгэм, зах зээл, хүний эрхийнхээ зарчимд суурилж чадсан уу гэх асуулт тавигддаг. Нэг тогтолцооноос нөгөө тогтолцоонд шилжих явцад түүнийг дагаж өөрчлөгдсөн татварын эрх зүйн систем 10-15 жил үргэлжлээд үүргээ гүйцэтгэж дуусдаг. Манай өмнөх нийгэм иргэнээ аж ахуй эрхлэх, өмчтэй байх, худалдаа наймаа явуулах эрхийг хорьж байсан. Хууль эрх зүйн тогтолцоо нь тэр үүргээ сайн гүйцэтгэсэн. Харин 1992 оноос иргэн өмчтэй, бизнестэй байх эрх нээгдсэнээс хойш батлагдан гарсан татварын хуулиуд аажмаар хөгжиж сайжирсаар ирсний нэг илрэл нь өнөөдөр УИХ-д өргөн бариад байгаа гурван хуулийн төсөл юм.

**ТЭДГЭЭР ХУУЛИЙН ГОЛ
КОНЦЕПЦИЙГ МУХАУТ-ЫН ЗҮГЭЭС
ДЭМЖИЖ, БИЗНЕС, ЭДИЙН ЗАСГИЙН**

**ОРЧНЫ ХӨГЖИЛД ЧУХАЛ ТҮЛХЭЦ
БОЛНО ГЭСЭН БАЙР СУУРИЙГ
ТА ИЛЭРХИЙЛЖ БАЙГАА. ЮУНД
ҮНДЭСЛЭН ЭНЭ БАЙР СУУРИЙГ
ИЛЭРХИЙЛЖ БУЙГАА ДЭЛГЭРҮҮЛЭН
ТАЙЛБАРЛАНА УУ.**

Өнгөрсөн 27 жилээ дүгнээд үзэхэд процесс нь маш хатуу татварын хуультай, дээрээс нь авлига, хар зах зээлээр асуудлыг шийдэх зам руу орчихсон байна. Татварын ил тод байдлын хуулийн дараа ил болсон 34.5 их наяд төгрөгийг 27 жилийн татварын систем л нууж байсан хэрэг. Одоо энэ бүхнийгээ задалж, иргэдийнхээ тусламжаар орлогоо бүртгэе гэж байгаа юм. Татварын өөрчлөлтийг хийснээс хойш 12 жил өнгөрч байна. Үндсэн хуулийн концепци рүүгээ хандсан өөрчлөлтүүд шаардлагатай болж байна. Мөн технологийн дэвшил орж ирлээ.

Энэ удаагийн өөрчлөлт бүртгэл дээр суурилж байгаа. Өнгөрсөн хоёр жил НӨАТ-ын бүртгэлийг харьцангуй сайн хийсэн. 2016 оны эхээр 1700 кассын машин байсан бол одоо 88 мянга байна. Хоёр жилийн хугацаанд бараг 40 дахин нэмэгдсэн. Нөгөө талаар 2016 оны эхээр 207 сая талон хэвлээд ард нь 34.3 их наяд төгрөг тэмдэглэгдсэн байдаг. 2017 онд 247 сая талон хэвлээд хойдталд нь 53-54

их наяд төгрөг тэмдэглэгдсэн. Тэгэхээр нэг жилийн дотор зөвхөн НӨАТ-ын бүртгэлээр 20 гаруй сая их наядын зөрөө орж ирж байна. Мөн өмнөх "Эдийн засгийн ил тод байдлын тухай" хуулиар 33 мянган аж ахуйн нэгж 34.5 их наяд төгрөгийн ажил үйлчилгээ, орлогоо ил гаргасан. Тэгэхээр өмнөх систем маань орлогоо бүртгэж чаддаггүй байжээ гэж дүгнэж болно. Бид иргэдийнхээ тусламжаар энэ бүхнийг хийж чадсан. Үүнд ямар ч ухаантай татварын байцаагч, ямар ч ухаантай татварын дарга хэрэггүй, иргэд талоноо авахад л боллоо. Иргэнийхээ тусламжтайгаар бид бүх орлогын цэгээ бүртгэсэн. Энэхүү орлогын цэгээ бүртгэсэн бол дараагийн шатанд аж ахуйн нэгжид боломж өгөхүйц "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийг баталж гаргах шаардлагатай.

ӨМНӨ БУЮУ ӨНӨӨДРИЙГ ХҮРТЭЛ МӨРДӨЖ БАЙГАА ХУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ СУЛ ТАЛУУД КОМПАНИ АЖ АХУЙН НЭГЖИЙН ӨСӨЛТ ХӨГЖЛИЙГ БООМИЛОХ, ОРЛОГОО НУУН ДАРАГДУУЛАХАД НӨЛӨӨЛЖ БАЙСАН ГЭЖ ТА ХЭЛЛЭЭ. ОДОО ЭНЭ ЧӨДӨР ТУШААГ ЧӨЛӨӨЛВӨЛ БИЗНЕСИЙН ОРЧИНД ТЭЛЭЛТ, ӨСӨЛТ БОЛНО ГЭЖ ҮЗЭЖ БАЙХ ШИГ?

Аж ахуйн нэгжүүд яагаад татвараас зугтдаг юм бэ мэдээлэл, мэдлэггүйн алдаа үүний цаана байдаг. Залилах зорилгоор хоёр тайлан гаргаад, хар зах зээл бий болгоод, түүн дээрээ мафи маягаар ажиллах гэсэн зүйл байхгүй. Нөгөө талаасаа энэ бүртгэлгүй ажил үйлчилгээ орлого их байх тусмаа бүртгэлтэй, татвараа төлж явдаг зах зээлээ улам хумьж эхэлсэн. Татвараа

төлж байгаа нь зах зээлээ эзлэг. Татвар төлөхгүй этгээдүүдийг өөгшүүлж, тэдэнд зах зээлээ ч алдаад, хар зах зээл ч бий болгоод байх хэрэггүй. Өнөөдөр манай монголчуудын 1/3 нь ядуу байгаагийн нэг шалтгаан нь төр татвараа авч чадахгүй явж ирсэн явдал. Та бүхэн тооцоод үз дээ. Нэг жилийн хугацаанд НӨАТ-ын зөрүү 20 их наяд төгрөг болж байна. Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль үйлчилснээр 34 их наяд төгрөгийн ажил, үйлчилгээ ил гарч ирсэн. Хэрвээ энэхүү 34 их наядын ажил, үйлчилгээнээс төр зөв системээр татвараа авч байсан бол 7-8 их наяд төгрөгийг төр татвараар авчих бололцоотой байсан. Сүүлийн жишээ болох 1700 кассын машин 88 мянгад хүрснээс харахад ч хар зах зээлдээр тоглолт явж байжээ. Нийт эдийн засгийнхаа бараг 60 хувийг алдаж байсан гэсэн үг. НӨАТ-ын бүртгэлээр 88 мянган татвар төлөгч нэмэгдсэн бол бидэнд дахиад 80 мянган татвар төлөгчийн нөөц бий. Мөн технологийн өөрчлөлтийг дагаад сүүлийн 80 мянган татвар төлөгчийн бүртгэлийг хялбар аргаар үнэгүй хийх бололцоо бүрэн байна. Татварын гурван хуулиас гадна 40 журам гаргахаар байгаа бөгөөд тэдгээр журам нь процессийг хуульчилна. Үүнд бид Засгийн газартай хамтран ажиллана. Өнгөрсөн хугацааны алдаа хуульдаа гэхээс илүү процессыг зохицуулсан журамдаа байсан. Учир нь мөрдөж ирсэн журамд төрийг нэгдүгээрт тавьж, татвар төлөгчийн асуудлыг удаад нь тавьсан байсан.

ШИНЭ ХУУЛИАР АЖ АХУЙН НЭГЖ, КОМПАНИУДАД ЯМАР БОДИТ ҮР ӨГӨӨЖ ИРЭХ БОЛ?

Компанийн хөгжил нь биологийн үйл

явц, байгалийн жам ёсон дээр тулгуурлан өрнөдөг. Аливаа бизнес, компани үүсч бий болох, хөгжих, мөхөх гээд өөрийн хөгжлийн үйл явцтай. Тэдгээр хөгжлийн үе шатуудад нь тохирсон орон зайг бүрдүүлж өгөхөд татварын хуулийн өөрчлөлт чиглэж байгаа. Ямар ч компани жилд дөрвөн тайлан гаргах нь том, жижгээс хамаарахгүй адилхан гэдэг маш хүнд процесс байдаг. Мөн маш өндөр өртөгтэй. Тэгэхээр үүнийг хялбаршуулж байна. Өргөн барьсан хуулийн төслөөр бол 50 сая төгрөг хүртэлх орлоготой аж ахуйн нэгж жилдээ ганц удаа тайлан тушаагаад орлогынхоо нэг хувийг татварт өгдөг болно. 50 саяас 1.5 тэрбум төгрөгийн орлоготой аж ахуйн нэгж жилдээ хоёр удаа тайлан гаргаж, төлсөн татварынхаа 90 хувийг НӨАТ-ын системтэй адилаар буцаанг авах бололцоотой болно. Харин 1.5-6 тэрбум төгрөгийн орлоготой аж ахуйн нэгж бол бүх татвараа төлөөдөрвөн тайлан гаргана. 6 тэрбумаас дээш орлоготой бол /одоогийн босго 3 тэрбум/ 25 хувийн татвар төлдөг болно. Энэ нь компани, бизнес өсч өндийх, томрох, мөхөх гээд биологийн хөгжлийг дагасан татварын тогтолцоо юм. Энэ бол хамгийн том өөрчлөлт нь.

Өмнөх хуулийн систем компани томрох тусам хүнд босго тавьж ирсэн. Дээр нь маш олон шатлалтай. НӨАТ-ын 10 хувийн босго ч гэдэг юм уу янз бүрийн босгууд компаниудыг улам жижигрүүлээд байдаг. Компаниудыг жижигрүүлэхэд хүргэсэн анхны хууль бол 1997 онд батлагдсан НӨАТ-ын хууль байсан гэж хэлнэ. Уг хуулийг батлахаас өмнө 3-4 жил мөрдөгдсөн Худалдааны тухай хуулийг нэрийг солиод л баталчихсан. Гэтэл энэ хоёр хуулийн зорилго, үүрэг тэс өөр.

Түүнээс хойш 10 саяын босгон дээгүүр Монголын компани болгон орох болоод байсан учраас өсч томрох эрмэлзэлгүй болсон. Хэдэн зуун компанитай хүн ч таарч байлаа. Яагаадгэвэл 10 саяас бага орлоготой байхын тулд 100 жижиг компани байгуулчихсан. Тэнд нь хорь, гучин нягтлан ажилладаг. Сүүлдээ бизнесээ бодох тэнхэлгүй болж, яаж жаахан орлогоонуух вэ, тараах вэ гэж боддог болсон байсан. Энэ байдал монголчуудыг маш эмгэнэлтэй байдалд аваачсан. Өнөөдрийн татварын системийн шинэчлэл хамгийн гол нь энэ компаниудыг яаж өсгөж томруулах вэ. Ялангуяа компанийн идэр нас 10-15 жил байдгийг ядаж 20 жил болгоё гэдэг үүднээс хийж байгаа юм.

ТАТВАР НЬ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧУХАА ХЭСЭГ. ТЭГВЭЛ ТАТВАРЫН ОРЧНЫ САЙН, МУУ ҮР ДАГАВРЫГ ХЭРХЭН ХЭМЖИХ ВЭ?

Татварын хуулийн үр нөлөөг юун түрүүнд эдийн засагт ямар үр дагавар авчрах вэ гэдгээр хэмждэг. Эдийн засгийн хөгжлийн үе шатаар хөөж харвал уналтын үе бүрт шинэ капитал орж ирж биднийг авраад байдаг. Жишээ нь малыг хувьчилж, эргэлтэд оруулснаар 1993 оны хүндрэлийг давж байсан. Дараа нь 1997 онд 40 мянган орон сууцыг хувьчлан эргэлтэд оруулж байсан. Харин 2005 оноос хойш бид өвөг дээдсээс заяасан газрын хэвлийн баялгаа эргэлтэд оруулснаар аврагдаж байв. Одоо ч ийм үйл явц үргэлжилж байгаа. Одоо бид байгаа дээрх бүх баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулж буй бизнесүүд дээрээ татварын шинэ систем нэвтрүүлж чадвал дахин "аврагдах" ёстой. Хоёрт, компаниуд зөв зохистой засаглал, бүтцээ сайжруулахад

санхүүгийн эрх чөлөө, татварын эрх зүйн эрх чөлөө их чухал. Газрын баялгаараа ч, ирээдүйд бий болох мал аж ахуй, газар тариалан, цаашид өсөх эдийн засгийн бүтцээ харсан ч өсч өндийхөд нь татварын систем чухал хэрэгтэй. Хоёрдугаарх нь шударга ёсны хэмжүүр юм. Хэн зах зээл дээр ашиг олж байна, тэр хүн татвараа төлөх ёстой. Хэн татвараа төлж байна, тэр хүн зах зээлээ эзэлдэг зарчим. ТҮЦ байна уу, Тавантолгой компани байна уу ялгаагүй.

МҮХАУТ ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙГ ХИЙХЭД ЗАСГИЙН ГАЗАРТАЙ НЯГТ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙГАА НЬ АНЗААРАГДАЖ БАЙНА. ЭНЭ Ч АЛЬ АЛЬ ТАЛДАА ҮР АШИГТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА БОЛЖ ЧАДАЖ БАЙГАА ЮУ?

Бид хамтарч ажиллаж байна. Заримдаа хөтөлж байна. Заримдаа сөргөлдөж

байна. Өнгөрсөн хаврын чуулганаар УИХ-д өргөн баригдсан "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн төслийг УИХ-ын чуулганаар унагаж, санаачилагчид нь буцаасан. Улмаар төслийг Засгийн газар дахин сайжруулж, өргөн барьсан. Энэ бүх үйл явц нь уг хуулийн төслийн цаана нь системийн ямар гайхалтай үр дүн гарах гээд байгааг харахгүй, өнөө маргаашийн улс төрийн шалтгаанаар асуудлыг шийдэх эрсдэл байгааг харуулсан.

"Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн төслийг өргөн барьж амжаагүй хоцроосоноор цогц шинэчлэл болж чадсангүй. Ирэх намрын чуулганы хугацаанд татварын шинэчлэл авчрах гурван хуулийг баталчих болов уу гэж найдаж байна. Ер нь аливаа системийн шинэчлэл иргэн, төр, эдийн засагт үр ашиг авчирдаг. Үүнд хугацаа алдаж болохгүй. Үр жимсээ яаралтай хураах л хэрэгтэй.

Ярилсан сэтгүүлч З.Боргилмаа

ТАТВАРЫН БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ БҮХЭЛДЭЭ ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ ШИНЭЧЛЭЛ РҮҮ ЧИГЛЭЖ БАЙНА

Б.Тэлмүүн

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга

Татварын эрх зүйн шинэчлэлийн тухай ярилцлага

ЗАСГИЙН ГАЗРААС ТАТВАРЫН БАГЦ ГУРВАН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ УИХ-Д ӨРГӨН БАРИАД БАЙНА. ЭДГЭЭР ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БОЛОН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЭЧЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА ЮУ БАЙСНЫГ ТАЙЛБАРЛАНА УУ?

Монгол Улсын Засгийн газар, Сангийн яамнаас авч хэрэгжүүлж буй томоохон ажлын талаар мэдээлэл авч байгаад баярлалаа. Татварын хууль тогтоомжийг зайлшгүй шинэчлэх олон шалтгаан байна. Эдгээрийн заримаас дурдвал:

Нэгдүгээрт, татварын багц хууль хамгийн сүүлд 2006 онд батлагдсанаас хойш 12 жил буюу эдийн засгийн бүхэл бүтэн нэг цикл өнгөрч байна. Энэ хугацаанд манай улсын эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын орчинд гарч буй хурдацтай, эрс өөрчлөлттэй уялдуулан татварын хуулиуд үндсээрээ өөрчлөгдөх хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Хоёрдугаарт, олон улсын татварын харилцаа гэдэг зүйл сүүлийн жилүүдэд маш чухлаар тавигдах боллоо. Үүнтэй зэрэгцэн олон улсын хэмжээнд татвараас зайлсхийхийн эсрэг шинэлэг дүрэм, стандартуудыг нэвтрүүлэх, татварын ил тод байдлыг хангаж орлогын бааз сууриа хамгаалах нь бидний хувьд цаг алдалгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээ

болжээ. Та бүхэн санаж байгаа байх. 2017 оны эцсээр Европын холбоо манай улсыг татварын зорилгоор хамтарч ажилладаггүй орны жагсаалтад оруулсан. Татвараас зайлсхийхийн эсрэг дүрэм журамд хэрэгжүүлдэггүй, ил тод байдлыг хангаагүй, мэдээлэл солилцоогүй орны тоонд оруулсан уг жагсаалтаас гарахад өгсөн амлалтуудыг хуулийн шинэчлэлийн төсөлд тусгасан.

Гуравдугаарт, техник технологийн орчин өөрчлөгдөж цахим үйлчилгээ, цахим татвар гэх ойлголт эрчимтэй хөгжиж байна. Үүнд чиглэсэн арга хэмжээнүүдийг бодлогын зорилт болгож байна. НӨАТ-ын цахим төлбөрийн е-баримтын систем, саяхнаас автомашины татварыг онлайнар төлөх бололцоог хэрэглээнд нэвтрүүлсэн гэх мэтчилэн шат дараатай олон алхмыг бид авч хэрэгжүүлэх болно. Ийнхүү татвар төлөгчийн зардал, цаг, хөдөлмөрийг хэмнэх өөрчлөлтүүдийг хуулийн төсөл тусгаад байна.

Мөн өнгөрсөн 12 жилийн хугацаанд татвар төлөгчдийн зүгээс гомдол, маргаан дагуулсан ойлгомжгүй, эсвэл хэрэгждэггүй, тэрчлэн хоорондоо зөрчилтэй заалтууд цаг хугацааны явцад түрэгдэн гарч ирсэн. Амьдралаас урган гарч байгаа тэдгээр асуудлуудыг бас цэгцлэх шаардлагатай байгаа юм.

Тавдугаарт, Засгийн газрын мөрийн

хөтөлбөрт тусгагдсан бодлогын арга хэмжээнүүдийг татварын орчноор дэмжих шаардлага бий. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, банкны зээлийн хүүг бууруулах гэх мэт. Ийм үндэслэлүүдээр татварын хуульд өөрчлөлт хийх шаардлага байна.

ЦАГ ҮЕИЙНХЭЭ ХЭРЭГЦЭЭ, ШААРДАГАД НИЙЦЭХ ЭНЭ УДААГИЙН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ ЗАРЧМЫН ЯМАР ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙГ АВЧРАХ ВЭ?

Нэн түрүүнд хөрөнгө оруулалт, бизнесийн болон ажил эрхлэлтийн орчинг таатай болгоё, бизнес эрхлэгчдэд тэлэх, томрох орон зайг нь олгоё гэж зорьж байна. Энэ хүрээнд тодорхой татварын хувь хэмжээг ч бууруулж байгаа. Тухайлбал, жижиг хэмжээний аж ахуйн нэгжүүдийг жилд 1 удаа тайлан гаргаад нийт орлогын 1 хувиар татвараа төлөх хялбаршуулсан боломжийг санал болгож байна. Мөн, татвар өөрөө төсвийн бодлогын нэг том хэсэг байдаг учраас зээлийн хүүг бууруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, иргэдийг орон сууцжуулах зэрэг эдийн засгийн суурь асуудлууд руугаа чиглэсэн бодлогын хөшүүрэг болдог. Эдгээр чиглэлээр татварын ачааллыг бууруулж байна.

Татварын бааз суурь өргөжиж байгаатай холбогдуулан татварын тэгш шударга байдлыг хангах шалгуурыг чухалчилсан. Татвараа төлдөг хэдийнхээ араас хөөцөлдөх биш илүү өргөн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл, бүртгэлгүй эдийн засаг руу чиглэсэн алхмуудыг нэвтрүүлэх юм. Татварын шинэчлэлийг хийснээр төсвийн орлого, татвар төлөгчдийн ачааллыг нэмэх сэдэл санаа байхгүй.

Зарчмын хувьд татвараа хугацаанд нь төлдөггүй, тайлагнадаггүй, зайлсхийх элдэв арга хэрэглэдэг,

маргаан үүсгэх замаар цаг хожихыг эрмэлздэг, эрсдэлтэй татвар төлөгчдийн хариуцлагыг чангатгаж, татвараа бүрэн хураадаг болно. Нөгөө талаас, үүрэг хариуцлагаа ухамсарлаж хугацаанд нь тайлагнадаг, төлдөг, хамтарч ажилладаг шударга татвар төлөгчдийн татвартай холбоотой зардал, элдэв хүндрэлийг бууруулах болно. Тухайлбал, татварын тайлан тушаасны дараа алдаагаа залруулахад төвөгтэй байдаг. Шинэ хуулийн төсөлд тайланг залруулах боломжийг нэг жилээр олгож, татварын алба тайлан хүлээж авахдаа үндсэн мэдээллийг нягтлан хөндлөнгийн мэдээлэлтэй тулган, алдаагаа залруулах боломж олгож, эргэх холбоотой ажиллах зарчмыг суулгаж өгч байгаа. Ийнхүү тэгш шударга татварын орчинг бүрдүүлэн, бүртгэлийн тогтолцоог сайжруулж, далд эдийн засгийг бууруулснаар дунд хугацаандаа орлого нэмэгдэх төлөв харагдаж байгаа.

Үүнээс гадна татвар төлөлтийг энгийн болгохыг зорьж буй юм. Өнөөдөр найман нэрийн барааны дэлгүүр, Оюутолгой, Эрдэнэт компанийн татварын тайлагналт яг адилхан тооцоолол, зарчмаар татвараа боддогбол гурван тэрбум төгрөгөөс доош татвар ногдуулах орлоготой компаниудыг жилд хоёр удаа тайлагнах боломж олгохоор төлөвлөөд байна. Хяналт шалгалтыг хуваарийн дагуу бүх компанийг ялгагүй хийдэг биш, эрсдэлд суурилж хийдэг болгох гэж байна. Ингэснээр эрсдэлгүй төлөгчдөд байнга хяналт шалгалт оруулаад байхгүй. Нөгөө талаас, төрийн байгууллагууд болон банк, санхүүгийн байгууллагаас хөндлөнгийн мэдээлэл хүлээн авах замаар татвар төлөгчийн эрсдэл тооцох, татвараас зайлсхийхээс сэргийлэх боломжийг бүрдүүлэх болно. Тэгэхээр татвар төлөгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлэх, татварын

албаны нөөц бололцоог үр ашигтай хуваарилан тухайн хэсэгт чиглүүлсэн байдлаар ажиллуулах зорилго тавьж байна. Татварын алба татвар төлөгч болгоныг шалгаад байхгүй. Эрсдэл, тоон мэдээлэл датаа шинжилгээнд суурилсан хяналт шалгалтыг хийдэг хялбаршуулсан байдал бий болно.

Бүхэлдээ эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн, татвар төлөгчдөд боломж, орон зай олгосон бодлогыг татварын багц хуулийн төсөлд тусгасан.

ТАТВАР ТӨЛӨГЧИД ЮУН ТҮРҮҮНД ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ, НЭР ТӨРӨЛ НЭМЭГДЭХ ҮҮ Л ГЭЖ АСУУХ БАЙХ. ХАРИН ТӨСӨВ БАТАЛЖ БУЙ УИХ-ЫН ГИШҮҮДИЙН ХУВЬД ТӨСВИЙН ОРЛОГО НЭМЭГДЭХ ҮҮ ГЭХ АСУУЛТ ЧУХАЛ БАЙЖ БОЛОХ ЮМ. ҮҮНД ЯМАР ХАРИУЛТ ӨГӨХ ВЭ?

Татварын хэмжээг нэмэхгүй, харин ч татварын ачааллыг зарим зорилтот хэсэг дээр бууруулж байгаа. Түүнчлэн, татвар тайлагнах, төлөхтэй холбоотой буюу хууль дагаж мөрдөхтэй холбоотой ардлыг бууруулна. Тухайлбал, НӨАТ суутган төлөгч биш, жижиг хэмжээний компани нийт татвар төлөгчийн 1/3 орчим хувь байдаг. Тэдгээр өрхийн шинжтэй, ахуйгаа залгуулах жижиг компаниуд хялбаршуулсан горимоор жилд нэг удаад тайлангаа гаргаад нийт орлогоос нэг хувийн татвар төлөх системд оруулж байгаа. Нөгөө талаас, энэхүү хялбаршуулсан горимд хамрагдах бол тэдгээр компаниудад е-баримт олгодог байх шаардлага тавигдана. Жижиг компаниуд системдээ борлуулалт, худалдан авалтаа бүртгүүлээд явж байхад орлого, зарлагыг тооцоод тайланг нь тохируулга хийгээд тайланг нь гаргаад өгөх бололцоотой. Дунд хэмжээний аж ахуйн нэгжүүд бол жилд дөрвөн удаа тайлан гаргадаг байсан бол хоёр удаа гаргадаг болж байна.

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН СУУРЬ ӨРГӨЖИХ ЮМ БАЙНА ГЭЖ ОЙЛГОЛОО. ҮҮНИЙГ ДАГААД ТАТВАРЫН ОРЛОГО ДУНД ХУГАЦААНДАА НЭМЭГДЭНЭ ГЭЖ ТА БҮХЭН ТООЦООЛЖ БАЙГАА ЮМ БАЙНА?

Татвар төлөгчийн тоо нэмэгдэхэд ямар нэг захиргааны арга хэрэглэхгүй. НӨАТ-ын буцаан олголтын систем гэхэд томоохон худалдааны төв, захууд бас НӨАТ-ын баримт өгөхгүй байгаа. Эдгээрээс худалдан авалт хийдэг бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулдаг. Тэгэхээр иймэрхүү асуудлуудыг аль болох шийдэж, хамруулдаг больё. Гэхдээ эдийн засгийн хөшүүргийн аргыг хэрэглэх замаар хамрагдалтыг нэмэгдүүлье гэж байгаа юм. Төсвийн орлого зарим төрөлд буурах боловч татварын бааз суурь нэмэгдсэнээр дунд хугацаандаа орлого өсөх болно. Иймд төсөвт ямар нэг хүндрэл учруулахгүй.

Хоёрдугаарт, татвараас зайлсхийдэг олон улсад туршигдсан шалгарсан аргуудын эсрэг дүрмүүдийг нэвтрүүлж байгаа. Нэг талдаа хүмүүс татвараа төлөөд байдаг, нөгөө талдаа арга зальтай хүмүүс татвараа завшаад яваад байх хуулийн цоорхой, хийдэл, боломжийг хааж өгнө. Ялангуяа үндэстэн дамнасан компаниуд их хэмжээний татвараас зайлсхийх боломжийг сайн ашигладаг. Цаанаа олон хуульч, санхүүчийн баг ажиллуулах боломжтой, энэ хэрээр олон улс дамнасан татвараас зайлсхийх схем гаргах боломжтой компаниудын эсрэг шалгарсан дүрэм нэвтрүүлнэ. Энэ нь орлогод тодорхой хэмжээнд эерэгээр нөлөөлнө гэж харж байгаа.

ДҮРЭМ ГЭХЭЭР ЗАХИРГААНЫ АРГА ХЭМЖЭЭ ЮУ, САНХҮҮГИЙН АРГА ХЭРЭГСЭЛ БАЙХ УУ?

Татварын суурийг багасгах, ашигт шилжүүлэхийн эсрэг байгууллага гэж бий. Олон улсны эдийн засгийн

хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын санаачилгаар байгуулсан тус байгууллагаас үндэстэн дамнасан компаниудаас татвараас зайлсхийж байгаагийн эсрэг 15 чиглэлээр зөвлөмж гаргасан байдаг. Үүнд Монгол Улс гишүүнээр элссэн. Тус байгууллагаас боловсруулсан татварын дүрэм, журмыг бид авч нэвтрүүлэх юм. Эдгээр нь захиргааны гэхээс илүү татвар ногдох зүйл, татварын ногдол тооцоход ашиглагддаг тооцооллын дүрмүүд юм. Жишээлбэл, гадны компани Монгол дахь үйл ажиллагаагаа санхүүжүүлэхдээ хөрөнгө оруулагчаасаа их хэмжээний зээл авдаг. Улмаар ашгаа олон буцаж гарахдаа орсон орлогынхоо 80 гаруй хувийг зөвхөн зээлийн хүүгийн зардал нэрээр зардалдаа шингээн ямар ч татвар төлөлгүй гаргачихдаг. Ийм хэлбэрийн татвараас зайлсхийх аргыг хэрэглэх бололцоог хааж байгаа.

Манай Улс Европын холбооны "Татварын зорилгоор хамтарч ажилладаггүй улс орнуудын жагсаалт"-д орсон. Улмаар шуурхай арга хэмжээ авч, Засгийн газрын тогтоолын дагуу тодорхой шийдвэрүүд гарч холбогдох байгууллагад шуурхай элсч орсон. Тэндээс тавигдаж байгаа шаардлагаыг ч хуулийн төсөлд бүрэн тусгасан. Шинэ хууль батлагдсанаар хар жагсаалтад орохгүй байх эрх зүйн орчин бүрдэнэ. Харин хуулийн төсөлд туссан татварын ил тод байдлыг хангах, мэдээлэл солилцох, татвараас зайлсхийхийн эсрэг олон улсын дүрмүүдийг нэвтрүүлэхгүй тохиолдолд хар жагсаалт руу эргэн орох бодитой эрсдэлүүд бий.

ТАТВАР БОЛ ТАТВАРЫН ТӨЛӨГЧИЙН ЗАН ҮЙЛИЙГ УДИРДАГ. ТАТВАР ТӨЛӨГЧИД ТАТВАРЫН БОДЛОГОТой САНАЛ НИЙЛЭХ, ҮГҮЙГЭЭС ХАМААРААД ТОДОРХОЙ ХАРИУ ХАНДАГА ҮЗҮҮДДЭГ ШҮҮ ДЭЭ. ТЭДНИЙ ХАРИУ ҮЙЛДЭЛД "ЯАГААД"

ГЭХ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТООЦОО СУДАЛГАА БАЙДАГ УУ?

Татвараас зайлсхийх хандлагыг аваад үзвэл хоёр төрлийн хэлбэр байгаа юм. Нэг хэсэг нь хууль журам зөрчөөд татварын орлогоо нуун дарагдуулж, завших арга байна. Энэ нь өөрөө хуулийн хариуцлага хүлээх үр дагавартай. Монгол Улс олон улсын жишгээрт татварын дарамт багатай орны тоонд ордог. Хувь хэмжээ өндрөөс болоод зугтаж байна гэж хэлэх бололцоо бага бөгөөд татвар т.

Нөгөө нэг хэлбэр гэвэл хуулийн хийдэл, цоорхой, хоцрогдсон байдал, давхар татварын гэрээг урвуулан ашиглах замаар татвараас зайлсхийх юм. Харин ямарваа хэвийн бизнес ашгаа олоод татвараа төлөх нь зайлшгүй байтал дээр дурдсан нэр бүхий компанийн жишээн дээр гэхэд орлогын 80 хувиа зээлийн хүүгийн зардал нэрээр хөрөнгөт татвараас зайлсхийнэ гэдэг эрүүл бус. Үүний эсрэг хууль, дүрэм журмаа сайжруулна, хийдлийг арилгана. Олон улсын байгууллагатай хамтарч ажиллаж, мэдээллээ солилцдог байх ийм л эрх зүйн орчныг бий болгоно.

ЗАСГИЙН ГАЗРЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТОД ТУСГАСАН БУСАД БОДЛОГЫГ ДЭМЖИХ ХӨШҮҮРГҮҮДИЙГ ТАТВАРЫН ХУУЛИУДЫН ТӨСӨЛД ТУСГАЖ БАЙГАА ГЭЖ ТА ОНЦОЛСОН. ТУХАЙЛБАЛ, ЯМАР БОДЛОГЫГ ЯМАР АРГА ЗАМААР ДЭМЖИХ ТАЛААР ТОДРУУЛНА УУ?

Татварын бодлогоор дамжуулан банкны зээлийн хүүг бууруулах бодлогыг хүчтэй дэмжиж байгаа. Арилжааны банкуудын гадаад, дотоодоос татсан эх үүсвэр буюу хөрөнгө оруулагчийн хүүгийн болон ногдол ашгийн орлогын суутган татварын асуудал яригддаг. Энэ татварыг 5 хувь болгон бууруулж буй.

Үүний ач холбогдол нь банкуудын татаж буй эх үүсвэрийн зардал багасчманай улсын зээлийн хүүгийн түвшин буурах нөлөөтэй. Энд тодруулаад хэлэхэд банкуудын орлогын татварыг бууруулж байгаа хэрэг огт биш юм. Сангийн яам банкны зээлийн хүүг бууруулах гэх бодлогын цогц олон арга хэмжээ хэрэгжүүлж байгаагийн нэг нь энэ.

Хүн амыг орон сууцжуулах бодлогыг дэмжих нэг хөшүүрэг нь анх удаад орон сууц худалдан авахад 3 сая хүртэлх төгрөгийн татварын хөнгөлөлт эдэлдэг байсныг 6 сая хүртэл нэмэгдүүлж байгаа. Түүнчлэн, ипотекийн зээлд бүх хүн хамрагдах боломжгүй. Тиймээс "Та ипотекийн зээлээ авчих. Одоогийн найман хувиар биш 10 хувиар авсан тохиолдолд 2 хувийн хүүгийн зөрүүг татварын хөнгөлөлт болгоод авч болно" гэх мэт буцаан олголт хэлбэрийн арга хэрэгслийг арга хэрэгслийг тусгаж байна.

Бодлогын бас нэг алхам нь хөрөнгийн зах зээлийг дэмжих. Хөрөнгийн зах зээлд сэргэлт ажиглагдаж байна. Сүүлийн үед хийгдсэн IPO-г харахад хөрөнгийн зах зээл дээрх эрэлт өндөрбайгаа нь харагдаж байна. Засгийн газрын зүгээс төрийн өмчит компаниудыг хөрөнгийн биржээр дамжуулан нээлтэй хувьчлах, тэдгээрийг илүү тод нээлтэй болох явдлыг бодлогоор дэмжиж байгаа. Ингэснээр аж ахуйн нэгжүүд хөрөнгийн биржээр дамжуулаад нээлтэй хувьцаагаа юм уу, бондоо арилжаалбал илүү давуу талтай байх болно гэх мэт.

ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН НЭГ АМИН СҮНС НЬ ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ, АШИГЛАХ ГЭЖ ОЙЛГОЛОО. ҮҮНИЙГ ДЭЛГЭРҮҮЛЭН ТАЙЛБАРЛАНА УУ?

Татварын шинэ орчин бүртгэл, тоон мэдээлэл, статистик, эрсдэлд

тулгуурлана. Татвар хураах үйл явцыг хүний хүчин зүйлээс чөлөөлж, илүү технологижуулна. Боломжтой бүхий л мэдээлэл бүртгэгдэж байдаг, татварын алба эдгээр мэдээллийг шинжлэн анализ хийн, эрсдэл тооцдог болно. Татварын албанд татвар төлөгч аль болох ирээд байх шаардлагагүй байлгахыг зорьж ажиллаж байна.

Татварын тэгш шударга байдлыг хангах, бааз суурийг нэмэгдүүлэхэд хамгийн чухал зүйл бол бүртгэл, хөндлөнгийн мэдээлэл, мэдээлэл солилцоо юм. Гадаад улс орнуудтай болон төрийн бусад байгууллагуудтай мэдээллийг сайтар солилцож, тэдгээрийг бүрэн дүүрэн, үр дүнтэй ашигладаг болох нь гол зорилгуудын нэг юм. Тухайлбал, иргэн Дорж татварын албанд 1 автомашинтай гэж бүртгүүлсэн хэдий ч тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээгээр 2 автомашинтай гэсэн мэдээлэл гарвал бид тухайн татвар төлөгчийг татварын зайлсхийх эрсдэлтэй гэж үзэж, татварыг бүрэн хураадаг болох юм. Харин үнэн шударгаар татварын тайлан, мэдээгээ өгдөг, энэ нь хөндлөнгийн мэдээллийн системээр баталгаажиж байвал татварын алба эрсдэлгүй гэж үзээд хяналт шалгалт хийх шаардлагагүй болох юм.

НЭГ ТАЛААС ТӨР ТАТВАРЫН ӨРИЙГ ХУРААХ ҮЙЛ ЯВЦ, НӨГӨӨ ТАЛААС ӨР ҮҮСГЭСЭН КОМПАНИ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭРХ АШИГ ГЭЭД ШҮҮХИЙН ШАТАНД ГОМДОЛ, МАРГААН ҮҮСГЭДЭГ АСУУДЛУУД БИЙ. ПРОЦЕССЫН ШИНЖТЭЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД БАС ХУУЛЬД ТУСГАГДАЖ БАЙГАА БАЙХ АА?

Татвар бол Үндсэн хуулиар заагдсан иргэний үүрэг, гарцаа байхгүй төлөх л учиртай. Ногдсон татвар нь бүртгэлээр зулсын төсвийн орлого буюу авлага болж нөгөө талдаа цалин, тэтгэвэр санхүүжүүлэх эх үүсвэр

болдог. Тэгэхээр энэ улсын хөрөнгө гэдэг зүйлийг төлөхгүй байх учиргүй.

Татварын өртэй зарим этгээдүүд өрөө төлмөөр байгаа хэдий ч эдийн засгийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хүндрэл учирсан тул график гаргаад төлье, данс битгий хаагаач, битгий албадлагын арга хэмжээ хэрэглээч гэдэг. Бид хичээе, ажиллая гэж байгаа тэр хэсэгт боломжийг нь илүү нээж өгч байгаа. Өр төлөх хугацааг өмнө нь зургаан сарын хугацаагаар сунгах боломжтой байсан бол одоо хоёр жилийн хугацаа тавьж өгдөг болно. Энэ хугацаандаа барьцаа тавиад графикаар татварын өрөө төлөөрэй гэдэг боломж олгоно.

Нөгөө нэг хэсэг нь элдэв арга саам хэрэглэж татварын өр төлөхөөс зугтдаг хэсэг юм. Жишээлбэл, татан буугдах нь тодорхойболсон, их хэмжээний татварын өртэй компани өр төлөхийн орондшүүхддэг. Шүүхийн гурван шатны процесст хугацаа их зарцуулна. Энэ хооронд компанийн эзэн хамаг өмч хөрөнгөө бусдад нэр дээр шилжүүлчихдэг. Тэгээд шүүхийн шийдвэр гарлаа, төр өрөө хурааж авах ёстой болдог нөгөө компани өмч хөрөнгө юу ч байдаггүй. Шүүхийн шийдвэрээр авч барагдуулах ёстой татварын өрнөөс бид 10 хувийг нь л авч чадаж байгаа ньшударга бус. Энэ нь улсын хөрөнгөөс хулгай хийж байгаатай ижил асуудал. Иймд хүлээн зөвшөөрөгдсөн, нэгэнт үүсэх нь тодорхой өр дээр татварын

албаер хураах ажиллагаа эхлүүддэг байх боломжийг олон улсын жишигт нийцүүлэн тусгаж байгаа. Иймэрхүү байдлаар ногдуулсан татвараа бүрэн хурааж чадахгүй байвал нөгөө талд нь нийтийн эрх ашиг хохирдог байж болохгүй.

САНГИЙН ЯАМ ИРЭХ ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛААД ЭХЭЛСЭН ҮЕ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ХЭЧНЭЭН ХУВЬ НЬ ТАТВАРААС БҮРДЭХЭЭР БАЙГАА ВЭ. ИРЭХ ЖИЛИЙН ТӨСВИЙН ОРЛОГО БҮТЭЦ, ХАРЬЦААНД ӨӨРЧЛӨЛТ ОРОХ УУ?

Өнгөрсөн 2017 оны эцсээр нийт орлого маань 7.9 их наяд, тэнцвэржүүлсэн орлого маань 7.2 их наяд төгрөгт хүрсэн. Үүнээс татварын орлого 6.3 их наяд төгрөг байна. Дараа жилийн хувьд яг одоо тооцоолол хийж байна. Эдийн засгийн үзүүлэлтүүд нэлээн сайжирч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа идэвхжиж байна. Экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеийнхээс бараг 40-өөд хувь нэмэгдлээ. Банкуудын зээл олголт мөн нэмэгдэж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өнөөгийн түвшнээс төдийлөн буурах төлөв харагдахгүй байгаа. Экспортын хувьд хилийн боомтын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулах арга хэмжээний дүнд өсөлттэй гарахаар байгаа. Дараа жилийн хувьд эдийн засаг болон төсвийн орлогын төлөв байдал зерэг харагдаж байна.

Ярилсан сэтгүүлч З.Борбилмаа

ҮНЭ ЦЭН БҮТЭЭХ “ХУВААЛЦАХУЙН” ЗАРЧИМ

Т.Ууганболд

СЭЗИС-ийн БУ-ын тэнхимийн багш, (MBA)

Б.Идэрсүрэн

СЭЗИС-ийн БУ-ын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

Abstract. *In neoclassical understanding, economic value and society have been indented against each other for too long. Consideration of maximizing profits constraints firms legitimize the idea to provide societal benefits. It means most firms have only a way to focus on economic success during past periods. Capitalism new era (i.e., expanding the concept of economic and social value) is accepted as a wider concept of how to increase efficiency, product quality, and strengths of the firm and to be growing sustainability. Critical discussion about this concept leads capitalism is not narrow, and making profit is related to society. The concept of current movements into capitalism rests on the premise that both economic and social progress must be addressed using value principles. It is named 'Shared Value'.*

Key words: *Shared Value, Capitalism, Economic Value, Societal, and Value Creation.*

ОРШИЛ

WW-II буюу дэлхийн хоёрдугаар дайны дараагаас дахин загварчлагдсан капитализмын эдийн засгийн тогтолцоонд шүүмжлэлтэй хандах хандлага улам нэмэгдсээр байна. Судлаачдын зүгээс үүнийг тус системд голлох оролцогчид болох бизнесийн компаниудын тооны өсөлт нь нийгэм эдийн засаг төдийгүй байгаль орчинд үүсч буй асуудлуудын гол шалтгаан гэж тайлбарлах хандлага их байдагтай холбоотой гэж үзэж байна. Харин капитал бүтээгч компаниудын зүгээс дээрх асуудлуудын шийдэлд тохиромжтой гарц олохын тулд санхүүгийн болон бусад шаардлагатай хөрөнгө төсөвлөж, сайн дурын олон талт ажлуудыг компанийн нийгмийн

хариуцлага нэрийн дор түгээмэл хийдэг. Гэвч нийгэмд үүсч буй асуудлын цар хүрээ улам бүр тэлж, нэгээс нөгөө рүү олон асуудал урган гарсаар байгаа нь шийдвэрлэхэд улам төвөгтэй болгосоор байна.

Шинжлэх Ухааны үндэслэлтэй тайлбар олохыг судлаачид оролдсоор байгаа ба Porter and Krammer нар 2011 онд "Creating shared value: Redefining the Role of Business in Society" нэртэй судалгааны өгүүллээрээ илүү ахицтай, логиктой ойлголтыг хөгжүүлж эхлээд байна. Тэдний дэвшүүлж буй байр суурь нь баялаг бүтээгч компаниудад гол асуудал байгаа бөгөөд тэд уламжлалт үнэ цэн бүтээх хандлага, арга барилдаа хэт ихээр баригдаж, илүү өргөн хүрээнд

сэтгэж чадахгүй байгаа гэж үзсэн байна. Тухайлбал, ихэнх бизнесүүд зохиомол хөөсөн дунд богино хугацааны санхүүгийн үр дүнг чухалчилж, үнэ цэнэ бүтээх боломжийг хумигдмал хүрээнд хардаг нь урт хугацааны амжилтыг тодорхойлох хэрэглэгчдийн хамгийн чухал хэрэгцээг харахгүй өнгөрөх, илүү өргөн цар хүрээнд нөлөөлөх боломжоос татгалздагаас үүсч байгааг тайлбарлажээ.

Тэд өөрсдийн энэхүү судалгааныхаа үр дүнд маш чухал гарцаагүй үнэнийг дэвшүүлсэн нь компаниуд үнэн хэрэгтээ бүтээгдэхүүн үйлчилгээ бүтээнэ гэдэг нь түүнийг хэрэглэх хэрэглэгчийн сайн сайхны төлөө, аливаа бизнесийн амин чухал байгалийн нөөцийг хомсдолыг бууруулахын төлөө, болон бусад нийлүүлэгч, түншүүдийнхээ амьдрах чадварыг сайжруулах болон нийгмийн бухимдлыг бууруулахын төлөө байдаг ба улмаар хийж чадах цар хүрээнийх нь түвшин нь тэдний капиталист системд хамгийн их ашигт ажиллагаанд хүрэх чадварыг хангах бололцоог олгодог гэж үзсэн явдал юм.

Капиталист системд нийгмийн асуудлуудыг харах өнцөг нь ЗГ болон иргэний оролцоонд тулгуурлах, мөн капитал бүтээгчдийн нийгмийн хариуцлагын оролцоог татварын уламжлалт хэвшмэл хандлагаар хангахыг оролдох зэрэг нь төдийлөн амжилттай болохгүй байгаа юм. Асуудлын мөн чанар нь системийн хүрээнд нийгмийн тогтолцооны өсөлт хөгжлийн хамрах хүрээг эдийн засгийн үр өгөөжөөс тусгаарлаж байгаа нь зардлын функцэд тулгуурласан стратегийн бодлогуудыг компаниуд

өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэнтэй холбоотой юм. Гэвч санхүүгийн богино хугацааны өгөөжийг илүү урт хугацаанд ашгийн дээд түвшинд хүргэх сонирхол бизнес эрхлэгчдийг эзэмдэж байдаг нь нийгмийн асуудлуудыг арай өөр өнцгөөс харахад хүргэсэн байдаг. Энэ нь бизнес эрхлэгчид үнэ цэн бүтээх тасралтгүй оролдлогоо нийгмийн тогтолцооны асуудлуудтай уялдуулах зарчимд суурилсан бизнесийн шинэ моделиудыг хөгжүүлэх суурь үндэс болсон байна. Үүнийг чадварлаг бизнес эрхлэгчдийн хувьд өрсөлдөөний давуу талаа бэхжүүлэх таатай боломжоор харах нь түгээмэл болж байгаа ч хэрхэн загварчлах шийдэл тодорхойгүйгээс дийлэнх компани уламжлалт "компанийн нийгмийн хариуцлага" хэрэгжүүлэх гэсэн хэвшсэн ойлголтоосоо салж чадахгүй байгаа нь тэд жинхэнэ үнэ цэн бүтээхэд саад учруулж байгаа юм. Түүнчлэн корпорацууд өнөөгийн санхүүгийн богино хугацааны үр өгөөжийг харахаас илүүтэй хуваалцахуйн үнэ цэнийг бүтээх зорилгын төлөө ажиллах ёстой ба энэ нь биднийг глобал эдийн засаг дахь бүтээмжийн өсөлт болон инновацийн дараачийн давлагаанд хөтлөх юм. Мөн капитализм болон нийгмийн харилцааг дахин хэлбэржүүлэх бололцоог олгоно. Магадгүй, бүгдээс түрүүнд хуваалцахуйн үнэ цэнэр бизнесийг дахин засаглахад суралцах нь хамгийн чухал боломж байж ч болох юм.

Компани илүү үр ашгийг бий болгохын тулд бүтээж буй үнэ цэн нэмэгдүүлэх, зардлаа зохистой хэмжээнд удирдах гэсэн уламжлалт капитализмын ойлголтоо өөрчилж нийгмийн асуудлуудыг боломж үүсгэж буй зардал гэж харах байдлаар үр ашгаа

тэлэхийг "Хуваалцахуйн сэтгэлгээний" зарчим гэх ба үүнийг ойлгохын тулд нийгмийн хөгжил, дэвшил болон компанийн амжилтын холбоосыг дахин харах шаардлагатай болно. Эндээс харахад "Хуваалцахуйн" үнэ цэн нь нийгмийн хариуцлага, филантропи, тогтвортой байдал биш бөгөөд эдийн засгийн амжилтад хүрэх шинэ үеийн арга, хандлага буюу бизнес сэтгэлгээний шилжилтийн дараа үеийн чиг баримжаа хэмээн тодорхойлж байгаа юм.

Бидний амьдарч буй ухаалаг зууны тэргүүлэх компаниудын төлөөлөл болох Google, IBM, Johnson&Johnson, Nestle, Unileve, Wall-Mart компаниуд өөрсдийн бизнесийн гүйцэтгэл болон нийгмийн тогтолцооны уялдаа холбог дахин боловсруулж хуваалцахуйн үнэ цэнийг хөгжүүлэх чухал оролдлогуудыг хийж эхлээд байгаа нь тэднээс үнэ цэн бүтээх дараагийн зарчим хөгжиж гарах нь гарцаагүй юм. Хэдийгээр үнэ цэнэ бүтэхийг илүү өргөн хүрээнээс харж тайлбарлах энэхүү ойлголт нь хөгжлийн эхэн үедээ явж байгаа ч бизнесийн лидерүүд болон шилдэг менежерүүд нийгмийн бодит хэрэгцээг гүнзгий таньж мэдэх, бүтээмжийг өсгөх, ашгийн

болон ашгийн бус байгууллагуудтай хамтран ажиллах мэдлэг, чадваруудаа хөгжүүлэх хэрэгтэй байгааг онцлох хэрэгтэй юм. Мөн ЗГ үүний эсрэг ажиллахаас илүүтэй хуваалцахуйн үнэ цэнийг нэвтрүүлэхэд хэрхэн зохицуулах талаар суралцах шаардлагатай болсон байна.

Капитализм бол хүний хэрэгцээг хангах, үр ашгийг сайжруулах, ажлын байр, хөрөнгө баялгийг бүтээх гайхалтай хөдөлгүүр. Гэвч энэ нь явцуу утгаараа нийгмийн томоохон сорилт бэрхшээлүүдийг бизнесүүд бүх бололцоогоороо даван туулахад маш том саад болж байна. Бидний дунд асуудлыг шийдэх боломжууд байсаар байгаа боловч харагдахгүй өнгөрсөөр байна. Компаниудын эрхэлж байгаа бизнесүүд бол хандив, тусламжийн донорууд биш юм, харин ч нийгмийн өмнө тулгарч байгаа дарамттай асуудлыг шийдэх хамгийн их боломжтой хүч юм. Энэ бол капитализмын шинэ тогтолцооны үзэл санаа үүсэх эхлэл гэдгийг 21-р зуун, хэрэглэгчид, ажилтнууд болон нийгмийн асар том, хурдацтай өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлага харуулж байна.

ЗАРДАЛ БОЛОМЖ АВЧИРДАГ

Капитал бүтээх болон нийгэмд үүсч буй асуудлууд олон жилийн туршид бие биетэйгээ зөрчилдсөөр ирсэн. Зөрчилдөөний гол шалтгаан нь институцийг хуулийн тогтолцоогоор хянахыг оролдсон эдийн засгийн зохицуулалтууд нь компаниудыг нийгмийн тулгамдсан асуудлуудыг зардал өсгөх сөрөг хүчин байдлаар харуулахад хүргэсэнтэй холбоотой. Тухайлбал, нео-классик эдийн засгийн үзэл баримтлалд корпорацуудад

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авах, ажлын аюулгүй байдлыг хангах зэрэг нийгмийн хөгжлийг сайжруулах шаардлага бүхий хязгаарлалтуудыг тулгадаг. Гэвч компаниуд үүнийг бүтээж буй үнэ цэнийх нь өртгийг нэмэгдүүлж, ашгийг буруулж байгаа гэж хардаг нь энэ онолын хандлага зөрчилдөөнийг үүсгэж буйг харуулж байгаа юм. Дээрхтэй ижил санааг дам нөлөөллийн онолоор мөн харуулдаг. Өөрөөр хэлбэл, компаниудаас хамаарч, бий болсон

агаарын бохирдол гэх мэт зардлыг тэд хариуцахыг хүсэхгүй байгаа үед гадагшлах дам нөлөө ихэсдэг. Тиймээс нийгмийн зүгээс эдгээр компанид өндөр татвар ногдуулах, тусгай зохицуулалт хийх, төлбөр авах шаардлага тулгах ёстой болдог учраас тухайн компаниуд эдгээр зардлыг дотогшлуулдаг.

Энэхүү бодлогын шийдвэрт нөлөөлж буй дам нөлөөллүүд нь компаниудын стратегийн суурь агуулга нь шууд утгаар нийгэм, байгаль орчны асуудлуудыг эдийн засгийн сэтгэлгээнээс хассан байдлаар сэтгэх нөхцөлийг үүсгэдэг байна. Иймээс нийгмийн асуудлуудыг шийдэх нь зөвхөн ЗГ болон төрийн бус байгууллагуудад тулгагдаж, корпорацын нийгмийн хариуцлагын хөтөлбөрүүд нь зөвхөн гадаад дарамт шахалтад хариу үзүүлэх, корпорацын нэр хүндийг өсгөхөд эсвэл зайлшгүй шаардлагатай зардалтай холбогдон хэрэгжиж байна. Гэвч компаниудыг стрессстүүлж буй дээрх асуудлуудыг үнэ цэнэрээ илүү их ашиг бүтээх бололцоотойг "Хуваалцахуй" үнэ гэсэн ойлголт бий болгож байгаа юм. Энэ нь байгууллагын дотоод зардлыг байнга нэмэгдүүлж байдаг үр ашиггүй эрчим хүчний хэрэглээ, түүхий эд материал, өртөг өндөртэй осол аваар, ур чадваргүй, сэтгэлгүй ажилчид гэх мэт нийгмийн хор хөнөөл, сул талуудыг ойлгон ухаарах тухай юм. Нийгмийн хор хөнөөл, хязгаарлалтуудад анхаарлаа хандуулахад компанийн дотоод зардлыг өсгөх шаардлагагүй байдаг. Өөрөөр хэлбэл, үйл ажиллагааны арга аргачлал, менежмент, шинэ технологийг ашиглах замаар инноваци хийж болдог. Үр дүнд нь компанийн бүтээмж болон зах зээлийн цар хүрээ өсөн нэмэгддэг.

Хуваалцахуйн үнэ цэн бол хувь хүний үнэт зүйл эсвэл компаниудад аль хэдийн бий болсон үнэ цэнийг хуваарилах болон хуваалцах тухай ойлголт огт биш юм. Харин энэ бол эдийн засгийн болон нийгмийн үнэ цэнийн хүрээг улам нэмэгдүүлэх тухай юм. Тус ялгааг харуулах тод жишээ бол аливаа худалдан авалт дах шударга худалдааны хөдөлгөөн юм. Шударга худалдааны зорилго бол ижил ургац хурааж буй ядуу фермерүүдэд илүү өндөр үнийг төлөх, орлогын тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэх байдаг. Энэ утгаараа шударга худалдаа бол фермерүүдийн үнэ цэнийг нэмэгдүүлэх бус бий болгосон үнэ цэнийг дахин зөв хуваарилахад чиглэгдэж байна. Хуваалцахуйн үнэ цэнийн сэтгэлгээгээр, фермерүүдийн үр ашиг, бүтээгдэхүүний чанар, тогтвортой байдлыг нэмэгдүүлэхийн тулд тариалан эрхлэх технологи, бүс нутгийн дэмжих үйлдвэрлэлийн кластер болон боловсролд нь төвлөрөн ажилладаг. Үүгээр компани болон нийлүүлэгч фермерүүдийн аль алиных нь өгөөжийг нэмэгдүүлж, ашгийн болон орлогын потенциал өсдөг. Coted Ivoire – ийн какао үйлдвэрлэгч фермерүүдийн дунд хийсэн судалгаагаар шударга худалдаа нь фермерүүдийн орлогыг 10-20 хувиар нэмэгдүүлсэн бол хуваалцахуйн үнэ цэнийн хөрөнгө оруулалт 300 хувиар өсгөж чадна гэсэн байна. Шинэ ханган нийлүүлэлтийн практикийг хэрэгжүүлэх, дэмжих кластерыг хөгжүүлэхэд анхны хөрөнгө оруулалт болон цаг хугацаа ихээхэн шаардах боловч эргэх өгөөж нь бүх оролцогч талуудад стратегийн өргөн ач холбогдол, эдийн засгийн үнэ цэнийг бий болгоно.

ХУВААЛЦАХҮЙН ҮНЭ ЦЭНИЙН СУУРЬ ЗАРЧИМ

Үндэс сууриндаа компанийн өрсөлдөх чадвар болон нийгэм олон нийтийн хөгжил хоорондоо нягт уялдаатай зүйлүүд юм. Өөрөөр хэлбэл, амжилттай бизнес эрхлэхэд зөвхөн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт хэрэгцээ бус бизнесийн үйл ажиллагааг дэмжих орчин, эрүүл нийгэм, нийгмийн өмч хөрөнгө чухал үүрэгтэй. Нөгөө талаар нийгэм амжилттай оршин тогтноход иргэдийн баялгийг өсгөх боломж, ажлын байр, амжилттай бизнесүүд чухал үүрэгтэй.

Капитализмыг хуучин, хумигдмал өнцгөөр харвал бизнесүүд хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, цалин урамшуулал өгч, худалдан авалт хийж, татвар төлж, хөрөнгө оруулалт хийж, ашиг олох замаар нийгэмдээ хувь нэмэр оруулдаг гэж үздэг. Харин бизнесийг энэ маягаар нь эрхлэн явуулбал нийгэмд үзүүлэх өгөөж үр ашиггүй байх болно. Нөгөөтээгүүр компаниуд нийгэм болон олон нийтийн асуудлуудаас ангид бие даасан томоохон нэгж (*тустогорхойлолт нь корпорацийн нийгмийн хариуцлагын талаарх ойлголтыг шүүмжлэгч Милтон Фригмены гэвшүүлсэн санаа байдаг*) байдаг. Энэ хандлага бол сүүлийн 20 гаруй жил удирдлагын сэтгэлгээнд түгэн дэлгэрсэн байна. Компаниуд өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ илүү олон хэрэглэгчдэд, илүү олныг зарахад голлох анхаарлаа хандуулдаг. Байнгын өсөн нэмэгдэж буй өрсөлдөөн, гүйцэтгэлтэй холбогдсон хувьцаа эзэмшигчдийн дарамт шахалтууд нь менежерүүдийг бүтцийн инженерчлэлийг дахин хийх, хүн хүчний нөөцийг багасгах, бага өртөгтэй бүс нутгуудад шилжих шийдвэрүүдэд хүргэдэг бөгөөд энэ

нь бүтээгдэхүүнүүд хоорондын ялгаа багасах, үнийн өрсөлдөөн, бодит бус инноваци, органик бус өсөлт, цэвэр өрсөлдөөний давуу тал үүсэхгүй байх нөхцөл үүсгэж байна. Энэ төрлийн өрсөлдөөнд ашгийн хэмжээ өссөн ч гэсэн олон нийт, нийгэм, хэрэглэгчид багахан хэмжээний өгөөж хүртдэг.

Стратегийн онолууд нь хэрхэн яаж амжилттай байх тухай сургадаг. Тиймээс ч компани амжилттай байхын тулд зорилтот хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангасан өвөрмөц үнэ цэнийн саналыг бүтээх шаардлагатай тулгарч байдаг. Мөн үнэ цэнийн хэлхээг хэрхэн оновчтой хэлбэржүүлсэн эсвэл бүтээгдэхүүн үйлчилгээг бүтээхээс эхлээд үйлдвэрлэх, худалдан борлуулах гэх мэт үйл ажиллагаануудын багцыг хэрхэн боловсруулснаас өрсөлдөөний давуу тал бий болдог гэж үздэг. Өөрөөр хэлбэл өмнөх хэдэн арван жилийн турш бизнесменүүд үйл ажиллагаануудаа хэрхэн загварчилж, уялдуулж, байршиж байгааг судалж ирсэн боловч үнэ цэнийн гинжин хэлхээнд нийгмийн асуудал, бэрхшээлүүд хэрхэн нөлөөлж байгааг ойлгоогүй байдал ажиглагддаг. Мөн нийгмийн суурь хэрэглээнүүдийн цаана ямар том боломжууд нуугдаж байгааг компаниуд олж харахгүй өнгөрсөөр байгаа юм.

Компаниуд өрсөлдөөний давуу тал бий болгоход бизнесийн боломжууд чухал байдаг. Гэтэл менежерүүдийн ихэнх нь салбарт эсвэл өрсөлдөөнд анхаарлаа хандуулж, салбарын бүтцийг компанийн ашигт ажиллагаанд нөлөөлөх боломж гэж харж байна. Харин тэд үйл ажиллагаанд нь нөлөөлж буй нийгмийн асуудлуудыг боломж

гэж харахгүй байгаа нь уламжлалт үнэ цэнийн холбоосыг илүү өргөн хүрээнд харах боломжгүй байдлыг үүсгэж байна. Эндээс менежерүүд капитализмын шинэ боломж гэж нэрлэгдэж буй "хуваалцахуйн үнэ цэн"-ийг ойлгох зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд үүнийг дараах байдлаар тодорхойлж болно.



Хуваалцахуйн үнэ цэн гэдэг нь "үнэ цэн бүтээж буй газар зүйн хүрээний нийгэм эдийн засгийн төлөвийг хамаарагдаж буй хүн ам зүйн төлөвтэй нь нэгэн зэрэг хөгжүүлэх, тасралтгүй сайжруулах компанийн системчлэгдсэн бизнесийн бодлого, үйл ажиллагааны багц" юм.

ХУВААЛЦАХУЙН ҮНЭ ЦЭН ХЭРХЭН БҮТЭЭГДДЭГ ВЭ?

Компаниуд нийгэмд үнэ цэнийг бүтээх замаар эдийн засгийн үнэ цэнийг бүтээж чадна. Өөрөөр хэлбэл, үнэ цэнийг бүтээх ялгаатай 3 арга зам байдаг.

1. Бүтээгдэхүүн ба зах зээлийн талаарх үзэл бодлоо өөрчлөх

Эрүүл мэнд, амьдрах орчин, эрүүл хооллолт, санхүүгийн аюулгүй байдал, орчны аюулгүй байдал гэх мэт нь нийгмийн зайлшгүй хэрэгцээнүүдийн үндэс суурь нь болдог. Харин эдгээрийг эдийн засгийн ханасан утгаар нь хангах нь бараг бололцоогүй байдаг. Хөгжингүй эдийн засагтай орнуудад бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээг нийгмийн хэрэгцээтэй нийцүүлэх хандлага хурдацтай өсч байна. Жишээ нь хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид уламжлалт зарчмаар амт чанар, тоо

хэмжээнд анхаарал хандуулдаг байсан бол хүмүүсийн илүү их хэрэглээ нь илүү тэжээллэг байх суурь хэрэгцээнд дахин анхаарахад хүргэж байна. Intel, IBM компаниуд хялбар, эдийн засгийн хэмнэлттэй, эрчим хүчний ашиглалт багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг хичээж байхад "Wells Fargo" компани хэрэглэгчдэд өр зээлээ барагдуулах, зээлээ удирдах, санхүүгийн төсөв төлөвлөгөө хийх шинэ төрлийн хэрэгсэл, бүтээгдэхүүний шугамыг хөгжүүлсэн байна. Түүнчлэн General Electric компанийн харилцаа холбоо, тээвэр, эрчим хүч, уул уурхайн салбаруудын "Ecomagination" төслийн бүтээгдэхүүнүүдийн борлуулалт 2009 онд 18 тэрбум долларт хүрч, дараагийн 5 жилд 2 дахин өссөн байдаг.

Хуваалцахуйн үнэ цэн бүтээх боломж нь эдийн засгийн ядуу буурай

хөгжилтэй улс орнуудад илүү байх хандлага байдаг. Өөрөөр хэлбэл, эдгээр улс орны нийгэм, эдийн засгийн байдал нь бусдын олж хараагүй байгаа боломжит зах зээлүүд болдогтой холбоотой юм. Тухайлбал дэлхийн томоохон бизнес эрхлэгчдийн анхаарал "Пирамидын доорх баялаг" руу анхаарлаа хандуулж Хятад, Бразил, Энэтхэгийн сая сая шинэ хэрэглэгчдийн хэрэгцээ, нийгмийн асуудлуудад хүрэхийг эрмэлзэж байна. Жишгээ Адидас компани, Бангладешийн Крамеен банктай хамтран ядуу иргэдэд зориулсан хямд үнэтэй спорт гутал үйлдвэрлэж байна. Мөн Кенид, Vodafone, M-PESA гар утасны банкны үйлчилгээ 3 жилийн дотор 10 сая гаруй хэрэглэгчдэд хүрч чадсан байна.

Капитализм нийгмийн илүү эмзэг, ядуу бүлгийнхэн рүү чиглэж ажиллаж эхэлж байгаа нь нийгмийн болон эдийн засгийн хөгжлийг экспоненциалаар өсгөх шинэ боломжууд байдагтай холбоотой. Компаниудын хувьд нийгмийн бүхий л хэрэгцээ, асуудлууд, зовлон бэрхшээлийг танин мэдэх, бүтээгдэхүүн үйлчилгээнд асуудлын шийдлийг шингээх нь энэ төрлийн үнэ цэнийг бүтээх эхлэлийн цэг юм. Нийгмийн болон эдийн засгийн өсөлт хөгжил, технологийн хувьслаас шалтгаалж тус боломжууд нь үргэлж өөрчлөгдөж, тогтмол бус шинжтэй байдаг. Нийгмийн хэрэгцээг тасралтгүй нээн илрүүлж байх нь уламжлалт зах зээл дээр дахин байрших, ялгарах болон бусдын олж хараагүй шинэ зах зээлийг нээн хөгжүүлэх боломжийг компаниудад олгодог. Бусдын орж үйлчлээгүй зах зээл нь бүтээгдэхүүн, үйлчилгээний өвөрмөц дизайн, бусдаас ялгаатай хуваарилалтын сувгийг мөн шаарддаг.


2. Үнэ цэнийн гинжин хэлхээний бүтээмжийг дахин шинэчлэх

Компанийн үнэ цэнийн гинжин хэлхээ нь байгалийн нөөцүүд, усны хэрэглээ, эрүүл мэнд аюулгүй ажиллагаа, ажлын нөхцөл байдал, хөдөлмөрийн шударга харилцаа гэх мэт нийгмийн асуудлуудад нөлөөлөө үзүүлж тэдний нөлөөлөлд мөн адил автдаг. Нийгмийн асуудлууд нь компанийн үнэ цэнийн хэлхээн дэх зардлыг бий болгодог учраас хуваалцахуйн үнэ цэнийг үүсгэх боломжууд нэмэгддэг. Өөрөөр хэлбэл, ЗГ-ын зохицуулалт, татварын бодлого оновчгүй байх тусам маш олон дам нөлөөллүүд компанийн дотоод ашигт ажиллагаанд хохирол учруулдаг. Жишээ нь бүтээгдэхүүний хаягдал сав баглаа, боодол, газны хэрэглээ нь зөвхөн байгаль орчинд нэмэгдэл зардлыг үүсгэхээс гадна бизнест ч хүртэл зардлыг нэмэгдүүлж байдаг. 2009 онд Wall-Mart компани сав баглаа бодлын хэрэглээ болон ачаа тээврийн маршрутаа 100 сая майлаар багасгаж, 200 сая долларыг хэмнэж чадсан байдаг. Мөн дэлгүүрүүдэд ашиглагдаж байсан пластикийн хэрэглээг хязгаарласан инновациуд нь олон сая долларыг хэмнэсэн байдаг.

Шинэ сэтгэлгээ нь уламжлалт хандлагаас илүү өргөн, гүнзгий түвшинд компанийн үнэ цэнийн хэлхээн/үйл ажиллагаанууг/ дахь бүтээмж болон нийгмийн тогтолцооны хөгжил хоорондын зохицуулалтыг шаардаж байна. Өөрөөр хэлбэл үнэ цэнэ хуваалцах зарчмаар нийгмийн асуудлуудад хандах, түүнд нийцүүлж үйл ажиллагааны шинэ хэлбэрийг боловсруулж ажилласнаар оролцогч талууд хооронд синерги үүсч, үйл ажиллагаануудын бүтээмж нэмэгдэж, зардлын хэмнэлт үүсдэг байна. Жишээ нь үйлдвэрлэгчдийн уламжлалт тээвэрлэлтээс шалтгаалж эсвэл түүнтэй үйл ажиллагаагаа нийцүүлэх шаардлагын улмаас жижиглэн худалдаачдад асуудал,

бэрхшээлийг үүсгэж болно. Гэвч энэ нь өнгөн хэсэгтээ жижиглэн худалдаачдын асуудал боловч үйлдвэрүүдэд нэмэгдэл зардлыг үүсгэх маш том асуудал байж

болно. Уламжлалт хандлагаар бусдын асуудал бол бусдын л асуудал байдаг, тиймээс тэд өөрсдөө энэ асуудлаа шийдэх ёстой гэж үзнэ.



Харин үйлдвэрлэгч хуваалцахуйн сэтгэлгээгээр жижиглэн худалдаачдад хандвал тэдний болон өөрсдийн асуудал бэрхшээлийг боломж болгон хувиргаж, аль алиныхаа бүтээмжийг өсгөхийн тулд оновчтой тээвэрлэлтийн үйл ажиллагааг дахин загварчилж болдог. Гэсэн хэдий ч

одоогоор цөөн хэдэн компаниуд бусдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, орчны үр нөлөө, ажилтнуудын тогтвор суурьшил, чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаануудын бүтээмжээс боломжит бүхий л өгөөжөө хүртэж чадаж байна.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Байгууллага нийлүүлэгчдэд нөлөөлөх эрх мэдлээ нэмэгдүүлж, аль болох үнийг хямд байлгах замаар бараа материал олж авах эсвэл өрхийн үйлдвэр, фермер, жижиг бизнес эрхлэгчдээс худалдан авалт хийх үйл явцыг бусдын ялгарлыг бууруулах (Commoditize) гэж нэрлэдэг. Сүүлийн жилүүдэд энэ үйл явдал улам эрчимжиж илүү орлого багатай байршилд байгаа нийлүүлэгчдээс аутсорсинг хийх

хандлага нэмэгдэж байна. Харин өнөөгийн зарим компаниуд ханган нийлүүлэгчдээ эмчлэхгүйгээр чанарын хувьд өсөлттэй, бүтээмжтэй, тогтвортой байх боломжгүй гэдгээ гүнзгий ойлгож байна. Өөрөөр хэлбэл, илүү нөөц олж авах боломжоор хангах, технологио хуваалцах, санхүүгийн туслалцаа үзүүлэх, нийлүүлэгчдийн чанарыг сайжруулах, их хэмжээгээр нийлүүлэх боломжийг гаргаж өгөх гэх мэтээр

тусалж, дэмжиж байна. Нийлүүлэгчид хүчтэй болох тусам тэдний орчны нөлөө гайхалтайгаар өсч, цаашлаад үр ашигт байдал нь нэмэгддэг. Энэ бол хуваалцахуйн үнэ цэн үүсч буйн илрэл юм.

Дээрх ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааны хамгийн сайн жишээг “Неспрессо” компаниас харж болдог. Тэд 2008 онд ойролцоогоор 101 тэрбум ам.долларын борлуулалт хийсэн ба дэлхийн хамгийн том хүнс үйлдвэрлэгч Нестлэ компанийн салбар бөгөөд 2000 оноос жил бүрийн өсөлт нь 30%-тай компани юм. Неспрессо жил бүр 2 тэрбум гаруй долларыг нэг хэрэглээний дээд зэргийн кофень борлуулалтаас олдог. Кофены бүтээгдэхүүний төрөлжилт нэмэгдэх тусам найдвартай нийлүүлэлтийн үйл ажиллагааг олж авахад маш их бэрхшээлтэй болсон байна. Учир нь ихэнх кофены үр Африк, Латин Америк зэрэг буурай хөгжилтэй орны орон нутгийн жижиг фермерүүдэд үйлдвэрлэгддэг бөгөөд

орчны дарамт шахалт, удирдлагын чадавхаас шалтгаалж бүтээмж, чанар, бүтээгдэхүүний тоонд байнга асуудал тулгардаг. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд Нестлэ компани тариалан эрхлэгчдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх, банкны баталгаа гаргах, ургамлын нөөц, пестицид, бордоо гэх мэт голлох нөөцүүдийн хадгалан хамгаалахад туслах замаар ханган нийлүүлэлтийнхээ үйл ажиллагааг дахин загварчилж тариаланчидтай эрчимтэй ажиллаж эхэлсэн. Мөн Нестлэ худалдан авалтын цэг дээр кофены чанарыг хэмжих орон нутгийн байгууламжийг бий болгосон ба ингэснээр илүү сайн үр тариалагчдад шууд урамшуулал олгох системийн мөн бий болгосон байдаг. Нэг га-гаас авах үрийн хэмжээ нэмэгдэж, үйлдвэрийн чанар сайжирсан нь тариаланчдын орлогыг болон орчинд нөлөөлөх нөлөөллийг нэмэгдүүлсэн байна. Үүний үр дүнд Нестлэ компани хамгийн сайн кофе ургуулах найдвартай нийлүүлэлттэй болсон байна.



ХУВИАРААЛТЫН СУВГИЙН ҮЙЛ АЖИЛААГАА

Компаниуд хуваалцахуйн сэтгэлгээгээр хуваарилалтыг сувгаа дахин зохион байгуулж, шинэчилж байна. Тухайлбал, iTunes, Kindle, Google Scholar (*эргэм шинжилгээний бүтээлүүдийг онлайнаар санал болгогор*) харуулахын зэрэгцээ ашигтай шинэ түгээлтийн загвар нь цаас болон хуванцруудын хэрэглээг эрс багасгаж байна. Мөн микрофинанс жижиг бизнес эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээ хүргэх үр ашигтай хуваарилалтын сувгийг боловсруулсан байна. Хуваарилалтын сувгийн шинэ загвар боловсруулах боломжууд нь уламжлалт бус зах зээл дээр их байдаг. Жишээ нь, Unilever компанийн Энэтхэг дахь салбар болох "Hindustan Unilever" компани 2000-аас доош хүн амтай тосгонуудад эмзэг бүлгийн эмэгтэй бизнес эрхлэгчдээр дамжуулан "Direct-to-home" хуваарилалтын сувгийг хөгжүүлсэн байдаг. Мөн тэд Энэтхэгийн 15 мужийн 100 мянга гаруй тосгодыг хамарсан 45 мянга гаруй бизнес эрхлэгчдэд бичил

зээлийн болон сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх хуваарилалтын сувгийг "Shakti" гэж нэрлэсэн бөгөөд эмэгтэйчүүдийн чадварыг нэмэгдүүлэхээс гадна, өрхийн орлогыг хоёр дахин нэмэгдүүлэх, эрүүл ахуйн бүтээгдэхүүний хүртээмжийг ихэсгэж халдварт өвчний тархалтыг бууруулах, олон нийт, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэгддэг. Энэ бол шаардлагатай хүмүүсийнх нь гарт, амьдралд нь хэрэгтэй бүтээгдэхүүнийг хүргэж нийгмийн үр өгөөжийг бий болгох, зах зээлийнхээ хүрч чадахгүй байгаа хэрэглэгчиддээ хэрхэн хүрч байгааг харуулсан бизнесийн өвөрмөц чадварын тод жишээ юм. Мөн "Shakti" төсөл нь Энэтхэг дэх Unilever-ийн нийт орлогын 5% -ийг эзэлдэг бөгөөд цаашлаад компани мэдээ, мэдээллийн харанхуй буюу алслагдмал орон нутагт үйл ажиллагаагаа чиглүүлж, компанийн эдийн засгийн үнэ цэнийг бий болгож байна.

АЖИЛТНУУДЫН БҮТЭЭМЖ

Ажилтнуудынхаа цалин хөлсийг бууруулах, тэтгэмж тэтгэлгийг хасах нь ажилтнуудынхаа бүтээмжтэй байх үндэс болдог сурч хөгжих боломжууд, аюулгүй байдал, сайн сайхан, эрүүл байдал, амьдрахуйц цалин хөлсний бодит эерэг нөлөөллийг таслан зогсоох эхлэл болдог. Жишээлбэл, олон компани ажилчдын эрүүл мэндийн халамжийн "үнэтэй" зардлыг багасгах, эсвэл эрүүл мэндийн даатгалыг бүхэлд нь арилгахыг эрмэлзэж байна. Гэтэл өнөөдөр тэргүүлэгч компаниуд алдсан ажлын өдрүүд, хорогдсон бүтээмж, эрүүл мэндийг нөхөн сэргээхэд гаргасан зардлууд нь нэмэгдүүлсэн

тэтгэмж, өсгөсөн цалингаасаа илүү хор хохиролтой байгаад суралцаж байна. Жишээ нь, Johnson&Johnson компани ажилтнуудаа тамхинаас гарахад нь дэмжлэг үзүүлж (өнгөрсөн 15 жилд 70% нь тамхинаас гарсан), мөн эрүүл мэндийн олон талт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр 250 сая ам.долларын хэмнэлтийг бий болгож чадсанаас гадна бүтээмж огцом нэмэгдүүлж чадсан байна. Хэрэв хөдөлмөрийн холбоо, эвслүүд энэ хуваалцахуйн сэтгэлгээ руу төвлөрч чадвал энэ төрлийн хөдөлмөрийн харилцаа илүү хурдтай хөгжих болно.

Байршил

Зах зээл илүү глобалчлагдаж, мэдээллийн урсгал нэмэгдэж, ложистик үнэгүй болж буй учраас байршил бол урт хугацааны чухал асуудал биш гэдэг үлгэр домог шиг ойлголт бизнесийн сэтгэлгээнд хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Байршил хямд болох тусам илүү сайхан болно гэдэг ч яг үнэндээ компанийн үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн хөгжил гандаж муудна гэдэгт хэн ч санаа зовдоггүй.

Бизнес эрхлэгчдийн дээрх хэт энгийн сэтгэлгээ нь бэрхшээлтэй тулгарч байна. Учир нь, зарим талаараа их тархан байршсан үйлдвэрийн системийн үйлдвэрлэлийн өртөг болон алслагдмал бүс нутгийн ханган нийлүүлэлтийн нуугдмал зардал өсөхөөс гадна эрчим хүч болон нүүрстөрөгчийн ялгаруулалтыг нэмэгдүүлдэг байна. Жишээ нь Wall-Mart бүс нутгийн хүнсний фермерүүдийн ойролцоох агуулахдаа буюу эх үүсвэрт нь үйлдвэрлэх (*sourcing produce*) практикийг өргөн нэвтрүүлсэн байдаг. Ингэснээр тээвэрлэлтийн зардлыг хэмнэхээс гадна, алслагдсан фермерүүдийн хямд үнийг нөхөхөөс илүүтэй жижиг хэмжээгээр нөөцлөх боломжийг нээж өгсөн юм. Мөн Nestle компани зах зээлийнхээ ойролцоо жижиг үйлдвэрүүдийг бий болгож, бүс нутгийн материаллаг нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлж байна.

Хөгжиж буй орнуудын үйлдвэр, компаниудын байршлын стратеги өөрчлөгдөж байна. Тухайлбал дэлхийн тэргүүлэгч самар үйлдвэрлэгч, Olam International компани Африкаас Азийн үйлдвэрүүд рүү түүхий самраа тээвэрлэж, үйлдвэртээ бүтээмж

өндөртэй ази ажилчдыг ажиллуулдаг байсан бол энэ үйл ажиллагаагаа хязгаарлаж, Африкийн бүс нутгуудад үйлдвэрлэлээ нээж, ажилчдыг нь сургаж эхэлсэн байна. Үүний үр дүнд Olam International үйлдвэрлэлийн болон тээвэрлэлтийг зардлыг 25%-иар бууруулсан байна. Мөн бүс нутгийн нутгийн фермерүүдтэй харилцаа сайжирч, бүс нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж чадсан байна.

Эдгээр өөрчлөлтүүд нь тэргүүлэгч компаниудын үйл ажиллагааг илүү эх үүсвэрт нь ойртсон, цөөн хэдэн томоохон байршилд төвлөрсөн үнэ цэнийн шинэ хэлхээг хэрхэн бий болгож байгааг харуулж байна. Өнөөг хүртэл олон компаниуд глобал түвшинд хүрнэ гэдэг нь хөдөлмөрийн зардал багатай байршлуудад үйлдвэр байгуулж, зардлыг хамгийн бага түвшинд нийлүүлэлтийн хэлхээг загварчлах тухай боддог байсан бол бодит байдал дээр ОУ-ын хүчтэй өрсөлдөгчид чухал нийгмийн бүлгүүдтэй гүнзгий харилцаа холбоо бий болгохыг хичээн ажиллаж байна. Компаниуд байршлын хувьд шинэ сэтгэлгээг олж харснаар хуваалцахуйн үнэ цэнийг бүтээх болно.

3. Бүс нутгийн кластеруудыг бүтээн бий болгох

Бүх зүйлийг өөрөө эзэмшдэг компани гэж байдаггүй. Компани бүрийн амжилт нь эргэн тойрон дахь бусад компани болон дэд бүтцээс ихээхэн хамаардаг. Уялдаатай бизнесүүд, нийлүүлэгчид, ложистикийн дэд бүтэц, компаниудын газарзүйн төвлөрөл бүхий кластеруудаас аливаа инноваци, бүтээмж шууд хамаардаг. Тухайлбал мэдээлэл, технологийн салбарт Silicon Valley, Кенийн

цэцэгчид, Энэтхэгийн Сураат дахь алмаз, эрдэнэс боловсруулагчдыг дурдаж болно. Аливаа кластеруудад зөвхөн бизнесүүд багтах бус академик хөтөлбөрүүд, худалдааны холбоо эвсэл, стандартын байгууллагууд, институцууд багтдаг. Мөн түүнчлэн хүрээлэн буй олон нийт, нийгмийн хэрэгцээг хангах олон нийтийн өмч хөвөнгүүдийг бий болгодог. Тухайлбал, сургууль, цэцэрлэг, цэвэр ус, шударга өрсөлдөөний хууль, чанарын стандарт гэх мэт. Кластерууд нь бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих, бүтээмж, инноваци, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Чадавхтай бүс нутгийн нийлүүлэгчид нь ложистикийг илүү үр ашигтай болгож, хамтарч ажиллахад хялбар болгодог. Мөн сургалт, тээврийн үйлчилгээ, бусад уялдаатай салбарууд дахь бүтээмж дээшилдэг. Дэмжих кластергүй бол ямар ч шинэ зүйл хөгжлийн хувьд удаашралтай, эсвэл уналтад ордог. Кластерыг хүрээлэн байгаа нөхцөл байдлуудын дутагдалтай талууд нь пүүс, компаниудад дотоод зардлыг бий болгодог. Олон нийтийн боловсрол муу байх нь бүтээмж болон сургалтын зардлыг нэмэгдүүлдэг. Тээврийн дэд бүтэц муу байх нь ложистикийн зардлыг өсгөдөг. Хүйс болон арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдал нь чадварлаг ажилтнуудын тоог цөөрүүлдэг. Ядуурал нь бүтээгдэхүүний эрэлтийг хязгаарлаж, байгаль орчны доройтол, эрүүл бус ажилчид, аюулгүй байдлын зардлыг нэмэгдүүлдэг. Пүүс, компаниуд кластерын хүрээлэн байгаа нөхцөл байдлуудын алдаа дутагдлыг засварлаж, компанийнхаа бүтээмжийг нэмэгдүүлэх замаар хуваалцахуйн үнэ цэнийг бүтээх кластеруудыг бүтээдэг.

Хөгжиж байгаа болон хөгжингүй улс орнуудад кластеруудыг бүтээн бий болгох гол нөхцөл нь нээлттэй, ил тод

зах зээл бий болох явдал юм. Үр ашиггүй эсвэл монополи зах зээл дээр ажилчид үнэгүй ашиглагдаж, нийлүүлэгчид шударга бус худалдаа, хэлэлцээрээс хохирч, үнийн ил тод байдал алдагдаж, бүтээмж буурдаг. Нээлттэй, шударга зах зээл нь бүс нутгийн иргэдийн худалдан авах эрх чөлөө болон орлогыг нэмэгдүүлж, компаниудад найдвартай нийлүүлэгч, нийлүүлэгчдийн чанар, үр ашигт тохирсон урамшуулал, түншүүдэд шударгаар хамтран ажиллах боломжийг олгодог. Үр дүнд эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн эерэг дүр зургууд бий болдог.

Компаниуд гол байршлууддаа кластеруудыг бий болгосноор компанийн амжилт болон бүс нутгийн олон нийт, нийгмийн амжилтын хооронд холбоос нэмэгддэг. Тухайлбал, компанийн өсөлт нь дэмжих үйлдвэрүүдэд ажлын байр бий болгож, шинэ компаниудыг үүсгэж, нэмэлт үйлчилгээнүүдийг үүсгэх олон талт нөлөөг үзүүлдэг.

Бидний өмнө нь дурдаж байсан Nestle компанийн ханган нийлүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн кластер бол үүний тод жишээ юм. Цаашлаад тус кластерт бүс нутгийн үйлдвэрлэгч бүр үр ашигтай, чанартай үйлдвэрлэл явуулахад шаардлагатай ложиситик, санхүү, технологи, хөдөө аж ахуйн барилга, байгууламжуудыг бий болгосон байдаг.

Кластерынхаа нөхцөл байдлын дутагдалтай талуудыг сайжруулах замаар ажиллаж байгаа өөр нэг сайн жишээ бол дэлхийн хамгийн том эрдэс, бордооны компани болох "Yara" юм. Тэд африкийн бүс нутгуудын ложистикийн дэд бүтцийн дутагдал нь фермерүүдэд бордоо болон бусад хөдөө аж ахуйн чухал түүхий эдийн борлуулалтаас үр

ашиг хүртэх, зах зээлдээ хүрч ажиллахад саад болж байгааг ойлгосон. Мөн тэд Mozambique — ээс Tanzania хүртэл хөдөө аж ахуйн хөгжлийн коридор бий болгож, зам, гүүр болон бусад хөрөнгө оруулалтад 60 сая долларыг зарцуулсан байна. Компани энэ санаачлангаа бүс нутгийн засаг, захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж, Норвегийн ЗГ-аас дэмжлэг авсан байна. Зөвхөн Mozambique-д л гэхэд 200 мянга гаруй жижиг фермерүүд, 350 мянган ажлын байр бий болсон байна. Тус сайжруулалт нь хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлэхээс гадна “Үгэг” —ийн бизнесийн цар хүрээг өсгөхөд чухал ач холбогдолтой.

Өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй бүс нутаг, олон нийтийн кластеруудыг хөгжүүлэхийн тулд компаниуд нэн тэргүүнд тухайн бүс нутгийн ложистик, нийлүүлэгчид, хуваарилалтын сувгууд, сургалт, боловсролын байгууллагуудын дутагдалтай асуудлуудыг олж харах хэрэгтэй.

Дараа нь компани өөрийн бүтээмж, өсөлтөд хамгийн их саад

тотгор учруулж буй сул талуудыг анхаарч, ямар асуудлууд дээр хэнтэй, хэрхэн хамтарч ажиллах вэ гэдгээ маш сайн салган ойлгох хэрэгтэй болдог. Үүнээс л хуваалцахуйн үнэ цэн бий болох боломжууд үүсдэг.

Компаниудын үйл ажиллагааг хязгаарлаж байгаа кластерын дутагдалтай талыг сайжруулахад чиглэгдсэн санал санаачилгууд нь олон нийтэд чиглэгдсэн корпорацын нийгмийн хариуцлагын хөтөлбөрүүдтэй харьцуулахад илүү үр нөлөөтэй байдаг. Учир нь, эдгээр хөтөлбөр нь үнэ цэнд төвлөхгүйгээр хэт олон асуудлуудад хязгаарлагдмал нөлөө үзүүлдэг.

Бүс нутгийн боловсрол болон дэд бүтцийг хөгжүүлэхэд хамтын хөдөлмөр шаарддаг, тиймээс компаниуд энэ зорилгыг биелүүлэх чадвартай, дэмжлэг үзүүлэхүйц, өртөг зардлыг хуваах боломжтой оролцогч талуудын жагсаалтыг гаргах шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл, ихэнх амжилттай кластеруудын хөгжлийн хөтөлбөрт хувийн сектор, ЗГ, ашгийн бус байгууллагуудын хамтын оролцоог чухалчилсан байдаг.

СУДЛААЧ ДОКТОРАНТ МАГИСТРАНТЫН БУЛАН

Эрхэм хүндэт уншигч таны энэ өдрийн амгаланг айлтгая.

"Economic Analytica" улс төрийн эдийн засаг судлал сэтгүүл нь олны хүртээл болсон цагаасаа уншигчдийн хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд нийцэж, улмаар цар хүрээгээ тэлэн өргөжиж байгаад бид бүхэн туйлын баяртай байна.

Сэтгүүлийн зүгээс өөрийн орны эрдэм судлалын ажилд хувь нэмэр оруулах, судлаач залуусыг дэмжих, тэдний эрдэм шинжилгээний өгүүлэл бичих чадварыг дээшлүүлэх зорилгоор энэ удаагийн дугаараас эхлэн докторант, магистрант оюутнуудад бүтээлээ нийтлүүлэх боломж олгон энэхүү буланг эрхлэн гаргаж байна.

Та бүхний судалгааны ажилд амжилт хүсэн ерөөе.

Редакцын зөвлөл

“ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ”-ИЙН ШИНЭЧЛЭН ЗОХИЦУУЛСАН АСУУДЛУУД

Д.Отгончимэг

СЭЗИС-ийн Ph.D хөтөлбөрийн докторант, (MBA)

Abstract. This study was conducted on the current regulatory drafting process of the General Law of taxation of Mongolia, and is prepared to be submitted to the Ikh Khural, which identifies and resolves current problems, and also changes were made to the existing law.

This study covers the issues of historical development of Mongolia's tax law, trend, general tax draft law, progress and weaknesses, and comparison of the US and Chinese tax system concepts of theory. Also, tax returns are based on the balance sheet of the EO's financial statements. Accountants and financial managers must have a good theoretical knowledge of taxation for elaboration accounting policies. As part of my research, I have studied the current situation of taxation Mongolia.

Key words: Taxation system, tax policy, general tax law

Хураангуй. Удахгүй УИХ-д өргөн барихаар бэлтгэгдэж байгаа МУ-ын татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалт, өнөөгийн тулгамдаж буй асуудлыг тодорхойлж шийдвэрлэж байгаа арга зам, одоо хэрэглэгдэж байгаа хуулиас ялгаатай өөрчлөлтүүдийн талаар энэхүү судалгааны ажлыг хийв. Судалгааны ажлын хүрээнд МУ-ын татварын эрх зүйн түүхэн хөгжил, чиг хандлага, татварын ерөнхий хуулийн төслийн шинэчилсэн асуудлууд, дэвшилтэт болон сул тал, АНУ, БНХАУ-ын татварын системийн онолын үзэл баримтлалын харьцуулалт зэрэг асуудлыг судлав. Мөн татварын тайлан нь ААНБ-ын санхүүгийн тайлан балансанд суурилж гардаг. НББ-ийн бодлого боловсруулахад нягтлан бодогч, санхүүгийн менежерүүд нь татварын хууль, тогтоомж, онолын мэдлэгтэй байх зайлшгүй шаардлагатай байдаг. Өөрийн судалгааны сэдэвт хамаарах үүднээс МУ-ын татварын өнөөгийн байдлын талаар хавсран судалсан болно.

Түлхүүр үгс: Татварын тогтолцоо, татварын бодлого, татварын ерөнхий хууль,

ОРШИЛ

Татвар нь түүхэн хөгжлийнхөө явцад улс орны санхүүгийн хүчирхэг хэрэгсэл, тусгаар тогтнолын бүрэн эрхт байдлын баталгааг хангах гол асуудал болж байсныг түүхийн үйл

явц гэрчилдэг. Татварын тогтолцоо нь өнөө үед ч төрийн төсвийн орлогыг бүрдүүлэх, эдийн засгийн аливаа бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх, нийгмийн сайн сайхныг дэмжих,

орлогыг тэгш хуваарилах гэх мэт үйл ажиллагааны үндсэн арга зам нь болдог. МУ-ын УИХ-аас баталсан Үндсэн хууль, татварын хууль тогтоомжуудын акт нь татварын тогтолцоог хангах гол эрх зүйн зохицуулалт болдог. Татварын эрх зүйн хэм хэмжээ нь нийтийн эрх зүйн салбар захиргааны эрх зүйн нэг хэсэг бөгөөд татварын тогтолцооны үндсэн зарчмуудын дагуу татвар нь тэгш шудрага, тодорхой, төлөгдөхүйц, үр ашигтай байх ёстой юм. Дэлхийн улс орнууд даяарших тусам улс орны эдийн засгийн хөгжлийн бодлогын хүрээн дэх татварын асуудал улам бүр нарийсч байна. Тухайлбал үндэстэн дамнасан корпорацуудын хүрээнд үнэ шилжүүлэлтийн аргачлал, техникийг боловсронгуй болгох, СТОУС болон OECD-ийн журам, татварын гэрээ, дотоодын хууль тогтоомжийн хүрээнд холбоотой талуудын ойлголтыг нэг мөр болгох, татварын нөлөөллийн судалгаа болон компанийн хөрөнгө шилжүүлэлт, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалт (ялангуяа уул уурхайн

салбарт) МУ-д сүүлийн жилүүдэд эрс нэмэгдсэнтэй холбоотой татварын системийг сайжруулах, татварын хууль зөрчих, тайлангаа буруу гаргах, татвар нуух гэх мэт олон асуудлууд тулгарч байна. Европын холбооноос Монгол Улс татварын орчин тааруу, Европын холбоотой хамтарч ажилладаггүй, татварын талаарх мэдээлэл ил тод бус байдалтай гэж дүгнэжээ. Татварын тогтолцооны орчноо сайжруулах үүргийн дагуу Засгийн Газар татварын багц хуулиудыг боловсруулж 2018 оны эхнээс Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, дагалдах бусад 20 хуулийн нэмэлт оруулах тухай төслийн талаар бүх нийтийн хэлэлцүүлэг явагдаж дуусаад МУ-ын УИХ-д өргөн барихад бэлэн болж байна.

МУ-ЫН ТАТВАРЫН ХӨГЖЛИЙН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАА


Эдийн засгийн онолоор татвар нь зах зээлийн эдийн засгийг зохицуулдаг гол механизм, хэрэгслэлүүдийн цогц юм. Төрөөс татварын бодлого, макро эдийн засгийн бодлогыг нэгдмэл системтэйгээр судалж, тохируулан тааруулж, нийгмийн өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай болдог. Эдийн засгийн ихэнх номлолд татварын үндсэн 2 үүргийг тодорхойлсон байдаг. Энэ нь санхүүгийн буюу төсвийн, үйлдвэрлэлийн буюу зохицуулалтын

үүргүүд юм. МУ-ын татварын өнөөгийн хөгжлийн үе шатыг авч үзвэл төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн энэ үеэс татварын бодлогыг шинээр тодорхойлох шаардлага бий болсон байна. 1990 он хүртэл албан татварын бие даасан эрх зүйн тогтолцоо байсангүй. УИХ-с татварын багц хуулиудыг үе шаттайгаар 1992 оноос эхлэн батлан мөрдүүлснээр татварын шинэ төрлүүдийг бий болгожээ. Татвар төлөгч гагцхүү хуульд

заасан үндэслэл, журмын дагуу татвараа өөрөө тодорхойлох болон татварын алба тодорхойлж төлүүлэх гэсэн 2 системээр, хуулиар тогтоосон хувь хэмжээгээр төлөх шинэ тогтолцоонд бүрэн шилжих болсон. Монгол Улсын татварын тогтолцооны хөгжлийн эхний үе шат 1992-2006 онуудад татварын санхүүгийн үүрэг голлож байв. Улсын сектор хувьчлагдаж, хувийн өмчит ААНБ-ууд дөнгөж үүсч, төсвийн орлогын тогтвортой эх үүсвэр төлөвшөөгүй энэ үед татварын тогтолцоог бүрдүүлэхдээ татварын орлогыг яаж бүртгэх вэ, хэрхэн орлогыг ихээр бүрдүүлэх вэ гэсэн үзэл давамгайлж байжээ. Энэ үед татварын бодлого хатуу, татварын хувь хэмжээ, хариуцлага өндөр байв. 2006-2008 онуудад татварын тогтолцоо шинэчлэгдэн боловсронгуй болох хөгжлийн дараагийн үе шатанд шилжиж татварын ерөнхий хууль, ААНОАТ, ХХОАТ, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын өршөөл үзүүлэх тухай хууль, Татварын ерөнхий хуулийг шинэчлэн баталсан байна. Татварын шинэчлэл хийгдснээр эдийн засгийн агуулгаараа татварын үйлдвэрлэлийн үүрэг гүйцэтгэх үндэс тавигдсан байна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн орчныг сайжруулж “ил тодын хууль” гэж

нэрлэсэн зарим хууль, татварын өршөөл үзүүлэх хууль нь 300 гаруй татвар төлөгчийн хэдэн тэрбум төгрөгийн татварын өрийг өршөөж, 2670 ААНБ, 3400 татвар төлөгч татварын шинэчилсэн тайлан гаргаж, татварын хэмжээг бууруулж бизнес эрхлэгчдийг дэмжиж, татварын ачааллыг бууруулжээ. 2010 онд агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль баталснаар татварын нэр төрөл нэмэгдсэн байна. 2012 онд Байгалын нөөц ашигласаны төлбөрийн тухай хуулиар салангид байсан хураамжуудыг нэгтгэн хуульчилсан байна. Мөн ус бохирдуулсаны төлбөрийн тухай хууль, хог хаягдлын тухай хуулиар төлбөрийн хураамжуудыг татварын алба хураан барагдуулахаар заажээ. Эдгээр хууль нь татварын тогтолцоог боловсронгуй болгохоос гадна аж ахуйн үйл ажиллагааны сөрөг үр дагаврыг зогсоох, төрөөс татварын бодлогоор дамжуулан эдийн засгийн үйлдвэрлэлийн болон зохицуулалтын үүргийг хэрэгжүүлж эхэлжээ. Татварын эрх зүйн шинэчлэлийн бодлогын хүрээнд тав дахь удаагийн өөрчлөлт МУ-д албан ёсоор хийгдсэн. Татварын ерөнхий хуулийг хамгийн сүүлд 2008 онд шинэчлэн найруулснаас хойш нийт 26 удаа нэмэлт өөрчлөлт оруулж байжээ.

Зураг 1. МУ-ын татварын бүтэц



ОУ-ЫН ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Татварын эрх зүйн түүхэн хөгжлийг авч үзвэл эртний үе буюу МЭӨ XVIII зууны үед Хаммурали хаан 282 зүйл бүхий татварын хууль анх гаргаж, түүнээс улбаалан Манушийн хууль, 12 хүснэгтийн хууль, Октавиан Август хааны үеийн Трибут хэмээх татварын хууль зэрэг татварын хэм хэмжээг зохицуулсан анхны эрх зүйн актууд батлагдаж байжээ. Татвар нь түүхэн хөгжлийнхөө явцад системгүй, зохион байгуулалтгүй хураагдаж байснаас гадна татварыг зуучлагч цуглуулж, улмаар татварын албад бий болж, XVII

зуунаас татварын систем бүрэлдэн бий болсноор XVIII зуун гэхэд татварын асуудал нь шинжлэх ухааны түвшинд системчлэгдэн гарч ирсэн. Орчин үед татварын үйл ажиллагаа нь бүрэн системчлэгдсэн төдийгүй өөрийн гэсэн бие даасан албадтай, хууль эрх зүйн зохицуулалтай болон хөгжиж иржээ. Гэсэн хэдий ч татвар ногдуулалтын механизмыг нийгмийн хөгжлийг даган улам боловсронгуй болгох асуудал улс орон бүрт харилцан адилгүй маргаантай байсаар байна.

¹ Г.Батхүрэл, Доктор(Sc.D), профессор. Монголын эзэнт улсын үеийн төрийн аж ахуйн удирдлагын сэтгэлгээний хөгжлийн судалгаа.

МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Монголын Эзэнт Улсын (МЭ 1160-1260) үеэс аж ахуйн удирдлагын сэтгэлгээний хөгжил эрчимтэйгээр хөгжиж ирсэн. Их хаадын үеэс Их засаг цааз гарч, аж ахуйн эдийн засгийн

бодлого (төрийн удирдлага, засаглал, төрийн гадаад бодлого, гадаад худалдаа, татварын бодлого, мөнгө санхүү гэх мэт), удирдлагын ухаан боловсронгуй болжээ.

Зураг 2. Монголын Эзэнт Улсын үеийн алба гувчуурын бодлого¹



Зураг 3. МУ-ын татварын түүхэн үечлэлийн онцлог

Түүхэн үе	Эртний болон Чингэс хаан, түүний залгамжлагч үе	Манжийн үе	Богд хаант Монгол Улсын үе	Социалист нийгмийн үе	Ардчилсан төрийн үе
Ногдох зүйл	мал, газар, эд хогшил, ажил үйлчилгээ	мал, хөрөнгө газар тариалан ажил үйлчилгээ	мал, газар байгалийн нөөц, ажил үйлчилгээ	орлого, ашиг, ажил үйлчилгээ, хөрнгө, газар тариалан, бараа, бүтээгдхүүн	орлого, ашиг, хөрөнгө, бараа үйлчилгээ, байгалийн баялаг, тусгай үйлчилгээ
Татвар төлөгч	Харьяат ард, эзлэгдсэн аймаг, оллзлогд	Монгол хаад ноёд, харьяат ардууд	Харьяат ардууд	Бүх иргэд, байгууллага	Иргэн ААНБ
Төлөх хэлбэр	Биесэр бүтээгдхүүн зоос, хөрөнгө	Биесэр бүтээгдхүүн зоос, хөрөнгө	Биесэр бүтээгдхүүн зоос, хөрөнгө	Хөрөнгө мөнгө	Мөнгө

1992 оны Үндсэн хуулиар “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж зааснаас гадна олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн

гадаад бодлого явуулахыг эрмэлзэх болжээ. 1991 оноос анх удаа гадаадын орнуудтай татварын гэрээг олон улсын түвшинд батлан хэрэгжүүлэх ажлыг эхэлсэн төдийгүй өнөөдрийн байдлаар 26 оронтой давхар татварын гэрээг Засгийн Газрын түвшинд байгуулан хэрэгжүүлээд байна.

ТАТВАРЫН ТАЛААРХ СУДААГДСАН БАЙДЛЫН СУДАЛГАА, ЧИГ ХАНДАГА

- Эрнэст энд Янг Монгол Аудит ХХК-с хийсэн МУ-д Татварын

хууль хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлуудын талаар судалгааг

2015 онд хийж дараах дүгнэлтийг хийжээ. Татвар төлөхгүй байдалтай тэмцэхээр их 20 орны удирдлагууд, сангийн сайдын санаачлага гарч дэлхий нийтээрээ нийлж татвар төлөхөөс зайлсхийх аргуудтай тэмцэх OECD-ийн BEPS (Base Erosion Profit Shifting) санаачлага гарган тэмцэж байхад Монгол Улс өнөөг хүртэл хамтарч ажиллах саналаа илэрхийлээгүй, харин татвар төлдөггүй этгээдүүдийг өршөөх хууль гаргах гэж байна. Улс хоорондын компаниудын дунд хийгдэж байгаа борлуулалтын үнэ бодит зах зээлийн үнэ биш байдаг. Энэ нь татварын төлөх хэмжээнд нөлөөлдөг. Татвараас зайлсхийдэг аргуудтай тэмцэх хэрэгтэй. ТЕГ зарим хэлтэс, газрын эрх зүйн чадамж муу, татварын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд татварын албаны ажилтны мэдлэг чадвар муугаас ялагддаг гэх мэт бэрхшээл их байдаг. Татварын хууль тогтоомжинд GAAR (General-Anti-Avoidance-Rules) гэсэн олон улсын ойлголтыг оруулах хэрэгтэй. Иймээс олон улсын туршлагаас судалж татварын тогтолцоог өөрчлөх нэн шаардлагатай гэжээ.

- Yang Hong-ийн бичсэн "An Introduction to China's taxation" номыг "Enrich Professional Publishing" Сингапурын хэвлэлийн газраас 2013 онд хэвлэн гаргасан. Хятад улсын эдийн засаг, санхүүгийн үсрэнгүй хөгжил нь дэлхийн нийтийн анхаарлыг татаж байна. Хятад улсын талаар үнэн зөв,

дэвшилтэт сонирхолтой мэдээлэл хайж буй оюутан, судлаач, бизнес эрхлэгчдэд зориулан энэхүү номыг хэвлэн гаргажээ. Уг ном нь сүүлийн жилүүдэд явуулж байгаа Хятадын татварын бодлогод харьцуулсан шинжилгээ хийсэн. Үүнд; Хятад улсын татварын онолын үзэл баримтлал, одоогийн татварын систем, татварын хүү, татварын урамшуулал, онцгой татвар тухай, мөн дараахь 9 төрлийн татвар болох нэмэгдсэн өртгийн татвар, хэрэглээний татвар, бизнесийн татвар, гаалийн татвар, ААНБ-ийн орлогын татвар, хувь хүний орлогын татвар, нөөцийн татвар, хөрөнгийн татвар, тусгай зөвшөөрлийн татварт илүү анхаарч судалсан байна.

- Н. Ван Робброек. Бельги Улсын корпорацийн татварын шинэчлэл. Үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүдэд зориулан Бельги улсын парламентаас 2018-2020 оны хооронд татварын шинэчлэл хийхээр зорьж байна. 2017 онд 33,9 хувь байснаас, 2018 онд 29,58 хувь, 2020 онд 25 хувь болгон тус тус татварыг бууруулна. Өөрчлөлтийн хүрээ нь Бельги улсын татвар төлөгч бизнес эрхлэгчдэд татварын хөнгөлөлтийн өөрчлөлт ба энэ нь тэдний үйл ажиллагааг өргөжүүлэхэд эерэг нөлөөтэй санхүүгийн хөшүүрэг болж өгнө. Ингэснээр Европын бусад орны корпорациудтай өрсөлдөх чадвар нэмэгдэж, хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг өснө. BEPS-ийн эрсдэл буурна гэж судлаач дүгнэсэн байна.

“ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ”-ИЙН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ШИНЭЧИЛСЭН АСУУДЛУУД

Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 14 бүлэг, 83 зүйлтэй. (2008 онд баталсан татварын ерөнхий хууль 9 бүлэг 76 зүйлтэй.) Уг хуулийн зорилго нь МУ-д татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, Монголын татварын алба, татвар төлөгч, энэ хуультай холбогдсон бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилготой.

Дараах тулгамдаж байгаа асуудлуудыг шийдсэн өөрчлөлтүүдийг нэмсэн байна. Үүнд:

№	Тулгамдаж буй асуудлууд	Хуулийн зүйл заалт	Оруулсан өөрчлөлт
1	Гадаад улсын иргэд Монгол Улсад данстай бол түүний мэдээллийг авах, солилцох нь хуулиар хориотой байсан.	4-р бүлэг. 18 дугаар зүйл	МУ-ын ОУ-ын гэрээний хүрээнд Татварын Алба нь гадаад улсын Татварын Алба болон адил чиг үүрэг бүхий байгууллагатай татвар төлөгчийн талаар мэдээлэл харилцан солино. хуульд өөрөөр заагаагүй бол гадаад улсын аливаа этгээдийн татвар төлөгчийн талаарх мэдээллийг задруулахгүй, мэдээлэл харилцан солилцох үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг Сангийн сайд баталж гаргана гэжээ.
2	Татварын алба нь өмнө нь татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдийн эсрэг арга хэмжээ авах эрхгүй байв.	16 дугаар зүйлд 78-р зүйлд зааснаар	Татвараас зайлсхийсэн гэх үйлдэл, эс үйлдлийн улмаас эрх нь зөрчигдөж буй этгээдийн үүрэг хариуцлагыг тодорхойлж, тохируулга хийж татварыг нөхөн төлүүлнэ. Хэрэв татвар төлөгч нь татварын хэмжээг бууруулж төлсөн бол: 25-100 %-иар нөхөн төлөх, тогтоосон хугацаанд татвар төлөөгүй бол хариуцлагыг төлөгдөөгүй татварын дүнд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,1% тэнцэх хэмжээний буюу энэ нь төлөх татварын 10%-аас хэтрэхгүй торгууль оногдуулахаар заасан байна.
3	Судлаачид далд эдийн засгийг судлан, түүнд нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг нь татвар төлөгчийн татварт хандах хандлага, татварын талаарх ойлголт, мэдлэг дутмаг байна гэж үздэг.	11дүгээр зүйл	Татвар төлөхөөс зайлсхийсэн, худал мэдээлсэн зэрэг татварын зөрчил гарахаас урьдчилан сэргийлж шинэчилсэн хуулийн төслийн татвар төлөгчийн хүсэлтээр, татварын үүргээ биелүүлэхтэй нь холбоотой асуудлаар мэдээлэл, заавар, зөвлөмж тодруулгыг биечлэн, утсаар, цахимаар өгөх ба татварын мэргэшсэн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх харилцааг хуулиар зохицуулна гэжээ.
4	Татварын байцаагч ажилдаа хариуцлаггүй хандсан, албан тушаалаа урвуулан ашиглаж үндэслэлгүйгээр татвар ногдуулах асуудал байдаг. Ө.Х үндэслэлгүйгээр их хэмжээний акт тавьж татвар төлөгчийн эрх ашгийг зөрчих, дарамталж авилга нэхсэн гэм буруутай албан тушаалтны санаатай болон санамсаргүй үйлдсэн зөрчил гардаг.	82 дугаар зүйл	“Татварын улсын байцагчийн хариуцлаг”-ыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу ажлаас чөлөөлөх, хохирлыг нөхөн төлүүлэх, төрийн албанд 10 жилийн хугацаанд эргэж ажиллахгүй байх зэргээр нэмэгдүүлсэн байна.

5	Татварын мэдээллийн ил тод байдал хангалтгүй байдаг. Татварын хуулийн хэрэгжилтийг хянах, татвар төлөгчдөд мэдээлэл түргэн шуурхай хүргэх, удирдлага болон бусад дотоод гадаадын байгууллагыг мэдээллээр хангах зорилгоор дараах нэмэлт өөрчлөлт олуулсан.	7 дугаар бүлэг “Татвар бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан”	Татварын албаны шаардлагатай мэдээллийн санг бүрдүүлэхэд хамтарч ажиллах байгууллагуудын гаргаж өгөх мэдээлэл, үүргийг тодорхойлсон. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага • Цагдаагийн байгууллага • Гаалийн байгууллага • Оюуны өмч, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага • Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага • Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж • Ашигт малтмал Газрын тосны Газар • Хил хамгаалах ерөнхий газар • Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны газар • Монгол банк • Бусад төрийн байгууллага, хуулийн этгээдийн нэр, мэдээлэл, үүргийг УИХ-с батална.
6	Сүүлийн жилүүдэд гадаад худалдаа, бизнесийн үйл ажиллагаа өргөжсөнтэй холбогдож, Олон Улсын стандартад нийцүүлэн бодит үнэ хэрэглэж, үнэ шилжүүлэхтэй холбоотой маргаан гарах болсон.	19 дүгээр зүйл	Харилцан хамаарал бүхий этгээдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээнд хэрэглэсэн үнэ нь бодит үнэ байх бөгөөд хэрэв үнэ тодорхойлох боломжгүй бол үнэ шилжүүлэх аргаар татварын ногдолыг тодорхойно гэж заасан. Тайланг татварын албанд хүргүүлэхийг хуульчлан, дээрх үйл ажиллагаатай холбоотой илүү дэлгэрэнгүй журмыг Сангийн сайд батална.
7	Бусад нэмэлт өөрчлөлтүүд	35 дугаар зүйл 44 дүгээр зүйл 48 дугаар зүйл	<ul style="list-style-type: none"> • Татварын алба хамгийн бага эрсдэлтэй байх зарчмыг баримтлан, татварын харилцаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Эрсдэлтэй татварыг хуульд заасан үндэслэлээр тогтоож урьдчилан хурааж авна. Үүнд: хууль бус үйлдлээр татвараас зайлсхийхийг оролдох, татварын буцаан олголт авах, залилангийн шинжтэй үйлдлээр хөрөнгөө шилжүүлэх, санаатайгаар дампуурах зэрэг татварын өр барагдуулах ажиллагаанаас зугтах, эсхүл зугтахыг оролдсон. Энэ тухай журмыг Татварын Ерөнхий газрын дарга батална. • Илүү төлсөн татварыг нэн тэргүүнд буцаан олгоно. Одоогийн хуулинд илүү төлөлтийг бусад татварт болон дараагийн төлбөрт нэн тэргүүнд суутган тооцдог байсан. • Татвар төлөгчийн өөрийн гаргасан хүсэлтийн дагуу хуульд заасан хөнгөлөх нөхцөл байгаа бол татварын өр төлөх хугацааг 1-2 жил хүртэл сунгах боломжыг хуулиар олгосон. Татвар төлөх хугацааг сунгахдаа татварын өр нь 3 саяас дээш, төлөх хугацаа 3 сараас их бол харьяа татварын алба барьцаа хөрөнгө шаардана. Барьцаалах ажиллагааг бусад холбогдох хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

Дэвшилтэт болон сул тал

Сангийн Яамны албан ёсны сайтад байршуулсан хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлгийн явцаас дүгнэн харахад иргэд дараах санал, шүүмжлэлийг дэвшүүлсэн байна.

- Нэр томъёоны тайлбаруудыг илүү нарийн тодорхойлох, найруулгын алдааг залруулах, ижил утгатай заалтуудыг хасах.
- Татвар төлөгчийн эрхийн талаар зүйл оруулсан боловч, үүргийн талаар тодорхойлсон зүйл оруулаагүй байна.
- Татварын мэдээллийн сантай холбоотой зарим нэг мэдээллийн зохицуулалтыг нэмэх.
- Үнэ шилжүүлэх ажил

гүйлгээнүүдийг нарийвчлан, тодорхой заан оруулах.

- Үндсэн хууль болон бусад хуулийн зүйл заалттай зөрчилдөж байгаа заалтын хэсгийг хасах.
- Татварын улсын байцаагчид хариуцлага тооцохдоо, удирдлагын буруутай үйл ажиллагааг хамруулж давхар хариуцлага хүлээлгэх талаар оруулах.

Сангийн сайд Ч.Хүрэлбаатар татварын багц хуулинд оруулж байгаа өөрчлөлтүүдийн зорилго нь "Бизнесийг дэмжих, ойлгожгүй, хийдэлтэй, тодорхой бус заалтуудыг цэгцлэх шаардлага бий болсон. Үүний тулд татвартай холбоотой маргаантай асуудлуудыг судалсны үндсэн дээр одоогийн байгаа хуулинд өөрчлөлт оруулсан." гэжээ.

АНУ-ЫН ТАТВАРЫН ТОГТОЛЦООНЫ СУДАЛГАА

АНУ байгуулагдсан цагаасаа хойш өндөр татвартай улс байсан ба үндэсний түүхийн турш татварын систем нь хувьсан өөрчлөгдөн иржээ. Зөвхөн орлогын татвараас гадна бусад татвар ЗГ-ын орлогыг бүрдүүлж байсан. Дайны үед татварын хэмжээг нэмэгдүүлдэг байв. Ялангуяа колончлогчдод илүү татварын дарамт очдог, Их Британи давхар бизнесийн бичиг баримтын татвар, тамганы татвар гах мэт олон төрлийн татвараас татвар авдаг байсныг 1700-д оны үед бослого хөдөлгөөн гарч, колониос гарч болиулжээ. 1861 онд дайныг санхүүжүүлэх зорилгоор анхны орлогын татварыг бий болгосон байна. Мөн үхлийн татвар авдаг байсан. АНУ эдийн засаг өнөөдөр чөлөөт үйлдвэрлэлийн систем дээр тулгуурладаг. Аж үйлдвэрээс ялгарч байгаа хорт бодисууд нь хүрээлэн буй орчинг ихээр бохирдуулдаг учир нийгмийн

ашиг тусын тулд ЗГ хязгаарлаж зохицуулахын тулд татварын бодлогыг ашигладаг байна. Дараах гол эдийн засгийн суурь 3 татвар ЗГ-ын орлогыг бүрдүүлдэг байна. Орлогын татвар нь хувь хүн, корпорацын ашиг орлогын татвараас бүрдэнэ. Холбооны ЗГ-ын орлогын ихэнх хувь нь дээрх татвараас бүрддэг. Хүн амын орлогын албан татвар нь ААНБ-ын орлогын татвараас 5 дахин илүү орлого оруулдаг. Орлогын татвар оногдуулах арга, болон хувь шатлалтай. Хувь хүний татвар нь цалин, хадгаламж, НДШ-ээс бүрдэнэ. Эргээд тэтгэвэрт зарцуулдаг. Борлуулалтын татвар нь ихэнх муж, томоохон хотуудын орлогын эх үүсвэр болдог. Татварын хувь муж бүрт ялгаатай. Онцгой татвар нь зарим хортой хэрэглээг хязгаарлах зорилготой, энэхүү орлогын татварыг хурдны зам, гүүр, олон нийтийн тээврийн үйлчилгээ, тэдгээрийн засварт зориулагддаг.

Зураг 4. АНУ-ын Татварын бүрдүүлэлт




БНХАУ-ЫН ТАТВАРЫН ТОГТОЛЦООНЫ СУДАЛГАА

Шинэ Хятадыг үүсгэн байгуулснаас хойш Хятадын татварыг хэд хэдэн удаа шинэчилжээ. 1994 онд аж үйлдвэр, худалдааны татварыг шинэчилснээр одоогийн татварын хэмжээ аажмаар өсөн нэмэгдэж иржээ. Хятад социалист зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхэд татварын бодлого нь эдийн засгийг нэмэгдүүлэх, зохицуулах стратегийн чухал хэрэгсэл болдог. Татварын хэм хэмжээнд татвар төлөгч, үндэсний татварын албанд хамаарах татварын байгууллагууд, татвар суутгах агент ба холбогдох талуудын, Улсын Татварын Удирдлагын Газрын чиг үүрэг, эрх мэдлийн хүрээний дүрэм журам, Төрийн зөвлөлийн захиргааны журмын дагуу боловсруулсан хуулийн норматив бичиг баримт хамаарна. Жишээлбэл: Татварын байгууллагын хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааны дүрэм. Татварын албаны хэм хэмжээ нь бусад татварын албадаас гаргасан

татварын дүрэм журамд зааснаас бусад захиргааны болон норматив бичиг баримт хамаарна. Үндсэн хуулинд зарим нэг татварын эдийн засаг ба нийгмийн үүргийг тодорхойлсон байдаг.

Татварын хууль нь татвар төлөгч Төр хоорондын татвар ногдуулах, цуглуулах, төлөхийг зохицуулах хуулийн арга хэлбэр, эрх үүргийг тодорхойлсон эрх зүйн хэм хэмжээ юм. Татварын хувь нь татварын объектод төлөх татварын дүнгийн харьцаа. Татварын хувь нь үндэсний орлого болон татвар төлөгчийн дарамтанд шууд нөлөөлдөг ба ирээдүйн эдийн засгийн үйл ажиллагааны боломжит үндэс суурь болдог. Татварын хувь хүмүүсийн амьдрал, аж ахуйн нэгжийн эдийн засгийн үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг. Татварын хувь хэмжээ нь 3 хэлбэртэй.


Зураг 5. БНХАУ-ын татварын хувь



Татварын бүтэц нь чухал гол татвар, бие даасан туслах татварыг тодорхойлох явцад татварын зохицуулах тодорхой нөхцөл байдлын

дагуу ялгаатай функцуудын хэлбэр, үр нөлөө ба цогц үйл ажиллагаа. Татварын дараах 5 бүтэц байна.

Зураг 6. БНХАУ-ын татварын бүтэц



Үндэсний татварын бодлогын чиглэл: Татварын бүтцийн нарийвчилсан тогтолцоо нь татварын үндсэн зарчмуудыг агуулсан байх ба үндэсний татварын бодлогын зорилтуудыг биелүүлэхэд чиглэгдэх ёстой. Сүүлийн жилүүдэд Хятад улс төсвийн болон мөнгөний бодлоготой уялдуулан үр ашигтай эрэлтийг дэмжихийн

тулд хадгаламжийн хүүнээс татвар ногдуулдаг болжээ. Цаашид хөрөнгийн бирж болон үнэт цаасны арилжааны зан үйлийг зохицуулахын тулд татвар ногдуулах, мөн шударга бус нийгмийн хувиарлалтыг багасгах, баян ядуугийн ялгааг багасгахын тулд өв залгамжлалын татвар, бэлэглэлийн татварыг ногдуулах болно.

ДҮГНЭЛТ

- Монгол Улс татварын эрх зүйн орчноо шинэчилж байгаа нь төр болон татвар төлөгч субъектүүдийн хоорондын харилцаанд үүсч байсан бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. 2008 онд Татварын ерөнхий хууль шинэчлэн баталснаас хойш 10 жил өнгөрч, нийгмийн хөгжил хурдацтай хөгжиж, холбогдох зарим нэг хууль шинээр баталсантай уяалдан уг хуулийг шинэчлэх зайлшгүй нөхцөлүүд бүрдсэн. Мөн МУ-д олон улсад төлөх өрийн хэмжээ эрс нэмэгдэж, Олон Улсын Валютын сантай хамтран ажиллаж татварын эрх зүйн орчинг өөрчлөх үндэслэл болж байна.
- Улс орон бүрт татварын тогтолцоо нь харилцан адилгүй байдаг. Энэ нь тухайн улсын нийгэм эдийн засгийн бүтэц, хүн ам, газар нутаг, хөгжлийн түвшингээс хамаардаг. АНУ-ын татварын тогтолцооны онцлог нь чөлөөт зах зээлийн эдийн засаг буюу аж үйлдвэр дээр суурильсан татварын тогтолцоотой. Хятад улсын татварын тогтолцоо нь социалист-эдийн засагт суурилсан, гол татварын орлого нь хөдөө аж ахуйн салбараас бүрддэг. Монгол Улс дээрх 2 улстай харьцуулахад социалист нийгмээс зах зээлийн эдийн засгийн нийгмийн системд шилжээд удаагүй, хүн ам хэт цөөн, эдийн засгийн хөгжлийн түвшин доогуур учраас татварын тогтолцооны хөгжил, татварын төрөл, хэмжээ, бүтцийн хувьд ялгаатай байна.
- МУ татварын одоогийн шинэчлэл нь татварын тогтолцооны хариуцлагыг нэмэгдүүлж байгаа. Жишээлбэл. Татварын тайланг хугацаанд нь хүргүүлээгүйгээс төлөх торгуулийн хэмжээг тогтоосон. Энэ нь НББ-ын бодлогод, ААНБ-ын нийгмийн хариуцлага, нягтлан бодогч нарын ажлын хариуцлага, тэдний ёс зүй талаар онцгойлон оруулах шаардлагатайг харуулж байна.

НОМ ЗҮЙ

1. Татварын ерөнхий хууль. 2008 он
2. Татварын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга. 2018 он
3. Ernest & Yong. Татварын хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлууд, хяналт шалгалт, маргаан таслах ажиллагаа. 2015
4. Г.Батхүрэл. Доктор(Sc.D), профессор. Монголын эзэнт улсын үеийн төрийн аж ахуйн удирдлагын сэтгэлгээний хөгжлийн судалгаа. 2014
5. С.Энхбаатар.(PhD). Татварын үндсэн үүрэг ба татварын зөв бодлого. 2015
6. Д.Цэвэлмаа. МБДС. Татварын бодлогод нөлөөлөх дотоод хүчин зүйлсийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага. 2016
7. С.Билгүүн. Татварын хуульч. Татварын эрх зүйн түүхэн чиг хандлага. 2015
8. Hong, Yang. An Introduction to China's Taxation. 2013

9. Kaplow Louis. The Theory of taxation and Public Economics
10. N.Van Robbroeck. The Belgian Corporate Tax Reform 2018-2020. International tax journal.2018.April
11. Booth.P.Bourne, Rayn.Taxation, Government Spending and Economic Growth.2016
12. <http://www.mta.mn>
13. <https://mof.gov.mn>
14. ikon.mn
15. <http://naog.gov.mn/>
16. <http://www.1212.mn/> МУ-ын Үндэсний Статистикийн хороо. МУ-ын нийгэм, эдийн засгийн байдал.2018-2
17. <https://www.efile.com/tax-history-and-the-tax-code>
18. <https://taxfoundation.org/summary-federal-income-tax-data-2017/>
19. <https://www.treasury.gov/resource-center/faqs/Taxes/Pages/economics.aspx>

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Д.Мөнгөнтуул

СЭЗИС-ийн Ph.D хөтөлбөрийн докторант, (MBA)

Abstract. In recent years the tourism sector has developed as the countries in the world have been globalized. Therefore, the global countries have paid more attention to developing the tourism sector in order to advocate sustainable development. Developing sustainable tourism is one of the primary goals for fulfilling the sustainable development goals. Thus, the study aims to investigate the following content of the research. This includes:

- i) Theoretical concepts and goals of the global sustainable development
- ii) Issues to terminologies of sustainable tourism
- iii) Sustainable tourism contribution to achieving sustainable development goals

Key words: Sustainable development, Sustainable tourism,

Хураангуй. Өнөөдөр дэлхийн улс орнууд глобалчлагдахын хэрээр аялал жуулчлалын салбарын хүрээ өргөжин тэлсээр байна. Ийм учраас дэлхийн улс орнууд аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар тогтвортой хөгжлийг бий болгоход ихээхэн анхаарсаар байна. Харин тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд дэвшигдэн гарч буй нэн тэргүүний нэг зорилт бол тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх явдал оршин байна. Иймийн учир судалгаа хийж буй сэдвийн хүрээнд дараах агуулгаар судалгааны ажлаа хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Дэлхийн тогтвортой хөгжлийн талаарх ойлголт, зорилтууд

Тогтвортой аялал жуулчлалын талаарх нэр томъёоны асуудал

Тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг хангахад тогтвортой аялал жуулчлалын оруулах хувь нэмэр

Түлхүүр үгс: Тогтвортой хөгжил, тогтвортой аялал жуулчлал

ТОВЧИЛСОН ҮГ

ТХЗ-Тогтвортой хөгжлийн зорилт

МХЗ-Мянганы хөгжлийн зорилт

ТАЖ-Тогтвортой аялал жуулчлал

ХАЖ-Холч аялал жуулчлал

НҮБ-Нэгдсэн Үндэстний Байгууллага

ОУ-Олон улс

ОРШИЛ

Аливаа юмс үзэгдлийг биологи, геологи, физикийн шинж чанар, хувьсал өөрчлөлтөөр дамжуулан судалдаг. Харин хувьслын тухай онол бий болсноор философичид хөгжлийн тухай асуудлыг нэлээд нарийвчлан авч үзэх болсон байна. Эртний философичдын нэг Гегель хөгжлийн тухай ойлголтыг судалж аливаа юмс үүсэн бий болж, өөрчлөгдөн шинэчлэгдэх замаар хөгждөг болохыг хүлээн зөвшөөрч хөгжлийн тухай түгээмэл зарчмыг тодорхойлсон байдаг. ХХ зууны үед хөгжлийн тухай ойлголтыг байгалийн болон нийгмийн шинжлэх ухаанд өргөн хүрээтэй авч үзэн дотоод механизмыг нарийн судлах замаар хөгжүүлсэн билээ. Хөгжил нь аливаа системд урт

хугацааны туршид хуримтлагдсаар эргэлт буцалтгүй гарч буй чанарын өөрчлөлт юм. Харин хөгжлийг нийгэм, нийгмийн гишүүд талаас нь тодорхойлбол "Нийгмийн системээс өөрийн гишүүд болон орчиндоо үйлчилгээ үзүүлэх чадвараа нэмэгдүүлэх зорилгоор сурах үйл ажиллагаа" юм. (Д.Бадарч, 2014) Хөгжлийн үйл явцын хоёр тал нь "тогтвортой" хөгжил ба "тогтвортой бус" хөгжил юм. Ийм учраас аливаа юмс үзэгдэл, тэр ч байтугай нийгэм тогтвортой ба тогтвортой бус хөгжлийн ээлж дараалалд байдаг. 1968 онд Италийн бизнесмэн Аурелио Печчи нийгэмд тогтвортой хөгжлийн тухай ойлголтыг таниулах, ойлгуулах ажлын эхлэлийг тавьсан байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАА

Тогтвортой хөгжил нь "Өнөөгийн хэрэгцээг хангахдаа ирээдүй хойч үеийн хэрэгцээ хангах боломжийг хязгаарлахгүй байх" явдал юм. (Brundtland Report, 1987) Эдийн засаг, байгаль орчин, нийгэм гэсэн 3 ойлголтын тулгуур багана нь тогтвортой хөгжил. Эдийн засгийн өсөлтийг хангаад зогсохгүй үр дүнг шударгаар хуваарилах, байгаль орчныг нөхөн сэргээх, хүмүүсийг хариуцлагатай иргэн болгох үйл явц руу хөгжлийг чиглүүлэх шаардлагатай гэсэн үг юм.

Зураг 1. Тогтвортой байдлын гурван тулгуур



Тогтвортой хөгжлийн 3 давхарга

- Эдийн засгийн тогтвортой байдал нь бараа, үйлчилгээний үйлдвэрлэлийг тогтвортой түвшинд байлгах, хөдөө аж ахуй болон үйлдвэрлэлийн секторыг тэнцвэржүүлэх, засгийн газрын болон гадаадын өр төлбөрийг зохих түвшинд нь байлгах.
- Байгаль орчны тогтвортой байдал нь баялаг, нөөцийн түвшинг тогтвортой барьж, хөрөнгө оруулалтыг ухаалгаар хийх,

биологийн төрөл зүйл, уур амьсгалын тэнцвэртэй байдал, экосистемийн үйл ажиллагааг хэвийн байлгах.

- Нийгмийн тогтвортой байдал нь тэгш хуваарилалтын системтэй, эрүүл мэнд, боловсрол, жендер, улс төрийн оролцоо зэрэг нийгмийн үйлчилгээг бүрэн тэгш хангах явдал юм. (Michigan, 2002)

Анх 1984 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар Байгаль орчин ба Хөгжлийн олон улсын комиссыг байгуулж байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангасан, нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэвшүүлсэн *"Бигний ирээдүй"* гэсэн илтгэлийг танилцуулсан байна. Хүн төрөлхтний үйлдвэрлэл, хүн ам зүй болон бусад олон хүчин зүйлс нь ертөнц, хүрээлэн буй орчныг доройтуулж байгаа учир одоогийн хэрэгцээг хангаж хойч үедээ тэр боломжийг олгох тогтвортой хөгжлийн замд шилжих нь чухал болохыг онцолсон. 1992 онд Бразили улсын нийслэл Рио Де Женеиро хотноо "Байгаль орчин ба ногоон хөгжил" сэдэвт бага хурлыг НҮБ-аас зохион байгуулж, зөвхөн өнөөгийн хүмүүсийн хэрэгцээг хангаад зогсохгүй ирээдүй үеийнхний амьдралыг аз жаргалтай байлгахын тулд "Дэлхий дахины XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр"-ийг дэлхийн өнөөгийн хөгжлийн үндсэн загвар болгон дэвшүүлсэн бөгөөд түүнийг 20 жилийн турш дагаж мөрдөхөөр батлан гаргасан байна.

Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг авч үзэхийн тулд эхлээд Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-уудын талаар дурдах нь зүйтэй.

2015 онд "Мянганы хөгжлийн зорилтууд" хөтөлбөрийн үйл ажиллагаа дуусгавар болж, улмаар "NO-ONE left behind-Хөгжлөөс хэн ч үлдэж хоцрох ёсгүй" уриатай Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) – ыг дэвшүүлсэн байна.

Зураг 2. Мянганы хөгжлийн зорилтууд 2000-2015



2002 онд Иоханнесбургт болсон

"Рио + 10" чуулга уулзалтаар өмнөх хугацааны ололт амжилтаа дүгнэн, хөгжлийн цаашдын шинэ хандлага, чиглэлийг тодотгож улмаар 2002-2005 онд "МХЗ"-уудыг тодорхойлж дэлхий дахинд хэрэгжүүлсэн байна. "МХЗ" нь зарим оронд үр дүнгээ өгсөн боловч зарим улс орнуудад үр дүнгээ өгч чадаагүй байна. Гэхдээ дэлхийн ихэнх улс оронд нэлээд амжилтад хүрсэн хэдий ч шийдвэрлэгдээгүй олон асуудал байсаар байна.

"МХЗ" нь ядуу буурай орнуудад чиглэсэн байдаг бол "ТХЗ" нь бүх улс оронд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. "МХЗ", "ТХЗ"-ийн аль алиных нь хамгийн тэргүүний зорилт нь ядуурлыг бууруулах асуудал руу чиглэдэг байна.

Зураг 3. Тогтвортой хөгжлийн зорилтууд 2016-2030



"Тогтвортой хөгжлийн зорилт-2030" нь **нийгэм, эдийн засаг, байгаль орчин** гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг юм.

Бүх улс орон, бүх хүнд хамааралтай, өөр хоорондоо холбоо бүхий 17 зорилготой байдаг. Эдгээр зорилгод хүрснээр дэлхий даяар томоохон өөрчлөлтийг авчрах, улс орон хоорондын болон нэг улс доторх ялгааг арилгах зорилготой. Энэхүү тунхаглалыг 2 жилийн хугацаанд улс орнууд хамтран боловсруулж, 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар баталж, бүх улсын ерөнхийлөгчид гарын үсэг зурснаар

2016 оны 1-р сарын 1-ны өдрөөс албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн байна. 17 зорилго нь тус бүртээ хүрэх

түвшин бүхий 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлттэй ажээ.

Хүснэгт 1. “ТХЗ”-ын шалгуур үзүүлэлтүүд

Зорилго	Зорилгын нэр	Зорилт	Үзүүлэлт
1	Ядуурлыг устгах	7	14
2	Өлсгөлөнг зогсоох	8	13
3	Эрүүл мэндийг дэмжих	13	27
4	Чанартай боловсролыг дэмжих	10	11
5	Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах	9	14
6	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	8	11
7	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	5	6
8	Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	12	17
9	Инноваци болон дэд бүтцийн нэмэгдүүлэх	8	12
10	Тэгш бус байдлыг бууруулах	10	11
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	10	15
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	11	13
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	5	8
14	Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10	10
15	Хуурай газрын эко системийг хамгаалах	12	14
16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	12	23
17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	19	25
Бүгд		169	244

ТОГТВОРТОЙ” БУЮУ “ХОЛЧ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ - НЭРШЛИЙН АСУУДАЛ

Тогтвортой аялал жуулчлалын талаар өгүүлэхээс өмнө “тогтвортой” гэдэг үгийн орчуулгын талаар авч үзье. “Sustain”, “Sustainable”, “Sustainability”, “Sustainable Development” гэсэн нэршлийг Монгол хэлнээ “Sustainable-тогтвортой”, “Sustainability-тогтвортой байдал”, “Sustainable development-тогтвортой хөгжил” гэж орчуулж хэрэглэж байна. Монгол орны хувьд “Тогтвортой” гэх үзэл баримтлал хүмүүсийн хүрээнд яригдаад нэлээд хугацаа өнгөрч, үгийн мөн чанар агуулгаараа илэрхийлэгддэг ч үгийн орчуулгын хувьд оновчтой буугаагүй, утгын зөрүүтэй байгаа талаар эрдэмтэн судлаачид шүүмжлэлтэй хандсаар

байдаг. Хэдий тийм ч тохиромжтой нэршил хараахан олдоогүй хэвээр л байна.

“Тогтвортой” гэдэг үгийн утга нь тогтвор бүхий, суурьшилтай, тогтоцтой, хэлбэлздэггүй, хөдөлгөөнгүй гэсэн утгатай. (Я.Цэвэл, 2013, хууд. 735) “Тогтвортой” гэдэг нь юмсын хөдлөхгүй байх бололцоо, төлөв томоо, зориг хүслийн шийд (ШУА, 2008, хууд. 1974) “Тогтох” гэдэг нь хөтөлбөргүй болох, үл хөдлөх, оршин тогтнох, хөдлөхөө болих, зогсох, өвчин эдгэрсний дараа биед эмгэг хоцрох, шийдвэрлэх, шийдэх, нэгэн тийш болох гэсэн утгатай. (Я.Цэвэл, 2013, хууд. 736) гэж толь бичгүүдэд тайлбарласан байдаг.

Уг нь "Тогтвортой байдал" гэдгийн англи утга "Sustainable" биш "Stability" гэдэг үгтэй илүү дүйцнэ. "Sustain" гэдэг гадаад үгийн гарал үүслийг авч үзвэл "Sustenance" гэдэг латин гарал буюу "Soutenir" гэсэн франц үгнээс гаралтай ажээ. "Sou" гэдэг нь франц хэлнээ гар доор, гартаа байлгах, гартаа оруулах гэсэн утгатай. "Tenir" нь ямар нэг зүйлийг урт хугацаагаар тогтоон барих, хэвээр нь байлгах, хэвэнд нь хадгалах гэсэн утгатай. "Sustainable" гэдэг англи утгаар нь авч үзвэл "Sustain" буюу дэмжих, туслах, үргэлжлэх, тогтоох, тогтоон барих гэх мэт олон утгатай үйл үгэнд "able" буюу чадвар гэсэн бүтээвэр залган үүссэн тасралтгүй, тасаршгүй, үргэлжид, тогтвортой гэсэн утга бүхий үүсмэл тэмдэг нэр бий болжээ. Тэгэхээр энэ агуулгаар "Sustainable" гэдэг нь ямар нэг зүйлийг дуусгахгүйгээр үр ашгийг нь хүртэх чадвартай, ямар нэг амьжиргааны эд зүйлсээ урт хугацаанд тогтоон барьж амьдрах чадвар эх үүсвэрээ тасралтгүй хадгалах, алсын хараатай гэсэн утгатай харагддаг.

Мөн түүнчлэн энэ үгийг "Тулхтай хөгжил" гэж орчуулах нэг хувилбар яригддаг. "Тулх" гэдэг үгийг монгол хэлний товч тайлбар тольд түшиг, тулгуур, найдвар гэж тайлбарласан байна. (Я.Цэвэл, 2013, хууд. 767). "Тэнцвэртэй ба Жам ёсны хөгжил" гэж тодорхойлох саналтай байдгаа Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн гуай нэгэнтээ дурсаж байжээ. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд "Тэнцвэр" гэдэг нь "Тэнцүүр" буюу хүч чадал тоо хэмжээний тохирол, харилцан адил тэгш, тэнцүү байдал, тэнцэн тогтох чадвар (ШУА, 2008, хууд. 2151), "Жам" гэдэг нь "Хүний ухамсраас үл хамааран зайлшгүй тохиолдох зүй тогтол, зүй ёсны, тэгж болох зүйн хэрэг, горим журам, ёс горим, зүй зарчим, ёс дэглэм, дэг журам, ёс заншил" гэж тайлбарласан байна. (ШУА, 2008, хууд. 871). Тэгэхээр "Тэнцвэртэй" хөгжил гэдэг нь тоо, өсөлтийн тэнцвэрийг хангадаг гэдэг утгаар (Balanced development) гэдэг

ойлголтоор тайлбарлагдах магадлалтай. Жам ёсны хөгжил гэхээр хүний хүчин зүйлээс хамааралгүй, шалтгаалахгүй гэсэн утга илэрхийлэхээр франц үгний нь "урт хугацаагаар тогтоон барих хүний хүчин зүйл" гэсэн агуулга үгүй болох талтай байгаа. Түүнчлэн эрчтэй, тухайн хэрэг явдлын гол шинжийг тааруулдаг, эв дүй, аргыг олохдоо ухаалаг цэцэн гэсэн утга бүхий "Ончтой", аливаа зүйлийн мөн чанар нь, жинхэнэ шалтгаан нь үүнд оршдог гэсэн утга агуулгатай "Оршмол", зүйтэй, ёстой, таатай, нийлэмжтэй, таарамжтай гэсэн утга бүхий "Зохистой", гэсэн үгнүүдийг бас хэрэглэж болох саналууд байдаг.

Хэдийгээр "Тогтвортой хөгжил"-ийн талаарх ойлголт нутагшсан боловч харин аялал жуулчлалын салбарт "Тогтвортой аялал жуулчлал" гэдэг ухагдахуун харьцангуй шинэ, агуулга хэлбэрээ бүрэн гүйцэд хараахан олж бэхжээгүй байгаа. Тиймээс энэхүү "Sustainable tourism" гэдэг нэршлийн асуудлыг өмнө дурдсанчлан үгний утга агуулгыг зөв илэрхийлж чадахуйц тохирсон нэр томъёог оновчтой олж тодорхойлох хүсэл сонирхлын дагуу зарим нэг судалгаа хийв. Аливаа нэр томъёо ухагдахууныхаа бүхий л талыг харуулж илэрхийлж чадахгүй ч хамгийн гол утга санааг илэрхийлсэн үгээр томъёолох хэрэгтэй байдаг.

Тогтвортой аялал жуулчлал гэдэг нь *"Хүрээлэн буй орчин, байгаль, түүх, соёлын нөөцийг сүйтгэлгүйгээр урт хугацаанд үр өгөөжтэйгээр ашиглан орон нутгийн өөрийн удирдлагын байгууллага ба иргэдийн оролцоог бий болгон эдийн засгийн баялаг бүтээхийн зэрэгцээ хойч үеgee эдгээр байгалийн нөөц, соёлын өвийг хэвээр нь өвлүүлэн үлдээхийг зарчим болгодог аялал жуулчлал"*.

Тиймээс **"Sustainable tourism"** гэсэн нэр томъёогоор илэрсэн хамгийн гол утга нь байгаль экологид ээлтэй, нийгэм соёлын ач холбогдолтой, эдийн

засгийн үр ашигтай, хэтийн бодлого бүхий аялал жуулчлалыг хэлж байгаа тул монгол хэлнээ буулгахдаа дээрх утгыг илэрхийлэх **"Холч аялал жуулчлал"** хэмээн нэрлэж болох юм.

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толиноо "холч" гэсэн тэмдэг нэр



"ТОГТВОРТОЙ" БУЮУ "ХОЛЧ" АЯЛАЛ ЖУУЛЧЛААЛЫН "ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭЭ

Дэлхийн хүн ам 200 000 жилийн турш өсч, 1 тэрбум болсон бол харин сүүлийн 200 хан жилийн дотор 7 тэрбум хүртэл өссөн байна. Энэ хандлагаар бол 2100 он гэхэд 11 тэрбумд хүрэх

нь 1) хол явж чадагч, холын замд эдэлгээ даадаг, 2) холын хараатай, хэтийн бодолтой гэсэн утгатай байна. Тиймээс **"Sustainable tourism"** гэдэг үгийг **"Холч аялал жуулчлал"** гэж томьёолж болох саналыг судлаачийн зүгээс дэвшүүлж байна.

төлөвтэй. (History, 2016) Дэлхийн хүн амын энэ их өсөлт дэлхийн нөөцийн тогтвортой байдалд шууд хамааралтай билээ.

Зураг 4. Дэлхийн хүн амын өсөлт




Түүнчлэн дэлхийн улс орнуудын түвшинд аялал жуулчлалаар аялагчдын тоо жилээс жилд өссөөр байна. Энгийн иргэнээс илүү жуулчид нөөцийг илүү хэрэглэдэг гэсэн судалгаа байдаг. Тиймээс хэдий чинээ олон хүн аялна төдий чинээ нөөц ашиглагдана. Энэ утгаараа аялал жуулчлал тогтвортой хөгжилд хамгийн их хамааралтай салбар болж байна.

"Аялал жуулчлал гэдэг нь явуулын хүмүүс ямар нэг ашиг хайхгүйгээр тодорхой газар оронд аялах болон зочлохоос үүдэлтэй цогц хамаарал бүхий үзэгдэл юм" (Leon, 2010) Аялал жуулчлал гэдэг бол өөрийн байнга амьдардаг орчноосоо өөр

газар байгаа хүн, түүний аялан явахад нь гарч болох бүхий л хэрэгцээг нь хангах үйлдвэрлэл, энэ үйлчлүүлэгч ба үйлчилгээний харилцаа дундаас үүсэн бий болох байгаль орчин, эдийн засаг, нийгэм соёлын нөлөөллүүдийн цогц нийлбэр ойлголт юм. (Welson, 1997)

Анх Швейцарь, Австри, Герман, Италийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын эртний дурсгалт нутгуудад хөгжсөн түүхтэй аялал жуулчлал нь одоо ихэнх орнуудад эдийн засгийн биеэ даасан салбар, 120 орны хувьд тэргүүлэх 5 салбарын нэг болсон байна.


Зураг 5. Дэлхийн аялал жуулчлалын өсөлт



НҮБ-аас аялал жуулчлалын талаар гаргасан судалгаагаар дэлхийн хэмжээнд 1950 онд 25 сая хүн жуулчилж байсан бол 2005 онд 800 саяд хүрсэн

ба 2030 он гэхэд нийт жуулчны тоо 1,8 тэрбум хүрнэ гэсэн таамаглалыг дэвшүүлсэн байна

Зураг 6. Дэлхийн олон улсын жуулчид



(UNWTO, 2017)

Тоон баримтыг авч үзвэл, дэлхий дахинд 2017 оны байдлаар нийт 1,323 сая хүн аялан жуулчилж, өмнөх онтой харьцуулахад 7%-ийн өсөлттэй буюу 84 сая жуулчнаар өссөн үзүүлэлттэй байна. Олон улсын жуулчид хөгжиж буй орнууд болох Ази, Латин Америк, Төв болон зүүн Европ, Ойрхи Дорнод мөн Африкийн орнуудаар аялах сонирхол нэмэгдэж байна. Энэ нь өндөр хөгжилтэй орноор аялах жуулчдын өсөлтийн хувиас хоёр дахин их буюу 2030 он гэхэд 4.4%-д хүрэх хандлагатай байна. Өөрөөр

хэлбэл, 2030 он гэхэд нийт аялагчийн 57% нь хөгжиж буй орнуудыг зорин, харин 43% нь өндөр хөгжсөн орнуудаар аялна гэсэн тооцооллыг Дэлхийн аялал жуулчлалын байгууллага 2016 оны тайландаа тусгажээ.

Сүүлийн 8 жилийн дүнгээр авч үзвэл, аялал жуулчлал дэлхийн хэмжээнд жил бүр дунджаар 4%-ийн тогтмол өсч буй үзүүлэлттэй ба энэ нь хөгжингүй орнуудад +5%, хөгжиж буй орнуудад +2%-ийн өсөлт ажиглагдсан байна.

Зураг 7. Дэлхийн жуулчдын тоо сүүлийн 3 жилээр



Аялал жуулчлал хэдийгээр “ТХЗ”-уудад маш чухал нөлөөтэй салбар боловч аялал жуулчлалын энэ олон төрлөөс чухам аль төрлийг түлхүү хөгжүүлж, улс орныхоо хөгжилд хувь нэмэр оруулах вэ? гэдэг нь бас чухал асуудал билээ. Аялал жуулчлалыг зорилгын хувьд: ерөнхий болон тусгай сонирхлын аялал, тээврийн хэрэгсэл, жуулчдыг байрлуулах газар, оролцогчдын тоо, зохион байгуулалт, үргэлжлэх хугацаа гэх мэт шинж чанарт нь тулгуурлан маш олон төрөл, ангилалд хамааруулж үздэг. Тэгвэл энэ олон төрлөөс “ТХЗ”-д хамгийн их нөлөө үзүүлдэг, хүн болон байгаль, нийгэмд ээлтэй, хамгийн тохиромжтой аялал жуулчлалыг тогтвортой буюу холч аялал жуулчлал гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Учир нь, масс аялал жуулчлал тухайн орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлдэг ч зөвхөн зугаа цэнгэлд зориулагдсан байдаг учир байгаль цаг уурын өөрчлөлт, агаар, усны бохирдол, биологийн төрөл зүйлийн хорогдол, түүх соёлын нөөцийн эвдрэл гэмтэл гэх мэт хүний хүчин зүйлийн нөлөөгөөр үүсч бий болдог байгаль орчны бохирдол, экосистемийн тэнцвэрийг алдагдуулах гэх мэт сөрөг үр дагаврууд бий болдог. Харин тогтвортой аялал жуулчлал нь хүрээлэн буй орчин, байгаль, түүх,

соёлын нөөцийг сүйтгэлгүйгээр урт хугацаанд үр өгөөжтэйгээр ашиглан орон нутгийн өөрийн удирдлагын байгууллага ба иргэдийн оролцоогоор дамжуулан эдийн засгийн баялаг бүтээхийн зэрэгцээ хойч үедээ эдгээр байгалийн нөөц, соёлын өвийг хэвээр нь өвлүүлэн үлдээхийг зарчим болгодог аялал жуулчлал билээ.


Тиймээс дэлхийн аялал жуулчлалын салбарт тогтвортой аялал жуулчлалын эрэлт хэрэгцээ улам бүр өсөн нэмэгдсээр байна. Өнөөгийн аялал жуулчлал нь “Масс аялал жуулчлал”-аас “Тогтвортой аялал жуулчлал” руу шилжих хандлагатай болж байна. (Stanislav Ivanov, 2013). Өөр соёл иргэншил, амьдралын хэв маягтай хүмүүсийг хэрхэн аж төрж, хэрхэн сэтгэж, юуг эрхэмлэн дээдэлж, ямар ёс заншил, уламжлалтай гэдгийг нүдээр харж, биеэр мэдэрч, ойлгож ухаарахын тулд тухайн орон нутагт нь очиж, иргэдтэй нь хамт хэсэг хугацаанд өдөр тутмын ахуйн ажилд нь оролцож, түүнээс суралцах хүсэл сонирхолтой жуулчдын тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр байна. (Edgell, 2013)

Уламжлалт аялал жуулчлал одоогийн жуулчдын сэтгэл ханамжийг өндөр байлгах тал дээр түлхүү анхаардаг бол тогтвортой аялал жуулчлалын хувьд өнөөдрийн

төдийгүй, ирээдүйн жуулчид, орон нутгийн иргэдийн сэтгэл ханамжийг нэг түвшинд авч үздэгээрээ онцлог ялгаа, давуу талтай юм.

Энэ ч утгаараа дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас 2017 оныг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх жил болгон зарласан байдаг.

Бүдүүвч 1. Уламжлалт болон тогтвортой аялал жуулчлалын ялгаа



(UNWTO. Sustainable tourism concepts)

Тогтвортой аялал жуулчлал маш олон талаас нь тодорхойлсон байдаг. Тухайлбал: "Аялагч, амрагчид орон нутгийн иргэдийн эрх ашиг, соёлын өв, байгаль орчны асуудлуудыг аялал жуулчлалын үйл ажиллагаанд ашиглахдаа тэдгээрийн эрх ашгийг тэгш хангасан байх" зарчимтай аялал жуулчлал (www.unesco.com) гэжээ. Орон нутгийн иргэдийн хүсэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн тэдний амьдралын чанар, стандартыг хангасан, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд болон аялагч жуулчдын эрэлт хэрэгцээг хангасан сэтгэл ханамжийг өндөр байлгах үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ аялал жуулчлалын суурь бааз болсон байгаль, түүх, соёлын нөөцөө байгаа хэвээр нь хадгалах, хамгаалах

үйл явцыг тогтвортой аялал жуулчлал гэнэ. (Hunter, 1995)

Дэлхийн аялал жуулчлалын байгууллага 1993 онд тогтвортой аялал жуулчлал нь "Одоогийн жуулчид болон уугуул иргэдийн хэрэгцээг хангахдаа ирээдүйн боломжийг дээшлүүлэх", 1995 онд "Орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, аялагчдад өндөр чанартай үйлчилгээ үзүүлэх, нутгийн иргэд болон жуулчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан хүрээлэн буй орчны чанарыг хангах эдийн засгийн хөгжлийн загвар" гэж тус тус тодорхойлсон байдаг. Тиймээс аялал жуулчлалын олон төрлөөс тогтвортой буюу холч аялал жуулчлал хамгийн тохиромжтой нь юм.

Бүдүүвч 2. “Тогтвортой буюу холч аялал жуулчлалын тулгуур ойлголтууд



Дэлхийн болон улс, бүс нутгийн хэмжээнд тодорхойлсон судлаач, эрдэмтдийн тодорхойлолтууд цаг үеэсээ шалтгаалахгүйгээр жуулчдын хүсэл сонирхол эрэлт


хэрэгцээг хангахдаа байгалийн нөөц, соёлын өвийг хадгалан хамгаалах, орон нутаг, нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх гэсэн агуулгыг хадгалж байна.

“ТАЖ” БУЮУ “ХАЖ”-ЫН “ТХЗ”-Д ШУУД НӨЛӨӨЛЖ БУЙ ЗОРИЛТУУД


Аялал жуулчлал нь “ТХЗ”-ын тогтвортой хөгжлийн эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох гэсэн 8-р зорилт, хариуцлагатай хэрэглээг дэмжих гэсэн 12-р зорилт,

далай, тэнгисийн нөөцийг хамгаалах гэсэн 14-р зорилттой шууд хамааралтай, бусад бүх зорилттой шууд бусаар хамаарч нөлөөлдөг салбар юм.

8: Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох



12: Хариуцлагатай хэрэглээг дэмжих



14: Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах, тогтвортойгоор ашиглах



8-р зорилт “Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох нь”:

Тогтвортой хөгжлийн үндсэн зарчим нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлт, зохистой ажлын байраар хангах асуудалд оршдог. Ядуурлыг бууруулах, бүрэн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь өсөлтийн

гол зорилго байдаг. Аялал жуулчлалын салбар энэ зорилтод шууд нөлөө үзүүлдэг салбар юм. Аялал жуулчлалын салбар дэлхийн экспортын 7%-ийг бүрдүүлж, 1.5 их наяд долларын орлого оруулж, үйлчилгээний экспортын 30%,


ДНБ-ий 10%-ийг эзэлдэг хөгжлийн хурдаараа санхүүгийн үйлчилгээ, бөөний худалдаа, тээвэр зэрэг олон салбараас хол түрүүлж олох орлого, ач холбогдлоороо ихэнх оронд эдийн засгийн биеэ даасан салбар, 120 орны тэргүүлэх 5 салбарын нэг болсон байна. (UNWTO, Annual report , 2016)

Дэлхийн хэмжээнд 1950 онд 25 сая жуулчин аялж байсан бол 2017 онд 50 дахин өссөн үзүүлэлттэй, 2030 он гэхэд 1,8 тэрбум жуулчин болох төлөвтэй байна. Сүүлийн 8 жилд жуулчдын тоо жил бүр дунджаар 4% тогтмол өсч, 2016 оны байдлаар аялагчид 1.220 тэрбум долларыг хэрэглээндээ зарцуулсан гэсэн судалгааны үр дүн байна. Аялал жуулчлал ДНБ-д шууд оруулсан хувь нэмэр 2016 онд 2,306.0 тэрбум ам.доллар (нийт ДНБ-ийн 3.1%), ДНБ-д оруулах нийт хэмжээ нь 7,613.3 тэрбум ам.доллар (ДНБ-ий 10.2%) байсан бол 2017 онд ДНБ-д шууд оруулсан хувь нэмэр 3.8%-аар, ДНБ-д оруулах нийт хэмжээ 3.6%-аар өссөн.

Энэ дүн 2027 онд 11,512.9 тэрбум ам.долларт хүрч 3.9%-аар өснө (ДНБ-ий 11.4%) гэсэн тооцоо судалгаа байна. (Council, 2017)

Нийт ажил эрхэлж буй 10 хүн тутмын 1 нь уг салбарт ажиллаж, тухайн улсад 1 жуулчин ирэхэд 20 ажлын байр шинээр бий болдог гэсэн тооцоо байдаг. Үүнээс гадна бусад салбаруудын эмэгтэйчүүдтэй харьцуулбал 2 дахин олон эмэгтэйчүүд уг салбарт ажил эрхэлж байна. 2016 онд аялал жуулчлалын салбарт 108,741,000 ажлын байр буюу нийт ажил эрхлэлтийн 3.6% байсан бол 2017 онд 2.1%, 2027 онд 4%-иар өсч 138,086,000 ажлын байр бий болно гэсэн тооцоо судалгаа байна. 2016 онд аялал жуулчлалын салбарын ажил эрхлэлт, түүний дотор шууд бусаар дэмжлэг үзүүлэх ажлын байр нь 292 220 000 байж энэ нь нийт ажил эрхлэлтийн 9,6%-ийг эзэлж байсан бол 2017 онд 298 сая болж 1,9%-аар өссөн үзүүлэлттэй. 2027 онд 2,5%-аар өсч 381,7 сая ажлын байр бий болох төлөвтэй байна. (Council, 2017).

Зураг 8. Аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тоо, бүс нутгаар. (сая)



Мөн 2016 онд аялал жуулчлалын салбарт оруулж буй хөрөнгө оруулалт 806.5 тэрбум ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 4.4%-тай тэнцэж байсан бол 2017 онд 4.1%-аар өссөн

үзүүлэлттэй байна. 2027 он гэхэд 1,307.1 тэрбум ам.долларт хүрч, нийт хөрөнгө оруулалтын 5.0%-ийг эзлэх боломжтой гэсэн тооцоо байна.

12-р зорилт “Хариуцлагатай хэрэглээг дэмжих”:

Одоогийн хэрэгцээг хангахдаа ирээдүйн хэрэглээг хязгаарлахгүй байх гол зарчмын үүднээс хариуцлагатай хэрэглээ маш чухал асуудал болдог. Аялал жуулчлал эрхлэхийн тулд байгаль орчинд үйл ажиллагаа явуулдаг. Тиймээс аялагчид жуулчдын сонирхлыг татахын тулд байгаль орчны хамгаалалт, байгалийн нөөцийн зохистой үр ашигтай хэрэглээ чухлаар тавигддаг. Дэлхий дээр олон сая хүн хүнсний хог хаягдал бий болгож байхад олон сая хүн өлсгөлөнгийн байдалд амьдарч байна. Энгийн иргэдээс илүү жуулчдын хэрэглээ харьцангуй их байх хандлагатай байдаг. Тиймээс аялал жуулчлалын салбарт хүнсний болон хог

хаягдлыг багасгах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх замаар тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой. Үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, хувь хүн, аялан амарч буй жуулчид хэн бүхэн уг асуудалд ухамсартай хандаж чадвал зохистой хэрэглээ аяндаа төлөвших болно. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй компаниуд орон нутгаасаа бүтээгдэхүүнээ худалдаж авдаг байх, ашигласан хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах замаар хувь нэмрээ оруулбал хариуцлагатай хэрэглээг дэмжихээс гадна байгаль орчны хамгаалалт сайжрах замаар байгалийн нөөцийн зохистой, үр ашигтай хэрэглээ аяндаа төлөвшинө.

14-р зорилт “Далай тэнгисийн нөөцийг хамгаалах”:

Усан дахь амьдралд далай тэнгис, нуур, цөөрөм, гол горхи зэргийг хамааруулж болно. Жуулчдын зорин очих газрын хамгийн эхний сонголт нь ус, далай тэнгисийн амьдрал, байгалийн үзэсгэлэнт газрууд болон хүрээлэн буй орчинтой салшгүй холбоотой байдаг. Тиймээс аялал жуулчлалын хамгийн чухал нөөц болохын хувьд энэ орчны бохирдол, хадгалаалт, хамгаалалт аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж буй хэн бүхний анхаарах хамгийн чухал асуудлын нэг болно. Энэ ч утгаараа аялал жуулчлалын салбарын “ТХЗ”-ын хүрээнд үзүүлэх нөлөө өндөр байна.

Хуванцар хог хаягдлын дийлэнх нь далайд хаягддаг. Жишээлбэл, загасны гэдэснээс тогтмол хуванцар сав гарч, энэ нь эргээд хэрэглэж байгаа хоол хүнсэнд нөлөөлнө. Саяхан гэхэд л халим загасны гэдэснээс 80 гялгар уут гарч, улмаар уг халим хорвоогийн мөнх бусыг үзсэн эмгэнэлт явдал тохиолдсон нь үүний нэг тодорхой илрэл юм. Далай тэнгисийг бохирдохоос сэргийлэх, нөөцийг нь хамгаалах, хууль бус ан агнуурыг зогсоох, гол горхины эх ундарга, эргэн тойронг арчлах, тордох зэргээр ТХЗ-ын “Далай тэнгисийн нөөцийг хамгаалах” зорилтыг хэрэгжүүлэх боломжтой юм.

ТАЖ БУЮУ ХАЖ-ЫН “ТХЗ”-Д ШУУД БУСААР НӨЛӨӨЛЖ БҮЙ ЗОРИЛТУУД

1-р зорилт “Ядуурлын бүх хэлбэрийг устгах”:

Ядуурлыг бууруулах нь “ТХЗ”-ын нэн тэргүүний зорилго бөгөөд үүнийг шийдэхийн тулд зохистой хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын


системийг сайжруулах зэрэг стратегийн асуудлыг авч үздэг. Бүх улс орон энэ асуудалд ихээхэн ач холбогдол өгч засгийн газрынхаа бодлого, хөтөлбөрт

тусган ажиллаж байна. Өндөр хөгжилтэй байна уу, хөгжиж буй орон байна уу гэдгээс үл хамааран, бүх оронд ядуурал оршин байдаг. 2017 оны байдлаар дэлхийн 103 орны 1,4 тэрбум хүн олон төлөвт байдлаар ядуу амьдарч байгаагийн 48% нь өмнөд Азид, 36% нь Саб Сахарын Африкад байна. Олон төрлийн хэлбэрийн ядуурлын бараг хагас буюу 48%-ийг 0-17 насны хүүхдүүд эзэлж байна. (ОРНИ, 2017) Ядуурлыг бууруулах зорилгоор олон

улсын олон талт байгууллагууд хөгжиж буй орнуудад туслах зорилготой үйл ажиллагаагаа явуулсаар байна.

"МХЗ" болон "ТХЗ" уудын үр нөлөөгөөр ядуурлын түвшин дэлхийн хэмжээнд буурч буй үзүүлэлттэй харагдаж байна. Өдөрт \$1.9-с бага орлоготой бол нэн ядуу гэж үзэх ба 1990 онд 1.9 тэрбум хүн нэн ядуу гэж бүртгэгдсэн бол 2015 оны байдлаар 702 сая хүн болж буурсан үзүүлэлттэй цаашид буурах боломжтой байна.


Зураг 9. Дэлхийн ядуурлын түвшин, ирээдүйн хандлага



2016 оны байдлаар ажилгүйчүүдийн 22 хувь нь ажилгүйдлийн тэтгэмж авч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 28 хувь нь халамж, 35 хувь нь нийгмийн

хамгаалал, 41 хувь нь жирэмсний тэтгэмж, тэтгэвэрт гарсан хүмүүсийн 68 хувь нь тэтгэвэр авч байна.

Зураг 10. Дэлхийн хүн амын хүртэж буй халамж, тэтгэмжийн эзлэх хувь



Аялал жуулчлалын салбар мөн адил энэ асуудалд нэлээд анхаарал хандуулах замаар хөрөнгө оруулалт хийж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, аялал жуулчлалын байгууллагуудаас ядуурлыг бууруулах төсөл хөтөлбөрүүдийг Африкт хэрэгжүүлж байна. Мөн дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас хэрэгжүүлдэг СТЕП төсөл нь дараах 7 үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор санхүүжилт олгодог байна. (UNWTO, 2017)

- Аялал жуулчлалын салбарт ажил эрхлэлт, ажлын байр бий болгох,
- Хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх замаар аялал жуулчлалд хувь нэмэр оруулах,
- Гар урлалын бүтээгдэхүүнээ

ядуу өрхүүд худалдах боломж олгох,


- Орлого багатай иргэд, аж ахуйн нэгжүүд уг салбарт ороход дэмжлэг үзүүлэх,
- Татвараар дамжуулан урамшуулах, татварын хөнгөлөлт үзүүлэх,
- Сайн дурын үндсэн дээр оролцох, сайн санааны үйл ажиллагаанд оролцох, жижиг орон нутагт туслах,
- Буурай улсын иргэдэд туслах, ядуу орны аялал жуулчлалын салбарт шаардлагатай хөрөнгө оруулалт хийх зэргийг дурдаж болно.

2-р зорилт "Өлсгөлөнг зогсоох":

Уг зорилгын хүрээнд газар тариалангийн ургацын хомсдол, нөөцийн үр ашигтай ашиглалт, хоол хүнсний хаягдал, хоол тэжээлийн дутагдал зэрэг асуудалд анхаарлаа хандуулдаг. Дэлхий дээр

ойролцоогоор 800 сая хүн өлсгөлөнд нэрвэгдэж, 9 хүн тутмын 1 нь шим тэжээлийн дутагдалд орж, 5 хүртэлх насны хүүхдийн 50% нь хоол тэжээлийн дутагдалд орж нас барж байна.

Зураг 11. Дэлхийн өлсгөлөнгийн индекс¹




¹ Тус индексийг тооцохдоо нийт хүн амын хоол тэжээлийн дутагдал, хүүхдийн жингийн дутагдал, өлсгөлөнд нэрвэгдсэн хүүхэд болон хүүхдийн нас баралт гэсэн 4 үзүүлэлтийг авч үздэг. 0-100 хүртэл эрэмбэлэх ба 50 ба түүнээс дээш бол "маш ноцтой", 35-50 хооронд "түгшүүртэй", 20-35 бол "ноцтой", 10-20 бол дунд зэргийн, 10-аас бага бол "бага" өлсгөлөнтэй гэж ангилдаг.

2017 оны байдлаар 9.9-өөс бага үзүүлэлттэй "бага" өлсгөлөнтэй 43 улс, 10-19,9 үзүүлэлттэй буюу "дунд зэргийн" өлсгөлөнтэй 23 улс, 20-34,9 "ноцтой" үзүүлэлттэй 44 улс, 35-49,9 "түгшүүртэй" үзүүлэлттэй 7 улс, 50-аас дээш буюу "маш ноцтой" үзүүлэлттэй 1 улс байна. (GHI, 2017)

Дэлхий даяар хоол тэжээлийн дутагдалд

орсон хүний тоо болон нийт хүн амд эзлэх хувь 2000-2002 онд 930 сая хүн буюу 15% байсан бол 2014-2016 онд 793 сая буюу 11% болж буурсан байна. 2016 оны байдлаар 5 хүртэлх насны 155 сая хүүхэд тураалтай, 52 сая нь бага жинтэй, 41 сая хүүхэд илүүдэл жинтэй гэсэн статистик мэдээлэл байдаг. 2000 онд энэ насны хүүхдийн 33% нь тураалтай байсан бол 2016 онд 23% болж буурчээ.

Зураг 12. Хоол тэжээлийн дутагдалд орсон хүн амын эзлэх хувь



Эх сурвалж: НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага

Аялал жуулчлалын салбар өлгөлөнг зогсоох болон уг үйл явцад хувь нэмэр оруулах зорилгоор орон нутагт хүнсний тариа тарьж ургуулах, үр тарианы эрүүл, найдвартай байдал, хоол, хүнсний ногоог экологийн чанараар нь жуулчдад хүргэх гэх мэт асуудлуудад анхаарлаа

² Хоол тэжээлийн дутагдал нь өлсгөлөнг хэмжих гол үзүүлэлт бөгөөд өдөрт авах ёстой илчлэгийг хангалттай авч чадахгүй байгааг илэрхийлж байна.

3-р зорилт "Эрүүл мэндийг гэмжих":

Эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлүүд, эх нялхсын эрүүл мэндийг сайжруулах, халдварт өвчнийг зогсоох, аюулгүй, үр дүнтэй, чанартай эм, вакцинаар хангаж, эрүүл мэндийн хангамжийг бүх нийтэд

хандуулж ажилладаг. Хөдөө аж ахуйн хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх асуудалд аялал жуулчлалын салбар тодорхой үүрэг гүйцэтгэдэг. Аялал жуулчлал өндөр хөгжсөн бүс нутгуудад хоол тэжээлийн дутагдал, хүнсний аюулгүй байдал харьцангуй асуудал багатай байдаг. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд жуулчдын хүнсний хэрэгцээнд нэлээд анхаарлаа хандуулдаг учир хүнсний шаардлагыг өндөр түвшинд хангаж чаддаг байна.

хүртээмжтэй байлгахад чиглэдэг. Бүх насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэнд, аваар ослоос урьдчилан сэргийлэх асуудал мөн адил аялал жуулчлалын салбарт чухлаар тавигддаг.

Агаарын, усан, төмөр, авто гэх мэт бүхий л төрлийн тээврийн үйлчилгээ нь аялал жуулчлалын салбарын нэн тэргүүний асуудал байдаг. Энэ утгаараа тээвэртэй холбоотой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, татвараас олсон орлогоосоо эрүүл мэндийн салбарт хуваарилах гэх мэтээр аялал жуулчлалын салбар иргэд


4-р зорилт “Чанартай боловсролыг гэмжих”:

Бүх хүнийг суралцах боломжоор хангаж, чанартай боловсролыг хүртээх зорилготой ба мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, багш болон сургуулийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаардаг. Аялал жуулчлалын салбарт бүх мэргэжлийн ажилтан шаардлагатай байдаг. Бүх ажилтанд нэн ялангуяа алслагдсан газарт сургалтын шаардлага байсаар байна. Тухайн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага цаг үетэйгээ хөл нийлүүлэх, хэрэгцээ нь жил жилээр өсөн нэмэгдэж буй жуулчдын сэтгэл ханамжийг өндөр байлгах, мэргэжсэн


эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчин нөхцөлийг сайжруулах, чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжуудыг нэмэгдүүлдэг. 2000-2015 оны хооронд ХДХВ-ийн тархалт 46%-аар, сүрьеэгийн тохиолдлын 17%, хумхаагаар өвчлөх эрсдэл 41%, халуун орны өвчин 21%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

үйлчилгээтэй байх зорилгоор зайлшгүй хөгжиж байх шаардлага тулгардаг. Хэдий туршлагатай ч хүн бүр өөрийгөө хөгжүүлэх хэрэгтэй байдаг. Түүнчлэн ямар нэг байдлаар боловсрол эзэмшиж чадаагүй хүмүүст насан туршийн боловсрол олгох, албан бусаар эзэмшсэн мэргэжлийг хүлээн зөвшөөрдөг байх асуудал яригддаг. 2014 оны байдлаар дэлхий даяар 3 хүүхэд тутмын нэг нь, буурай хөгжилтэй орнуудад 10 хүүхэд тутмын 4 нь сургуулийн өмнөх болон бага боловсролд хамрагдаж чаддаг байна.

Зураг 13. Дэлхий даяарх сургуулийн насны сургуулиас завсардсан хүүхдүүдийн боловсролын түвшинг хүйсээр харуулав (хувиар)



Зураг 14. Сургуулиас завсардсан хүүхдийн тоо



Эх сурвалж: Боловсрол, ШУ, соёлын байгууллага, НҮБ

5-р зорилт “Жендерийн тэгш байдлыг хангах”:

Дэлхий даяар жендерийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн зөрчигдөж буй эрхийг хамгаалах зэрэгт анхаарч, хууль эрх зүйн зохицуулалт, жендерт суурилсан ялгарлалыг

арилгахыг зорьдог. 2000-2016 оны дунджаар, эрэгтэйчүүдтэй харьцуулбал эмэгтэйчүүд гэрийн ажилд 3 дахин их цаг зарцуулдаг байна. 2017 онд парламент дахь эмэгтэйчүүдийн оролцоо дөнгөж

23.4%-д хүрээд байна. Дэлхийн олон оронд эрэгтэй, эмэгтэйчүүдийн хооронд тэгш бус байдал оршсоор байна. Ажил эрхлэлт, цалин хөлс, карьер, шийдвэр гаргалт болон улс төр, эдийн засгийн шийдвэр гаргах бүхий л түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байсаар байна. Аялал жуулчлалын салбар бусад салбартай харьцуулахад хамгийн олон эмэгтэй ажилтантай салбар.

Бизнесийн байгууллагад ажиллахаас гадна хувиараа газар тариалан, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэргээр аялал жуулчлалын үр шимийг хүртэх боломжтой байдаг. Энэ утгаараа аялал жуулчлалын салбар нь худалдаа үйлчилгээг хамардаг учир энэ салбарт эмэгтэйчүүдийн оролцоо, тэдний хөдөлмөр эрхлэх боломж харьцангуй өндөр үзүүлэлтэй байдаг.

Зураг 15. Аялал жуулчлалын салбарт ажиллагсдын хүйс

Аялал жуулчлалын салбарт ажиллагсдыг нэгж бүрт хүйсээр харуулав (2009, x1000)



Source: Business Register Employment Survey (BRES) (2009), Workforce Jobs 2009.

6-р зорилт “Баталгаат ундны ус ариун цэврийн байгууламжаар хангах”:

Нийт хүн амын түвшинд ундны болоод хэрэглээний усны чанарыг сайжруулах, эко системийг бий болгохыг зорьдог. Энгийн иргэдээс жуулчид илүү их ус хэрэглэдэг гэсэн судалгаа байдаг. Ус бол шавхагддаг нөөц юм. Тиймээс дэлхий дээр хүн бүр энэ асуудалд анхаарах хэрэгтэй байдаг. Ундны усыг аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, усны бохирдлыг багасгах, гол, горхи, далай, тэнгисийн усанд бохир, хог хаягдлыг хаях үйл явцыг зогсоох, тэдгээрийг хамгаалах асуудал нэн чухал байдаг.

Аялал жуулчлалын салбар мөн адил эдгээр асуудалд хамгийн чухал нөлөө үзүүлдэг салбар билээ. Жишээ нь, гольфын талбай ус их хэрэглэдэг. Аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ душны усыг сайн цацруулаад бага ус хэрэглэх, жуулчны зорин очих газрууд борооны ус, саарал усыг ашиглах гэх мэтээр хувь нэмрээ оруулах шаардлагатай юм.

2015 онд 5.2 тэрбум (дэлхийн хүн амын 71%) хүн ундны усыг аюулгүй эх үүсвэрээс хэрэглэж, 2.9 тэрбум (дэлхийн хүн амын 39%) хүн ариун

цэврийн хэрэглээний усыг аюулгүй, боловсронгуй технологиор ашиглаж байна. Гэвч 892 сая (дэлхийн хүн амын 12%) хүн задгай бие засах газар ашиглаж байгаа нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй юм. Дэлхийн 2 тэрбумаас илүү хүн хангалттай цэвэр, хүрэлцээтэй ус

7-р зорилт "Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх":

Нийт хүн амыг найдвартай, тогтвортой эрчим хүчээр хангах, дэлхийн эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй үйлчилгээг нийтэд хүргэхийн тулд түлш үйлдвэрлэх технологийг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, мөн сэргээгдэх эрчим хүчийг эрчимжүүлэх явдалд дэлхий нийтээр анхаарлаа хандуулж байна. 2014 онд дэлхийн хүн амын 85,3% нь цахилгаанаар хангагдсан нь 2000 оны 77,6%-тай харьцуулахад дэвшил гарсан байна. Хотын оршин суугчдын 96% нь цахилгаанаар хангагдсан бол орон

хэрэглэж чадахгүй байна. Хойд Африк, Өмнөд Ази, мөн Төв болон Зүүн Азийн орнуудын хүн амын 60%-аас доошгүй нь ундны усны хязгаарлагдмал хэрэглээтэй, ирээдүйд усны нөөц багасах эрсдэлтэй байна.

нутагт хүн амын 73% нь эрчим хүчинд холбогдсон байна. Гэсэн хэдий ч 1,06 тэрбум хүн энэ үндсэн үйлчилгээг авч чадахгүй байна. Жилд ойролцоогоор 250 нартай өдөр тохиодог учраас өдөр нарны эрчим хүчийг цуглуулдаг батерей бүхий нарны панель суурилуулах /нарны, салхины, эрчим хүч/ асуудалд аялал жуулчлал эрхэлдэг байгууллагууд өндөр ач холбогдол өгдөг. Сүүлийн жилүүдэд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж 2010-2014 онд 17,5-18,3 хувь хүртэл, эрчим хүчний хүчин чадал 2,1 %-аар өссөн хэдий ч үр ашгийг нэмэгдүүлэхэд хангалттай биш юм.

Эрчим хүчний хангамж хоттой харьцуулахад хөдөөд бага байна



3 тэрбумаас их хүн зориулалтын түлш болон технологийг хэрэглэдэггүй

9-р зорилт "Инноваци болон гэд бүтцийг хөгжүүлэх":

Дэд бүтэц, аж үйлдвэр болон инноваци гурав нь эдийн засгийн өсөлтийн хөдөлгөгч хүч, хөгжлийн суурь бааз юм. Уян хатан дэд бүтцийг хөгжүүлэх, хүртээмжтэй тогтвортой аялал жуулчлалыг дэмжих, байгаль, нийгэмд ээлтэй технологи нэвтрүүлэх гэх мэтээр тасралтгүй өсөн нэмэгдэж буй жуулчдын хэрэгцээ шаардлагыг хангахын тулд аялал жуулчлалын салбарт инноваци зайлшгүй хэрэгтэй байдаг. 2015 онд агаарын тээврийн эдийн засагт үзүүлсэн нөлөө 2.7 тэрбум (дэлхийн ДНБ-ий 3.5%) ам.доллар байв. 2005-2016 онд хөгжиж буй орнуудад нэг хүнд ногдох

үйлдвэрлэлийн нэмүү өртөг 59%-аар өссөн, үүний ердөө 2%-ийг Европ болон Хойд Америкийн орнууд эзэлж байгаа юм. 2000-2014 онд аж үйлдвэр өндөр хөгжсөн 10 оронд үйлдвэрээс гаралтай нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг тогтвортой бууруулж чадсан байна. Судалгаа хөгжил дэх дэлхийн хөрөнгө оруулалт 2000-2014 онд жилд дунджаар 4.5%-аар өссөн. 2014 оны байдлаар судалгаа, хөгжлийн хөрөнгө оруулалт дэлхийн ДНБ-ий 1.7% буюу 1.8 их наяд ам долларт хүрсэн ажээ. 2016 онд дэлхийн хүн амын 95% гар утасны 2G, 84% 3G сигналыг авч чаддаг болсон

байна. Инновацийг хатуу болон зөөлөн дэд бүтцэд ашиглаж болдог. Жуулчдыг өндөр сэтгэл ханамжтайгаар үдэх ёстой. Жишээ нь, тусгайлсан мэндчилгээг



Цөөн хэдэн хөгжингүй орнууд, далайд гарцгүй улсууд болон хөгжиж буй жижиг арлын улс бүр дэлхийн агаарын ачаа тээврийн 1-2,7% эзэлж байна

үйлчилгээндээ нэвтрүүлэхэд л инноваци болдог. Энэхүү инновацийг хийснээр жуулчдын тоо нэмэгдэн энэ нь эргээд эдийн засагтаа хувь нэмэр оруулдаг.



Судалгаа хөгжил дэх хөрөнгө оруулалт 2000-2014 онд жилд дунджаар 4.5%-аар өссөн

10-р зорилт “Тэгш бус байдлыг бууруулах”:

Олон улсын эдийн засаг, санхүүгийн шийдвэр гаргахад хөгжиж буй орнууд дуу хоолойгоо нэгтгэх замаар улс хоорондын болон нэг улс доторх тэгш бус байдлыг багасгах асуудалд нэлээд анхаарч байна. 2011-2015 онд 83 орноос 49 оронд хүн амын хамгийн ядуу 40%-ийн нэг хүнд ногдох орлого үндэсний дунджаас өссөн нь орлогын тэгш бус байдал буурч байгааг харуулна. Олон улсын худалдааны нөхцөл хөгжингүй орнуудад сайжирч, 2005-2015 онд экспортын тэг тарифын шугам 49-65% болж нэмэгджээ. Хөгжиж буй орны иргэд хөгжингүй орнуудад ажил, хөдөлмөр эрхлэх замаар өөрийн орлогоо нэмэгдүүлэх боломж их

байна. Аялал жуулчлалын хөгжлийн нөлөөгөөр валютын экстенж солилцоо нэлээд хийгдэх боломж бүрдэж байна. Монгол Улсад хөдөө орон нутгийг аялал жуулчлалын салбартай уялдуулан хөгжүүлэх боломж өндөр байна. Гар урлал, газар тариалан, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхлэх замаар хүн амын тэгш бус байдлыг багасгах, бага орлоготой иргэдийн эдийн засгийг дэмжих боломжтой. Гар утасны шинэ болон сайжруулсан технологиуд мөнгөн гуйвуулгын төлбөрийг 2-4%-аар буурахад хүргэсэн хэдий ч ихэнх мөнгөн гуйвуулгын хүрээнд уг технологийг ашиглаж чадахгүй байна.

11-р зорилт “Ээлтэй хот иргэдийн оролцоог дэмжих”:

Иргэддээ аюулгүй улс орон жуулчдад нэгэн адил аюул багатай байдаг. Дэлхийн ихэнх улсууд хотожсон байдаг ба хамгийн их хотожсон 10 орны 9 нь Азийн улс байдаг. Ихэнх оронд аяллын зорих газар нь томоохон хотуудад чиглэсэн байдаг. Учир нь, тэнд олон соёл байдаг учир үзэх харах зүйл, зочид буудал элбэг, бизнес эрхлэлт, санхүүгийн үйлчилгээ нэг дор төвлөрсөн байдаг. Тиймээс эдгээр хотын аюулгүй байдал хамгийн чухал юм. Аялал жуулчлалын салбарын байгууллагууд хөгжлийн

бэрхшээлтэй болон оюун санааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан орц гарц таних тэмдэг гэх мэт стандартууд, хөл муутай хүмүүст зориулан барилга байгууламжаа зохион байгуулах шаардлагатай байдаг. Хүртээмжтэй, олон хүнд нээлттэй байхыг эхнээс нь тооцоолох шаардлагатай. Дэлхийн хүн амын дийлэнх буюу талаас илүү нь хотод амьдардаг. Дэлхийн соёлын өв, байгалийн нөөцийг хамгаалах асуудалд аялал жуулчлалын салбарын оруулах хувь нэмэр өссөөр байна.

ДЭМБ-ын 2014 оны судалгаагаар хотод амьдарч буй хүмүүсийн 10 тутмын 9 нь хортой агаараар амьсгалж байна



101 орны хотуудад нийт хог хаягдлын 65% төвлөрч байна

13-р зорилт “Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах”:

Жилээс жилд хүний хүчин зүйлийн нөлөөгөөр хувьсан өөрчлөгдөж буй уур амьсгал, түүнээс улбаалсан байгалийн гамшиг зэрэг нь зөвхөн аялал жуулчлалын салбарт бус улс орны эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг. Ус дагасан аялал жуулчлалын хувьд дэлхийн дулаарал, усны түвшин,

элс, салхи зэрэг нь маш хүчтэй нөлөөллийг авчирдаг. Тиймээс эдгээр нөлөөллийг бууруулах, түүнтэй дасан зохицох, эрт илрүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, хүлэмжийн хийг бууруулахад дэлхийн аялал жуулчлалын салбар ашгийнхаа 5%-ийг зориулж байна.

15-р зорилт “Хуурай газрын экосистемийг хамгаалах.

Жуулчид зорин очих, үзэх сонирхох зүйлсийн нэг нь яах аргагүй хүрээлэн буй орчин, байгаль, ан амьтан байдаг. Тиймээс хүний хүчин зүйлийн улмаас үүсч болох сөрөг нөлөөнөөс ногоон ой модыг хамгаалах, ойн нөөцийн тогтвортой байдлыг хангах, ан амьтныг хууль бусаар агнах, борлуулахыг зогсоох, биологийн төрөл зүйлийн хорогдлыг багасгахад аялал жуулчлалын бизнес эрхлэгч байгууллага, хувь хүний

оролцоо маш чухал байдаг. Зарим газарт ширэнгэн ой шатаах, эсвэл нэгхэн төрлийн ургамал тариалж хөрс газрыг эргэн сэргэхгүйгээр болгох зэрэг нь хувь хүний ухамсар, мэдлэгээс шалтгаалдаг хүчин зүйлүүд байдаг. Аялал жуулчлалын салбар эмзэг газрыг, зэрлэг ан амьтан, хүрээлэн буй орчныг хайрлан хамгаалахад санхүүжилт олгодог.

16-р зорилт “Энх тайван шуграга ёсыг цогцлоох”:

Аялал жуулчлал нь энхтайван байдлыг бий болгох, урт хугацаанд оршин тогтнох боломжийг олгох, дайн дажныг зогсооход анхаарал хандуулдаг төдийгүй энх тайван байдал нь улс хоорондын дипломат харилцааны шинэ арга

хэрэгсэл болдог. Аливаа саад тотгорыг үгүй хийж, зочид болон хүлээн авагчийг хооронд нь холбодог, аюулгүй байдлын заналхийллээс урьдчилан сэргийлдэг уян хатан салбар нь аялал жуулчлалын салбар билээ.

17-р зорилт “Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх”:

Аялал жуулчлалд зөвхөн нэг байгууллага бус олон талын оролцоо, бүхий л талуудын түншлэл хамаардаг. Зөвхөн том газруудын үүрэг хариуцлага биш, хувь хүний үүрэг ч энд чухал байдаг. Аялал жуулчлалын салбарт бизнес эрхлэгчид, хэрэглэгчид, төр, засгийн бодлого боловсруулагчид, орон нутгийн удирдлага, байгууллагууд, иргэд, олон

улсын болон төрийн бус байгууллагууд, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд хамтран ажилладаг салбар юм.

Ийнхүү аялал жуулчлал нь дэлхий нийтээр хэрэгжүүлж буй “Одоогийн хэрэгцээг хангахдаа ирээдүй хойч үеийн хэрэгцээгээ хангах боломжийг хязгаарлахгүй байх” зарчмаас хэнч


хоцрох ёсгүй уриатай “Тогтвортой хөгжлийн бүхий л зорилтуудад хамгийн их хамааралтай, шууд нөлөө үзүүлдэг салбар юм. Тиймээс улс орон бүр аялал

жуулчлалын тусламжтайгаар “ТХЗ”-ыг хэрэгжүүлэхэд нэг алхам урагшлах боломж бүрдэнэ.

ДҮГНЭЛТ

- Тогтвортой хөгжлийн талаар шинжилгээнүүддээ тулгуурлан санал болгож буй схем болон дараах дүгнэлтүүдийг гаргав. “ТХЗ”-ын хүрээнд авч үзсэн

Бүдүүвч 3. Тогтвортой хөгжил ба тогтвортой аялал жуулчлалын агуулгын схем (Leon, 2010)



- Тогтвортой хөгжил нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн тэгш байдал, хүрээлэн буй орчны амьдрах чадварыг гол шалгуур үзүүлэлтээ болгон авч үздэг. “ТАЖ” буюу “ХАЖ” нь жуулчдыг нас, хүйс, гарал угсаагаар үл ялгаварлан тэдний аюулгүй байдлыг ханган, сэтгэл ханамжийг дээд түвшинд байлгах, орон нутгийн иргэдийн ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх боломжийг олгодог. Иймд урт хугацаанд үр ашигтай, тасралтгүй оршин тогтнохын тулд жуулчдын зорин очих газар болон бизнесийн өрсөлдөх чадварыг хангах, жуулчдаас бий болдог нийгэм, эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлэх, жуулчдын орлогоос тодорхой хэсгийг

ядуурлыг бууруулахад хуваарилах нь эдийн засгийн үр ашгийг бий болгож тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

- “ТАЖ” буюу “ХАЖ” нь орон нутгийн иргэдийн ая тухтай амьдрал, нөөцийн хэрэглээ зэргийг дэмжих байдлаар амьдралын чанарыг дээшлүүлэх, нийгмийн доройтлоос зайлсхийх боломжийг олгодог. Иймээс тухайн бүс нутгийн ирээдүйн хөгжил, удирдлагын шийдвэр гаргалт, төлөвлөлтөд орон нутгийн иргэдийг оролцуулахад анхаарах хэрэгтэй байна. Үүнээс гадна жуулчдаас олж буй орлогын тодорхой хувийг орон нутагт хуваарилах, аялал жуулчлалаас орон нутгийн эдийн

засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг өндөр түвшинд байлгах, иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг дээшлүүлснээр нийгмийн тэгш байдлыг бий болгох нь тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмэр болно.

- “ТАЖ” буюу “ХАЖ” нь хот суурин газар болон хөдөө орон нутаг дахь газар нутгийн чанар, байгаль орчин, хөдөөгийн уламжлалт соёлд нөлөөтэй учраас аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэхийн тулд дахин сэргээгдэхгүй нөөцийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах, нутгийн уугуул иргэдийн өвөрмөц түүхэн соёл, өв уламжлал, зан заншлыг хадгалах, байгаль орчин, зэрлэг ан амьтдын амьдрах орчны хамгаалалт, тэдэнд учирч болзошгүй аюулыг багасгахад анхаарах нь чухал байна.
- Аялал жуулчлалын бизнес эрхлэгчид болон жуулчдаас бий болсон хог хаягдал, усны бохирдол, агаарын бохирдлыг хамгийн бага байлгахад анхаарах зэргээр хүрээлэн буй орчны амьдрах чадварыг нэмэгдүүлэх нь тогтвортой хөгжлийг дэмжиж буйн илрэл гэдгийг анхаарах нь чухал юм.
- “ТАЖ” буюу “ХАЖ”-ыг улс орнууд бодлогын хүрээнд тодорхойлж, дэмжин, хамгийн тохиромжтой шалгуур үзүүлэлтийг стандарт болгон мөрдөж байна. Энэхүү шаардлагыг хангасан аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, бусад аргаар урамшуулах замаар дэмждэг, олон нийтэд мэдээлдэг байх нь тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

НОМ ЗҮЙ:

1. Brundtland Report, U. N. (1987). *Our Common Future*. United Nations World Commission on Environment and Development .
2. Council, W. t. (2017). *Travel & tourism economic impact 2017 world. Travel & tourism economic impact 2017 world*, 1.
3. Data, O. w. (2017). *Our world in data*. Retrieved from <https://ourworldindata.org/>: <https://ourworldindata.org/extreme-poverty>
4. Edgell, D. S. (2013). *Tourism Policy and Planning: Yesterday, Today, and Tomorrow. Tourism Policy and Planning*.
5. GHI, G. h. (2017). *Global hunger index*. Retrieved from <http://www.globalhungerindex.org/download/2017-download.html>
6. History, A. M. (2016, 11 04). *www.youtube.com*. Retrieved from Human Population Through Time: https://www.youtube.com/watch?v=PUw-mA3Q0_OE&t=1
7. Hunter, C. (1995). *Journal of sustainable tourism*.
8. Leon, M. G. (2010). *Turismo sostenible y bienestar social*. Barcelona: Erasmus ediciones, 2010.
9. OPHI. (2017). *Global multidimensional poverty index*. University of Oxford.
10. Stanislav Ivanov, M. (2013). *Mass tourism vs Eco mass tourism*. Bulgaria.
11. UNWTO. (2016). *Annual report* .
12. UNWTO. (2017). *Tourism highlights*.
13. UNWTO. *Sustainable tourism concepts*, 2. (n.d.).
14. www.unesco.com. (n.d.).
15. <https://www.e-unwto.org/doi/pdf/10.18111/wtobarometeresp.2017.15.4.1>
16. Д.Бадарч, Б. (2014). *Системийн сэтгэлгээ*. Улаанбаатар: ШУТИС.
17. ШУА. (2008). *Монгол хэлний гэлгэрэнгүй тайлбар толь*. Улаанбаатар.
18. Я.Цэвэл. (2013). *Монгол хэлний товч тайлбар толь*. Улаанбаатар.

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ОРОН НУТГИЙН БАНКНЫ НЭГЖҮҮДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Б.Амарзаяа

СЭЗИС-ийн МВА хөтөлбөрийн магистрант

Abstract. Mining activities, especially extraction of and processing at strategic coal and mineral deposits such as Tavantolgoi, Oyu Tolgoi, and Nariinsukhait, had intensified in Umnugovi province since 2010. However, between late 2014 and the third quarter of 2016, the mining industry stalled across the province leading to loss of revenue for local businesses, high unemployment rate, rising rate of credit risk due to the stated negative impacts on repayment capacity of borrowers, and eventually 7.75% increase in low-quality loans in banks' loan portfolios by the second half of 2016, reaching a decade-high. 2015 through the third quarter of 2016, the percentage of low-quality loans increased, on average, by 5.4%.

To identify the factors contributing to loan quality deterioration witnessed in the portfolios of the commercial bank branches in Umnugovi province, socio-economic conditions and the current status of the financial sector were assessed employing multivariate regression models and PESTLE analyses. For the purpose of validating the results of the quantitative research, a questionnaire was constructed and a follow-up survey was conducted among loan specialists at eight out of nine commercial banks that have branches in Umnugovi province, namely Khan, State, Xac, Golomt, TDB, Capital, NIBank, and Capitron banks. A local branch of Chinggis Khaan bank has not issued any loan to date since its opening in 2017.

It is concluded that, in Umnugovi province, rising rate of low-quality loans is effected by mining industry downturn, unemployment and other factors. But inflation, yuan rate, the average salary of business entities and the weighted average interest rate of the loan is negative impacts. Guidelines concerning this phenomenon were put forth for loan specialists at local commercial bank branches.

Key words: Credit risk of commercial banks, low-quality loan, local commercial bank branches, low-quality loan rate in Umnugovi province

Хураангуй. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа 2010 оноос хойш эрчимтэй хөгжиж, ялангуяа Өмнөговь аймагт стратегийн ач холбогдол бүхий Тавантолгой, Оюу толгой, Нарийн сухайтын орд газруудад ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа идэвхжиж эхэлсэн байна. Гэтэл 2014 оны сүүлээс 2016 оны 3 дугаар улирал хүртэл хугацаанд тус аймаг дахь уул уурхайн салбарын үйл ажиллагаа зогсонги байдалд орж бизнес эрхлэгчдийн орлогыг хумигдуулж, улмаар ажилгүйдэл ихэсч, зээлдэгчдийн төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөн зээлийн эрсдэлийг нэмэгдүүлж, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх дүн 2016 оны 2-р хагас гэхэд 7.75 хувь буюу сүүлийн 10 жилд байгаагүй өндөр хэмжээнд хүрчээ. Өөрөөр хэлбэл, 2015-2016 оны 3 дугаар улирал хүртэл хугацаанд дунджаар 5.4 хувь болсон байна.

Иймд Өмнөговь аймгийн банкны нэгжүүдийн зээлийн чанарт нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор тус аймгийн нийгэм эдийн засгийн орчин болон санхүүгийн салбарын өнөөгийн байдлыг судалж, чанаргүй зээлд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор олон хүчин зүйлийн регрессийн загвараар үнэлж, PESTLE аргаар чанарын шинжилгээ хийжээ. Тоон шинжилгээг баталгаажуулах зорилгоор Өмнөговь аймгийн Даланзадгад сумын банкны нэгжүүдийн зээлийн мэргэжилтнүүдээс санал асуулга боловсруулан судалгаа авч, дүн шинжилгээ хийсэн бөгөөд асуулга судалгаанд Өмнөговь аймагт байрладаг нийт 9 банкны нэгжээс Хаан, Төрийн, Хас, Голомт, Худалдаа хөгжил, Капитал, Үндэсний хөрөнгө оруулалтын, Капитрон зэрэг 8 банк хамруулав. Чингис хаан банк 2017 онд байгуулагдсан ба одоогоор зээл олголт хийгээгүй байгаа болно.

Энэхүү судалгааны үр дүнд Өмнөговь аймгийн чанаргүй зээлийн хувь хэмжээ, уул уурхайн салбарын уналт, ажилгүйдэл болон бусад хүчин зүйлсийн нөлөөгөөр нэмэгддэг. Харин юаны ханш, инфляци, тус аймгийн аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтнуудын дундаж цалин, банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү сөрөг нөлөө үзүүлдэг гэсэн дүгнэлтэд хүрсэн бөгөөд судлаачийн зүгээс банкны нэгжүүдийн зээлийн мэргэжилтнүүдэд зориулж тус аймгийн онцлогт тохирсон санал, зөвлөмжийг боловсруулсан болно.

Түлхүүр үгс: Арилжааны банкны зээлийн эрсдэл, чанаргүй зээл, орон нутгийн банкны нэгж, Өмнөговь аймгийн чанаргүй зээл

ОРШИЛ

2010 оноос Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтууд ихээр орж ирж эдийн засгийн өндөр өсөлтийг бий болгожээ. Энэ хугацаанд Өмнөговь аймгийн хувьд аж үйлдвэрийн салбарын 98-99 хувийг нүүрсний үйлдвэрлэл, борлуулалт эзэлж, нүүрсний борлуулалт 2010-2011 онд 350.4-479.6 тэрбум төгрөгт хүрсэн төдийгүй уул уурхайн салбарыг дагасан худалдаа, үйлчилгээний салбар эрчимтэй хөгжсөн. 2012 оны хагасаас хойш гадаадын хөрөнгө оруулалтууд буурч, 2014 оноос экспортын түүхий эдийн үнэ буюу нүүрсний үнэ буурч, уул уурхайн салбар уналтанд орсноор тус аймгийн банкны нэгжүүдийн зээлийн чанар огцом мууджээ. Ийнхүү 2016 оны 2-р улирлын эцэс гэхэд 112.7 тэрбум төгрөгийн 8.7 тэрбум төгрөг буюунийт

зээлийн багцын 7.75 хувийг чанаргүй зээл эзлэх болсон байна. Харин 2016 оны 3-р улирлаас уул уурхайн салбар идэвхжиж эхлэхэд иргэд харилцагчдын төлбөрийн чадвар сайжирч, банкуудын зээл олголтын хэмжээ эргэн нэмэгдэж, 2017 оны эцэстнийг зээл 172.2 тэрбум төгрөг болж чанаргүй зээлийн хэмжээ 5.1 тэрбум төгрөг болж буурсан ба нийт зээлийн багцын 2.99 хувь эзэлсэн байна.

Иймд Өмнөговь аймгийн хэмжээнд чанаргүй зээлд нөлөөлөгч гол хүчин зүйлсийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах арга замыг хайж, тус аймгийн банкны нэгжүүдийн зээлийн мэргэжилтнүүдэд орон нутгийн онцлогт тохирсон санал зөвлөмжийг боловсруулах зорилгоор энэхүү судалгааг хийсэн болно.

СУДАЛАГДСАН БАЙДЛЫН СУДАЛГАА

Зээлийн эрсдэл болон эрсдэлийн удирдлагын чиглэлээр гадаад, дотоодын олон арван эрдэмтдийн ном, хэвлэмэл бүтээл, өгүүлэл, судалгаа, эрдмийн ажил нийтлэгдсэн байдаг бөгөөд энэхүү чиглэлээр хийсэн судалгааны ажлууд өсөн нэмэгдсээр байна.

Дотоодод орон нутгийн онцлог болон уул уурхайн салбараас хамаарсан судалгаа хараахан байхгүй байгаа бол БНХАУ-ын эдийн засаг судлаач ХИА Chun-mei "БНХАУ-ын Шуудангийн Хадгаламж банкны

"Binzhou" салбар дахь уул уурхайн салбарыг дагасан зээлийн эрсдэлийг бууруулах менежментийн системийг бий болгох талаар судалж уул уурхайн (Data Mining) технологийг хэрэглэвэл үр дүнтэй" гэж дүгнэжээ. "Data mining" технологийг нэвтрүүлснээр уул уурхайн салбарын талаар бодит мэдээллийг түргэн шуурхай цуглуулж, шинжилгээ хийж, эрсдлийг банкны салбарын бодит шинж чанаруудтай хослуулан зээлийн эрсдэлд менежмент хийх боломжтой гэж үзсэн нь чухал байв.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН ОНОЛ АРГА ЗҮЙ

Зээлийн эрсдэл нь макро болон микро олон хүчин зүйлээс хамаардаг бөгөөд эдгээр хүчин зүйлсүүд нь зээлийн төрөл бүрийн хувьд харилцан адилгүй байдаг. Макро эдийн засгийн орчин, зээлдэгчдийн салбарын ашигт ажиллагаанд гарч байгаа өөрчлөлт, ханшийн хөдөлгөөн зэрэг макро буюу гадаад хүчин зүйлсийг банкууд шууд удирдах боломжгүй бөгөөд эдгээрийн зээлийн эрсдэлд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тодорхойлоход ихээхэн хүндрэлтэй юм. Харин микро хүчин зүйлс буюу өөрийн үйл ажиллагаа эсвэл өөрсдийн мэдэлд байдаг бусад хүчин зүйлсүүдээр эрсдэлийг удирдах, болзошгүй эрсдэлийг таамаглах боломж харьцангуй их байдаг. (Н.Ургамалсүвд, 2009)

Банкны хувьд зээлийн эрсдэл бий болох үндэс нь гадаад, дотоод хоёр үндсэн хүчин зүйлсээс хамаардаг. Гадаад хүчин зүйлд улс орны эдийн засгийн хямрал, байгалийн үзэгдлийн нөлөөлөл, хууль тогтоомжийн өөрчлөлт, улс

төрийн байдал зэрэг зээлийг эрсдэлтэй болгодог гадаад хүчин зүйлүүдийг авч үздэг. Банкны хүчин чармайлтаар тэр болгон шийдвэрлэж чадахгүй учир аливаа зээл ямар нэг хэмжээгээр эрсдэлтэй байдаг. (Л.Оюун, 2004)

Зээлийн эрсдэл үүсэх нь тухайн зээлдэгчийн нөхцөл байдал болон зах зээлийн нөхцөл байдал буюу системийн эрсдэлээс хамаарна. Эдийн засгийн өсөлттэй байгаа тохиолдолд зээлийн эрсдэл үүсэх нь бага байх ба зах зээлийн нөхцөл байдал хэлбэлзтэй, инфляци ажилгүйдэл ихтэй, хямралын үед зээлдэгч зээлээ төлөхгүй байх магадлал өсдөг. Үүнийг системийн эрсдэл гэнэ. Нөгөө талаас зах зээлийн ижил нөхцөл байдалд зээлийн эрсдэл үүсэх нь зээлдэгч тус бүрийн хувьд харилцан адилгүй байдаг. Үүнийг зээлдэгчийн эрсдэл гэнэ. (Б.Мөнхзаяа, 2013)

Арилжааны банкны эрсдэлийн менежмент нь эрсдэлийг танин мэдэх үе шат, эрсдэлийг хэмжих, шинжлэх үе

шат, хариу үйлдлийн удирдлагын үе шат, урьдчилан хөдлөх, гүйцэтгэлийг үнэлэх үе шат гэсэн 4 үе шаттай (Gallati.R., 2003) Эдгээр үе шатуудыг авч үзвэл:

1. Эрсдэлийг танин мэдэх үе шат. Энэхүү үе шат нь 1940 оныг хүртэл үргэлжилжээ. Эхний үе шатны зорилго нь байгууллагын зорилго, үйл ажиллагааны онцлог, орчины тодорхой бус байдлаас учирч болзошгүй эрсдэлийг тодрхойлох, түүнээс хамгаалахад чиглэгддэг. Үүнд байгаль цаг уур, үйлдвэрлэлийн осол гэмтэл, гал усны аюулаас хамгаалах, тэдгээрийн аюулын хэмжээг тодорхойлох, даатгуулах үйл ажиллагаа хийгддэг.
2. Эрсдэлийг хэмжих, шинжлэх үе шат. Танин мэдсэн эрсдэлээ хэмжих аргазүй боловсруулах

ба эрсдэлийн төрөл, онцлогоос хамааран тооцох аргазүй боловсруулах ба эрсдэлийн төрөл, онцлогоос хамааран тооцох аргазүй нь өөр байна. Банк эрсдэлийг тооцох аргазүй нь хамгийн их эрсдэл буюу VAR аргыг ашиглах болсон байна.

3. Хариу үйлдлийн удирдлагын үе шат. Хэт их хэмжээний ашиг олох зорилго бүхий үйл ажиллагаа тэр хэмжээний алдагдалыг дагуулдаг. Файолын тодорхойлсон удирдлагын аргазүйд тулгуурлан хөгжиж байна.
4. Урьдчилан хөдлөх, гүйцэтгэлийг үнэлэх үе шат. Эрсдэлийг урьдчилан таамаглах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, удирдлагын шинэ аргазүй бий болгох үе шат юм.

АРИЛЖААНЫ БАНКНЫ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙГ ТООЦОХ АРГАЧЛАА

Зээлийн системийн эрсдэлийг тооцох тоон аргууд:

Р.Мертоны загвар, Credit Siusse Financial Products Credit Risk + (CR+), Credit Portfolio View (CPV) гэсэн үндсэн гурван зээлийн багцын загвар байдаг.

1) Р.Мертоны загвар: Зээлийн эрсдэлийг үнэлэх аргачлалд Р.Мертоны загварыг хамгийн түгээмэл хэрэглэдэг. Р.Мертон нь 1974 онд Ф.Блаэк болон М.Шольс нарын боловсруулсан хувьцааны үнэлгээний загварыг зээлийн эрсдэлийг үнэлэхэд хөрвүүлж чадсанаараа 1997 онд Нобелийн шагнал хүртсэн байдаг. Энэ аргачлалын гол санаа нь тухайн компанийн зах зээлийн нийт өртөг бага болох тусам зээлээ эргүүлэн төлөх магадлал багасдаг гэж

үзсэн бөгөөд тодорхой хугацааны дараах компанийн зах зээлийн өртөгийг үнэлэхдээ хувьцааны үнийн хэлбэлзлээс хамааруулсан нь онцлог болж чадсан юм.

2) "Credit Siusse Financial Products' Credit Risk + " (CR+). Энэ арга нь эрсдэлийн өмнөх өгөгдлүүд (historical default rates) болон түүний хэлбэлзэл (volatilities)-ийг ашиглан багцын алдагдлын тархалтыг үнэлэхдээ актуар (actuarial) 2 аргыг ашигладаг.

3) Credit Portfolio View (CPV) загвар. Энэ загвар нь эрсдэл ба макро эдийн засгийн хувьсагчдын өөрчлөлтийн холбоон дээр үндэслэдэг. Энэхүү загвар нь бусад загвартайгаа харьцуулахад салбарын зээлийн эрсдэл

(industryspecific macroeconomic index)-ийг макро хүчин зүйлээс хамааруулан тооцдог ороо онцлогтой юм.

Зээлийн эрсдэлийг тооцох чанарын арга:


Зээлийн эрсдэлийг тооцох чанарын олон арга байдаг ба үүнээс PESTLE шинжилгээ нь салбарт нөлөөлөх гадаад хүчин зүйлийг үнэлэх, зах зээлийн өсөлт, бууралтыг ойлгоход туслах стратегийн чухал хэрэгсэл гэж үздэг. Бизнесийн болон стратегийн төлөвлөлт, маркетингийн төлөвлөгөө, бүтээгдэхүүний хөгжлийн төлөвлөгөө болон судалгааны тайлангуудад өргөн ашиглагддаг. Энэ шинжилгээ нь улс төрийн орчноос хууль эрхзүйн орчныг салгаж тайлбарлагдгаараа онцлог. Компани ба салбарын тааламжтай байдалд ихээхэн нөлөөлдөг хүчин зүйлүүдийн дотроос улс төр, эдийн засаг, нийгэм, технологи, орчны ба хууль эрх зүйн нөлөөлөл юм.

Өмнөговь аймгийн банкны нэгжүүдийн өнөөгийн байдал

Өмнөговь аймагт 2017 оны жилийн эцсийн байдлаар 9 арилжааны банкны 8 салбар, 48 тооцооны төв, 1 тооцооны касс нийт 57 нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр банкуудад 158380 иргэн, ААНБ-ын харилцах данс, 70784 иргэн, ААНБ-ын хадгаламжийн данс тус тус байршиж, нийт 24382 иргэн, аж ахуй нэгжид олгосон зээлийн үлдэгдэлтэй байна. ПОС, ПОБ машин 690 ширхэг, АТМ, БМОМашин 49 ширхэг, Мобайл банк хэрэглэгчдийн тоо 40888, Интернет банк хэрэглэгчдийн тоо 23389, картаар үйлчлэгч иргэн 593, байгууллага 70 байна.(Өмнөговь аймаг дахь монгол банкны хэлтэс, 2017)

Активын байдал: 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт актив хөрөнгө 417,974.0 сая төгрөг болж 2008 оноос 16.6 дахин, өнгөрсөн оны мөн үеэс 73.1 хувиар өссөн байна. Энэ нь сүүлийн 10 жилд байгаагүй огцом өсөлтийг бий болгожээ.

Зураг 1. Өмнөговь аймгийн банкны нэгжүүдийн нийт актив сүүлийн 10 жилээр



Эх сурвалж:(Өмнөговь аймаг дахь монгол банкны хэлтэс, 2017)


2017 оны жилийн эцэст нийт активын 4.4 хувийг мөнгөн хөрөнгө, 40.3 хувийг цэвэр зээл, 2.7 хувийг үндсэн

хөрөнгө, 52.6 хувийг бусад хөрөнгө тус тус бүрдүүлжээ. Цэвэр зээл 2008 онд нийт активын 92 хувийг эзэлж байсан

бол 2017 онд 40.3 хувь болж буурсан байна. Бусад хөрөнгийн уг өндөр өсөлтөнд зээлийн өсөлтөөс гадна авлага, зээлийн хойшлогдсон төлбөр, салбар

хоорондын тооцоо, бараа материал, биет бус хөрөнгө зэрэг нөлөөлсөн байна. Зураг 2-оос харна уу.

Зураг 2. Өмнөговь аймгийн банкны нэгжүүдийн активын бүтэц




Эх сурвалж: (Өмнөговь аймаг дахь монгол банкны хэлтэс, 2017)

Зээл:

Өмнөговь аймаг дахь банкны нэгжүүдийн зээлийн үлдэгдэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 172,212.4 сая төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 37.8 хувиар, 2008 оноос 743.6 хувиар өссөн байна. Харин эдийн засгийн өсөлтийн үе буюу 2011 оноос 2.2 дахин буюу 220

хувиар өссөн үзүүлэлтэй байна. Орон нутаг дахь банкуудын зээл банкны салбарын нийт зээлийн 23.2 хувийг бүрдүүлж байгаа бол Өмнөговь аймаг орон нутгийн нийт зээлийн 5.4 хувийг бүрдүүлж байна.

Зураг 3. Өмнөговь аймгийн банкны нэгжүүдийн зээлийн үлдэгдэл, чанаргүй зээлийн




Эх сурвалж: (Өмнөговь аймаг дахь монгол банкны хэлтэс, 2017)

Зээлийн хамгийн өндөр өсөлт 2010-2011 онд гарч байсан бол чанаргүй зээлийн өсөлт 2012-2016 оны хооронд дунджаар 21.34 хувийн жилийн өсөлттэй гарчээ.

2017 онд чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар буурсан байна.

Зураг 4. Өмнөговь аймгийн сумдын нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: (Өмнөговь аймаг дахь монгол банкны хэлтэс, 2017)

Аймгийн төв Даланзадгад сум болон уул уурхай төвлөрсөн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс зэрэг сумдын зээлийн үлдэгдэл бусад сумаас өндөр байна. Чанаргүй зээлийн 55.4 хувь

нь Даланзадгад суманд, 19.5 хувь нь Цогтцэций суманд, Ханбогд суманд 17.7 хувь нь байх бөгөөд Номгон, Ноён суманд чанаргүй зээл байхгүй байна.

Зураг 5. Өмнөговь аймгийн банкны нэгжүүдийн чанаргүй зээл




Эх сурвалж: (Өмнөговь аймаг дахь монгол банкны хэлтэс, 2017)

Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь 2008 онд 2.89 хувь байсан бол эдийн засгийн өсөлтийн үед буюу 2011 онд 0.57 хувь болж буурч байсан байна. Харин 2013 оны 3-р улирлаас чанаргүй зээлийн хувь

хэмжээ өсч 2016 оны 2-р улиралд 7.75 хувь болж сүүлийн 10 жилд байгаагүй их хэмжээний зээл чанаргүйтжээ. 2017 онд уг үзүүлэлт 2.99 хувь болж өнгөрсөн оны мөн үеэс 47.2 хувиар буурчээ.

Зураг 6. Өмнөговь аймгийн банкны нэгжүүдийн чанаргүй зээл-бүтээгдэхүүний төрлөөр




Эх сурвалж: (Өмнөговь аймаг дахь монгол банкны хэлтэс, 2017)

2015 оны эхэнд нийт чанаргүй зээлийн 74.3 хувийг бизнесийн зээл эзэлж байсан бол 2017 оны эцэст 51.2 хувь болж буурсан байна. Хэрэглээ болон ипотекийн зээлийн нийт чанаргүй зээлд эзлэх хувь 44.2 хувь болж өсч байгаа нь иргэдийн зээлийн зориулалт

автомашин, хувийн сууц, орон сууц зэрэг хэрэглээ рүү хэт чиглэсэн, урт хугацаанд зээлийн төлбөр төлж өрхийн санхүү муудсантай холбож болно. Өмнөговь аймгийн чанаргүй зээлийн хувь хэмжээг улсын болон орон нутгийн чанаргүй зээлийн хувьтай харьцуулбал:

Зураг 7. Өмнөговь аймгийн банкны нэгжүүдийн чанаргүй зээлийн хувь




Эх сурвалж: (Монгол банк, 2017)

Өмнөговь аймгийн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 2009-2011 онд орон нутаг болон улсын дундаж үзүүлэлтээс бага байсан бол 2013 оноос аажим өсч 2016 онд 5.66 хувь болж оргил үедээ хүрсэн ба 2017 онд эргээд орон нутгийн дундаж үзүүлэлт рүү дөхөж буурчээ.

Энэхүү бууралтыг авч үзвэл 2016 оны 1-р улирлын эцэст чанаргүй зээлийн хэмжээ 8.1 тэрбум төгрөг байсан. 2016-

2017 онд аймгийн ШШГАЛба 1.8 тэрбум төгрөгийг төлүүлсэн бол үлдсэн 1.2 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийн бууралтыг харилцагчдын орлого нэмэгдээд төлсөн эсвэл активыг ангилах, эрсдэлийн сан байгуулж зарцуулах журмын шинэчилсэн найруулгын дагуу банкууд балансаас хассан байж болно.

Зураг 8. Өмнөговь аймгийн ШШГА-ны шийдвэр гүйцэтгэлийн биелэлт



Эх сурвалж: (Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, 2018)

Өмнөговь аймгийн эдийн засгийн голлох үзүүлэлт болох ДНБ, болон нүүрс үйлдвэрлэл борлуулалтыг авч үзвэл:

Зураг 9. Өмнөговь аймгийн ДНБ-ий өсөлтийн хувь




Эх сурвалж: (Монголын статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2018)

Өмнөговь аймгийн сүүлийн 9 жилийн ДНБ болон нэг хүнд ногдох ДНБ-ийг авч үзвэл 2013 онд хамгийн өндөр буюу 454.7 сая төгрөг, нэг хүнд ногдох ДНБ 7.9 сая төгрөг байсан байна.

Харин 2016 оны ДНБ 2008 оноос 3.7 дахин, нэг хүнд ногдох ДНБ 2.8 дахин өссөн бол 2015 оноос 46.1 хувиар, нэг хүнд ногдох ДНБ нь 41.5 хувиар өсчээ

Зураг 10. Өмнөговь аймгийн нүүрсний үйлдвэрлэл, борлуулалт сүүлийн 10 жилээр




Эх сурвалж: (Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс, 2018)

Нүүрс үйлдвэрлэлт 2017 онд 2008 оноос 20.4 дахин, борлуулалт 26.1 дахин өссөн бол өнгөрсөн оны мөн үеэс нүүрс үйлдвэрлэл 1,8 дахин, нүүрс

борлуулалт 2,4 дахин өссөн байна. Сүүлийн 10 жилийн оргил өсөлт 2017 онд гарчээ.

Зураг 11. Аймгийн төсвийн орлого



Эх сурвалж: (Монголын статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2018)

2017 онд улсын төсөв 2431.1 тэрбум төгрөг байсан бөгөөд үүний 44 хувийг Улаанбаатар хот бүрдүүлсэн бол Өмнөговь аймаг 21 аймгаасаа хамгийн

их буюу 6 хувийг бүрдүүлсэн байна. Түүнчлэн тус аймгийн ДНБ болон төсвийн орлого нь уул уурхайн салбарын идэвхжилийг дагаж өөрчлөгдөж байна.

ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭ БА ҮР ДҮН

Өгөгдөл цуглуулах ба шинжилгээ хийх арга:

Тоон аргын хувьд судалгааны өгөгдөл цуглуулахдаа зээлийн эрсдэлд нөлөөлөх макро хүчин зүйлийн хувьсагчдаас инфляци, юань болон ам.долларын төгрөгтэй харьцах ханш, Өмнөговь аймгийн ажилгүйдлийн түвшин, ААНБ-н ажилчдын дундаж цалин, нүүрс борлуулалтын хэмжээ зэрэг 7 хувьсагчийн мэдээллийг 2008 оны 4 дүгээр улирлаас 2017 оны 4 дүгээр улирал хүртэл хугацаагаар сонгон авсан ба 2014 оны 1-р улирлаас

2016 оны 1-р улирлыг дуустал хугацааг уул уурхайн салбарын уналтын үе гэж үзэн дамми хувьсагч оруулж тооцсон. Хувьсагчуудын өөрлөлтийг хувиар илэрхийлж, зээлийн чанарт хамгийн их нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлов.

Тоон өгөгдлүүдээс юань болон ам долларын ханш хоорондоо нягт хамааралтай байсан тул төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг хасч тооцсон. Үнэлгээг тооцох явцад нүүрсний борлуулалт ач холбогдолгүй үнэлэгдсэн тул тэгшитгэлээс хасагдсан ба дараах үр дүн гарсан болно.

Хүснэгт 1. Эмпирик шинжилгээний үр дүн

№	Тайлбарлагч хувьсагчид	Коэффициент	t-Statistic	Шинжилгээний үр дүн
1	INF	-0.407	-3.464	Инфляци нэг нэгжээр нэмэгдэхэд чанаргүй зээл 0.371-0.424 нэгжээр буурдаг. Инфляци нэмэгдэж байна гэдэг нь эрэлтээс үүдсэн үйлдвэрлэл өсч улмаар ДНБ-ий хэмжээ өсөхөд иргэдийн цалин, орлого худалдан авах чадвар нэмэгдэнэ. Энэ нь зээлийн эргэн төлөлтөнд эерэг нөлөө үзүүлдэг байна.
2	INF(-1)	-0.371	-3.997	
3	INF(-2)	-0.385	-3.998	
4	INF(-3)	-0.389	-4.698	
5	INF(-4)	-0.424	-4.209	
6	DUMMY	0.012	3.022	Уул уурхайн салбарын уналт 1 нэгжээр нэмэгдэхэд чанаргүй зээлийн хэмжээ 0.012 нэгжээр нэмэгддэг
7	CNY	-0.128	-2.672	Юаний ханш 1 нэгжээр өсөхөд чанаргүй зээл 0.128 нэгжээр буурч байдаг.
8	UNRATE(-3)	0.010	2.838	Ажилгүйдлийн түвшин 1 нэгжээр нэмэгдэхэд чанаргүй зээлийн хэмжээ 0.010 нэгжээр нэмэгддэг. /3 улирын хожимдолтой/

9	SALARY(-2)	-0.036	-2.846	Өмнөговь аймгийн ААНБ-ын ажилтнуудын дундаж цалин 1 нэгжээр өсөхөд чанаргүй зээлийн хэмжээ 0.036 нэгжээр буурдаг /2 улирлын хожимдолтой/
10	RATE(-8)	-0.068	-1.671	Тус аймгийн банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү 1 нэгжээр өсөхөд чанаргүй зээл 0.068 нэгжээр буурдаг. 8 улирлын хожимдолтой. Зээл олголт нэмэгдэж эдийн засгийн нөхцөл сайжрахад эрсдэлийг нэмэгдүүлж, зээл олголт багасч эдийн засаг хумигдахад зээлийн эрсдэл буурдаг байна.
11	C	0.066	15.971	Банкны дотоод үйл ажиллагаа болон бусад хүчин зүйлээс шалтгаалсан байдал 1 нэгжээр өсөхөд чанаргүй зээл 0.066 нэгжээр өсдөг байна.

Дээрх үзүүлэлтээс харахад чанаргүй зээлд уул уурхайн салбарын уналт, ажилгүйдэл, бусад хүчин зүйлс нь эерэг нөлөө үзүүлсэн бол инфляци, төгрөгийн юаньтай харьцах ханш, ААНБ-ын ажилтнуудын цалин, зээлийн хүү нь сөрөг нөлөө үзүүлжээ.

Шинжилгээний үр дүнг шугаман регрессийн тэгшитгэлээр илэрхийлбэл доорх байдалтай гарлаа. Үүнд:

$$\text{Substituted Coefficients: NPL} = 0.066 - 0.127 \cdot \text{CNY} - 0.407 \cdot \text{INF} - 0.371 \cdot \text{INF}(-1) - 0.385 \cdot \text{INF}(-2) - 0.389 \cdot \text{INF}(-3) - 0.424 \cdot \text{INF}(-4) - 0.036 \cdot \text{SALARY}(-2) + 0.010 \cdot \text{UNRATE}(-3) - 0.068 \cdot \text{RATE}(-8) + 0.012 \cdot \text{DUMMY}$$

Эмпирик шинжилгээ хийхэд детерминацийн коэффициент буюу тайлбарлах чадварын үзүүлэлт 0.89 гэж гарч байгаа нь Өмнөговь аймаг дахь банкны нэгжүүдийн чанаргүй зээлийн 89 хувийг ажилгүйдэл, уул уурхайн салбарын уналтын байдал, ААНБ-ын ажилтнуудын дундаж цалин, юаний ханш, зээлийн хүү зэргийн өөрчлөлтөөр тайлбарлаж байна. Харин үлдсэн 11 хувийг банкны дотоод үйл ажиллагаа болон бусад хүчин зүйлээр тайлбарлаж болно.

Мөн нүүрсний борлуулалт сүүлийн 2 жил тэр тундаа 2017 онд сүүлийн 10 жилд байгаагүй түүхэн өндөр өсөлт гаргасан хэдий ч чанаргүй зээлийн бууралтанд нөлөөлөх нөлөө бага байгаа нь томоохон бизнес эрхлэгчид эсвэл хэсэг бүлэг хүмүүс зээл авдаггүй, авах шаардлагагүй хүмүүс байж болох юм.

Чанаргүй зээлд нөлөөлсөн хүчин зүйлийн тоон шинжилгээний үр дүн:

Өмнөговь аймаг дахь банкны нэгжүүдийн чанаргүй зээлд уул уурхайн салбарын уналт, ажилгүйдэл болон бусад хүчин зүйлс эерэг нөлөө үзүүлж байсан бол юаний ханш, инфляци, тус аймгийн ААНБ-ын ажилтнуудын дундаж цалин, банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү сөрөг нөлөө үзүүлжээ. 2014-2016 онд уул уурхайн салбарын уналт гол нөлөөлөгч хүчин зүйл болж эерэг хүчтэй хамааралтай байсан байна. Уул уурхайн салбарын идэвхжил чанаргүй зээлийг бууруулж, уналт нь чанаргүй зээлийг нэмэгдүүлдэг байна.

ААНБ-ын ажилтнуудын дундаж цалингийн өсөлт 2 улирлын хожимдолтойгоор, инфляци 4

улирлын хожимдолтойгоор чанаргүй зээлийг бууруулдаг бол, банкуудын зээлийн хүүгийн бууралт 8 улирлын хожимдолтойгоор чанаргүй зээлийг нэмэгдүүлдэг байна.


Инфляци хамгийн ихдээ 2010 оны 1-р улиралд 0.07 хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол хамгийн багадаа 2010 оны 3-р улиралд -0.028 хувийн сөрөг нөлөө үзүүлсэн байна. Эрэлтээс үүдсэн үйлдвэрлэл өсч, улмаар ДНБ-ий хэмжээ өсөхөд иргэдийн цалин болон бусад орлого, худалдан авах чадвар нэмэгдэж, зээлийн эргэн төлөлтөд эерэг нөлөө үзүүлж, чанаргүй зээлийг бууруулахад нөлөөлдөг байна.

Санал асуулгын үр дүн: Тоон шинжилгээг баталгаажуулах зорилгоор Өмнөговь аймгийн нийт зээлийн багцын 43.2 хувь, чанаргүй зээлийн 55.4 хувийг эзэлдэг, нийт хүн амын 38 хувийг эзэлдэг Даланзадгад сумын чанаргүй зээлтэй 8 арилжааны банкыг сонгож тэдгээрт ажиллаж байгаа 29 зээлийн мэргэжилтнүүдээс санал асуулга авахад

Өмнөговь аймгийн банкны нэгжүүдийн хувьд зээлийн чанар нь гадаад хүчин зүйлсээс голчлон уул уурхай эрдэс баялагийн салбарын зогсонги байдал, нүүрс борлуулалтын өөрчлөлт, зээлийн хүүний өсөлтөөс ихээхэн хамаарна гэж үзсэн бөгөөд ажилтнуудын цалингийн орлого, ажилдаа тогтвортой ажиллах байдал, өрхийн орлогыг нэг хүн бүрдүүлэх байдал, мөн иргэд, аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн боловсрол сайн биш байгаа нь зээлийн хувьд эрсдэлтэй гэж дүгнэжээ. Харин зээлийн эрсдэлд нөлөөлөх дотоод хүчин зүйлсээс банкны зээлийн хорооны хуралд гишүүдийн оролцох оролцоо маш чухал ба танил тал харж зээл олгох, хэн нэгний өгсөн үүрэг даалгавар зээл олгох нь эрсдэлэй гэж үзсэн байна.


PESTLE шинжилгээний үр дүн: Энэ шинжилгээ нь зах зээлийн өсөлт, бууралтыг ойлгоход туслах стратегийн чухал хэрэгсэл гэж үздэг бөгөөд макро орчны өргөжүүлсэн судалгаа ба дараах үр дүн гарсан. Зураг 12-аас харна уу.

Зураг 12. PESTLE шинжилгээний үр дүнд



Судалгааны үр дүнгээс үндэслэн орон нутгийн хувьд зээлийн эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох арга замыг зураглан харуулбал:

Зураг 13. Зээлийн эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох арга зам



ДҮГНЭЛТ

- Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг нь уул уурхай, эрдэс баялагийн салбараас өндөр хамааралтай байгаа бөгөөд 2017 онд Өмнөговь аймаг төдийгүй улсын хэмжээнд нүүрс олборлолт борлуулалт сүүлийн 10 жилд байгаагүй түүхэн өндөр үзүүлэлтийг бий болгосон байна. Гэсэн хэдий ч тус аймгийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтээс харахад орон нутагт хийгдэж буй зарим бүтээн байгуулалт, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт ард иргэдийн амьдрал, худалдан авах чадварт нөлөөлсөн шууд нөлөөлөл бага байна.
- Уул уурхайгаас шалтгаалсан эдийн засгийн энэхүү байдал иргэд болон аж ахуйн нэгж байгууллагыг зээлийн эрсдэлд өртөмтгий болгож байна. Иймд банкууд

өнгөрсөн хугацааны туршлагаасаа сургамж авч зээлийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хяналт тавих, мөн эдгээр эрсдэлийг давах хангалттай хэмжээний капиталын нөөцтэй байх шаардлагатайг харуулж байна. Цаашлаад уул уурхай, эрдэс баялагийн салбарын уналтаас сэргийлэх, хамгаалах арга хэмжээг банкны нэгжүүд авч ажиллах хэрэгтэй ба орон нутгийн банкны нэгжүүдэд ажиллаж буй ажилтнуудын ур чадвар, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

- Тус аймаг уул уурхайн салбарын бүс нутаг хэдий ч уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрлэл гэсэн эдийн засгийн салбарт олгогдсон зээл маш бага, банкны нэгжүүдэд хэрэглээний зээл

ихээхэн төвлөрч байна. Иймд бусад эдийн засгийн салбарууд болох хөдөө аж ахуй, аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэл зэрэг

салбарыг хөгжүүлэхэд өөрийн хувь нэмэр оруулж багцын төвлөрлийг бууруулах хэрэгтэйг харуулж байна.

НОМ ЗҮЙ

1. *BIS, Amendment to the Capital Accord to incorporate market risks.* (1996).
2. Gallati.R. (2003). *Risk management and capital adequacy*New YorkMc-Graw-Hill.
3. Б.Мөнхзаяа. (2013). *Санхүүгийн байгууллагын эрсдэлийн менежмент.* Улаанбаатар хот.
4. Л.Оюун. (2004). *Арилжааны банкны зээл, зээлийн шинжилгээ.* Улаанбаатар.
5. Монгол банк. (2017). *Зээлийн нэгдсэн тайлан.* Улаанбаатар хот.
6. Н.Ургамалсүвд. (2009). *Банкны системийн зээлийн эрсдлийн өөрчлөлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс.* Улаанбаатар.
7. Өмнөговь аймаг дахь монгол банкны хэлтэс. (2017).
8. Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба. (2018). *Шүүхийн шийгвэртэй банкны төлбөрийн талаарх суралгаа.* Даланзадгад сум.
9. <https://www.mongolbank.mn/liststatistic.aspx>
10. <http://www.1212.mn/>
11. <http://www.umnugovi.nso.mn/page/97>
12. <http://www.omnogovi.gov.mn/i/3>
13. <http://eds.b.ebscohost.com/eds/detail/detail?vid=3&sid=68802e32-3758-41bb-9f67-d5e53895eae3%40sessionmgr103&bdata=JnNpdGU9ZWRzLWxpdmU%3d#AN=1357222&db=edsebk>

НАЙМАН ХУВИЙН ЗЭЭЛИЙН ЧАДАМЖ ИРГЭН, БАНК АЛЬ АЛЬ ТАЛДАА ШАВХАГДАЖ БАЙНА УУ?

З.Боргилмаа

СЭЗИС-ийн Төрийн бодлогын менежментийн
мастерын хөтөлбөрийн магистрант, сэтгүүлч

Abstract. It is obvious that further needs of Ipotek loan with the minimum requirements are highly required for the average or low-income citizens who cannot meet the high requirement and pass the threshold of receiving eight-percentage ipotek loan. Besides this, it could solve other social and economic issues in particular way. Although a program named 'Establishing a long-term sustainable system to finance apartments' has been successfully implemented since 2013, it has brought some unwanted results and the action has almost stopped after the election of 2016. The temporary and careless analysis of the policy makers leads to this circumstance so it is necessary to find out the appropriate options that can meet the reality and the market situation not to take risks of losing the political status and encountering the public irritation. This study aims to do analysis of the program implementation and give the related recommendations on further options how to successfully continue this.

Key words: Apartment loan, Ipotek loan, loan program, loan potentiality

Хураангуй. Ипотекийн 8 хувийн зээлд хамрагдах бүхий л талын шалгуур, босгыг давж чадахгүй байгаа нийгмийн дунджаас доош давхаргад хамаарах хүн амын хэсэгт зориулсан босго багатай ипотекийн зээлийн хэрэгцээ шаардлага цаашид үүсэх нь тодорхой байгаа төдийгүй үүнийг шийдвэрлэх нь нийгэм, эдийн засгийн бусад цөөнгүй асуудлыг дам шийдэхүйц чухал асуудал юм.

2013 оноос хэрэгжиж эхэлсэн “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох” хөтөлбөр амжилттай эхэлсэн ч 2016 оны сонгуулийн дараагаас “хүсээгүй үрдүнгүүд” нь ил болж, улмаар үйл ажиллагаа нь саараад байна. Энэхүү сааралт, мухардлын шалтгаанд эрх баригчид богино хугацаанд дүн шинжилгээ хийж, цаашид бодит байдал, зах зээлтэйгээ уялсан хувилбар, гарцыг хурдан олж хэрэгжүүлэхгүй бол улс төрийн том оноо алдах, иргэдийн бухимдалтай тулгарах эрсдэл харагдаж байгаа юм. Тиймээс энэхүү судалгааны хүрээнд уг хөтөлбөрийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, цаашид амжилттай үргэлжлүүлэхийн тулд ямар хувилбар байж болох санал дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Орон сууцны зээл, ипотекийн зээл, зээлийн хөтөлбөр, зээлийн чадамж

ОРШИЛ

Найман хувийн зээлийн чадамж иргэн, банк аль аль талдаа шавхагдаж байна уу? гэдэг асуудлыг дэвшүүлж,

тийм, үгүй гэх хариултыг нийгэмд яаралтай өгөлгүй, шийдэлгүй удсанаас шалтгаалан уг хөтөлбөр тодорхой

хугацаанд зогсоход хүрвэл орон сууцны зээл угаасаа 8% байсан, байсаар байх болно гэсэн хүлээлт, итгэл үнэмшилтэй яваа иргэд, утаанаасаа салах гарцыг орон сууцжуулалт гэж харж байгаа нийгэмд энэ нь маш том цохилт байх болно. Уг хөтөлбөрт 2013 оноос 2017 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд 4.2 их наяд төгрөгийг зээлэнд гаргаж, үүнд 93 мянган өрх айл хамрагдан шинээр орон сууцанд орсон байна. Өнөөдөр нийслэлд 352 812 өрх айл амьдарч байгаагийн 148600 нь орон сууцанд, үлдсэн 204000 айл гэр хороололд амьдарч байна. Тэгэхээр орон сууцанд амьдарч буй нийт айл өрхийн 50% нь Ипотекийн 8 хувийн зээлийн үр шимийг хүртэгсэд юм. Ипотекийн 8%-ийн зээлийн хөтөлбөрийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө нь Улаанбаатар хотын орон сууцны хорооллын оршин суугчдын 50%-ийг бий болгосон байна.

Уг хөтөлбөрийг санаачлагч Ардчилсан нам засгийн эрхийг барьж байх үед Засгийн газар, Монголбанкнаас тус хөтөлбөрт зориулан сард 100 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад олгож байсан бол 2018 оны Улсын төсөвт нийтдээ 120 тэрбум төгрөгийг ипотекийн зээлийн эх үүсвэрт зориулахаар тусгаад байгаа юм. Мөн 2017 оны 12 дугаар сарын байдлаар сард 25 тэрбум төгрөгийг өгч байна. 2017 оны 12 дугаар сарын статистикаар сард арилжааны банкууд

нийтдээ 60 тэрбум төгрөгийг ипотекийн зээлд олгосон байгаа ба үүний 25 тэрбум нь Засгийн газраас олгосон, 35 тэрбум нь банкууд өөрийн эх үүсвэрээс олгосон мөнгө юм. Ипотекийн зээлийн эргэн төлөлтөөс сард 25-40 тэрбум төгрөг дараагийн зээлийн эх үүсвэрт хуримтлагддаг байна.

Бодит байдал гэвэл 2016 оны есдүгээр сар хүртэл ипотекийн найман хувийн зээлд сард дунджаар 2000 орчим хүн хамрагддаг байсан бол 2016 оны есдүгээр сараас энэ тоо 600-800 орчим болж, 3 дахин буурчээ. Тодруулбал, 2013 оны 12 дугаар сард нийт 2423 иргэнд ипотекийн зээл олгогдож байсан бол 2017 оны 12 дугаар сард банкууд нийтдээ 816 иргэнд уг зээлийг олгосон байна. Өнөөдөр гэр хороололд амьдарч байгаа 200 мянга гаруй өрхийн 10 хувь нь л газар дээрээ амьдрах сонирхолтой, бусад 90 хувь нь тохилог орон сууцанд амьдрах хүсэлтээ илэрхийлсэн гэх судалгааг Нийслэлийн удирдлагууд мэдээлсэн байдаг. 2017 оны байдлаар нийслэлд борлогдоогүй шинэ орон сууц 36 мянга байв.

Бодит байдлыг дээрх үзүүлэлтүүдээс харахад хямд эх үүсвэртэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэх эрэлт, хэрэгцээ байгаа ч хэрэгжүүлэх нөхцөл, журам, механизмаа эргэн харахгүй бол мухардалд орж байна.

ХЭРЭГЖИЛТ, ҮР ДАГАВРЫН ШИНЖИЛГЭЭ

Шалгуур нэг: Хөтөлбөрийн үзүүлж буй үр нөлөө

Уг хөтөлбөрийг 2013 оноос хэрэгжүүлж эхэлснээс энэ хүртэл буюу 2013 оноос өмнө Монголын арилжааны банкуудаас 20 жилийн хугацаанд ердөө 940 гаруй тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосон байдаг. 2013 оноос энэ


тоо өсч, жилд их наядаар хэмжигдэх хэмжээнд хүрээд байв. Улмаар 2016 оны сонгуулийн дараагаас зогсонги байдалтай болжээ. Уг нь ипотекийн зээл олголт 2010 оноос хойш тасралтгүй өссөөр 2013 оны эцэс гэхэд 2 их наяд төгрөгт хүрч, 2015 оны сүүл гэхэд 3.4 их наяд төгрөгт хүрсэн байна. Энэ хэмжээний зээлд 90 мянган өрх

айл хамрагдан шинээр орон сууцанд орсон юм. /2017 оны 12 дугаар сарын мэдээгээр зээлдэгчийн тоо 93.1 мянга болсон. Нийт зээлийн үлдэгдэл 4.2 их наяд төгрөгт хүрсэн байна/

Мөн энэ нь барилгын салбарт том дэмжлэг болж, бараг 100-аад мянган орон сууцны борлуулалтыг 2 жилд хийсэн эдийн засгийн нэг үр нөлөө

байна. Түүнчлэн ипотекийн зээлдэгчийн тоо 2010 оноос хойш тав дахин өсч, банкны системийн зээлийн 30 хувийг эзлэх хэмжээнд хүрч, ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ тун бага буюу 1,3-1,8 хувь байгаа нь банкны салбар, санхүүгийн бүтээгдэхүүн талаасаа сайн нөлөө үзүүлсэн үзүүлэлт юм.

Зураг 1. Олгосон зээлийн бүтэц



Эх сурвалж: Монголбанк

Одоогоор /2017 оны 12 дугаар сарын байдлаар/ 93.1 мянган айл найман хувийн зээлээр орон сууцтай болсны гуравны нэг орчим нь арилжааны банкны өндөр хүүтэй зээлээс найман хувь руу шилжсэн байна. Эдгээр иргэний сард зээлд төлдөг мөнгө нь хоёр дахин буурчээ. Түүнчлэн 93 орчим мянган айл ипотекийн зээлд хамрагдсанаар иргэдийн гар дээрх бэлэн мөнгө хомсдож эхэлсэн ч шаардлагагүй хэрэглээ рүү урсч байсан мөнгө банк руу зээлийн эргэн төлөлтөд шилжсэн байна. Үүнээс үүдээд архины хэрэглээ, зугаа цэнгээ, шоуны хэрэглээ


буурч, зээлдэгчдийн амьдралын хэвшил, санхүү, хөдөлмөрийн сахилга бат дээшилжээ. Үйлчилгээний зарим салбар, нийтийн хоол, ресторан, баарны борлуулалт муудсан зэрэг нь нийгэмд үзүүлсэн, эерэг, сөрөг дам нөлөө юм.

Шалгуур хоёр: Бодлогын хүсээгүй үр дүн юу байв?

1. Сард олгох зээл олголтын хэмжээ 10 дахин буурав. Ипотекийн зээл буцаан олголтоороо санхүүждэг. Нэг үгээр хэлбэл, эхний үйлчлүүлэгчийн эргэн төлөлтөөр дараагийн хүнд

зээл олгодог гэсэн үг. Зээлийн эргэн төлөлтөөс сард 34-40 орчим тэрбум төгрөг төвлөрч, энэ эх үүсвэрээр


сар бүр орон сууцны ипотекийн санхүүжилтийг олгодог.



Хөтөлбөр амжилттай, эрчимтэй хэрэгжсэн 2016 оны зургадугаар сар хүртэлх хугацааны статистикаар: Нийт зээлдэгчдийн тоо 85622-т хүрчээ. 2016 оны наймдугаар сарын 7-ны байдлаар банкууд 10846 иргэний 665.3 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтийг хүлээн авч, 3392 иргэний таван хувийн хүүтэй 161.3 тэрбум төгрөгийн, 6261 иргэний найман хувийн хүүтэй 420.4 тэрбум

төгрөгийн зээлийг олгожээ. Нэг хүн дунджаар 58.3 сая төгрөгийн зээлд хамрагддаг гэсэн судалгаа байдаг ч 2016 оны есдүгээр сараас энэ тоо буурах хандлагатай болжээ. Өмнө нь сард 2000 гаруй хүн ипотекийн зээлд хамрагддаг байсан бол 2016 оны есдүгээр сараас 1000 хүрэхгүй хүнд зээл олгох болжээ.

Зураг 2. Тухайн сард олгосон зээл



2. Зээлд хамрагдсан иргэдэд 8%-ийн хүү дарамт үүсгэв. Ипотекийн 8%-ийн зээл хэрэгжиж эхлэх хүртэл орон сууцны зээлийн хүү асар өндөр, хатуу нөхцөлтэй байсныг олон нийт дорхноо мартсан байна. Бүр орон сууцны зээлийг сонирхох

нь илүүц, олон айр өрхийн хувьд давагдашгүй хүчин байсан байсан юм. Энэ байдлыг халж, 8 хувийн хүүтэй ипотекийн зээл зах зээлд дөнгөж гарч ирэхэд энэ нь асар том боломж, бололцоо санагдаж, 90 мянгөн өрх айл уг бололцоог

ердөө 2 жилийн хугацаанд амжиж ашигласан хэрэг. 2010 оноос хойш төрийн албан хаагч гэх мэт явцуу хүрээнд 5 болон 8 хувийн хүүтэй зээлийг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд түрүүч нь 8 дахь жилдээ лизингээ төлж байна гэсэн үг. Ингээд эргээд хартал 8 хувийн хүү гэдэг нь тухайн үедээ л том боломж байснаас биш бас ч үгүй санхүүгийн дарамт болохыг амьдрал дээрээ мэдэрч эхлэв. Тэдний гомдол: 80 саяын зээлийн 20 жилийн 8 хувийн хүү 82 сая төгрөг байгаа нь өндөр байна.

3. **Банкны зуучлалын хөлс 4% байгаа нь өндөр.** Зээлийн хүүний 4% нь банкны зардал болон ашигт суутгагдаж байгаа. Жилд банк уг зээлд 2 сая төгрөгийн зардал гаргах нь үнэн үү. Зээл нэг гарлаа л бол яг цаасан дээр 20 жил хийх ажил, зардал байхгүй шүү дээ... Банкны зуучлалын хөлс 4% байгаа нь хэт өндөр биш үү гэх гомдлууд гарч эхэлжээ. Арилжааны банкуудын тайлбараар бол 1% нь зээлийн эрсдэлийн санд төлөгддөг бөгөөд банкуудын зуучлалын үйл ажиллагаанд 3% нь шингэж байгаа аж.

Шалгуур гурав: Тэгш байдлын хэмжүүр

1. **Ипотекийн зээлд зориулсан 3.4 их наяд төгрөг барилга, банкний дэмжсэн.** 2016 оны сонгуулийн дараа төрийн эрх нэг хүчнээс /АН/ нөгөө хүчин /МАН/ рүү шилжсэн. Монголбанкны удирдлага мөн солигдсон бөгөөд шинээр гарч ирсэн эрх баригчид Монголбанкинд шалгалт хийгээд 3.2 их наяд төгрөгийн алдагдал тогтоосон. Засгийн газрын үнэт цаасны өр 2016 оны эцэс гэхэд 3.2 их наяд төгрөг хүрээд байв. Ипотекийн зээлд мөн 3 их наяд
- орчим төгрөг зарцуулсан. Эдгээр тоонд их ач холбогдол өгч байгаа ч хоорондоо ямар учир шалтгаантайг хараахан тогтоогоогүй ч "Үнэ тогтворжуулах хөтөлбөр гэх зэрэг зарим салбарыг дэмжсэн бодлогоор нь Монголбанкны өмнөх удирдлагуудыг буруутган хуулийн байгууллагад шалгаж байгаа. Энд онцлоход ипотекийн зээлийн хөтөлбөр нь барилгын салбар болон банкны салбарыг дэмжсэн бодлого болсон гэх шүүмжлэл. Энэ тохиолдолд эдийн засгийг бүхэлд нь удирдах, төсөв, сангийн бодлогоор баялгийн дахин хуваарилалт хийхдээ барилга, банк зэрэг чадавх бүхий хэсгийг дэмжсэн нь оновчтой биш гэж үзэж байгаа юм.
- Монголбанкны өнөөгийн удирдлагууд /МАН/ "Ипотекийн зээлийн хөтөлбөр бол төсөвтэй адилтгах шинж чанартай үйл ажиллагаа учраас Төв банкны мөнгөний бодлогын үйл ажиллагаанаас тусдаа байх ёстой. Төв банк нь төсвийн шинжтэй үйл ажиллагааг удаан хугацаанд санхүүжүүлэх нь Төв банкны алдагдлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны бие даасан хараат бус байдлыг алдагдуулах, Төв банкны бодлогод итгэх олон нийтийн итгэлийг сулруулж, үндсэн зорилт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах зорилгоо биелүүлж чадахгүйд хүргэх эрсдэлтэй" гэж үзэж байна.
2. **Ипотекийн 8%-ийн зээлийн босго давж чадахгүй хэсэг гадна үлдэв.** 2017 оны байдлаар зах зээлд борлогдоогүй орон сууц 36 мянга байсан бол гэр хороололд амьдарч байгаа өрхийн тоо 216 мянга

байгаа. Гэр хороололд амьдарч буй иргэдийн 189 240 өрх нь орон сууцанд амьдрах хүсэлтээ холбогдох газруудаас явуулсан судалгаанд илэрхийлсэн байна. Тэгэхдээ гэр хорооллын өрхийн тоог "эрэлт" гэж тооцоход учир дутагдалтай. Орон сууц худалдан авах хүсэлтэй өрхийн тоо гэж үзэж болно. Санхүүгийн чадавхаар баталгаажсан хүсэлтийг эрэлт гэж

тооцох учраас 216 мянгөн өрхийн тоог эрэлт юм уу, зах зээл гэж шууд тооцох боломжгүй. Үндсэндээ 30 хувиа төлөөд зээлд хамрагдах боломжтой, банкны шалгуур хангах хүмүүс өнгөрсөн хугацаанд зээлд хамрагдаад дууссан. байна Одоо ийм шалгуурыг хангах бололцоогүй хэсэг нь үлдээд байгаа.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ПРОЦЕССЫН ШИНЖИЛГЭЭ

Эдийн засгийн суурь өгөгдлүүд ямар байсан бэ?

1. Ипотекийн 8 хувийн зээлийн хөтөлбөр хэрэгжиж эхлэх үед Монголбанкны бодлогын хүү 10.5 хувь байжээ. 2012 оны УИХ-ын сонгуулийн дараа Ардчилсан

нам эрх баригч болж, бодлогоо хэрэгжүүлсэн ба Монголбанкны бодлогын хүүг 13.25-аас шат дараатай бууруулсаар жилийн дотор 10.5 хувьд хүргэжээ. Нэг үгээр бол мөнгөний тэлэх бодлого хэрэгжүүлж, эдийн засгийг мөнгөөр тэтгэж эхэлсэн байна.

Хүснэгт 1. Монголбанкны хүү, жилийн хувь

Хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн/зарласан огноо	Бодлогын хүү	Репо	Овернайт хадгаламж	Овернайт репо	Овернайт	Барьцаат зээл
2017/12/25		11.0	12.0	9.0	13.0	
2017/06/15		12.0	13.0	10.0	14.0	
2017/03/17		14.0	16.0	13.0	17.0	
2016/12/19		14.0	16.0	13.0	17.0	
2016/08/18		15.0	17.0	14.0	18.0	
2016/05/05		10.5	11.0	8.5	12.5	
2016/01/14		12.0	12.5	10.0	14.0	
2015/01/15		13.0	13.5	11.0	15.0	
2014/07/31		12.0	12.5	10.0	14.0	
2013/06/24		10.5	11.0	8.5	12.5	
2013/04/05		11.5	12.0	9.5	13.5	
2013/03/13		12.5	13.0	10.5	14.5	
2013/01/25		12.5	16.5			21.5
2012/04/17		13.25	17.25			22.25
						20.5
						21.25

Нэг зах зээл дээрх хүүнүүдийн хэмжээ хоорондоо илүү ойрхон байвал тухайн зах зээл дээр гажиг бага үүсдэг. Өндөр, нам, харьцангуй хүүтэй олон зээлүүд бий болвол гажуудал үүснэ гэж үздэг. Тэгэхээр бодлогын хүү 10.5 байхад ипотекийн

8 хувийн зээлийн хөтөлбөрийг эхлүүлсэн нь гажиг бага үүсгэсэн гэж болно.

2. Хөтөлбөр хэрэгжиж эхэлж байх 2013 он болон 2016, мөн 2017 оны байдлаар инфляци тун бага түвшинд байсныг харцгаая.

Хүснэгт 2. Улсын инфляци -2013 оны байдлаар

	Сарын	Оны эхнээс	Жилийн
2013/12	0.7	11.9	11.9
2013/11	1.3	11.1	12.0
2013/10	1.4	9.7	10.8
2013/09	1.4	8.2	9.9
2013/08	1.7	6.7	9.4
2013/07	0.1	4.9	8.3
2013/06	-0.3	4.7	8.8
2013/05	0.3	5.1	9.7
2013/04	1.1	4.8	10.4
2013/03	0.8	3.6	9.8
2013/02	1.0	2.8	11.3
2013/01	1.4	1.4	12.6

Хүснэгт 3. Улсын инфляци -2016 оны байдлаар

	Сарын	Оны эхнээс	Жилийн
2016/12	0.7	1.1	1.1
2016/11	0.5	0.4	0.2
2016/10	-0.7	-0.1	-0.1
2016/09	-0.6	0.6	-0.1
2016/08	-1.0	1.2	-0.2
2016/07	-0.6	2.3	0.9
2016/06	-0.3	2.9	1.6
2016/05	0.1	3.3	1.8
2016/04	1.4	3.1	2.1
2016/03	0.5	1.7	1.7
2016/02	0.7	1.2	2.0
2016/01	0.5	0.5	1.7

Хүснэгт 4. Улсын инфляци -2017 оны байдлаар

	Сарын	Оны эхнээс	Жилийн
2017/12	0.5	6.4	6.4
2017/11	0.1	5.8	6.5
2017/10	0.4	5.7	6.9
2017/09	0.2	5.3	5.8
2017/08	0.8	5.1	5.0
2017/07	0.0	4.2	3.4
2017/06	-0.6	4.1	3.3
2017/05	0.3	4.4	3.7
2017/04	1.1	4.1	3.4
2017/03	0.9	3.1	2.5
2017/02	0.9	2.1	2.1
2017/01	1.2	1.2	1.9

2018 оны нэгдүгээр сард инфляци 1.4 хувьтай байна.

3. 2010-2012 оны уул уурхайн хоёр дахь шатны тэлэлт болж, Оюутолгой төсөл нь хөрөнгө оруулалт болон экспортод, тэрчлэн нүүрс экспортын том бүрэлдэхүүн хэсэг болж орж ирснээр экспорт жилд 37-40 хувь өсч, гадаадын хөрөнгө оруулалт 10 тэрбум ам.доллар болсон байна. Ерөнхийдөө Монголын нийт эдийн засагтай тэнцэх хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт орж иржээ. Алт тушаалт мөн 8-9 тонн хүрчээ. Үүний зэрэгцээ гадаад зээлийн эх үүсвэр ахиу нэмэгдэж, 3.2 тэрбум ам.доллар болсон байна. Эдгээр жилүүдэд орлогын санхүүжилт, эх үүсвэр хүртээмжтэй, хангалттай байсан боловч харамсалтай нь эдийн засагт ажлын байр, бүтээмж, хөрөнгө оруулалт, хуримтлал болж тогтоогүй. богино хугацааны мөчлөгтэй байв.
4. Уул уурхайн өсөлтийн цикл дуусч, 2012-2016 онд эдийн засаг асар хүнд үе рүүгээ хөл тавьсан гэж болно. Энэ хугацаанд гадаадын хөрөнгө оруулалт 14 тэрбумаас 1.8 тэрбум болж буурчээ. Харин алт тушаалт 2013 оны хуулийн өөрчлөлтөөс болоод тогтвортой өсөх хандлагатай болсон. Мөн бондын эх үүсвэрээр нэлээд санхүүжилт татсан байна. Хамгийн гол нь 2009 онд 4 тэрбум ам.доллар байсан эдийн засаг 2012 он гэхэд 3 дахин томорсон байна. Ийм том хэмжээний эдийн засгийг бага валютын орлогоор хэрхэн удирдах вэ гэдэг том сорилт, бэрхшээл тулгарсан байна. *Эдийн засгийн ийм нөхцөлд эрх баригч Аргчилсан нам Ипотекийн найман хувийн зээлийн бодлогыг хэрэгжүүлснээр улс төрийн өндөр оноо авч, нийгмийн сэтгэлзүйг тогтвортой барьж чадсан байна.*

Улс төрийн мөчлөг гаргасан процессүүг:

1. 2016 онд УИХ-ын сонгууль болж, үүний үр дүнгээр эрх баригч хүчин солигдсон. Улс төрийн мөчлөг эдийн засаг, бодлогод нөлөөлөх нэг хүчин зүйл. Энэ ч утгаар 2016 оны тавдугаар сар буюу сонгуулийн өмнө 10.5 хувь байсан бодлогын хүүг шинээр гарч ирсэн эрх баригчид шууд 15.0 хувь болгов. Ингэснээр суурь зээлийн хүү ипотекийн зээлээс даруй 7 хувиар өндөр болсон. Ашгийн төлөө ажиллаж байгаа арилжааны банкуудад зээлийн хүүгийн энэ их зөрүү нь ипотекийн зээлийг санхүүжүүлэх сонирхлыг бууруулах нөлөөтэй. Өнгөрсөн хугацаанд Монголбанк арилжааны банкуудад ипотекийн зээлийн хүүгийн алдангид нэг их наяд гаруй төгрөг хэвлэж өгсөн байна. Тэр үед буюу анх ипотекийн найман хувийн зээлийн хөтөлбөр эхэлж байх үед бодлогын хүүгийн зөрүү ердөө 2.5 хувь байсан бол 3 дахин өссөн гэсэн үг.

Бодлогын хүүгийн өсөлттэй холбоотойгоор мөнгөний эргэлт, хөрөнгө оруулалт буурна. Үүнийг дагаад хөдөлмөрийн зах зээл хямарна гэсэн үг. Ипотекийн зээлд хамрагдаж, цалингийн орлогоосоо зээлээ төлдөг ажилгүй болсон тохиолдолд зээлийн төлөлтөд асуудал үүснэ гэсэн үг. Хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой байдал өөрөө чанаргүй зээлээс сэргийлэх баталгаа болж өгдөг. Тэгэхээр уг зээлэнд хамрагдсан болон шинээр орохоор зэхэж буй айл өрхүүдийн хувьд эдийн засгийн томоохон проблем нь алын байр. Ажилгүйдэл үнэмлэхүй байдлаар буурсан үед бодлогын хүүгээ аажмаар өсгөдөг.

2. Монголбанк бодлогын хүүг эрх

баригч МАН 2016 оны наймдугаар сард тийнхүү огцом нэмж 15.0 хувь болгосон бол үүнээс хойш шат дараатай бууруулсаар 2017 оны 12 дугаар сард 11 хувь болгожээ. Ингэснээр 8 хувийн зээлийн хүүгийн зөрүү бодлогын хүүгийн зөрүү 3 хувь болсон байна.

3. Монголбанкны ерөнхийлөгчийн 2016 оны аравдугаар сарын 25-ны тушаалаар "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-ыг шинэчлэн баталжээ. Журамд орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийг Монголбанк өөрийн өмчлөлд байгаа ипотекийн зээлээр баталгаажсан бондын үндсэн болон купоны төлбөрийн эргэн төлөлтийн орлогоор санхүүжүүлэхээр тусгажээ. Санхүүжилтийн схемийг эргэн харж, оновчтой бүтэцтэй болохоор Төв банк ажиллаж байгаа ч тодорхой үр дүнд хүрээгүй л байна. Ганц Төв банк ипотекийн асуудалд шийдвэр гаргах бололцоогүй учраас Засгийн газартай бодлоготой зарчмаа нийцүүлэх, Барилга, хот байгуулалтын яамтай хамтарч судлах, ажиллах шаардлага үүссэн байна.

Улс төрийн сорилт:

Иргэдийн зүгээс талархал, дэмжлэг хамгийн ихээр хүлээсэн Ипотекийн зээлийн хөтөлбөрийг сөрөг хүчний зүгээс сааруулах сонирхол гарч байсныг үгүйсгэхгүй. Энэ мөн нэг сорилт болж байв. Тухайлбал, 2015 оны 10 дугаар сард "Иргэний хуулийн болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн зарим заалтын тодорхой хэсэг нь Үндсэн Хууль зөрчсөн байна" гэх үндэслэлээр иргэн А.Базар цэцэд гомдол гаргасан юм. Тэдгээр заалтыг Цэц хүчингүй болгох тохиолдолд

банкны зээлийн барьцаанд байгаа үл хөдлөх хөрөнгийг Банкны зөвшөөрөлгүйгээр түрээслэх, зарах боломж үүсэх тул банкууд болгоомжилсон. Үүнийг сөрөг хүчин МАН-ын зүгээс зохион байгуулж, Цэцэд хандсан гэх хардлага дэгдсэн байна.

- 2015 оны 10 дугаар сарын 13нд Цэцийн дунд суудлын хуралдаан болж, Цэц барьцаанд буй үл хөдлөх хөрөнгийг Банкнаас заавал зөвшөөрөл авч байж бусдад түрээслэх, хэлслэх, бусдын эзэмшилд шилжүүлэх, давхар барьцаалахаар зохицуулсан байсан нь Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэж хүчингүй болголоо.
- 2015 оны 11 дүгээр сарын 30-нд УИХ шийдвэрийг хүлээж авалгүй Цэцийн дүгнэлтийг хүлээж авалгүй Цэцэд буцаалаа. Мөн Монголбанк тэргүүтэй мөнгө санхүүгийн гол байгууллагуудаас цэцийн шийдвэрийг эсэргүүцэж Санхүүгийн Тогтвортой байдлын зөвлөмж гаргасан байна.
- 2015 оны 12 дугаар сарын 9-нд Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар маргааныг дахин хянаж, өмнөх шийдвэрээ дахин баталгаажуулан эцэслэн шийдвэрлэсэн. Мөн хуралдаанаар УИХ-ын 88 дугаар тогтоолыг хянан хэлэлцсэн байна.
- 2015 оны 12 дугаар сарын 10-нд Монголын банкуудын

холбоог төлөөлж ХХБ-ны гүйцэтгэх захирлын орлогч О.Орхон "Орон сууцны найман хувийн зээл ингээд хууль эрх зүйн орчингүй болж байгаа учир иргэдийг болон банкуудыг эрсдэлд оруулахгүйн тулд бид орон сууцны найман хувийн зээлийг Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрээс үүдэн зогсоож байна" гэв.

- 2015 оны 12 дугаар сарын 10-нд АН-ын бүлэг, МАХН-МУАН-ын эвслийн бүлгээс Цэцийн дүгнэлтээр хүчингүй болсон заалтуудын тухайд хуулийн нэмэлт өөрчлөлт хийж, 8 хувийн зээлийг үргэлжлүүлэн явуулах боломжийн төлөө ажиллана гэж мэдэгдэл хийв.
- 2015 оны 12 дугаар сарын 11-нд "МАН Цэцтэй хуйвалдан орон сууцны 8 хувийн зээлийг 20 хувь болгуулаа", "Цэц МАН-ын захиалгаар шийдвэр гаргалаа" гэх мэдээлэл цахим орчинд шуугиан тарьж, улмаар энэхүү мэдээллийг худал гүтгэлэг хэмээн МАН-ын төлөөлүүд мэдэгдлээ.
- 2015 оны 12 дугаар сар 11-нд "Цэцийн шийдвэрт банкны ямар нэгэн хүүтэй холбоотой асуудлыг авч хэлэлцээгүй. Банк хэдэн хувийн хүүтэй, ямар зээлээ, хэнд олгох вэ гэдэг нь Үндсэн хуулийн маргааны асуудал биш" хэмээн Үндсэн хуулийн цэцийн

гишүүн Д.Наранчимэг мэдэгдлээ

- 2015 оны 12 сар 12-нд Банкуудын холбооны гүйцэтгэх захирал Ж.Үнэнбат "Цэцийн шийдвэр 8 хувийн зээлтэй холбоогүй" гэх тайлбарыг эсэргүүцэж байгаа бөгөөд тэрээр "Цэцийн шийдвэр нь арилжааны банкны зээлийг эрсдэлд оруулж байна" гэж тайлбарлалаа.

Энэ мэт үйл явц эргэн тойронг нь өрнөж байсан ч эргэн төлөлт сайтай, нийгмийн хүчтэй захиалгатай, барилгын салбарын хөрөнгө оруулалтыг бас гэмжих үүрэгтэй, АН-ын улстөрийн нэр хүндэг нөлөөтэй хөтөлбөр тул эрх баригчид яаж ийгээг хамгаалж үлдэх нь тодорхой байлаа.

Найман хувийн зээлийн чадамж иргэн, банк аль аль талдаа шавхагдаж байна уу?

Энэ асуултад тийм гэх хариултыг өгмөөр байгаа ба яагаад энэ хариултыг сонгож байгааг дараах хоёр үзүүлэлтээр тайлбарлая:

Нэг. Зээлийн эх үүсвэр багассан. Уг хөтөлбөрийг санаачлагч Ардчилсан нам засгийн эрхийг барьж байх үед Засгийн газар, Монголбанкнаас хөтөлбөрт зориулан сард 100 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад олгож байсан бол 2017 оны 12 дугаар сарын байдлаар сард 25 тэрбум төгрөгийг өгч байна. 2017 оны 12 дугаар сарын статистикаар сард арилжааны банкууд нийтдээ 60 тэрбум төгрөгийг ипотекийн зээлд олгосон байгаа ба үүний 25 тэрбум нь Засгийн газраас олгосон, 35 тэрбум нь банкууд өөрийн эх үүсвэрээс олгосон

мөнгө юм. 2018 он гарсаар уг эх үүсвэрт Монголбанк 1 ба 2 дугаар сард тус тус 16.6 тэрбум төгрөгийг гаргажээ. Улсын нэгдсэн төсөвт ипотекийн зээлийн эх үүсвэрт нийтгээ 120 тэрбум төгрөгийг төсөвлөсөн ба өнгөрсөн тавдугаар сард нийт 46 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гаргажээ. Ипотекийн зээлийн эргэн төлөлтөөс сард 25-40 тэрбум төгрөг дараагийн зээлийн эх үүсвэрт хуримтлагддаг байна.

Хоёр. Зээлдэгчийн тоо 3 дахин буурсан. 2016 оны есдүгээр сар хүртэл ипотекийн найман хувийн зээлд сард дунджаар 2000 орчим хүн хамрагддаг байсан бол 2016 оны есдүгээр сараас энэ тоо 600-800 орчим болж, 3 дахин буурчээ. Тодруулбал, 2013 оны 12 дугаар сард нийт 2423 иргэнд ипотекийн зээл олгогдож байсан бол 2017 оны 12 дугаар сард банкууд нийтдээ 816 иргэнд уг зээлийг олгосон байна. Энэ нь уг зээлийн хөтөлбөрийг зориулсан гол сегмент өөрчлөгдөж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл урьдчилгаа 30 хувь, хүү 8% байх зээлийг худалдан авагч гол сегмент буюу зах зээл нь ханасан байна. Энэ нь банкуудын зээлийн мэргэжилтнүүдийн практик дүгнэлт, яг албан ёсны судалгаагаар баталгаажсан тоо байхгүй гэдгийг сануулах нь зөв байх. /судлах шаардлагатай/ Тэгэхээр сегментийг өөрчилж, зээлийн гол худалдан авагч нь урьдчилгаа 30%, хүү 8% гэдэг босгыг давж чадахгүй байгаа нийгмийн хэсэг гэж тооцоолж, тэдэнд зориулсан шинэ журам, нөхцөлийг бий болгох замаар үргэлжлэх хэрэгтэй болж байна.

Гурав. Орон сууцны үнийн өсөлт урьдчилгаа 30 хувийг ч өсгөж байна. Дэлхий дахинд үл хөдлөх хөрөнгө нэг ижил онцлогтой нь үнэ нь үргэлж өсч байдаг зүй тогтол юм. Энэ зүй тогтлоор орон сууцны үнэ хөтөлбөр эхэлж байх

үеийнхээс өсчээ. Хэрэв үнэхээр зүй тогтол юм бол цаашид ч өснө. Энэ нь ипотекийн зээлийн урьдчилгаа орон сууцны үнийн дүнгийн 30 хувийг мөн шууд хамаарлаар өсгөж байна гэсэн үг. 30 хувь гэх тоо өөрчлөгдөхгүй ч үүний цаана багтаж байгаа үнийн дүн өсч байгаа нь иргэдээс тэр хэмжээний хуримтлалыг шаардаж байна гэсэн үг. Хуримтлал, орлого нь ипотекийн зээлийн болзол хангасан иргэд ерөнхийдөө зээлд хамрагдаад дууссан байна. Одоо хуримтлал, орлого нь уг зээлийн болзол хангахад хүрэлцэхгүй байгаа иргэд гол сегмент гэж банкныхан үзэж байгаа. Гэтэл орон сууцны үнийн өсөлт нь урьдчилгаа 30 хувьд төлөх үнийн дүнг бүүр ч өсгөөд байгаа нь угаасаа 30 хувийг төлөх хуримтлал хүрэлцээгүй хэсэгт том дарамт болж байна. Тийм учраас зээлийн зориулалт нийгмийн ямар хэсэг рүү чиглэх шаардлагатай болоод байгааг дахин оновчтой тодорхойлж, онцлогт нь тохируулсан шинэ журам бий болгох хэрэгтэй болов уу. Зөвхөн зээлийн журмыг биш барилгын компаниудын борлуулалтын үнийг төрөөс зохицуулах шаардлагатай байж болох юм.

Дээрх нөхцөл шалтгааны улмаас найман хувийн зээл олголт, орон сууцжуулалт удаашрав. 2016 оныг хүртэл сард 100 тэрбум төгрөгийг зарцуулж байсан ипотекийн зээлд Монголбанк он гарсаар 2018 оны 1, 2 дугаар сард тус тус 16.6 тэрбум төгрөгийг гаргажээ. Тухайн сард зээлдэгчийн тоо 800 орчим /эх үүсвэрт 60 тэрбумыг гаргаж байх үед/ байгаа бол эх үүсвэрийн нөөцөөс шалтгаалаад цаашид үүнээс ч буурах нь тодорхой болж байна. Тэгвэл одоо зах зээлд бэлэн байгаа, борлогдохоо хүлээж байгаа 36000 орон сууцыг сард 800-аар борлуулна гэвэл ийм хурдаар бол тэдгээр орон сууц 3.7 жилийн дараа борлогдож дуусна гэсэн үг.

ДҮГНЭЛТ: Цаашид яах вэ?

- Найман хувийн зээлийн бодлого Засгийн газрын /2012-2016/ анх тооцоолсон гол priority зорьсон үр дүндээ магадгүй маш богино хугацаанд хүрчээ. Монголбанкны хувьд тухайн үед 3-4 их наяд төгрөгийг маш богино хугацаанд rollout хийх /хурдан өөрийгөө санхүүжүүлэх түвшинд хүрэх/ нь гол зорилго байсан бөгөөд энэ зорилгыг арилжааны банкны бүтэц л гүйцэтгэж чадахаар байв. Харин цаашид үүнийг гүйцэтгэх өөр илүү боловсронгуй бүтэц шаардлагатай байж болох юм. Үүнийг шийдвэрлэх замаар нийгмийн гол захиалга болох зээлийн хүү болон урьдчилгааг бууруулж болно.
- Мөн хамгийн гол зүйл болох санхүүжилтийн өөр шинэ эх үүсвэр олох нь чухал байна.
- Нэг чухал зүйл бий нь борлуулах орон сууцны үнийг буулгах талаар холбогдох яам нь ажиллах ёстой. Дэлхий дахинд үл хөдлөх хөрөнгө нэг ижил онцлогтой нь үнэ нь үргэлж өсч байдаг зүй тогтол юм.
- Засгийн газар ямар арга хэмжээ авахаар ажиллаж байгаа нь тодорхойгүй байна
- 2016 оны сонгуулийн дараа эрх баригч болсон хүчин ипотекийн зээлийн шинэ хувилбарыг боловсруулахаар оролдож байгаа. Гол зарчим нь урьдчилгаа 30 хувь болон зээлийн найман хувийн хүүг хөндөхгүй байх. Өөрөөр хэлбэл, зээлдэгчдэд шинэ хувилбар шууд байдлаар нөлөөлөхгүй байх ёстой гэсэн тооцооллыг гол болгох чиглэл баримталж байгаа гэх мэдээлэл байна.
- Олон Улсын Валютын Сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Монголбанкны зүгээс 2018 оны есдүгээр сар гэхэд хөтөлбөрийг Засгийн газарт бүрэн шилжүүлэхээр ажиллаж байна. Харин Засгийн газар ипотекийн хөтөлбөрийг цаашид хэрхэн үргэлжлүүлэх, хүртээмжийг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдэг дээр Дэлхийн банкнаас авсан зөвлөмжийн дагуу хэд хэдэн санал гаргаад журамдаа тусгахаар ярьж байгаа аж. Одоогоор журмаа эцэслэн тогтоогүй байгаа. Зарим мэдээллээр урьдчилгааг 25 хувь болгох, дахин дахин суурьшлын бүсэд зээл авсан бол хүүг нь бууруулна гэх зэрэг саналууд явж байна. Монголбанк энэ журамтай танилцаад, саналаа өгсөн. Одоогийн байдлаар ипотекийн зээлийн хөтөлбөр Монголбанкны эзэмшиж буй ипотекийн зээлээр баталгаажсан бондын үндсэн төлбөрөөс сан үүсгээд, үүнийгээ банкуудад хуваарилаад явж байгаа. Нэг, хоёрдугаар сард тус бүр 16.6 тэрбум төгрөгийн санхүүжилт гарсан. Засгийн газраас энэ онд 120 тэрбум төгрөгийг ипотекийн зээл олгоход төсөвт суулгасан байна. Зээийн хүүгийн хувьд одоо байгаа 8 хувийг Монголбанк бодлогын хүүтэй харьцуулаад өндөргүй гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ: Засгийн газарт яг одоо юу шаардлагатай вэ?

Нэг. Хүсэх хэрэгтэй. Ямартай ч хөтөлбөрийг үргэлжлүүлэх нь нийгмийн захиалга гэдэгт итгэлтэй байгаа бол тууштай байх зориг, зорилго, эрмэлзэл чухал. Одоогоор хөтөлбөр зогсчихоогүй,

сард зээл авч буй иргэний тоо оргил үеэс 3 дахин буурсан ч энэ нь болж л байна гэсэн байдлаар хандах, тайвшрах нь буруу. Зээлийн эх үүсвэр, зээлдэгчийн тоо аль аль нь цаашид буурах процесс

эхэлсэн учраас үүнээс илүү муу болохыг хүлээж, нийгэмд цочроо үүссэний дараа арга хэмжээ авна гэвэл энэ нь сайн бодлого биш. Эрэлт нь өндөр байгаа, барилгын материал үйлдвэрлэлийн хүчин чадал нь хангалттай байгаа одоогийн боломжийг ашиглаж, орон сууцжуулах ажлаа үргэлжлүүлэх хэрэгтэй.

Хоёр. Үр дүнд итгэх хэрэгтэй. Мөнгө зээлийн бодлогын хүрээнд аливаа улсын төр нь тухайлсан нэг бодлогын хүрээнд зорилтот сегментийг, салбарыг чухал гэж үзээд тодорхой санхүүгийн эх үүсвэр бий болгон дэмжиж болно. Орон сууцны 8 хувийн зээл бол тийм эх үүсвэртэй хөтөлбөр юм. Монголд хуримтлал хийдэг дундаж давхаргыг том болгох зорилгоор хямралын үеэр эхлүүлсэн, эх үүсвэртэй бодлого. Тухайн үед банкууд өөрийн эх үүсвэрээр дунджаар 16-17 хувьтай ипотекийн зээл олгож байсан тул хориод жилд нийтдээ гучин мянган хүнээс хэтрээгүйг санах хэрэгтэй.

Гурав. Ойрын хугацаанд тодорхой алхмуудыг хийх хэрэгтэй.

Ипотекийн зээлийн журамг гараах байдлаар өөрчлөлт оруулах:

- a. Зээлийн урьдчилгаа төлбөрийг 15 хувь хүртэл бууруулах,
- b. Зээлийн хүүг инфляци, ханш зэрэгтэй уялдан уян хатан, хөдөлгөөнтэйгээр тогтоох. 80 мкв хүртэлх талбайтай байр худалдан авбал 7%, 50 хүртэлх мкв байр авбал 5%, 80-аас дээш мкв байр авбал 8.5%, 100-аас дээш мкв байр авбал 9% гэх мэт бас байж болно. /санхүүгийн арга хэрэгсэл/

- c. Орон сууцны талбайн үнийг аль болох бодитой багаар тогтоох. Тухайлбал, барилгын компаниудтай зөвшилцөн ашгийн хувьд хязгаар тогтоох байдлаар. /Энэ нь захиргааны зохицуулалтын арга/

Санхүүжилтийн эх үүсвэр олох. БНСУ-аас авахаар тохиролцсон 800 сая ам.долларын 400 саяыг орон сууц барих болон ипотекийн зээлийн эх үүсвэрт зарцуулж болно.

Зээлийг олгож байгаа бүтцийг эргэн харах. Ипотекийн зээлийн чиглэлээр гол үйл ажиллагаа явуулдаг МИК-ийг менежмент, өмчлөлийнх нь хувьд олон улсын зах зээл рүү ойртуулах. Энэ тогтолцоог Монголд анх үүсэхэд Азийн хөгжлийн банк идэвхтэй оролцсон. Азийн хөгжлийн банкны 2005 оны тайланд үндэслээд тухайн үеийн Засгийн газар, Монголбанк, арилжааны банкуудын оролцоотой байгуулж, улмаар МИК болгосон байна. Тиймээс энэ бүтцээрээ дамжуулаад гадаад, дотоодын зах зээлээс хөрөнгө татах орчныг бүрдүүлж өгөх хэрэгтэй. Ипотекийг төсвөөс мөнгө гарган дэмжихгүй ч олон улсын зах зээлээс мөнгө татах боломж нээлттэй.

Барилгын компаниудтай ширээний ард сууж орон сууцны талбайн үнэд ашгийн 30 хувиас илүүгүй гэдэг ч юм уу хязгаар тавьж зохицуулах талаар зөвшилцөх. Мөн ипотекийн зээлээр орон сууц авах хүсэлтээ илэрхийлсэн иргэдийн чадамжид суурилсан талбай бүхий байр захиалах. Өөрөөр хэлбэл, борлуулагч, худалдан авагч хоёрын эрэлт, хэрэгцээг уялдуулах нь аль аль талдаа ашигтай.



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨГӨӨ СУРГАЛТЫН ТӨВ

Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Глобал эдийн засгийн судалгааны хүрээлэн нь **"Бизнесийн зөвлөгөө сургалтын төв"**-өөрөө дамжуулан бизнесийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн хувь хүмүүстэй хамтын ажиллагаагаа идэвхжүүлж, захиалгат судалгаа шинжилгээ, бизнесийн зөвлөгөө, сургалт зэрэг үйлчилгээг санал болгон ажиллаж байна.

Бид эдийн засаг, бизнесийн бүхий л талбаруудаар нарийн мэргэшиж, төрийн болон бизнесийн байгууллагуудтай хамтран үр ашигтай ажиллаж ирсэн 100 гаруй багш-зөвлөх-судлаачдынхаа чадавх, туршлагад тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг.

Та бүхэн өөрсдийн бизнесийн онцлог, бодит эрэлт хэрэгцээнд нийцсэн дараах зөвлөх үйлчилгээний төрлүүдээс сонголтоо хийж хамтран ажиллах боломжтой. Үүнд:

- Бизнесийн оношлогоо
- Захиалгат төрөл бүрийн сургалт
- Салбарын, байгууллагын захиалгат судалгаа
- Эрдэм шинжилгээ судалгааны төсөлт ажил
- Захиалгат зөвлөх үйлчилгээ
- Тендер, бизнесийн төсөл, төлөвлөгөө зэрэг баримт бичиг боловсруулалт
- Хөндлөнгийн болон экспертийн үнэлгээ
- Мэргэшүүлэх төрөл бүрийн сургалт
- Хамтарсан сургалт, семинар, хэлэлцүүлэг
- Оюутны зөвлөх үйлчилгээ зэрэг болон та бүхний эрэлтээс хамаарсан бусад чиглэлүүдийг санал болгож байна

Бид, их сургуулийн нийгмийн хариуцлагаа дээдлэж та бүхэнтэй нийгмийн инновацийг хамтран бүтээж ажиллахдаа үргэлж таатай байх болно.

ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА БАРИМТЛАХ ТЭРГҮҮЛЭХ ЗАРЧИМ



ХЭРЭГЦЭЭ, БОДИТ БАЙДАЛД НИЙЦСЭН

Бизнесийн орчны болон захиалагч байгууллагын бодит эрэлт хэрэгцээ, оношлогоонд тулгуурласан практик хэрэглээ бүхий оновчтой шийдэл, үр дүнд суурилсан чанартай гүйцэтгэл, тасралтгүй сайжруулалт, эргэх холбоотой хамтын ажиллагааг эрхэмлэнэ



МАНЛАЙЛАГЧ, ШУУРХАЙ БАГ

Судалгаа зөвлөх үйлчилгээний бүх талбаруудаар нарийн мэргэшсэн экспертүүд, багш-судлаачид болон бизнесийн салбар бүрт амжилттай ажиллаж буй практик туршлагатай гадаад дотоодын зөвлөх судлаачдын хамтарсан багтай



МЭРГЭЖЛИЙН, НАЙДВАРТАЙ, ХАРААТ БУС

Харилцагч байгууллагынхаа эрх ашгийг эрхэмлэж, зөвлөх үйлчилгээний стандарт, судлаачийн ёс зүйг чанд сахиж, харилцагчийн мэдээллийн нууцыг хадгалан, мэргэжлийн хараат бус зарчмыг баримтална

ЗАХИАЛГАТ СУРГАЛТ, СУДАЛГАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ЧИГЛЭЛЭҮҮД

Бид дараах чиглэлүүдээр захиалгат судалгаа, сургалт, зөвлөх ажил, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээс гадна тухайн байгууллагын бизнесийн онцлог, бодит эрэлт хэрэгцээнд нийцсэн, оношлогооны үр дүнгээс хамаарсан мэргэжлийн зөвлөх үйлчилгээг захиалгын дагуу уян хатан, хэсэгчилсэн ба цогц, эргэх холбоотойгоор хэрэгжүүлнэ.



Бизнесийн Удирдлагын мэргэжлийн зөвлөгөө, төсөл хэрэгжүүлэх болон захиалгат судалгаа, сургалтууд



Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зөвлөгөө өгөх, захиалгат ажил гүйцэтгэх болон захиалгат судалгаа, сургалтууд



Экономиксийн эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, зөвлөх үйлчилгээ



Санхүүгийн удирдлагын мэргэжлийн зөвлөгөө өгөх, захиалгат ажил гүйцэтгэх болон захиалгат судалгаа, сургалтууд



Хэрэглээний математик ба статистикийн мэргэжлийн зөвлөгөө өгөх, захиалгат судалгаа, сургалтууд



Бизнесийн эрх зүйн мэргэжлийн зөвлөгөө өгөх, захиалгат ажил, захиалгат судалгаа, сургалтууд



Англи хэл судлалын зөвлөгөө өгөх, захиалгат ажил, захиалгат судалгаа, сургалтууд



Мэдээллийн системийн мэргэжлийн зөвлөгөө өгөх, захиалгат болон захиалгат судалгаа, сургалтууд



Нийгэм, улс төр, төрийн байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах мэргэжлийн зөвлөгөө өгөх, захиалгат ажил, захиалгат судалгаа, сургалтууд

Бидэнтэй холбоо барих:

Утас: 70158812, 99142519, 99804389

Е-мэйл хаяг: yanjmaa.b@ufe.edu.mn khaliun.m@ufe.edu.mn

Вэбсайт: ufe.edu.mn

FB хаяг: Бизнесийн зөвлөгөө сургалтын төв

Хаяг: УБ хот, 13381, Энхтайвны өргөн чөлөө-5 СЭЗИС С байр 301 тоот

ECONOMIC ANALYTICA

УЛС ТӨРИЙН ЭДИЙН ЗАСАГ СУДЛАЛ

Эдийн засгийн шинжлэх ухааны эрдэмтэн судлаач, багш оюутан, мөн эдийн засгийн чиглэлээр бичдэг сэтгүүлч нарыг эрдэм шинжилгээний өгүүлэл, эдийн засгийн өгүүлүүдээ "Economic Analytica – Улс төрийн эдийн засаг судлал" сэтгүүлд хүргүүлж хэвлүүлэхийг урьж байна.

Манай сэтгүүл нь хэвлэгдэх өгүүлүүдээ доорх академик болон техникийн шаардлагыг тавих болно.

ЗОХИОГЧИЙН ҮҮРЭГ

МЭДЭЭЛЛИЙН СТАНДАРТ

- Зохиогч өөрийн судалгааны үр дүнг танилцуулахдаа гүйцэтгэсэн ажлаа бүрэн дүүрэн тайлагнаж, судалгааны ач холбогдлыг нь бодитойгоор илтгэнэ.
- Судалгааны тоон мэдээлэл бодитой, үнэн зөв байх шаардлагатай.
- Өгүүлэлд тодорхой мэдээлэл болон эшлэлийг хангалттай оруулсан байна.
- Хууран мэхэлсэн болон санаатайгаар алдаатай бичлэгийг ёс зүйгүй үйлдэл гэж үзэн хүлээн зөвшөөрөхгүй.

БҮТЭЭЛ

Зохиогчид өөрийн судалгааны эх бүтээлийг ирүүлнэ. Харин зохиогчид бусдын бүтээлээс болон бусдын үг ашигласан тохиолдолд заавал эх сурвалжийг эш татсан байх шаардлагатай

ОЛОН УДААГИЙН БУЮУ ДАВХАЦСАН НИЙТЛЭЛ

Зохиогч нэг судалгааны ажлыг нэгээс илүү сэтгүүл эсхүл анхдагч хэвлэлд нийтлүүлэхгүй. Адилахан эх бичмэлийг нэгээс илүү сэтгүүлд хэвлүүлэх нь нийтлэлийн ёс зүйгүй үйлдэл юм.

ЭХ СУРВАЛЖАА НОТЛОХ

Зохиогч бусдын бүтээлийг хүлээн зөвшөөрч, тухайн судалгааны агуулгад нөлөөлсөн бүтээлийг нэр зааж, эшлэл татсан байх шаардлагатай.

ЭХ БИЧМЭЛИЙН ЗОХИОГЧИЙН ЭРХ

Тухайн судалгааны бүтээлийн концепц гол санаа, загвар, гүйцэтгэл, аль эсхүл судалгааны дүгнэлт тайлбар зэрэгт зарчмын хувь нэмэр оруулсан хүмүүсийг зохиогчид хамааруулна. Харин судалгаа хийх явцад тодорхой ажилд оролцсон бол талархлын хэсэгт тэмдэглэнэ.

ТОДРУУЛГА БА СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Бүх зохиогч эх бичмэлдээ аливаа санхүүгийн, эсхүл бусад үндэслэл бүхий сонирхлын зөрчил байвал тодруулга хийх хэрэгтэй. Төслийн санхүүгийн дэмжлэгийн бүх эх сурвалжийн талаар тодруулга хийсэн байна.

НИЙТЛЭГДСЭН БҮТЭЭЛ ДЭХ ЗАРЧМЫН АЛДААНУУД

Хэрэв нийтлэгдсэн бүтээлд нь утгын алдаа, эсхүл доголдол гарсан бол зохиогч сэтгүүлийн редактор, хэвлэн нийтлэгчид мэдэгдэх ба бүтээлийг нийтлэхийг цуцлах, аль эсхүл хэвлэлийн алдааг засах дээр хамтран ажиллах бүрэн эрхтэй.

ӨГҮҮЛЛИЙН БҮТЭЦ




- Эх бичмэлийг WORD DOC, PDF хэлбэрээр илгээн.
- Хэрэв таны эх бичмэл тусгай тэмдэгт, томъёо зэрэг агуулсан бол PDF хэлбэрээр давхар илгээнэ.
- Сэдвээ Монгол хэлээр бичнэ
- Дараах бүтцийг ашиглана
 - Танилцуулга /сонголтоор/
 - Дэд хэсэг /хүснэгт, график, тайлбар агуулсан.../
 - Хавсралт /хэрэв байгаа бол/
 - Товчилсон үгийн тайлбар
 - Ашигласан материал – номзүй
 - График, хүснэгтүүдийг текст дотор биш тусад нь файл үүсгэн хийх.

ОНЦЛОН ТЭМДЭГЛЭСЭН ТЕКСТ, ГАРЧИГ, БОЛОН ГАДААД НЭР ТОМЬЁОНУУД

- Хэрэв текстийг онцлон тэмдэглэхийг хүсвэл доогуур зурааснаас илүүтэйгээр италик-ийг ашиглах. Текстийг өнгөөр тодруулах нь тийм ч зохистой биш.
- Гадаад нэр томьёонуудыг онцлохын тулд доогуур зураас биш италик-ийг ашиглах
- Ном, киноны нэрийг онцлохын тулд доогуур зураас биш италик-ийг ашиглах

ФОРМАТ

- Зөвхөн Юникод фонт ашиглах,
- Гарчгууд үндсэн хэсгээс ялгаатай бичигдэх,
 - Гарчгууд дээрээс доош /томоос жижигрүү/ шаталсан байх
- Хөл тайлбарууд бүтээлийн төгсгөлд биш тухай тухайн хуудасны доод талд тусгагдсан байх,
 - Маш урт хөл тайлбарыг хавсралт хэсэгт оруулах.
- Хүснэгт, графикуудыг задгай болон зурган форматаар хавсаргасан байх, зэрэг болно

 Монгол Улс, Улаанбаатар хот,
Төв шуудан – 558 хайрцаг,
“Амаржаргал Сан” ТББ
 (976) 9909-4435
 info@amarjargal.org
economic.analytica@gmail.com



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2017 оны 7 сарын 5-нд хуралдсан СЭЗИС-ийн Удирдах зөвлөлийн хурлаар эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулах шийдвэрийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. СЭЗИС-ийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, бакалавр, магистр, докторын бүхий л хөтөлбөрт суралцаж байгаа оюутнууд практик ажлын дөртэй болж бизнесийн зөвлөгөө өгөх, судалгаа шинжилгээ хийх үр чадвар эзэмших бололцоо нөхцөлийг бүрдүүлэн хангах болно.

ЗОРИЛГО

Монгол улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн судалгаа шинжилгээ, бизнесийн зөвлөгөө, сургалтын чанартай бүтээгдэхүүн бий болгож нийтийн хүртээл болгох, үр нөлөөтэй судалгааны байгууллага болж төлөвших.

ЗОРИЛТ

- Монгол улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн макро, микро түвшний тэргүүлэх чиглэлийн судалгааг глобал эдийн засгийн чиг хандлага, монгол ахуй, монгол хүний онцлог, төрийн бодлоготой холбон судалдаг нэр хүндтэй судалгааны институт болж төлөвших;
- Эрдэм шинжилгээ, судалгааны орчин үеийн арга, аргачлал, мэдээлэл харилцааны технологи, судалгаа шинжилгээний сүүлийн үеийн ололт амжилтыг эзэмшин судалгаа шинжилгээний үйл ажиллагаанд хэрэглэж, хэвшүүлэх, СЭЗИС-ийн бүх оюутан, багш нарын хүртээл болгох;
- Судалгаа шинжилгээний лаборатори, техник хэрэгсэл, програм хангамж, дадлагын газар, бизнес инкубатор зэрэг шаардлагатай материаллаг баазийг бүрдүүлэн судалгаа шинжилгээ, бизнесийн зөвлөгөө, сургалтыг зохион байгуулахад үр дүнтэй ашиглах;
- Бүтэц, зохион байгуулалт, материаллаг бааз, санхүүгийн хувьд бэхжиж, цаашдаа бие даан үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх
- Гадаад, дотоодын ижил төстэй судалгааны байгууллагуудтай үр ашигтай хамтын ажиллагааны харилцаа тогтоож, харилцан туршлага судлах, олон улсын шилдэг туршлагаас суралцах зэргээр судалгаа шинжилгээ, бизнесийн зөвлөгөө, сургалтын чанар чансааг олон улсын түвшинд хүргэх зэрэг болно.

ЧИГ ҮҮРЭГ

- СЭЗИС-ийн Эрдэм шинжилгээ судалгааны тэргүүлэх чиглэлүүдийн дагуу судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх
- Төр, хувийн хэвшил, иргэний байгууллагуудтай хамтран ажиллаж тэдний захиалга, санхүүжилтээр судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, СЭЗИС-ийн төсөвт эрдэм шинжилгээ судалгаанаас орох орлогыг нэмэгдүүлэх
- СЭЗИС-ийн захиалга, санхүүжилтээр хийгдэх судалгааны ажлуудын хэрэгцээг тодорхойлж, зохион байгуулж, хугацаанд нь гүйцэтгэж хүлээлгэн өгөх
- Бизнесийн зөвлөгөө, богино хугацааны сургалтын бодит хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн боловсруулж, бизнес эрхлэгчдэд санал болгох, гүйцэтгэх, тайлагнах
- Гүйцэтгэсэн судалгааны ажил, бизнесийн зөвлөгөө, сургалтын үр дүнг нийтийн хүртээл болгох, судалгааны бүтээлийн санг баяжуулах, эрдэм шинжилгээний бүтээлийн үзэсгэлэн, хурал, семинар зохион байгуулах зэрэг арга хэмжээ авах
- Судалгаа шинжилгээний арга зүйг боловсронгуй болгон судалгааны анхдагч мэдээллийн баазыг бий болгож баяжуулах
- СЭЗИС-д ажиллаж байгаа доктор, профессор, дэд профессоруудтай нягт хамтран ажиллаж, тэдний хүчин чармайлтаар судалгаа, бизнесийн зөвлөгөөний захиалга авах, гүйцэтгэх, хийсэн ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх, урамшуулах арга хэмжээ авах

